



МОНГОЛБАНК



WORLD BANK GROUP

**ЭДИЙН ЗАСАГ,  
САНХҮҮГИЙН НЭР  
ТОМЬЁОНЫ  
ТАЙЛБАР ТОЛЬ**

УЛААНБААТАР  
2015

DDC  
413  
Д-467

© 2015. МОНГОЛБАНК

Энэхүү тайлбар толь нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Монголбанкнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Танд хүрч буй энэхүү хувь нь анхны хэвлэлт тул цаашид засч, сайжруулах аливаа санал, шүүмжийг Монголбанкны Хяналт Шалгалтын Газарт ирүүлбэл бид талархан хүлээж авч, дараа дараагийн хэвлэлтэд тусган хүргэх болно.

ISBN 978-99973-63-35-0

---

---

## ГАРЧИГ

---

---

Өмнөх үг.....	5
Эдийн засаг .....	9
Банк, санхүү, хөрөнгө оруулалт.....	57
Анхны нийтийн арилжаа .....	169
Үл хөдлөх хөрөнгө, ипотекийн зээл .....	179
Англи нэр томъёоны жагсаалт буюу индекс.....	197



---

## ӨМНӨХ ҮГ

---

**М**онголбанк санхүүгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүртэж буй хэрэглэгч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлэх талаар олон талт арга хэмжээ хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”-ийн санхүүжилтээр Монголбанкны Хяналт шалгалтын газраас санаачлан энэхүү тайлбар толийг зохиогчидтой хамтран бүтээж Табухний гар дээр хүргэж байна.

Санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр шинэ ойлголт, нэр томьёонууд бий болж, тэдгээрийг цэгтэй, ойлгомжтой, нэг мөр болгон тайлбарлах шаардлага тулгараад байна. Бид өмнө нь эрдэмтэн, судлаач, багш нарын гаргаж байсан санхүүгийн чиглэлийн толь бичгийн агуулгыг давталгүйгээр олон улсын болон Монголын санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч байгаа нэр томьёог түлхүү оруулж, энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарлахыг хичээллээ. Ингэснээр санхүүгийн чиглэлээр суралцаж байгаа оюутан сурагч, судлаачдаас эхлээд хэвлэл мэдээллийн ажилтан, санхүүгийн зах зээлийн оролцогчид, энгийн иргэд хүртэл англи хэл дээрх мэргэжлийн ном, сэтгүүлийг ашиглах боломжтой болох, танин мэдэхүйн хүрээг тэлэх, нэгдсэн цэгц ойлголттой болоход дөхөм болно гэж найдаж байна.

Энэхүү тайлбар толийг боловсруулсан зохиогчид, ажлын хэсгийн гишүүд, үнэтэй санал, хувь нэмрээ оруулсан Монголбанк, Дэлхийн банкны “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”-ийн хамт олонд Монгол улсын санхүүгийн зах зээлийн хөгжил, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үйлсэд өндөр хувь нэмэр оруулж байгаад нь талархаж буйгаа илэрхийлье.

МОНГОЛБАНК

---

## ЗОХИОГЧИЙН ҮГ

---

**М**онгол Улсын санхүүгийн салбарыг өнөөг хүртэл үндсэндээ банкны сектор тодорхойлж иржээ. Гэвч энэ хандлага тун удахгүй төгсгөл болно. Та бид ойрын ирээдүйд хөрөнгийн захын үсрэнгүй хөгжлийн гэрч болох цаг ойрхон байна. Өнөөдөр Монгол Улсын Засгийн газар, хувийн компаниуд нэгэнт дотоод, гадаад санхүүгийн захын тоглогчид болжээ. Хөрөнгийн захын хурдацтай хөгжил нь иргэдийн санхүүгийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх шаардлагыг зүй ёсоор тавьж байна. Энэхүү эрэлт хэрэгцээг иш үндэс болгож, орчин цагийн хөгжлийн чиг хандлагаас хоцрохгүйг хичээж иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн энэхүү толь бичгийг боловсруулан гаргахыг бид хичээсэн билээ.

Монгол Улсад өмнө нь энэ чиглэлээр хэвлэгдэх байсан санхүүгийн толь бичгүүдийг бид нэгбүрчлэн шүүрдэн үзэж, түүнчлэн Англи, АНУ, Австрали зэрэг улс орны туршлагад тулгуурлаж зайлшгүй тайлбарлах ёстой нэр томъёоны жагсаалтыг эхлээд гаргасан болно. Ингэхэд хоёр төрлийн хүндрэл бэрхшээл учирч байв. Нэгд, англи хэл дээрх нэр томъёог монгол хэл рүү янз бүрээр хөрвүүлэх тохиолдол цөөнгүй байв. Хоёрт, урьд өмнө нь монгол хэлэнд огт бууж байгаагүй нэр томъёотой нэлээдгүй тааралдав. Энэ нь бидний ажлын хамгийн хүнд хэцүү хэсэг байсан ч голчийг нь алдахгүйг хичээнгүйлэн ажиллаа. Алдсан, оносон аль аль нь бий биз. Эрхэм хүндэт уншигчид өөрсдийн санал бодлыг ирүүлбэл ихэд талархах болно.

Бид санхүү, хөрөнгө оруулалтын үг хэллэг, нэр томъёог тулхүү оруулахыг хичээсэн болно. Толь бичгийн гол онцлог нь энэ юм. Өнгөхөн хараход олон үг хэллэг, ойлголт Монгол Улсын хувьд хамааралгүй мэт санагдаж болох ч энэ нөхцөл байдал тун удахгүй өөрчлөгднөө гэдэгт зохиогчид итгэл төгс байна. Өнөөдөр хувьцаа, бондын талаар сонсоогүй, мэдэхгүй хүн цөөн. Тэгвэл арваадхан жилийн өмнө үнэт

цаас, хөрөнгийн бирж, IPO буюу анхны нийтийн арилжааг мэддэг хүн хэд байсан билээ.

Тус толь бичиг нь “Эдийн засаг”, “Банк санхүү, хөрөнгө оруулалт”, “Үл хөдлөх хөрөнгө, ипотекийн зээл” болон “Анхны нийтийн арилжаа” гэсэн 4 бүлгийн 1300 орчим үг хэллэг, нэр томьёонос бүрдэнэ. Ипотек болон үнэт цаасны анхны нийтийн арилжааг ийнхүү тусад нь бүлэглэсэн нь Монгол Улсын санхүүгийн захын хөгжлийн өнөөгийн онцлогийн тусгал юм. “Чингис” бонд, “Самурай” бонд, Таван толгой компанийн IPO буюу анхны нийтийн арилжаа, Засгийн газар, Төв банкнаас хамтран хэрэгжүүлж буй 8 хувийн ипотекийн зээлийн хөтөлбөрийн талаар сонсоогүй хүн өнөөдөр Монголд ховор биз ээ. Энэ бол Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд эргэлт буцалтгүй татагдан орсны баталгаа.

Нэр томьёоны англи хэл дээрхи үг хэллэгийг толь бичгийн ард Индексийн хэсэгт хадаж өгөв. Иймд англи нэр томьёоноос эхлэн хайж буй уншигч Индекст хандан холбогдох тайлбарыг аль хуудаснаас авч болохыг магадлана уу.

Аливаа толь бичиг бол нэр томьёоны талаар анхдагч үндсэн ойлголт өгөх зорилготой байдаг. Хэдийгээр эл тольд бид зарим тодорхойлолтыг жишээгээр баяжуулан аль болох өргөн дэлгэр мэдлэг мэдээлэл өгөхийг зорьсон ч онолын тайлбар, үндэслэлийг холбогдох ном, сурх бичгээс лавшруулан судлахыг зөвлөж байна.

Эцэст нь энэхүү төслийг хэрэгжүүлсэн Дэлхийн банкны “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”, мөн толь бичгийг ариутган шүүж, үнэтэй зөвлөмж өгсөн эрдэмтэн мэргэд, эдийн засгийн ухааны мэргэжилтнүүдэд гүн талархлаа илэрхийлье.

## ЗОХИОГЧИД



---

## ЭДИЙН ЗАСАГ

---

### A

**Ажил /Work/** Зорилго, үр дүнд хүрэхэд гаргаж буй хүчин чармайлт (цалин хөлсний төлөө), ямар нэгэн юмыг хийхэд хэрэглэж буй дадал туршлага, мэдлэг, тодорхой ажил, албан тушаал хаших, ажил мэргэжил, бизнес, худалдаа гэх мэт.

**Ажил мэргэжил /Occupation/** Ажил, эсхүл мэргэжил. Түүнчлэн ажлын төрөл (заримдаа тавигдах шалгуураар тодорхойлогоно).

**Ажил эрхлэлтийн түвшин /Employment rate/** Ерөнхийдөө ажил эрхэлж буй 15 ба түүнээс дээш насын иргэдийн нийт ажиллах хүчинд эзлэх хувь. Манай улсын хувьд сүүлийн 7 хоногт ядаж 1 цаг цалин, орлоготой ажил эрхэлсэн хүнийг ажил эрхэлдэг гэж тодорхойлдог байна.

**Ажил, ажлын байр /Job/** Захиалгаар, тохирсон хөлсөөр хийх ажил. Тогтмол ажил эрхлэлттэй холбоотой цалинтай ажлын байр.

**Ажилгүйдлийн төрөл /Types of unemployment/** Ажилгүйдлийг хэд хэд янзаар ангилах боломжтой. Мөчлөгийн ажилгүйдэл нь эдийн засаг уруудах үед бий ажлаас нөгөө ажилд шилжих үед үүсэх ажилгүйдлийг шилжилтийн ажилгүйдэл гэнэ. Цаг үеийн шаардлагаар зарим ажлын байр шаардлагадах үед бутцийн ажилгүйдэл үүсдэг. Улирлын чанартай ажил мэргэжлээс шалтгаалан улирлын ажилгүйдэл бий болно. Далд ажилгүйдэл бол албан ёсны статистикт тусгагдаагүй ажилгүйчүүдийн тоо юм. Тогтмол (архаг) ажилгүйдэл гэдэг нэр томьёог оюуны, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд хэрэглэдэг.

**Ажилгүйдлийн түвшин /Unemployment rate/** Тухайн улсын нийт ажиллах хүчинд ажилгүйчүүдийн эзлэх хувиар ажилгүйдлийн түвшинг тодорхойлно.

**Ажилгүйдэл /Unemployment/** Ажил идэвхтэй хайж буй ажилгүй иргэдийн тоо. Манай улсын хувьд сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй бөгөөд хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй болон бүртгэлгүй, ажил идэвхитэй хайж байгаа, ажиллахад бэлэн хүнийг хамруулж ажилгүйчүүдийг тооцдог.

**Ажилд орохыг хүссэн өргөдөл /Letter of application/** Ажил хайж буй хүний ажил олгогчид бичсэн захиа. Түүнд ажил хайгч өөрийгөө танилцуулахын сацуу тус ажлын байрны шалгуурыг хэрхэн хангаж буйгаа тайлбарлаж ярилцлагад орох хүсэлтээ илэрхийлнэ. Өргөдлийн зорилго нь ажил олгогчид итгэл үнэмшил төрүүлэхэд оршино.

**Ажиллах хүч /Labor force/** Ажил эрхэлж буй болон ажилгүйчүүдийн нийлбэрээр тухайн улсын ажиллах хүчинг тодорхойлно. Манай улсын хувьд ажиллах хүчинд ажил эрхэлдэг хүн, ажилгүй иргэдийг хамруулж байгаа бөгөөд энэ нь цаашдаа улс, аймгийн нийгэм, эдийн засаг, ялангуяа ажиллах хүчний бодлого төлөвлөлтөнд чухал ач холбогдолтой мэдээлэл болдог.

**Ажилчид /Workers/** Ажил гүйцэтгэхээр (бүтээгдэхүүн үйлчилгээ үйлдвэрлэх) хөлслөгдсөн хүмүүс.

**Ажлын ёс зүй /Work ethic/** Ажлын байр болон түүнтэй холбоотой ёс зүйн хэмжээг цөмөө болгосон үнэт зүйлсийн систем, ажлаа сайн хийх хариуцлага ухамсар.

**Ажлын ур чадвар /Work skills/** Тухайн ажлыг хийж гүйцэтгэх чадвар.

**Алдагдсан боломжийн өртөг /Opportunity cost/** Нөөцийн хомсдмолов байдлаас шалтгаалан нэг хувилбарыг сонгоход цаана нь сонгох боломжгүйд хүрсэн хамгийн сайн (хоёр дахь сайн) хувилбарын үнэ цэнээр хэмжинэ.

**Амьжиргааны түвшин /Standard of living/** Хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлнэ.

**Антrepренёр /Entrepreneur/** Өөрийн ур чадвар, санаачлагад тулгуурлан шинэ бизнест хүч сорьж буй хүн. Антrepренёр хүний онцлог нь бусдын “эрсдэл” гэж харах зүйлийг “боломж” хэмээн харж чаддагт оршино. Жишээ нь Стив Жобс нь Apple Inc компаний хамтран үүсгэн

байгуулагч бөгөөд Америкийн антрепренёруудын том төлөөл юм.

**Ахиу биет бүтээгдэхүүн /Marginal physical product (MPP)/** Үйлдвэрлэлийн аль нэг нөөцийг нэг нэгжээр ахиулахад (бусад нөөц тогтмол) нийт гарц буюу бүтээгдэхүүний хэмжээ хэдэн нэгжээр нэмэгдэхийг харуулдаг.

**Ахиу бүтээгдэхүүн буурах хууль /Law of diminishing marginal returns/** Үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа эдийн засгийн нөөцийүүдийн ядаж нэг нь (ихэвчлэн капитал) тогтмол байх буюу богино хугацаатай холбоотой ойлголт юм. Хувьсах нөөцийг нэмэгдүүлэх тусам (ихэвчлэн хөдөлмөр) нэгж хувьсах нөөцийн нэмж үйлдвэрлэх бүтээгдэхүүний хэмжээ буюу ахиу бүтээгдэхүүн хэмжээ буурахыг харуулна.

**Ахиу бүтээгдэхүүний орлого /Marginal revenue product (MRP)/** Эдийн засгийн нөөцийг нэг нэгжээр ахиулахад нэмж олох орлогын хэмжээг харуулна. Ахиу бүтээгдэхүүний хэмжээг тухайн бүтээгдэхүүнийг борлуулсан үнээр үржүүлж тооцно.

**Ахиу зардал /Marginal cost/** Бүтээгдэхүүний тоо хэмжээг нэг нэгжээр ахиулахад үйлдвэрлэлийн нийт зардал ямар хэмжээгээр нэмэгдэхийг харуулна. Нийт зардлын өөрчлөлтийг үйлдвэрлэлийн тоо хэмжээний өөрчлөлтөд харьцуулж тооцно.

**Ахиу орлого /Marginal revenue (MR)/** Үйлдвэрлэлийн хэмжээг нэг нэгжээр нэмэгдүүлэхэд нийт орлогын нэмэгдэх хэмжээ.

**Ахиу үр ашиг /Marginal benefit/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ, эсхүл үйлдвэрлэлийг нэг нэгжээр ахиулахад бий болох нэмэлт үр ашиг. Үүнийг мөнгөөр, эсхүл ханамжаар хэмжиж болно.

**Ахиу хадгалах хандлага /Marginal propensity to save (MPS)/** Ахиу хадгалах хандлага гэдэг нь бэлэн орлого нэг нэгжээр нэмэгдэхэд хадгаламж хэдэн нэгжээр нэмэгдэхийг харуулна.

**Ахиу ханамж /Marginal utility/** Бүтээгдэхүүний хэрэглээг нэг нэгжээр ахиулахад хэрэглэгчийн ханамж хэдэн нэгжээр нэмэгдэхийг харуулна.

**Ахиу ханамж буурах тухай хууль /Diminishing marginal utility/** Тодорхой хугацааны интервалд бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх тусам дараа дараагийн нэгж бүтээгдэхүүнээс нэмж авах таашаал (ахиу ханамж) буурахыг хэлнэ.

**Ахиу хэрэглэх хандлага /Marginal propensity to consume (MPC)/** Ахиу хэрэглэх хандлага гэдэг нь бэлэн орлого нэг нэгжээр нэмэгдэхэд хэрэглээ хэдэн нэгжээр нэмэгдэхийг харуулна.

**Ахиуц шинжилгээ /Marginal analysis/** Тухайн үйлдэл, үйл ажиллагаатай холбоотойгоор гарах нэмэлт үр ашгийг нэмэлт зардалтай нь харьцуулан шийдвэр гаргах арга.

**Ацаглаа, аутсорсинг /Outsourcing/** Компанийн зарим үйл ажиллагааг өөр компанийд хариуцуулах явдал.

**Ашгийг хамгийн их байлгах /Profit maximization/** Ахиу орлого ахиу зардалтай тэнцэх үед пүүсийн ашиг хамгийн их байна. Ахиу орлого нь ахиу зардлаасаа их (бага) үед үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх (бууруулах) нь ашгийг нэмэгдүүлнэ.

**Ашгийн бус байгууллага /Nonprofit organization/** Орлогын албан татвараас чөлөөлөгдсөн байгууллага. Орлогоо гишүүд, дэмжигчдийн татвар, хандиваас бүрдүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ үнэгүй, эсхүл өртгөөс доогуур үнээр нийлүүлэх ёстой.

## Б

**Байгалийн баялаг /Natural resources, land/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ашиглаж болох "байгалийн хишиг". Тухайлбал, далай, агаар, ашигт малтмал, ой мод, газрын баялаг гэх мэт. Газар, эсхүл бусад байгалийн баялагт хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд эдгээр нөөцийн зарим хэсэг нь капиталын нөөц болно. Байгалийн баялгийг газар гэх нь ч бий.

**Банк хоорондын цахим арилжааны систем /Interbank electronic system/** Төв банк болон банкуудын хооронд хийж буй банк хоорондын захын арилжааг гүйцэтгэх цахим системийг хэлнэ.

**Бартер /Barter/** Нэг бараа, үйлчилгээг нөгөө бараа, үйлчилгээгээр шууд арилжих (мөнгө ашиглалгүйгээр) хэлбэр.

**Бизнес /Business/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиг олох зорилгоор үйлдвэрлэж буй байгууллага, үйл явц.

**Бизнесийн мөчлөг /Business cycles/** Эдийн засгийн үйл ажилагаанд гарч буй хэлбэлзэл (өсөлт, бууралт). Хэлбэлзэл нь далайц болон үргэлжлэх хугацааны хувьд харилцан адилгүй байна. Ихэвчлэн бодит ДНБ-ээр хэмждэг.

**Бизнесийн төлөвлөгөө /Business plan/** Компанийн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх боломж, стратегийг тусгасан тайлбар.

**Бизнесийн хууль эрх зүйн хэлбэрүүд /Legal forms of business/** Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компанийн хэлбэрээр байгуулна. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна.

**Богино хугацаа /Short run/** Үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа эдийн засгийн нөөцүүдийн ядаж нэг нь тогтмол байх хугацаа.

**Бодит болон нэрлэсэн үзүүлэлтийн ялгаа /Real vs. Nominal/** Мөнгөн утгыг илэрхийлэх хоёр арга зам. Нэрлэсэн мөнгөн утгыг оны үнээр, харин бодит мөнгөн утгыг зэргэцүүлэх үнээр (суурь үеийн үнээр) хэмжинэ. Нэрлэсэн мөнгөн утгыг холбогдох үнийн индексээр засварлах замаар бодит мөнгөн утгыг олно.

**Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн /Real Gross Domestic Product (GDP)/** Зэрэгцүүлэх үнээр илэрхийлэгдсэн ДНБ. Нэрлэсэн (оны үнээр) ДНБ-ийг үнийн дефляторт харьцуулах замаар тооцно. Эдийн засгийн үйл ажиллагааг үнэлэхэд хэрэглэнэ. Нэрлэсэн ДНБ-ий өсөлт нь үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон үнийн өсөлтийн аль алиных нөлөөг харуулдаг. Харин бодит ДНБ нь тухайн эдийн засгийн бодит үйлдвэрлэлийн тоо хэмжээний өсөлтийг харуулдаг.

**Бодит хүү /Real interest rates/** Нэрлэсэн (зарласан) хүүгээс инфляцийг хасч бодит хүүг тооцно. Хадгаламжийн хувьд авч үзвэл хадгаламжийн бодит хүү нь таны хадгаламж бодитоор буюу барааны үнэ цэнийн бууралтыг тооцвол ямар хэмжээгээр өөрчлөгдсөнийг харуулна. Тухайлбал,

банкны зарласан хадгаламжийн хүү жилийн 15%, жилийн инфляци 10% гэвэл таны хадгаламжийн бодит хүү 5% бөгөөд энэ нь таны хадгаламжийн бодит үнэ цэнэ 5%-иар л өссөн болохыг харуулна.

**Бодит цалин /Real wage/** Инфляциар засварласан цалин. Цалингийн худалдан авах чадвар, цалингаар худалдан авч болох бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ.

**Бодлогын хүү /Policy rate/** Төв банк нээлттэй захын үйл ажиллагаагаар дамжуулан удирддаг богино хугацаатай хүүгийн зорилтот түвшин. Манай улсын хувьд бодлогын хүүг Төв банкны 7 хоногийн хугацаатай үнэт цаасны хүүгээр төлөөлүүлдэг. Бодлогын хүүгийн өсөлт (бууралт) нь мөнгөний бодлогыг Төв банк чангaruулж (сулруулж) буйг харуулдаг. Тухайлбал, эдийн засгийн уналтын үед Төв банк ДНБ-ий зөрүүг багасгахын тулд бодлогын хүүг бууруулдаг бол эдийн засгийн халалтын үед инфляцийг хазаарлах зорилгоор бодлогын хүүгээ өсгөдөг байна.

**Боломжит дотоодын нийт бүтээгдэхүүн /Potential gross domestic product (GDP)/** Хөдөлмөр болон бусад нөөцийг бүрэн дүүрэн ашиглах нөхцөлд эдийн засгийн үйлдвэрлэж чадах ДНБ. ДНБ-ий урт хугацаанд хүрч чадах хамгийн өндөр түвшин. Ердийн ажилгүйдлийн үеийн ДНБ.

**Боломжит хувилбар /Alternative/** Тухайн нөхцөл байдалд хийж болох олон сонголтын нэг нь буюу авч болох олон арга хэмжээний нэг нь.

**Буцалтгүй тусlamж /Grant/** Ихэвчлэн Засгийн газар, корпораци, сан зэргээс ашгийн бус хуулийн этгээд, боловсролын байгууллага, бизнесийн байгууллага, хувь хүн зэрэг хүлээн авагч талд буцаан төлөхгүй нөхцөлтэй олгосон мөнгөн хөрөнгө.

**Бүрэн ажил эрхлэлт /Full employment/** Ажил эрхлэлтийн ердийн (ажиллах хучний 93-95 хувь) түвшин буюу шилжилтийн ажилгүйдэл 5-7 хувьтай байх үеийн ажил эрхлэлтийн түвшин. Нөгөө талаас эдийн засагт мөчлөгийн ажилгүйдэлгүй байхыг бүрэн ажил эрхлэлт гэж үздэг. Өөрөөр хэлбэл, шилжилтийн, улирлын ажилгүйдлийг эдийн засагт хэвийн ажилгүйдэл гэж үздэг.

**Бүтцийн ажилгүйдэл** /Structural unemployment/ Эдийн засгийн бүтцийн илрэл болсон шинэ ажлын байрны хэрэгцээ шаардлагаас хүмүүсийн өнөөгийн чадвар, дадлага туршлага, байршил нь хоцорч буй тохиолдолд бүтцийн ажилгүйдэл үүсдэг.

**Бүтээгдэхүүн (бараа)** /Goods, product/ Эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй биет зүйлс.

**Бүтээмж** /Productivity/ Нэгж орц (эдийн засгийн нөөц)-д ногдох гарц (бүтээгдэхүүн, үйлчилгээ)-ын хэмжээ.

**Бэлэглэлийн гэрээ** /Gift deed/ Хөрөнгө өмчлөгч нь өөрийн хөрөнгийг бэлэглэх замаар нөгөө талд шилжүүлэхийг зөвшөөрч хийсэн (ихэвчлэн ойрын хамаарал бүхий этгээдүүдийн хоорондын) гэрээ.

**Бэлэглэлийн татвар** /Gift tax/ Бэлэглэлийн гэрээгээр нэг этгээдээс нөгөө этгээдэд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгөд ногдуулсан татвар. Ихэнх бэлэг хуулийн дагуу татвараас чөлөөлөгддөг.

## B

**Валютын зөвлөл** /Currency board/ Дотоодын мөнгөн тэмдэгтийн гадаад валютын эсрэг ханшийг тогтмол байхаар тогтоодог төрийн байгууллага (зарим улс оронд).

**Валютын ханш** /Exchange rate/ Нэг улсын мөнгөн тэмдэгтийг нөгөө улсын мөнгөн тэмдэгтээр солилцох үнэ. Тухайлбал, америк долларын төгрөгтэй солилцох ханш 2014 оны 9 дүгээр сарын 25-ны байдааар 1840 төгрөг байна.

**Вариаци** /Variance/ Дундаж утгаасаа хазайх хазайлтыг хэмждэг магадлалын онол болон статистикт хэрэглэгддэг үзүүлэлт.

## Г

**Гадаад валютын нөөц** /*Foreign exchange reserve*/ Гадаад валютын нөөц гэдэг нь тухайн Төв банкны балансад бүртгэлтэй гадаад валютаар гадаадын банк санхүүгийн байгууллагад байршуулан хадгалж буй хөрөнгө юм. Тухайн улсын гадаад валютын нөөц нь тухайн улсын гадаад худалдаа, зээлийн төлбөр гэх мэт бүх төрлийн гадаад төлбөр тооцоог хийхэд байнга ашиглагдаж байдаг.

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт** /*Foreign direct investment (FDI)*/ Θөр улсад компани, эсхүл бизнесийг эзэмшихтэй холбоотой хөрөнгө оруулалт. Тухайлбал, өөр улсад үйлдвэр барих гэх мэт. Харин хөрөнгийн биржид хөрөнгө оруулах буюу санхүүгийн активуудыг худалдан авч буйг багцын хөрөнгө оруулалт (*portfolio investment*) гэдэг.

**Гипер инфляци** /*Hyperinflation*/ Унийн ерөнхий түвшин хурдацтай өсөх явдал. 1956 онд Филип Каган хэт инфляцийг тодорхойлоходоо сарын инфляци 50 хувиас давснаар эхлэх бөгөөд эргээд 50 хувиас дотогш орох үеийн (дор хаяж нэг жилийн турш хадгалагдах ёстой) өмнөх сараар дуусгавар болдог гэжээ. ХБНГУ-д хэт инфляцийн үед мөнгөний ханш унаснаар хүмүүс мөнгийг тоолохын оронд жинлэж байсан түүх байдаг.

**Гүйлгээнд байгаа мөнгө** /*Currency in circulation*/ Банкнаас гадуурхи мөнгө болон банкуудын касст байгаа мөнгөний нийлбэр.

**Гүйлгээний зардал** /*Transaction cost*/ Эдийн засгийн солилцоо хийх үед буюу зах зээлд оролцох үед бий болж буй зардал. Жишээ нь, үнэт цаас худалдах, худалдан авах үед үүссэн брокерийн шимтгэл, үнийн зөрүү гэх мэт.

## Д

**Далд ажилгүйчүүд** /*Discouraged workers*/ Ажиллах насны боловч ажил идэвхитэй хайхаа больсон, ажил олдоно гэж итгэхээ больсон иргэд, ажил идэвхтэй хайдаггүй тул ажилгүйдлийн албан ёсны статистикт ордоггүй.

**Дам нөлөө /Externalities/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, эсхүл хэрэглээ нь зах зээлийн солилцоонд шууд оролцохгүй байгаа хүмүүсийн аж амьдралд дам нөлөөлх үзэгдэл. Дам нөлөө нь эерэг, эсхүл сөрөг байж болно.

**Даяаршил /Globalization/** Дэлхийн улс орнуудын эдийн засаг, нийгэм соёл нь харилцаа холбоо, тээвэрлэлт, худалдааны нэгдсэн сүлжээний тусlamжтайгаар нэгдэх үйл явц.

**Дефляци /Deflation/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин үргэлжлэн буурах үзэгдэл. Инфляцийн түвшин тэг хувиас доогуур (хасах инфляци) болох үед тохиолдоно. Инфляцийн хурдац буурах үзэгдэл (дисинфляци)-тэй андуурч болохгүй. Инфляци нь мөнгөний худалдан авах чадварыг бууруулдаг бол дефляци нь эсрэгээрээ худалдан авах чадварыг нэмэгдүүлнэ. Инфляци болон дефляцийн аль аль нь эдийн засгийн тогтвортой өсөлтөд сөрөг нөлөөтэй.

**ДНБ-ий дефлятор /Implicit price deflator/** Үнийн индекс бөгөөд оны үнээрх ДНБ-ийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлсэн ДНБ-д харьцуулж тооцно. ДНБ-ий дефляторын тусlamжтайгаар нэрлэсэн (буюу оны үнээрх) ДНБ-ийг засварлаж бодит (буюу зэрэгцүүлэх үнэд шилжүүлсэн) ДНБ-ий угтыг олох боломжтой.

**Дорд бараа /Inferior good/** Хэрэглэгчийн бодит орлого өсөхийн хэрээр эрэлт нь буурдаг бараа.

**Дотоодын нийт бүтээгдэхүүн /Gross domestic product (GDP)/** Улс орны хуанлийн жилд тухайн улсын эдийн засгийн нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэсэн бүх эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнэ цэнийн нийлбэр.

**Дундаж орлого /Average revenue (AR)/** Нийт орлогыг бүтээгдэхүүний тоо хэмжээнд харьцуулсан харьцаа.

**Дундаж тогтмол зардал /Average fixed cost (AFC)/** Нийт тогтмол зардлыг бүтээгдэхүүний тоо хэмжээнд харьцуулсан харьцаа.

**Дундаж хувьсах зардал /Average variable cost (AVC)/** Нийт хувьсах зардлыг бүтээгдэхүүний тоо хэмжээнд харьцуулсан харьцаа.

Дэлхийн банк /World Bank/ Хөгжиж буй орнуудад зээл олгож, техник туслалцаа үзүүлдэг олон улсын байгууллага.

Дэлхийн Худалдааны байгууллага /World Trade Organization/ 100 гаруй гишүүн улс орныг эгнээндээ нэгтгэсэн байгууллага. Эдгээр улс орнууд худалдааны гэрээний дагуу тарифын хэмжээг зохицуулж, маргаантай асуудлаа шийдвэрлэнэ.

## E

Европын холбоо /European Union (EU)/ 1992 оны Маастрихтын гэрээний дагуу байгуулагдсан Европын улс орнуудын холбоо. Гишүүн орнууд худалдаандаа квот, тариф хэрэглэдэггүй бөгөөд эдийн засгийн олон асуудлаар нэгдсэн бодлого хэрэгжүүлдэг байна.

Ердийн монополь /Natural monopoly/ Үйлдвэрлэлийн цар хүрээний давуу байдал нь тухайн пүүст зах зээлийн бүх бүтээгдэхүүн, үйлчилгээг бусад пүүстэй харьцуулахад доогуур зардлаар үйлдвэрлэх боломжийг олгож буй салбар.

## 3

Зардлын инфляци /Cost-push inflation/ Үйлдвэрлэлийн өртөг зардлын өсөлтөөр өдөөгдсөн инфляци.

Засгийн газрын доголдол /Government failures/ Ардчиллын журмаар сонгогдсон засгийн газар ард түмний олонхийн санал хүсэлтэд тулгуурлан шийдвэр гаргадаг. Гэвч бодит амьдрал дээр засгийн газрын доголдол үүсэх (гаргасан шийдвэр нь олонхийн эрх ашгийг төлөөлж чадахгүй байх) тохиолдол гардаг. Засгийн газрын оролцоо нь бүтээгдэхүүн, нөөцийн үр ашиггүй хуваарилалтыг дагуулах үзэгдэл. Төсвийн бодлогын үр ашиг хангалтгүй байх явдал.

Засгийн газрын зардал /Government expenditures, Government spending/ Бүх шатны Засгийн газрын худалдан авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ (татвар, зээлээр санхүүжигдэнэ). Тухайлбал, батлан хамгаалах, шүүх, цагдаа, зам, боловсрол, зам гүүр, байшин барилга бариулах гэх мэт.

**Засгийн газрын орлого /Government revenues/** Засгийн газрын зарцуулалтыг санхүүжүүлэх татвар болон зээлээр босгосон хөрөнгийн эх үүсвэр.

**Засгийн газрын оролцоо /Role of Government/** Эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах засгийн газрын арга хэмжээ. Тухайлбал, өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжих, ердийн монополийг зохицуулах, зах зээлийг мэдээлэл, үйлчилгээгээр хангах, гаднах дам нөлөөг зохицуулах, нийгмийн барааг нийлүүлэх, иргэдийн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, орлогын дахин хуваарилалт хийх, мөнгөний системийн зохистой байдлыг хангах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад Засгийн газар оролцно.

**Засгийн газрын эдийн засгийн үүрэг /Economic functions of Government/** Зах зээлийн эдийн засгийн үед засгийн газар нь бизнесийн болон нийгмийн үйл хөдлөлийг зохицуулах, өрсөлдөөнийг хөхүүлэн дэмжих, зах зээлийн доголдлыг арилгах (нийтийн барааг нийлүүлэх, гаднах дам нөлөөг зохицуулах замаар), орлогыг дахин хуваарилах, макро эдийн засгийг тогтвржуулах үргийг хүлээдэг.

**Зах зээл /Markets/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний солилцоо явагдах боломжийг олгож буй газар, институт, технологийн тогтолцоо. Түүнчлэн, зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг тодорхойлох бүх худалдах болон худалдан авах хэлцлүүдийн нийлбэр цогц.

**Зах зээлд нэвтрэх саад /Barriers to entry/** Тухайн салбарт нэвтрэхэд саад учруулж буй хүчин зүйлс. Тухайлбал, тухайн салбар дахь компаниудын хувьд зардлын давуу тал үүсгэж буй хүчин зүйлс (тухайлбал, компаниудын хэт том хэмжээ, патент болон лиценз гэх мэт).

**Зах зээлийн бүтэц /Market structure/** Тухайн зах зээлийн өрсөлдөөний түвшинг илтгэнэ, нэг туйлд нь маш олон үйлдвэрлэгчид, худалдан авагчид байж болох бол нөгөө туйлд нь хэдхэн (эсхүл бүр цорын ганц) үйлдвэрлэгч, худалдан авагч байж болно.

**Зах зээлийн доголдол /Market failures/** Зах зээлийн зүгээс бүтээгдэхүүн, үйлчилгээг үр ашиггүй хуваарилж буй явдал. Зах зээлийн нэг тоглогчийн нөхцөл байдлыг бусад тоглогчийн нөхцөл байдлыг дордуулахгүйгээр сайжруулах

боломж байснаар тус доголдол илэрнэ (Үр дүн нь Парето үр ашиггүй).

**Зах зээлийн эдийн засаг /Market economy/** Зах зээлийн үнийн системээр дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээ, нөөцийг хуваарилж, хэрэглэгчид, үйлдвэрлэгчдийг (өөр өөрийн сонирхолтой) уялдуулж буй эдийн засаг.

**Зах зээлийн эдийн засгийн хууль эрх зүйн үндэс /Legal foundations of a market economy/** Зах зээлийн эдийн засгийг дэмжих хууль тогтоомж болон институтууд. Тухайлбал, хувийн өмчийг хамгаалах, гэрээг албадан хэрэгжүүлэх тогтолцоо.

**Захиргаадалтын эдийн засаг /Command economy/** Үйлдвэрлэл, хуваарилалттай холбоотой эдийн засгийн ихэнх асуудлыг төвлөрсөн төлөвлөгөөний дагуу шийдвэрлэж буй эдийн засаг. 1990 оноос өмнө Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт буюу захиргаадалтын эдийн засгийн тогтолцоотой байсан.

**Зоос /Coins/** Төв банкнаас гүйлгээнд гаргасан металлан мөнгө.

**Зорилтуудын хоорондох өгөө-аваа /Trade-offs among goals/** Зорилтод хүрэхэд гарах зардлыг нь үр ашигтай нь харьцуулсан эдийн засгийн шинжилгээ. Тухайн зорилтыг хэрэгжүүлэх эсэх нь тус шинжилгээний үр дүнгээс хамаарна.

**Зохион бүтээгч /Inventors/** Шинэ үйл явц, ашиглалт, машин, эсхүл хэрэглэх аргыг нээж буй (сэдэж буй) хүн.

**Зохистой хүлээлт /Rational expectations/** Ирээдүйн хүүгийн түвшин болон эдийн засгийн үйл явдлын талаархи иргэдийн хүлээлт. Ийм хүлээлт боломжтой бүх мэдээлэлд (үүний дотор засгийн газрын өнөөгийн болон ирээдүйн бодлогын үр нөлөөний таамаглал) тулгуурласан байдаг.

**Зохистой хүлээлтийн онол /Rational expectations theory/** Шинэ сонгодог онолын урсгал. Пүүсүүд, иргэд эдийн засаг болон засгийн газрын бодлогын талаар зохистой хүлээлттэй байна. Иймд тэдний сонирхлоо урьтал болгосон үйл хөдлөл нь бодлогын нөлөөг байхгүй болгох боломжтой хэмээн номлодог.

**Зохицсон хүлээлт, адаптив хүлээлт /Adaptive expectations/** Өнгөрсөн хугацаанд болсон үйл явдал нь ирээдүйд болох үйл явдлын хүлээлтийг бүрдүүлэх үйл явц. Тухайлбал, өнгөрсөн хугацааны инфляци хүлээгдэж байсан түвшнээс өндөр байсан бол иргэдийн инфляцийн хүлээлт нэмэгдэх болно.

**Зохицуулалт /Regulation/** Эдийн засгийн зохицуулалт гэдэг нь тухайн салбар дахь (ялангуяа, ердийн монополь) үнэ болон хэмжээг зааварчлах явц юм.

**Зэрэгцэх үзүүлэлт /Coincident indicators/** Эдийн засгийн идэвхжлийн мөчлөгтэй давхцаж, бодит үйлдвэрлэлтэй зэрэг хөдөлж буй эдийн засгийн үзүүлэлтүүд (ажил эрхлэлт, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн, бодит орлого, боловсруулах салбар, худалдаа гэх мэт).

## И

**Ижил бус бүтээгдэхүүнүүд /Heterogeneous products/** Чанар болон бусад онцлогоор (өнгө, амт, загвар, баталгаа, эсхүл нэмэлт үйлчилгээ гэх мэт.) ялгарах бүтээгдэхүүнүүд.

**Ижил бүтээгдэхүүнүүд /Homogeneous products/** Ялгарах онцлоггүй, ижил төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ.

**Илүүдэл /Surplus/** Бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хэмжээ нь эрэлтээсээ давах нөхцөл байдал. Ихэвчлэн бүтээгдэхүүний үнэ нь зах зээлийн тэнцвэрт үнээс дээгүүр тогтох үед тохиолдоно.

**Илүүдэл нөөц /Excess reserves/** Банк болон санхүүгийн байгууллагуудын хууль журмаар тогтоосон хэмжээнээс илүү нөөцийг хэлнэ. Тухайлбал, Монголбанкаас банкуудад тогтоосон заавал байлгах нөөцөөс илүү гарсан банкуудын Монголбанкин дахь харилцах дансны мөнгөний хэмжээ.

**Илүүдэл өгөөж /Excess return/** Тухайн хөрөнгө оруулалтын өгөөжийг эрсдэлгүй хөрөнгө оруулалтын өгөөжтэй харьцуулсан үзүүлэлт. Тухайлбал, хөрөнгө оруулалтын өгөөж 5%, эрсдэлгүй хөрөнгө оруулалтын өгөөж 1.5% бол тухайн хөрөнгө оруулалтын илүүдэл өгөөж нь 3.5% байна.

**Импорт /Imports/** Бусад улс орноос худалдан авч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ.

**Инноваци /Innovation/** Шинэ санаа, арга техник.

**Инфляци /Inflation/** Хэрэглээний сагсанд багтсан буюу өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий буюу дундаж үнийн түвшний өсөлт. Манай улсын хэрэглээний сагсанд 2014 оны байдлаар 329 бүтээгдэхүүн, үйлчилгээ багтаж байна. Нийт эрэлтийн (эрэлтийн гаралтай инфляци), эсхүл нийлүүлэлтийн талын (зардлын гаралтай инфляци) дарамт нэмэгдэх нь инфляцийг өдөөнө. Жишээ нь, манай улсын хувьд жилийн инфляцийн хамгийн өндөр түвшин 1993 онд 325 хувьд хүрч байсан.

**Инфляцийн шалтгаан /Causes of inflation/** Мөнгөний хэт их нийлүүлэлт нь инфляци үүсэх нэг шалтгаан болдог. Түүнчлэн, үйлдвэрлэлийн зардлын өсөлт нь инфляцийг дагуулж болно. Татварын өсөлт, гадаад зээлийн өртөг нэмэгдэх нь мөн инфляцид хүргэх боломжтой. Дайн дажин инфляцийг өдөөх нь түгээмэл байдаг.

**Инфляцийн эрсдэл /Inflation risk/** Инфляцийн түвшин нь хөрөнгө оруулалтын өгөөжөөс давах магадлал. Энэ нь хөрөнгө оруулалтын бодит өгөөж сөрөг буюу бодитоор хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурч байгааг илтгэнэ.

## К

**Капитал /Capital/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх зориулалттай санхүүгийн бус урт хугацаат хөрөнгө (тухайлбал, байшин барилга, машин техник, тоног төхөөрөмж).

**Капиталын нөөц /Capital resources/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх зориулалттай нөөц (тухайлбал, тоног төхөөрөмж, машин техник, байшин барилга).

**Квот /Quotas/** Тухайн бүтээгдэхүүний импорт, эсхүл экспортод Засгийн газраас тогтоосон хязгаар. Захиргаадалтын эдийн засгийн хувьд үйлдвэрлэлийн төлөвлөгөө.

**Кейнсийн онол /Keynesian theory/** Нийт эрэлтийн хэлбэлзэл нь бизнесийн мөчлөгийг бий болгоно, иймээс төсөв, мөнгөний бодлогоор бизнесийн мөчлөгт нөлөөлж эдийн засгийн тогтвортой байдлыг хангах ёстай гэсэн

макро эдийн засгийн онол. Ж.М.Кейнс нь Кейнсийн онолын үндэслэгч юм.

**Кейнсийн эдийн засаг /Keynesian economics/** Засгийн газар нийт эрэлтийг удирдах замаар эдийн засгийг тогтвортжуулж болох тухай онол.

**Ковариаци /Covariance/** Магадлалын онол, математик статистикт хэрэглэгддэг ойлголт. Хоёр санамсаргүй хэмжигдэхүүний хоорондох шугаман хамаарлын хэмжүүр. Хэрэв ковариаци + (-) бол хоёр үзүүлэлт хоорондоо ээрэг (сөрөг) хамааралтайг илтгэнэ. Харин ковариацийн хэмжээ нь хамаарлын хүчийг илтгэхгүй.

**Коммунизм /Communism/** Ангигүй, засгийн газаргүй, нөөц баялаг нь нийтийн эзэмшилд буй, орлогыг хэрэгцээний хэрээр хуваарилах тогтолцоонд тулгуурласан эдийн засгийн системийн талаархи сургааль. ЗХУ (1990 он хүртэл), БНАСУ, Куба зэрэг улсад оршин тогтнож буй захиргаадалтын эдийн засгийн системийг ойлгодог.

**Компани ба өрхийн сектор /Businesses and households/** Орлого, бүтээгдэхүүний урсгал, эргэлтэд оролцож буй эдийн засгийн хоёр сектор. Компаниуд эдийн засгийн нөөцүүдийг өрхүүдээс авна. Нөөцийн төлбөр нь өрхүүдийн орлого нь болно. Өрхүүд орлогоо компаниудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад зарцуулна. Өрхүүдийн зарцуулалт нь компаниудын орлого болно.

## M

**Макро эдийн засаг /Macroeconomics/** Нийт эрэлт, нийт нийлүүлэлт, төсөв, мөнгөний бодлого зэрэг эдийн засгийг бүхэлд нь багтаасан эдийн засгийн салбар.

**Макро эдийн застийн бодлого /Macroeconomic policies/** Засгийн газраас макро эдийн засгийн зорилтуудыг (тухайлбал, ажилгүйдэл болон инфляцийг бууруулах) хангахын тулд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ (төсөв, мөнгөний бодлого). Эдийн засгийн бодлого гэх нь ч бий.

**Макро эдийн засгийн тэнцвэр /Macroeconomic equilibrium/** Нийт эрэлт нь нийт нийлүүлэлттэй тэнцэх эдийн засгийн төлөв байдлыг хэлнэ.

**Макро эдийн засгийн үзүүлэлтүүд /Macroeconomic indicators/** Макро эдийн засгийн үзүүлэлтүүд гэдэг нь улс орны эдийн засгийн төлөв байдлыг харуулж буй статистик тоо мэдээ юм. Засгийн газар болон хувийн секторын зүгээс хүү, дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн индекс, хөдөлмөрийн зах, жижиглэн худалдаа, төлбөрийн тэнцэл, төсвийн болон мөнгөний бодлого зэрэг макро эдийн засгийн чухал мэдээллийг тогтмол тооцон гаргаж байдаг.

**Микро эдийн засаг /Microeconomics/** Эдийн засгийн нэгжүүдийг (өрхийн аж ахуй, компаниуд болон зах зээлүүд) судалдаг эдийн засгийн салбар. Тухайн зах зээл дээр үнэ болон тоо хэмжээ хэрхэн тогтох, үнийн механизмын нь эдийн засгийн нөөц болон орлогыг хэрхэн хуваарилж буйг судална.

**Монополь /Monopoly/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний цорын ганц нийлүүлэгч бүхий зах зээлийн бүтэц. Түүнчлэн, бүтээгдэхүүн, үйлчилгээг дангаар нийлүүлж буй компани (монополист компани).

**Монополът өрсөлдөөн /Monopolistic competition/** Бага зэргийн ялгаатай (тухайлбал, загвар, эсхүл чанараар), төгс орлуулдаггүй бүтээгдэхүүн, үйлчилгээг зарж буй олон тооны үйлдвэрлэгчид бүхий зах зээлийн бүтэц бөгөөд төгс бус өрсөлдөөний нэг хэлбэр юм.

**Монополь үйлдвэрлэгчид /Monopolies/** Тухайн зах зээл дээр (салбар) зөвхөн нэг үйлдвэрлэгч ноёрхох явдал.

**Монопсони /Monopsony/** Цорын ганц нөөцийн худалдан авагчтай зах зээлийн нөхцөл байдал. Нөөцийг худалдан авч буй цорын ганц пүүс, монопсонист пүүс ч гэдэг.

**Мөнгө /Money/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөрт төлж болох зүйл. Мөнгө нь солилцооны, хадгалах, хэмжих гэсэн үүргийг гүйцэтгэнэ. Мөнгө нь зөөвөрлөхөд хялбар, тогтмол үнэ цэнэтэй, дахин ашиглах боломжтой, мөнгөн тэмдэгтийг хэдэн онд гүйлгээнд гаргаснаас үл хамааран ижил худалдан авах чадвартай, хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой.

**Мөнгө хүүлэхийн эсрэг хууль /Usury law/** Зарим улс оронд (тухайлбал, АНУ) мөрдөгддөг хууль. Тухайн төрлийн зээлийн хувьд зөвшөөрөгдөх хүүгийн дээд хязгаарыг

тогоосон хууль. Тус дээд хязгаараас давсан хүүтэй зээлийг хууль бус зээл гэж үздэг.

**Мөнгөн бус хөшүүрэг /Non-monetary incentive/** Хүмүүст ямар нэгэн зүйл хийх сэдэл өгч буй, мөнгө, орлого, эсхүл эдийн засгийн баялагтай холбоогүй хүчин зүйл. Жишээ нь, ажлын байрны нөхцөл, цаг бүртгэх уян хатан байдал, нэр хүнд олох зэрэг нь ажил хийх хөшүүрэг болдог.

**Мөнгөн зардал /Explicit cost/** Компанийн зүгээс эдийн засгийн нөөцийг худалдан авахад зарцуулж буй мөнгөн төлбөр.

**Мөнгөн тэмдэгтийн код /Currency code/** Улс бүрийн мөнгөн тэмдэгт нь З үсгээс бүрдсэн үсгэн тэмдэглэгээтэй байдаг. Үсгэн тэмдэглэгээ нь давхар З оронтой тоотой уягdsan байдаг. Энэхүү З оронтой тоог мөнгөн тэмдэгтийн код гэдэг.

**Мөнгөн тэмдэгтийн тэмдэглэгээ /Currency designation/** Улс бүрийн мөнгөн тэмдэгт нь З үсгээс бүрдсэн үсгэн кодтой байдаг бөгөөд үүнийг мөнгөн тэмдэгтийн тэмдэглэгээ гэнэ. Тухайлбал, америк долларыг USD, Европын холбооны мөнгөн тэмдэгт болох еврог EUR, Монгол төгрөгийг MNT гэж тэмдэглэдэг.

**Мөнгөн хөрөнгийн таамаглал /Liquidity forecast/** Банкуудын бэлэн нөөцийн төлөв байдлын ирээдүйн төсөөлөл. Банкуудын бэлэн нөөц нь банкуудын касс дахь бэлэн мөнгөнөөс гадна Төв банкин дахь харицлах дансан дахь мөнгө, хөрвөх чадвартай үнэт цаастай хамруулж ойлгоно.

**Мөнгөн хөшүүрэг /Monetary incentive/** Хүмүүст ямар нэгэн зүйл хийхэд түлхэц өгч буй мөнгө, орлого, эсхүл эдийн засгийн баялагтай холбоотой хүчин зүйл. Жишээ нь, урамшуулал, мөнгөн шагнал, тэтгэлэг, хувьцаа зэрэг байж болно.

**Мөнгөний бодлого /Monetary policy/** Төв банкны зүгээс мөнгөний нийлүүлэлт, мөнгөний өсөлтийн хурд, зээлийн олдоцыг зохицуулах замаар үнийн тогтвортой байдлыг хангах төрийн бодлого.

**Мөнгөний бодлогын зөвлөл /Monetary policy council/** Монголбанкны мөнгөний бодлогыг томьёолох,

боловсруулах, шийдвэр гаргах эрхтэй зөвлөл. Манай улын мөнгөний бодлогын зөвлөл нь 14 гишүүнээс бүрддэг. Монголбанкны Ерөнхийлөгч 7 гишүүнийг Монголбанкны захирлуудаас, үлдсэн 7 гишүүнийг бусад байгууллагаас томилдог байна.

**Мөнгөний зөөлөн бодлого /Easy-money policy/** Бодлогын хүүг бууруулах, заавал байлгах нөөцийн шаардлагыг сулруулах, нээлттэй захын үйл ажиллагаагаар үнэт цаас худалдан авах замаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, эдийн засгийг идэвхжүүлэх мөнгөний бодлого.

**Мөнгөний нийлүүлэлт /Money supply/** Бага мөнгө буюу M1 мөнгийг хадгаламжийн байгууллагаас гадуурхи мөнгө болон харилцах (чекийн) дансан дахь мөнгөний нийлбэрээр тооцно. M2 мөнгөнд M1 мөнгөөс гадна хадгаламжийн данснууд үлдэгдэл ордог.

**Мөнгөний ордер /Money order/** Тодорхой мөнгөн дүнгээр худалдаж авах маягт. Худалдан авагч нь маягтанд заасан хувь хүн, аж ахуйн нэгжид төлбөрийг шилжүүлэхийг үүрэг болгон гарын үсэг зурна.

**Мөнгөний тооны онол /Monetarist theory/** Мөнгөний нийлүүлэлтийн үндэсний орлого, үнийн түвшинд гүйцэтгэх үүргийг чухалчлан авч үздэг онол. Мөнгөний тооны онол баримтлагчид мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт нь үндэсний орлогод зөвхөн богино хугацаанд нөлөөлнө, харин урт хугацаанд зөвхөн үнийн түвшинд нөлөөлнө гэж үздэг.

**Мөнгөний үүрэг /Functions of money/** Мөнгө нь солилцох, хадгалах, хэмжих гэсэн 3 үндсэн үүргийг эдийн засагт, нийгэмд гүйцэтгэнэ.

**Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ /Time value of money/** Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ хэлбэлзэж болох тухай ойлголт. Өнөөдрийн мөнгөний худалдан авах чадвар тухайлбал, 10 жилийн өмнөхөөс өөр юм. Хүүгийн түвшинг харгалzan үзэх замаар мөнгөний ирээдүйн үнэ цэнийг тооцож болно. Тухайлбал, 5%-ийн хүйтэй, 1 жилийн хугацаатай 100 төгрөгийн хөрөнгө оруулалт нь жилийн дараа 105 төгрөг болно. Иймээс 5%-ийн хүү хүлээж буй хөрөнгө оруулагчийн хувьд өнөөдрийн 100 төгрөг, жилийн дараах 105 төгрөгийн үнэ цэнийн хувьд яг ижил юм.

**Мөнгөний шинж чанар /Characteristics of money/** Мөнгөний дараах б шинж чанар байдаг: удаан хугацаанд ашиглаж болох, авч явахад хялбар, жижиг нэгжүүдэд хуваах боломжтой, мөнгөн тэмдэгт нь хэдэн онд гүйлгээнд гарснаас үл хамааран нэг л худалдан авах чадвартай байх, нийлүүлэлтийг нь хянах боломжтой байх, бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байх.

**Мөнгөний эргэлтийн хурд /Velocity of money/** Нэг төгрөг тухайн жилийн эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад дунджаар хэдэн удаа зарцуулагдаж байгааг харуулна.

**Мөчлөгийн ажилгүйдэл /Cyclical unemployment/** Эдийн засгийн идэвхжил, бизнесийн мөчлөгтэй холбоотойгоор компаниуд үйл ажиллагаагаа зогсоох, цар хүрээгээ бууруулснаар үүсч буй ажилгүйдэл.

## Н

**Нийгмийн даатгал /Social security/** Нийгмийн даатгал гэж даатгалын сан бүрдүүлж, уг сангаас даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, ажилгүй болоход өөрт нь, эсхүл даатгуулагч нас барагд түүний асрамжинд байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд нь тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгч эрсдэлээс хамгаалах арга хэмжээг хэлнэ.

**Нийгмийн даатгалын шимтгэл /Social security tax/** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг санхүүжүүлэх зорилгоор ажилчид болон ажил олгогчдод ногдуулах татвар.

**Нийгмийн сонголтын онол /Public-choice analysis/** Улс төрийн шийдвэр чухам яж гардгийг судалдаг эдийн засгийн нэг салбар юм. Шийдвэр гаргалт нь Засгийн газар болон бусад байгуулагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд нөлөөлж байдаг. Эдийн засгийн зарчмууд улс төрд хэрхэн хэрэгжих буйг судалдаг онол.

**Нийгэмлэг болон хот /Communities and cities/** Нийгэмлэг гэдэг нь эдийн засгийн нэг ашиг сонирхолтой жижиг нийгмийн бүлэг юм. Хотыг санхүүгийн болон бизнесийн төв хэмээн үзэж болно.

**Нийлүүлэлт /Supply/** Нийлүүлэлт гэдэг нь тодорхой хугацаанд үнийн боломжтой түвшин бүрийн хувьд үйлдвэрлэгчдийн зах зээлд борлуулах зорилгоор нийлүүлж чадах бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ юм.

**Нийлүүлэлтийг тодорхойлогч хүчин зүйлс /Determinants of supply/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг тодорхойлогч хүчин зүйлсийг үнийн болон үнийн бус хүчин зүйлс (үйлдвэрлэгчдийн тоо, үйлдвэрлэлийн зардал, технологи, бүтээмж зэрэг орно) гэж тодорхойлж болно. Үнийн бус хүчин зүйлсийн нөлөөгөөр нийлүүлэлтийн муруй баруун (зүүн) тийш шилжвэл үнэ бүрийн хувьд үйлдвэрлэгчдийн тодорхой хугацаанд (тухайлбал, 7 хоног бүр) нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэж (буурч) байгааг илэрхийлнэ.

**Нийлүүлэлтийг тэлэх төсвийн бодлого /Supply-side fiscal policy/** Нийт нийлүүлэлтийн муруйг баруун тийш нь шилжүүлэх замаар эдийн засгийн үйлдвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого (тухайлбал, татварыг бууруулсанaar компаниудыг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх гэх мэт).

**Нийлүүлэлтийн үнийн мэдрэмж /Price elasticity of supply/** Үнийн өөрчлөлтөөс шалтгаалан тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн хэмжээнд гарч буй өөрчлөлтийн хэмжүүр. Үнэ нь нэг хувиар өөрчлөгдхөхөд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн хэмжээ хэдэн хувиар өөрчлөгдхөхийг харуулна.

**Нийлүүлэлтийн хууль /Law of supply/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нэмэгдвэл (бууравал) үйлдвэрлэгчдийн нийлүүлэх тоо хэмжээ (тодорхой хугацаанд хамаарах) өсөх (буурах) зүй тогтол.

**Нийлүүлэлтийн хэмжээ /Quantity supplied/** Борлуулагчдын тодорхой хугацаанд тухайн үнээр нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ.

**Нийлүүлэлтийн шок /Supply shock/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг гэнэт өөрчилж буй үйл явдал. Тухайн барааны нийлүүлэлт гэнэт нэмэгдэх, эсхүл буурах нь нийлүүлэлтийн шокийг дагуулж болно. Энэхүү гэнэтийн өөрчлөлт нь тэнцвэрт үнэд нөлөөлнө. Нийлүүлэлтийн сөрөг шок (нийлүүлэлт буурах) нь тухайн барааны үнийг

өсгөж нийлүүлэлтийн муруйг зүүн тийш шилжүүлнэ. Нийлүүлэлтийн сөрөг шок нь стагфляци (үнийн өсөлт, бүтээгдэхүүний бууралт)-д хүргэж болно. Нийлүүлэлтийн эерэг шок (нийлүүлэлт нэмэгдэх) нь тухайн бүтээгдэхүүний үнийг бууруулж, нийт нийлүүлэлтийн муруйг баруун тийш шилжүүлнэ. Техник, технологийн дэвшил нь бүтээмж болон үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр нийлүүлэлтийн эерэг шокийг дагуулж болно.

**Нийт зардал /Total cost (TC)/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд гарах бүх зардал буюу нийт тогтмол болон хувьсах зардлын нийлбэр.

**Нийт нийлүүлэлт /Aggregate supply/** Нийт нийлүүлэлт нь үнийн байж болох түвшин бүрийн хувьд үйлдвэрлэгчдийн нийлүүлж чадах бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ (бодит ДНБ)-г харуулна. Үрт хугацааны нийт нийлүүлэлт нь үнийн бүх түвшний хувьд тогтмол ДНБ-ий түвшинг (бүрэн ажил эрхлэлтийн үе) харуулна. Богино хугацааны нийт нийлүүлэлтийн хувьд үнэ хэлбэлзэхийн хэрээр бодит ДНБ-ий түвшин өөрчлөгднө.

**Нийт орлого /Total revenue (TR)/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтаас олсон нийт мөнгө буюу бүтээгдэхүүний үнийг борлуулсан тоо хэмжээгээр үргжүүлж онло.

**Нийт эрэлт /Aggregate demand/** Нийт эрэлт нь үнийн байж болох түвшин бүрийн хувьд өрхийн аж ахуй, пүс компаниуд, засгийн газрын зүгээс худалдан авахад бэлэн байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний бодит хэмжээ (бодит ДНБ)-г харуулна.

**Нийтийн бараа /Public goods/** Засгийн газраас нийлүүлдэг бараа. Нийтийн барааны нэг хүний хэрэглээ нь бусад хүний хэрэглээг бууруулахгүй, хэрэглээг төлбөрөө төлсөн хүмүүсээр хязгаарлах боломжгүй.

**Нийтийн барааны шинж чанар /Nonexclusion/** Төлбөрийг нь төлөөгүй байлаа ч хэрэглэж болох, хэрэглээг нь түдгэлзүүлэх боломжгүй зарим бүтээгдэхүүн, үйлчилгээ (тухайлбал, гудамжны гэрэл, батлан хамгаалах гэх мэт).

**Нийтийн баялгийн эмгэнэл /Tragedy of the commons/** Нийтийн өмчид байгаа нөөц баялгийг (тухайлбал, газар, усан сан гэх мэт.) хэт ашиглах, зүй бусаар ашиглах явдал.

**Нөхөрлөл /Partnership/** Хоёр ба түүнээс дээш эзэмшигчтэй бизнесийн хэлбэр ба эзэмшигчид нь пүүсийн ашиг, алдагдлыг хуваана.

**Нэг хүнд ногдох ДНБ /Per Capita Gross Domestic Product (GDP)/** Тухайн жилд улс оронд үйлдвэрлэсэн бүх эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнийг хүн амын тоонд харьцуулсан харьцаа.

**Нэгдсэн үнэтэй арилжаа /Uniform-price auction/** Арилжаанд оролцогчийн өрсөлдөөнт бус болон өрсөлдөөнт санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын таслагдсан хүүгээр биелэх арилжааг хэлнэ.

**Нэрлэсэн ДНБ /Nominal Gross Domestic Product (GDP)/** Нэг жилийн дотор улс оронд үйлдвэрлэсэн бүх эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн үнэ. Оны үнээрх ДНБ гэх нь ч бий.

## О

**Огт мэдрэмжгүй нийлүүлэлт /Perfectly inelastic supply/** Үнэ өөрчлөгдхөд нийлүүлэлтийн хэмжээнд ямар ч өөрчлөлт гарахгүй байх нөхцөл байдал.

**Огт мэдрэмжгүй эрэлт /Perfectly inelastic demand/** Үнэ өөрчлөгдхөд эрэлтийн хэмжээнд ямар ч өөрчлөлт гарахгүй байх нөхцөл байдал.

**Олигополи /Oligopoly/** Зах зээл дээрх тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний дийлэнхийг, эсхүл бүгдийг цөөн тооны, харьцангуй том компаниуд үйлдвэрлэж (борлуулж) байгаа зах зээлийн бүтэц. Зах зээлд нэвтрэх сонирхолтой шинэ компаниуд үлэмж саад тотгортой тулгарна. Зарим олигополи нэгэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бол зарим нь харилцан адилгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж байдаг.

**Олон улсын валютын сан /International Monetary Fund (IMF)/** Гишүүн орнуудын ханшийн зохицуулалтад хяналт тавих, санхүүгийн хүндэрэл бэрхшээлтэй тулгарч буй гишүүн орнуудад мөнгө зээлдүүлэх зорилготой олон улсын байгууллага.

Орлогын албан татвар */Income tax/* Засгийн газраас аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогод ногдуулж буй татвар. Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулийн дагуу хувь хүний орлогын жилийн дунд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна. Харин аж ахуйн нэгжийн 3 хүртэл тэрбум төгрөгийн орлогоос 10 хувийн татвар, 3 тэрбум төгрөгөөс дээш орлогоос 300 сая төгрөг дээр 3.0 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дунгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулна. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төлөхтэй холбоотой харилцааг хуулиар зохицуулдаг.

Орлогын нөлөө */Income effect/* Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэд өөрчлөлт орсноор эрэлтийн хэмжээнд гарах өөрчлөлтийн нэг хэсэг нь. Тухайлбал, үнийн бууралт нь хэрэглэгчийн бодит орлогыг нэмэгдүүлж тухайн бүтээгдэхүүний эрэлтийн хэмжээнд өөрчлөлт оруулна.

Орлогын тэгш бус байдал */Income inequality/* Эдийн засаг дахь нийт орлого нь өрх гэр, хувь хүмүүс, эсхүл тодорхой бүлгүүдэд тэгш бус хуваарилагдсан байдал.

Орлогын функциональ хуваарилалт */Functional distribution of income/* Эдийн засгийн нийт орлогыг цалин, түрээс, хүү болон ашигт (нөөцүүдийн төлбөр) хуваах явдал.

Орлогын хуваариалт */Distribution of income/* Улс үндэстний орлого иргэд, өрхийн аж ахуй, эсхүл нийгмийн бүлгүүдээр хэрхэн хуваарилагдаж буйг харуулна.

Орлогын эргэлт */Circular flow/* Бүтээгдэхүүн, орлогын эдийн засгийн нэг сектороос нөгөө секторт шилжих хөдөлгөөн. Орлогын эргэлтийг диаграмаар харуулах нь нийтлэг байdag.

Орлох бүтээгдэхүүн, үйлчилгээ */Substitute goods and services/* Нэг бүтээгдэхүүн, үйлчилгээний оронд хэрэглэж болох өөр бүтээгдэхүүн, үйлчилгээ (тухайлбал, крантны ус болон савласан ус, кино болон концерт гэх мэт).

**Ө**

**Өгөө-аваа /Trade-off/** Нэг үр ашиг, давуу талыг бий болгохын тулд нөгөө үр ашиг, давуу талаас татгалзах явдал.

**Өдрийн репо хэлцэл /Intraday repo/** Банк өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон үнээр тухайн өдөрт багтаан буцаан худалдан авах нөхцөлтэйгээр Төв банкинд худалдах хэлцлийг хэлнэ.

**Өмчлөх түрээс /Rent to own/** Хэрэглэгч нь төлбөрийг 7 хоног бүр, эсхүл сар бүр хийх замаар гэр ахуйн цахилгаан бараа, тавилга зэрэг барааг түрээслэн өмчлөх хэлцэл. Лизингийн хувьд хэрэглэгч нь түрээслж буй барааг дуртай үедээ худалдан авч болдог бол өмчлөх түрээсийн хувьд зөвхөн гэрээнд заасан хугацааны дараа худалдан авч болно. Хэрэглэгчдийн хувьд ихээхэн зардал чирэгдэлтэй хэлцэл байдаг.

**Өрсөлдөөн /Competition/** Хоёр ба түүнээс дээш тооны хүн, байгууллага ижил бүтээгдэхүүн, үйлчилгээ, эсхүл санхүүгийн үйлчилгээг зarah/авах оролдлого. Хэрэглэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг авахаар бусад хэрэглэгчидтэй өрсөлдөнө. Харин үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулахын тулд бусад үйлдвэрлэгчидтэй өрсөлдөнө.

**Өрсөлдөөнт бус санал /Non-competitive bid/** Ялгавартай үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүгээр, нэгдсэн үнэтэй арилжааны үед амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын таслагдсан хүүгээр тус тус биелэх саналыг хэлнэ.

**Өрхүүд /Households/** Нэг талаас бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч буй, нөгөө талаас эдийн засгийн нөөц (хөдөлмөр, газар, ур чадвар, капитал)-ийг зарж (түрээслэж) буй хувь хүн болон өрх булийн нэгжүүд.

## П

**Пүс, компани /Firms/** Өрхийн аж ахуйн сектороос эдийн засгийн нөөцийүдийг худалдан авч өрхийн аж ахуй болон засгийн газарт бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлж буй эдийн засгийн нэгжүүд.

## С

**Сайн дурын солилцоо/худалдаа /Voluntary exchange, Voluntary trade/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг бусдад худалдах явц. Худалдагч болон худалдан авагчийн аль аль нь тус худалдаанаас хожих хүлээлттэй байдаг.

**Солилцоо /Exchange/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг мөнгө, эсхүл бусад бүтээгдэхүүн, үйлчилгээгээр солилцох явц.

**Сонголт /Choice/** Боломжтой хувилбаруудыг өөр хооронд нь харьцуулсны үндсэн дээр гаргасан шийдвэр, эсхүл авсан арга хэмжээ.

**Сонирхлын бүлэг /Special interest group/** Хуулийн тодорхой асуудлаар нэгдсэн хүмүүсийн үйл ажиллагаа, зохион байгуулалт. Тэд мэдээлэл цуглуулах, улс төрчдийг лоббидох, байр сууриа олон нийтэд хүргэх үүднээс хамтран ажилладаг.

**Сөрөг дам нөлөө /Negative externality, Spillover cost/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, эсхүл хэрэглээ нь зах зээлийн солилцоонд шууд оролцохгүй байгаа хүмүүсийн аж амьдралд сөргөөр дам нөлөөлөх үзэгдэл. Энэхүү үр нөлөөг “гуравдагч этгээдийн зардал”, эсхүл “сөрөг дам нөлөө” ч гэх нь бий. Бусдын үйлдвэрлэл, эсхүл хэрэглээнээс үүдэн гуравдагч талд оногдуулж буй зардал.

**Стандарт хазайлт /Standard deviation/** Стандарт хазайлт нь хэлбэлзлийг илэрхийлдэг тул эрсдэлийн хамгийн түгээмэл хэмжүүр болдог. Стандарт хазайлт санамсаргүй хэмжигдэхүүн дунджаасаа хэр хазайж буйг илэрхийлнэ.

**Сурталчилгаа /Advertising/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэхийн тулд зар, сурталчилгааны аргыг ашиглах явдал (хэвлэл мэдээллийн хэрэгслээр бараагаа сурталчлах, хямдруулалт зарлах, алдартай хүмүүсийг сурталчилгаанд тоглуулах гэх мэт).

**Суурь он, суурь үе** /Base year or period/ Аливаа үзүүлэлтийн цаг хугацааны туршид хэрхэн өөрчлөгдсөнийг шинжлэхэд харьцуулах зорилгоор суурь болгон ашиглаж буй үе буюу сар, жил гэх мэт цаг хугацааны нэг агшинг хэлнэ. Ихэнх тохиолдол тоон цувааны хамгийн эхний жилийг суурь үе болгодог.

**Суутгал** /Withholding/ Ажил олгогчоос олгох цалин хөлснөөс суутган Засгийн газарт төлж буй татвар.

**Сэдлийг бууруулах хүчин зүйл** /Disincentive/ Хүмүүсийн ямар нэгэн зүйл хийх сонирхлыг үгүй хийх хүчин зүйл (тухайлбал, мөнгөний бодлого чангараахад зээлийн хүү нэмэгдэх тул зээл авах явдал багасна).

**Сэдэл** //Incentive/ Ямар нэгэн зүйл хийх сэдлийг өгч буй урамшуулал буюу шагнал (тухайлбал, мөнгө, давуу тал, эсхүл таатай мэдрэмж).

**Сэтгэл хөдлөлөөр худалдан авах** //Impulse buying/ Харьцуулсан судалгаа, ашиг, алдагдлын шинжилгээ хийлгүйгээр, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах явдал.

## Т

**Тариф** /Tariff/ Импортоор орж ирсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд оногдуулах албан татвар.

**Татвар** /Taxes/ Θрхийн аж ахуй, аж ахуйн нэгжүүдийн зүгээс засгийн газарт заавал төлөх төлбөр. Монгол Улсын татвар нь албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ.

**Татвар ногдуулалт** /Taxation/ Улсаас татвар төлөгчид төлбөр оногдуулах явц.

**Татварын Ерөнхий газар** /Tax office/ Төсвийн татварын орлогыг бүрдүүлэх үүрэгтэй засгийн газрын агентлаг.

**Технологийн өөрчлөлт** /Technological changes/ Үйлдвэрлэлд ашиглаж буй тоног төхөөрөмж, арга техник, үйл явц сайжирснаар пүүсийн үйлдвэрлэх чадварт гарч буй ахиц дэвшил.

**Тогтмол цалин** /Salary/ Ажил олгогчоос сар, эсхүл хоёр долоо хоног тутам төлөх тогтмол төлбөр. Жилийн

цалингаар ч илэрхийлдэг. Голдуу мэргэжлийн хүмүүс, эсхүл “цагаан захтан” гэх оюуны хөдөлмөр эрхэлдэг ажиллагсадад олгодог.

**Төв банкны арга хэрэгслүүд /Tools of the Central bank/** Төв банкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор ашигладаг арга хэрэгсэл. Тухайлбал, нээлттэй захын үйл ажиллагаа (Төв банкны үнэт цаасны арилжаа, репо арилжаа, Төв банк зах зээлээс ЗГ-ын үнэт цаас худалдан авах, худалдах), байнгын хэрэгсэл (овернаит репо, овернаит хадгаламж), заавал байлгах нөөц, бодлогын хүү зэрэг нь Төв банкны бодлогын арга хэрэгслүүд юм.

**Төв банкны овернаит зээл /Central bank overnight loan/** Банкны эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгээр худалдан авах хэлцэл хийх замаар Төв банкнаас банкинд банк хоорондын цахим систем хаахаас дараагийн ажлын өдөр уг систем нээх хүртэл хугацаатай олгож буй санхүүжилтийн байнгын хэрэгслийг хэлнэ.

**Төв банкны овернаит хадгаламж /Central bank overnight deposit/** Өдрийн эцэст илүүдэл нөөцтэй банкнаас банк хоорондын цахим систем хаахаас дараагийн ажлын өдөр уг систем нээх хүртэлх хугацаанд Төв банкинд байршуулж байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Төв банкны репо арилжаа /Central bank repo auction/** Төв банкнаас зарласан арилжаагаар банкны эзэмшиж буй үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэйгээр худалдан авах хэлцлээр банкинд санхүүжилт олгох нээлттэй захын үйл ажиллагааг хэлнэ.

**Төв банкны үнэт цаас (ТБҮЦ) /Central bank bill/** Төв банкны мөнгөний бодлогын нээлттэй захын хэрэгсэл бөгөөд хямдруулсан хэлбэрээр арилжигдаж, тогтоосон хугацааны дараа нэрлэсэн үнээр эргэн төлөгдөх үнэт цаасыг хэлнэ. Одоогийн байдлаар Монголбанкнаас 1 долоо хоног, 4 долоо хоногийн хугацаатай үнэт цаас гарган мөнгөний зах дээр арилжаалж байна.

**Төвлөрлийн харьцаа /Concentration ratio/** Хамгийн том 4, эсхүл 8 компанийн тухайн салбарт эзлэх хувийн жин. Төвлөрлийн харьцаа нь компаниудын салбар дахь

давамгайллыг хэмжих ба тухайн салбар олигополь шинжтэй эсэхийг харуулна.

**Төвлөрсөн төлөвлөгөөт систем** /*Planned economic system*/ Юуг, яаж, хэнд зориулж үйлдвэрлэхийг зах зээл бус төвлөрсөн төлөвлөгөөгөөр шийдвэрлэдэг эдийн засгийн систем. Социализмын үед үйлдвэрлэлийн төлөвлөгөө, бүтээгдэхүүн, үйлчилгээний хуваарилалтыг Улсын төлөвлөгөөний комисс гүйцэтгэдэг байв.

**Төгрөг** /*Togrog (MNT)*/ Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт. Нэг төгрөг нь 100 мөнгөтэй тэнцүү.

**Төгс бус өрсөлдөөн** /*Imperfect competition*/ Компаниуд нь дангаараа тэнцвэрт үнэд нөлөөлж чадахуйц зах зээлийн бүтэц. Компаниуд ашгаа хамгийн их байлгах үнэ болон бүтээгдэхүүний хэмжээг тодорхойлно.

**Төгс мэдрэмжтэй нийлүүлэлт** /*Perfectly elastic supply*/ Үнийн өчүүхэн төдий өөрчлөлт нь нийлүүлэлтийн хэмжээг хязгааргүй өөрчлөх нөхцөл байдал.

**Төгс мэдрэмжтэй эрэлт** /*Perfectly elastic demand*/ Үнийн өчүүхэн төдий өөрчлөлт нь эрэлтийн хэмжээг хязгааргүй өөрчлөх нөхцөл байдал.

**Төгс өрсөлдөөн** /*Perfect competition*/ Mash олон тооны харьцангуй жижиг пүүсүүд адил төсөөтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй зах зээлийн бүтэц. Тухайн салбарт нэвтрэхэд, эсхүл гарахад саад тогтор учрахгүй. Төгс өрсөлдөөнт захад үйл ажиллагаа явуулж буй пүүсүүд нь үнийг хүлээн авагчид байдаг ба урт хугацаанд зөвхөн хэвийн ашиг олно.

**Төлбөрийн тэнцлийн алдагдал** /*Balance of payments deficit*/ Тухайн улсын хөрөнгийн гадагшлах урсгал нь дотогшлох урсалаас давах үед төлбөрийн тэнцэл алдагдалтай гарна. Төлбөрийн тэнцлийн алдагдал нь гадаад валютын нөөцийг бууралтаар хаагдана.

**Төлбөрийн тэнцлийн ашиг** /*Balance of payments surplus*/ Тухайн улсын хөрөнгийн дотогшлох урсгал нь гадагшлах урсалаас давах үед төлбөрийн тэнцэл ашигтай гарна. Төлбөрийн тэнцлийн ашиг нь гадаад валютын нөөцийг нэмэгдүүлнэ.

**Төлбөрийн тэнцэл /Balance of payments/** Гадаадын улс орнуудтай тухайн жилд хийгдсэн бүх хэлцлийг (бүтээгдэхүүн, үйлчилгээ, биет болон санхүүгийн актив) мөнгөн нэгжээр илэрхийлсэн бүртгэл. Ерөнхийдөө тухайн хугацаанд хэдий хэмжээний гадаад валют тухайн улсаас бусад улс руу гарсан болон бусад улсаас тухайн улс руу орсоны бүртгэл бөгөөд орсон гарсаны цэвэр зөрүүгээр төлбөрийн тэнцлийн ашиг, алдагдал тодорхойлогдоно.

**Төлөвлөгдөөгүй зардал /Unplanned spending/** Боломжтой хувилбаруудыг сайтар судлалгүйгээр мөнгө зарцуулж, улмаар төлөвлөгдөөгүй үр дагаварт хүрэх.

**Төлөвлөгдөөгүй үр дагавар /Unintended consequences/** Тухайн шийдвэр, эсхүл үйлдлээс үүдэн гарах хүлээгдэж байгаагүй, төлөвлөгдөөгүй үр дүн.

**Төлөвлөгдсөн зардал /Planned spending/** Сайтар бодож тооцоолсон зарцуулалт. Хүлээгдэж буй үр ашиг нь хангалттай өндөр байх тул тус зардлыг гаргаж болно гэсэн хэрэглэгчийн эрэгцүүлэлийн илэрхийлэл.

**Төсвийн алдагдал /Budget deficit/** Улсын төсөвтэй холбоотой ойлголт бөгөөд тухайн жилд засгийн газрын зардал нь орлогоосоо давсан тохиолдолд төсөв алдагдалтай гарна. Төсвийн алдагдал нь улсын өрийг нэмэгдүүлнэ.

**Төсвийн ашиг /Budget surplus/** Улсын төсөвтэй хамаатай ойлголт бөгөөд тухайн жилд засгийн газрын орлого нь зардаасаа давсан тохиолдолд төсөв ашигтай гарна.

**Төсвийн бодлого /Fiscal policy/** Эдийн засгийн нөхцөл байдлыг хянаж, зохицуулахын тулд Засгийн газраас зарцуулалт болон татварын түвшинд хийж буй зохицуулалт.

**Төсвийн тэлэх бодлого /Expansionary fiscal policy/** Нийт эрэлтийг нэмэгдүүлж эдийн засгийг идэвхжүүлэхийн тулд засгийн газрын зүгээс зардлаа өсгөх, болон эсхүл татварыг бууруулах явдал.

**Төсвийн хатуу бодлого /Contractionary fiscal policy/** Нийт эрэлтийг хумиж инфляцийн дарамтыг бууруулах, эдийн засгийн хэт өндөр өсөлтийг сааруулахын тулд Засгийн газар зарцуулалтаа багасгах (эсхүл татварыг нэмэх) арга хэмжээ.

**Төсөв /Budget/** Улс орон, байгууллага, хувь хүний орлого, зарлагын төлөвлөгөө (сарын, улирлын, жилийн).

**Төсөөлөл /Assumptions/** Үнэн зөв хэмээн таамаглаж буй, төсөөлж буй нөхцөл.

**Туршилтын эдийн засаг /Experimental economics/** Хүмүүсийн зах зээлийн үйл хөдлөлийг лабораторийн нөхцөлд туршиж судлах эдийн засгийн салбар.

**Тусlamж авагч /Grantee/** Хэн нэгнээс ямар нэгэн хөрөнгийг өмчлөх эрхийг хүлээн авагч талыг хэлнэ.

**Тусlamж үзүүлэгч /Grantor/** Хэн нэгэнд ямар нэгэн хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэгч талыг хэлнэ.

**Туулайчлах /Free rider/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нь төлөлгүйгээр үр ашгийг нь хүртэх явдал.

**Тэнцвэрт тоо хэмжээ /Equilibrium quantity/** Зах зээлийн тэнцвэрт үнээр худалдан авах, нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ.

**Тэнцвэрт үнэ /Equilibrium price, Market-clearing price/** Худалдан авагчдын авахыг хүсч буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ нь борлуулагчдын нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээтэй тэнцэх үеийн үнэ.

**Тэнцвэртэй төсөв /Balanced budget/** Орлого нь зарлагатайгаа тэнцэх санхүүгийн төлөвлөлөгөө.

## Ү

**Удаан эдэлгээтэй бараа /Durable goods/** Гурваас дээш жилээр ашиглагдах бараа.

**Уламжлалт эдийн засаг /Traditional economy/** Үйлдвэрлэл, хуваарилалттай холбоотой эдийн засгийн ихэнх асуудлыг хуучны ёс уламжлал, зан заншлын дагуу шийдвэрлэж буй эдийн засаг.

**Үлсын өр /National debt/** Төсвийн алдагдлыг санхүүжүүлүүлэх зорилгоор Засгийн газрын бусдад тавьсан өр (нийтийн өр ч гэх нь бий). Засгийн газрын өрийг дотоод (дотоод зээлдүүлэгчдэд өгөх өр) болон гадаад өр (гадаад зээлдүүлэгчдэд өгөх өр) гэж ангилж болно.

**Улсын төсөв** /State budget/ Засгийн газрын орлогын болон зарцуулалтын төлөвлөгөө.

**Уналт** /Depression/ Удаан хугацааны турш үргэлжлэх эдийн засгийн огцом агшилт.

**Урвууrepo** /Reverse repo/ Ямар нэгэн үнэт цаасыг ирээдүйдилүү өндөрүнээрэргүүлэн худалдах нөхцөлтэйгээр өнөөдөр худалдан авах гэрээг хэлдэг. Тухайлбал, зарим Төв банк урвуу репог банкуудаас мөнгө татах замаар мөнгөний нийлүүлэлтийг удирдах, банк хоорондын захын хүүд нөлөөлөх хэрэгсэл болгож ашигладаг.

**Урсгал тэнцэл** /Current account/ Төлбөрийн тэнцлийн бүрэлдэхүүн хэсэг. Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт, импорт, хөрөнгө оруулалтын цэвэр орлого, бусад улстай хийсэн шилжүүлгийн төлбөрийг бүртгэнэ.

**Урт позици** /Long position/ Тухайн хөрөнгийн үнэ нь өснө гэсэн хүлээлтээр үнэт цаас, бараа, валют худалдан авах.

**Урт хугацаа** /Long run/ Үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа эдийн засгийн бүх нөөцийг өөрчлөх боломжтой хугацаа. Эдийн засгийн салбараас шалтгаалан урт хугацаа нь харилцан адилгүй байдаг.

Y

**Үйлдвэрлэгчид** /Producers/ Эдийн засгийн нөөцийг ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж буй хүмүүс, компаниуд.

**Үйлдвэрлэгчийн хожоо** /Producer surplus/ Бүтээгдэхүүний борлуулсан үнэ болон компанийн зүгээс зөвшөөрч чадах хамгийн бага үнийн хоорондох зөрүү.

**Үйлдвэрлэл** /Production/ Эдийн засгийн нөөцийг боловсруулах, өсгөх, ургуулах, бусад аргаар ашиглах замаар хэрэгцээ шаардлагыг хангах бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох явц.

**Үйлдвэрлэлийн боломжийн мурой** /Production possibilities frontier/ Бүрэн ажил эрхлэлттэй эдийн засгийн чадавхийг харуулах хүснэгт буюу график (өгөгдсөн эдийн засгийн нөөц болон технологийн хувьд). Ихэнхдээ хялбар

байлгах үүднээс хоёр бүтээгдэхүүний хослолын олонлогоор төлөөлүүлэн харуулдаг.

**Үйлдвэрлэлийн зардал /Costs of production/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардлагатай эдийн засгийн нөөц (газар, хөдөлмөр, үндсэн хөрөнгө, менежмент)-ийн төлбөр.

**Үйлдвэрлэлийн үр ашиг /Productive efficiency/** Тухайн хэмжээний бүтээгдэхүүнийг чанарыг нь алдагдуулахгүйгээр хамгийн бага зардлаар үйлдвэрлэх явц буюу техникийн үр ашиг.

**Үйлдвэрлэлийн хүчин зүйлс /Factors of production/** Бүтээлч нөөц буюу хүмүүст хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардлагатай зүйлс. Байгалийн баялаг, хүний нөөц, капитал болон удирдлага.

**Үйлдвэрчний Эвлэл /Labor union/** Ажилчдын эдийн засгийн салбараар, эсхүл ажил, мэргэжлээр эвлэлдэн нэгдсэн эдийн засгийн институт. Үйлдвэрчний эвлэл нь цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар ажил олгогчтой гэрээ хэлцэл хийдэг.

**Үйлчилгээ /Services/** Эдийн засгийн хэрэгцээг хангахын тулд иргэд, компани, засгийн газрын зүгээс гүйцэтгэж буй үйл ажиллагаа.

**Үйлчилгээний хураамж /Service charge/** Харилцагчиддаа санхүүгийн үйлчилгээ үзүүлсний төлөө санхүүгийн байгууллагын авч буй шимтгэл хураамж.

**Үл үзэгдэгч гар /Invisible hand/** Үл үзэгдэгч гар гэсэн нэр томьёог анх Адам Смит хэрэглэсэн байдаг. Хувийн эрх ашгийг урьтал болгох компани, хувь хүмүүсийн шийдвэр гаргалт нь эдийн засгийн эмх журмыг бий болгож нийгмийн эрх ашгийг хангадаг гэсэн санаа.

**Үнийн бус өрсөлдөөн /Non-price competition/** Компаниуд үйлчлүүлэгчдийг татахын тулд үнийн бус аргаар (тухайлбал, сурталчилгаа, бэлэгтэй худалдаа гэх мэт) өрсөлдөх явдал.

**Үнийн бус хүчин зүйлс /Non-price determinants/** Эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлж буй үнийн бус хүчин зүйлс. Тухайлбал, нийлүүлэлтийн хувьд зах зээлийн хэмжээ, технологи, засгийн газрын зохицуулалт, нөөцийн өртөг, хүлээлт, татвар ба татаас зэрэг үнийн бус хүчин зүйлс байж

болов болэрэлтийн хувьд хэрэглэгчдийн дур сонирхол, бусад барааны үнэ, хүлээлт, орлого, зах зээлийн хэмжээ зэргийг дурьдаж болох юм. Үнийн бус хүчин зүйлсийн өөрчлөлт нь эрэлт, эсхүл нийлүүлэлтийн муруйг шилжүүлнэ.

**Үнийн доод хязгаар /Price floor/** Хууль тогтоомжоор зохицуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд борлуулах доод үнэ.

**Үнийн дээд хязгаар /Price ceiling/** Хууль тогтоомжоор зохицуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний дээд үнэ.

**Үнийн манлайлал /Price leadership/** Олигополь зах дээр нэг пүүс нь үнийн шийдвэрийг салбарaa төлөөлөн гаргах явдал. Нэг пүүсийн тогтоосон үнийг бусад нь дагах явдал.

**Үнийн нэмэгдэл /Mark up/** Үнийн нэмэгдлийг барааны худалдаалж буй үнээс уг барааны нийт зардлыг хасч тооцно. Мөн дилер өөрийн данснаас үнэт цаас худалдан авч, худалдаж байгаа тохиолдолд үнэт цаасыг худалдан авсан дилерийн үнэ, уг үнэт цаасыг хөрөнгө оруулагчид зарж буй үнийн зөрүүг хэлнэ.

**Үнийн тогтвортой байдал /Price stability/** Инфляци, эсхүл дефляци ажиглагдахгүй нөхцөл байдал. Нийгмийн томоохон зорилтуудын нэг бөгөөд эдийн засаг хэр сайн ажиллаж буйн шалгуур үзүүлэлт. Жишээ нь, ихэнх улс орнуудын мөнгөний бодлогын гол зорилго болдог. Английн Төв банкны инфляцийн зорилтот түвшин 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 0.5% байна.

**Үнийн түвшин /Price level/** Эдийн засаг дахь бүх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн жигнэсэн дундаж үнэ.

**Үнийн ялгаварлал /Price discrimination/** Адил бүтээгдэхүүнийг өөр өөр хэрэглэгчдэд харилцан адилгүй үнээр зarah явдал.

**Үнэ /Price/** Нэгж бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад шаардлагатай мөнгөн дүн буюу нэгж бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахад олох мөнгөн дүн.

**Үнэ хүлээн авагч /Price taker/** Ашгаа алдалгүйгээр зах зээлийн үнээс өөр үнийг тогтоох чадваргүй, төгс өрсөлдөөнт захад үйл ажиллагаа явуулж буй компани.

**Үнэмлэхүй давуу тал** /Absolute advantage/ Адил хэмжээний эдийн засгийн нөөцөөр илүү олон тооны бүтээгдэхүүн, үйлчилгээг (бусад үйлдвэрлэгчтэй харьцуулахад) үйлдвэрлэх чадвар.

**Үр ашигтай үйл хөдлөл** /Economizing behavior/ Хувилбаруудын давуу болон сул талыг харьцуулсны үндсэн дээр хамгийн ашигтай хувилбарыг сонгох явдал.

**Үр дагавар** /Consequence/ Шийдвэр гаргалт, эсхүл үйлдлийн үр дүн, нөлөө. Үр дагавар нь эерэг, эсхүл сөрөг байж болно.

**Үржүүлэгчийн нөлөө** /Multiplier effect/ Өрхийн аж ахуй, компаниуд, эсхүл Засгийн газрын зардлын бага хэмжээний өөрчлөлт нь эдийн засгийн үйлдвэрлэлийг үлэмж хэмжээгээр өөрчлөх тухай ойлголт юм. Зарлага багасвал үржүүлэгч нь эсрэг зүгт ажиллана.

**Үүсмэл эрэлт** /Derived demand/ Эдийн засгийн нөөцийн эрэлт нь эцсийн бүтээгдэхүүний эрэлтээс хамаарах үзэгдэл. Тухайлбал, үр тарианы эрэлт нэмэгдэхэд газар тариалангийн салбарт ажиллагсдын эрэлт нэмэгдэнэ.

## X

**Хамтын хэрэглээ** /Shared consumption/ Бусдын хэрэглээг бууруулахгүйгээр хэрэглэж болох бүтээгдэхүүн, үйлчилгээ. Тухайлбал, гудамжны гэрэл, радио гэх мэт.

**Ханамж** /Utility/ Хэрэглэгч бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэснээр бий болох сэтгэл ханамжийн хийсвэр хэмжүүр.

**Ханшийн супралт** /Currency devaluation, Depreciation of currency/ Нэгж дотоодын мөнгөн тэмдэгтээр худалдан авах гадаад валютын хэмжээ буурах үзэгдэл. Өөрөөр хэлбэл, үндэсний мөнгөн тэмдэгтийн үнэ цэнэ бусад улсын мөнгөн тэмдэгтийн эсрэг буурах. Жишээ нь ам.долларын ханш 1500 төгрөгөөс 1800 төгрөг болж өсөх нь ам.долларын хувьд ханш чангараахарин төгрөгийн хувьд супрах үзэгдэл юм.

**Ханшийн эрсдэл** /Exchange rate risk/ Тухайн эдийн засгийн үндсэн валютаас бусад гадаад валютаар санхүүгийн гүйлгээ хийхэд ханшийн өөрчлөлтөөс бий болдог санхүүгийн эрсдэл.

**Харилцан хамаарал** /*Interdependence*/ Нэг хүний гаргасан шийдвэр нь бусдын гаргах шийдвэрт нөлөөлөх нөхцөл байдал. Тухайлбал, дэлхийн аль нэг өнцөгт өрнөх үйл явдал нь бусад бүс нутагт нөлөөлөх, эдийн засгийн нэг секторт болж буй үйл явдал бусад секторт нөлөөлөх явдал.

**Харьцангуй давуу тал** /*Comparative advantage*/ Бусад үйлдвэрлэгчийг бодвол бүтээгдэхүүн, үйлчилгээг алдагдсан боломжийн бага өртгөөр үйлдвэрлэх чадвар. Харьцангуй давуу тал нь төрөлжилт, худалдаа явагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлнэ.

**Харьцангуй үнэ** /*Relative price*/ Нэг барааны үнийг нөгөө барааны үнээр илэрхийлсэн (хоёр үнийн харьцаа) харьцаа. Энэ нь алдагдсан боломжийн өртгийн хэмжүүр, эдийн засгийн шийдвэр гаргалтад нөлөөтэй үнэ юм.

**Харьцуулсан худалдан авалт** /*Comparison shopping*/ Тухайн бүтээгдэхүүний үнэ (зардлаа хамгийн бага байлгах), эсхүл загварыг (чанар, хэмжээ гэх мэт) судалсны үндсэн дээр худалдан авах шийдвэр гаргах явдал.

**Ховор, хомс байдал** /*Scarcity*/ Эдийн засгийн байгаа нөөц нь хүний хүсэл хэрэгцээг хангахгүй байх явдал. Түүнчлэн тухайн эдийн засгийн нөөцийн хувьд нэг бус, хэд хэдэн хэрэглээ байж болох нөхцөл байдал юм. Хувь хүн, аж ахуйн нэгж (пүүс, төр засгийн байгууллагууд) бүр ховор хомс байдалтай тулгардаг.

**Хомсдол** /*Shortage*/ Бүтээгдэхүүний эрэлт нь нийлүүлэлтээсээ давах тохиолдолд үүсэх нөхцөл байдал. Ихэвчлэн бүтээгдэхүүний үнэ зах зээлийн тэнцвэрт үнээс доогуур үед тохиолдох үзэгдэл.

**Хослох бараа** /*Complementary goods and services, Complements*/ Ихэвчлэн хамтдаа хэрэглэгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээ (тухайлбал, шүдний оо, сойз, үзэг, бэх гэх мэт).

**Хоцрох үзүүлэлтүүд** /*Lagging indicators*/ Эдийн засаг (бодит үйлдвэрлэл) бүхэлдээ өөрчлөгдсөний дараагаар өөрчлөгддэг үзүүлэлтүүд (тухайлбал, хүүгийн түвшин, нэгж бүтээгдэхүүнд ногдох хөдөлмөрийн зардал, компанийн ашиг гэх мэт).

**Хөвөгч (уюн хатан) ханш** /*Flexible (Floating) exchange rate*/ Зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдох

чөлөөтэй хэлбэлзэх (хөвөх) ханш. Тухайлбал, Монголбанк ханшийн хөвөгч дэглэмийг баримтлан ажилладаг ба төгрөгийн гадаад валютудын эсрэг ханшийг зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хүчин зүйлс тодорхойлж байдаг.

**Хөдөлмөр** /*Labor*/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлд ашиглаж болох хүний нөөцийн тоо хэмжээ, чанар.

**Хөдөлмөрийн зах** /*Labor market*/ Ажил олгогч болон хөдөлмөр эрхлэгчийн хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулж буй орчин. Хөдөлмөрийн зах зээлийг хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийн муруйгаар илэрхийлнэ. Хоёр муруйн огтолцол нь тэнцвэрт цалин болон энэхүү тэнцвэрт цалингаар ажиллах цагийг харуулна. Ажил олгогч нь хөдөлмөрийн зах зээл дээр хамгийн сайн ажилчин авч ажиллуулах сонирхолтой байдаг бол ажиллагсад нь хамгийн сайн сэтгэл ханамж, цалин хөлс санал болгосон ажлын байранд ажиллах сонирхолтой байдаг.

**Хөдөлмөрийн хуваарь** /*Division of labor*/ Ажилчид үйлдвэрлэлийн шат дамжлагын зарим хэсгийг нь хариуцан ажиллах ажлын зохион байгуулалт.

**Хөрөнгийн данс** /*Capital account*/ Төлбөрийн тэнцлийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хөрөнгийн гадагшлах болон дотогшлох урсгалыг бүртгэнэ. Хөрөнгийн гадагшлах урсгал гэдэг нь тухайн улсын харьятууд бусад улсын харьятуудаас биет капитал болон санхүүгийн активуудыг худалдан авахад гаргаж буй зардал юм. Хөрөнгийн дотогшлох урсгал гэдэг нь бусад улсын харьятууд тухайн улсын харьятуудаас биет капитал болон санхүүгийн активуудыг худалдан авахад гаргаж буй зардал юм.

**Хөрөнгийн дансны тэнцэл** /*Capital account balance*/ Тухайн улс дахь гадаадын хөрөнгө оруулалтаас гадаад дахь тухайн улсын хөрөнгө оруулалтыг хассан ялгавар.

**Хөрөнгө оруулалт** /*Investment*/ Ирээдүйд орлого авчирна гэсэн итгэлтэйгээр худалдан авсан аливаа хөрөнгө, эсхүл бараа. Хөрөнгө оруулалт нь эдийн засгийн болон санхүүгийн хувьд өөр өөр угтатай байдаг. Эдийн засгийн хувьд өнөөдөр хэрэглэж чадахгүй боловч ирээдүйд баялаг бүтээх барааны худалдан авалт юм. Жишээ нь, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйлдвэрийн барилгад хөрөнгө оруулах, машин тоног төхөөрөмж худалдан

авах, их сургууль, коллежид сурахад хөрөнгө оруулах нь эдийн засгийн хөрөнгө оруулалт юм. Санхүүгийн хувьд ирээдүйд орлого авчрах, эсхүл илүү өндөр үнээр зарагдах магадлалтай худалдан авсан хөрөнгө юм. Бонд, хувьцаа, үл хөдлөх хөрөнгө нь санхүүгийн хөрөнгө оруулалтын жишээ юм.

**Хувийн нөөц боломж** /Personal resources/ Хүнд байгаа хугацаа, мөнгө, мэдлэг, туршлага, ур чадвар.

**Хувийн өмч** /Private property/ Зах зээлийн эдийн засгийн үндэс суурь. Хувь хүн, компаниудын биет болон биет бус хөрөнгө эзэмших хуулиар хамгаалагдсан эрх. Хувийн өмчийг зөвхөн эзэмшигчийн зөвшөөрснөөр, зөвхөн тогтсон процедурын дагуу (тухайлбал, борлуулах, бэлэглэх) бусдад шилжүүлнэ.

**Хувийн секторыг шахан гаргах** /Crowding-out/ Засгийн газар санхүүгийн эх үүсвэрийн төлөө өрсөлдөж эхэлснээр (хэрэглээ, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхийн тулд) зээлийн хүү өсч, улмаар хувийн хөрөнгө оруулалт багасах үзэгдэл.

**Хувийн хэрэглээний бүтээгдэхүүн** /Private good/ Үр ашгаа зөвхөн худалдан авсан хүнд өгөх бүтээгдэхүүн.

**Хувь тэнцүүлсэн татвар** /Proportional tax/ Татварын орлого өссөн ч татварын хувь хэмжээ үл өөрчлөгдөх тогтолцоо.

**Хувьсах зардал** /Variable costs (VC)/ Пүүсийн үйлдвэрлэлийн хэмжээнээс шууд хамаарч өөрчлөгдөх үйлдвэрлэлийн зардал. Тухайлбал, шууд хөдөлмөр, шууд материал, зарим үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэх мэт.

**Хувьсах зарлага** /Variable expenses/ Долоо хоног, эсхүл сар бүр хэлбэлзэх зардал. Тухайлбал, хоол хүнс, хувцас, амралт зугаа цэнгэл гэх мэт.

**Хувьсах орлого** /Variable income/ Долоо хоног бүр, эсхүл сар бүр хувьсах орлого.

**Худалдаа** /Trade/ Бүтээгдэхүүн, үйлчилгээг мөнгө, эсхүл өөр бүтээгдэхүүн, үйлчилгээгээр солилцох явдал.

**Худалдааны тэнцэл** /Balance of trade/ Төлбөрийн тэнцлийн нэг хэсэг нь бөгөөд бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт, импортыг бүртгэнэ. Худалдааны тэнцлийг

дотор нь бүтээгдэхүүний болон үйлчилгээний тэнцэл гэж хоёр хуваана. Улс орны экспорт нь импортоос давж байвал худалдааны тэнцэл эерэг байна. Харин импорт нь экспортоос давж байвал худалдааны тэнцэл алдагдалтай байна.

**Худалдааны хожоо** /*Gains from trade*/ Худалдаа хийснээр хэрэглэгч болон үйлдвэрлэгчийн хожоо өсөх явдал. Худалдаа нь хувь хүн, бус нутаг, улс орон өөрийн илүү сайн хийж чадах бүтээгдэхүүн дээр төвлөрч, үйлдвэрлэхгүй байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг бусдаас худалдан авснаар эдийн засгийн үр ашиг дээшилж, нийт хэрэглээ, сайн сайхан байдал нэмэгдэнэ гэж үздэг.

**Худалдааны хориг саад** /*Trade barriers*/ Улс орнуудын хоорондох чөлөөт худалдаанд саад учруулж буй хязгаарлалтууд. Тухайлбал, тариф, импорт, экспортын квот, тарифын бус хязгаарлалт (лицензийн шаардлага, хүнд суртал).

**Худалдан авах чадвар** /*Purchasing power*/ Орлогын мөнгөн нэгжээр худалдан авч болох бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ.

**Хуримтлал** /*Saving*/ Ирээдүйд ашиглах үүднээс хадгалсан мөнгө буюу татварын дараах бэлэн орлогоос хэрэглээний зардлыг хассан дүн. Энэ нь хадгаламжийн данс, хадгаламжийн сертификат хэлбэртэй байж болно.

**Хуримтлалын төлөвлөгөө** /*Savings plan*/ Ирээдүйд зарцуулах мөнгийг хадгалах төлөвлөгөө.

**Хуулийн болон нийгмийн тогтолцоо** /*Legal and social framework*/ Нийгэм болон түүний эдийн засгийн суурийг бүрдүүлж буй хууль тогтоомж, институтууд, уламжлал, зан заншил, урамшуулал, хөшүүргийн систем.

**Хууран мэхлэх явдал** /*Deceptive practices*/ Бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулахын тулд компанийн зүгээс хууран мэхлэх аргыг ашиглаж буй үйлдэл. Тухайлбал, өгөөш хаях, худал сурталчилгаа хийх гэх мэт.

**Хүмүүн капитал** /*Human capital*/ Ажил эрхэлж баялаг шинээр бүтээж буй хүний нөөц, түүний мэдлэг боловсрол, эрүүл мэнд зэргийг хамруулж ойлгоно.

**Хүн ам зүй /Demography/** Хүн амын тоо, бүтэц, тархалт, нягтрал, өсөлт, шилжих хөдөлгөөн, нас баралт, төрөлт зэргийг судалдаг шинжлэх ухаан.

**Хүн амын орлогын хуваарилалт /Personal distribution of income/** Хувь хүн, гэр бүлүүдийн орлогын ангилал. Хүмүүсийг орлогоор нь (хамгийн ихээс хамгийн бага руу) бүлэглэн харуулах.

**Хүний нөөц /Human resources/** Хүмүүсийн эрүүл мэнд, боловсрол, дадлага туршлага, мэргэшил, ур чадварыг агуулсан боломжит нөөц.

**Хүний нөөцийн хөрөнгө оруулалт /Human capital investment/** Хүмүүсийн эрүүл мэнд, мэдлэг, дадлага туршлага, ур чадварыг ахиулах үүднээс тэдний боловсрол, сургалтад хөрөнгө оруулалт (цаг хугацаа, хүчин чармайлт, нөөцийн) хийх явдал.

**Хүртсэн үр ашгаар татвар төлөх зарчим /Benefits-received principle/** Улсаас бүтээгдэхүүн, үйлчилгээ хэлбэрээр ашиг тус хүртэж буй иргэд тэдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардлагатай татварыг төлж байх ёстой гэсэн зарчим.

**Хүртээмжийн индекс /Affordability index/** Хүн амын тодорхой нэг зүйл худалдан авах чадварыг харуулсан индекс. Хүртээмжийн индексийг 100-аар төлөөлүүлэн хүн амын дундаж орлоготой иргэн тухайн зүйлийг худалдан авах боломжтойг харуулдаг бол 100-аас доош индекстэй бол худалдан авах боломж бага, 100-аас дээш бол илүү боломж байгааг илэрхийлнэ.

**Хүүгийн хувь хэмжээ /Interest rate/** Хэн нэгний мөнгийг ашигласны төлөө төлөх үнэ, зээлж авсан дүнгийн хувиар илэрхийлнэ.

**Хүчин зүйлийн нөөцүүд /Factor endowments/** Улс орнуудын нөөц, баялгийн харилцан адилгүй байдал нь алдагдсан боломжийн өртгийг ялгавартай байхад хүргэдэг гэсэн онол. Харьцангуй их байгаа нөөц баялгаа ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь улс орны харьцангуй давуу талыг бий болгоно.

**Хүчин зүйлсийн үнэ /Factor prices/** Газар, капитал, хөдөлмөр, менежментийн үнэ.

**Хэвийн бараа /Normal good/** Хэрэглэгчийн бодит орлого өсөхийн хэрээр эрэлт нь нэмэгддэг бараа.

**Хэвийн тархалт /Normal distribution/** Статистикт хэрэглэгддэг ойлголт бөгөөд график нь тэгш хэмтэй, хонхон хэлбэртэй байдаг. Хэвийн тархалтын ихэнх утга нь дундаж руугаа төвлөрөх ба цөөн хэдэн ажиглалт дунджаас бага, эсхүл илүү угтатай байна. Тухайлбал, насанд хүрсэн хүмүүсийг санамсаргүй байдлаар түүвэрлэж өндрийг нь хэмжвэл ихэнх хүнийг 1.2-2.1 метрийн хооронд байх бөгөөд маш цөөн хүн 1.2 метрээс нам, эсхүл 2.1 метрээс өндөр байх болно.

**Хэрэглэгч /Consumers/** Хувийн хэрэгцээгээ хангах (дахин борлуулах, бусад бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхийн тулд бус) үүднээс бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэж буй хүмүүс.

**Хэрэглэгчийн илүүдэл /Consumer surplus/** Хэрэглэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөө төлөхөд бэлэн үнэ болон бодит үнийн хоорондох ялгавар.

**Хэрэглэгчийн эдийн засаг /Consumer economics/** Хэрэглэгчийн зах зээлийн шийдвэр гаргалт, мөнгөний зарцуулалтыг судалдаг эдийн засгийн салбар.

**Хэрэглэх /Consume/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдаж авах явдал.

**Хэрэглээ /Consumption/** Өрхийн аж ахуй, хувийн сектор, Засгийн газрын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдаж авах зарцуулалт. Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдаж авах үйл явц.

**Хэрэглээний үнийн индекс /Consumer Price Index (CPI)/** Тодорхой тооны бүтээгдэхүүн, үйлчилгээнээс бүрдсэн хэрэглээний сагсны тайлант үеийн өртгийг суурь үеийн өртөгтэй нь харьцуулсан үнийн индекс. Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтөөр инфляцийг хэмжинэ.

**Хэрэгцээ /Wants, Needs/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэснээр хангаж болох хүсэл, шаардлага.

**Хэсэгчилсэн төлбөр /Installments/** Зээл, эсхүл ямар нэгэн бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа төлбөрийг үе шаттайгаар хэсэгчлэн төлж буй төлбөр. Жишээ нь, 1 сая

төгрөгийн үнэтэй бараа бүтээгдэхүүнийг З сарын хугацаанд эхний хоёр сарын эцэст 300 мянган төгрөг, З дахь сарын эцэст 400 мянган төгрөг төлөх хуваарь гаргасан бол сар бүр төлөх дүнгүүд хэсэгчилсэн төлбөр юм.

## Ц

**Цаасан мөнгө /Paper money/** Улс оронд солилцооны хэрэгслээр хүлээн зөвшөөрөгдсөн цаасан дэвсгэртүүд. Цаасан мөнгийг Төв банк гүйлгээнд гаргана.

**Цалин /Wage/** Ажилласан цаг, эсхүл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо хэмжээтэй шууд уялдаатайгаар биеийн хөдөлмөрийн үйлчилгээнд төлөх төлбөр. Хөгжингүй орууладад өдөр бүр, эсхүл долоо хоног бүр олгогдоно.

**Цалингийн зээл /Payday loan/** Зээлийн төлбөрийг ирээдүйн цалин, түүнтэй адилтгах нөхөн олговрын орлогоор эргүүлэн төлөх нөхцөл бүхий зээл. Цалингийн зээлийн өртөг (хүү болон шимтгэл, хураамж) харьцангуй өндөр байдаг.

**Цалингийн шимтгэл, суутгал /Payroll deduction/** Ажилчин, албан хаагчийн цалингаас суутгах татвар, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл гэх мэт.

**Цэвэр экспорт /Net exports/** Экспортоос импортыг хассан утга.

## Ч

**Чанарын харьцуулалт /Quality comparison/** Нэг бүтээгдэхүүн нь бусад бүтээгдэхүүнээсээ илүү эсэхийг шалгах явц.

**Чөлөөт худалдаа /Free trade/** Худалдааны хориг, саадгүйгээр бүтээгдэхүүн үйлчилгээг сайн дурын үндсэн дээр солилцох явдал.

## Ш

**Шийдвэр гаргалт** /Decision, Decision making/ Боломжтой хувилбаруудын үр дагаврыг харьцуулан үзсэний дараа хүрэх дүгнэлт.

**Шийдвэр гаргалтын хүснэгт** /Decision-making grid/ Хувилбаруудын давуу болон сул талыг тусгасан хүснэгт. Энэ нь шийдвэр гаргалтыг хөнгөвчилнө.

**Шийдвэр гаргах шаталсан арга** /Paced Decision-making process/ Асуудлыг үр ашигтай шийдвэрлэх үйл явц бөгөөд дараах үе шатыг хамарна: асуудлыг томьёолох, боломжтой хувилбаруудыг жагсаах, шалгуурыг тодорхойлох, хувилбаруудыг үнэлэх, шийдвэр гаргах.

**Шилжилтийн ажилгүйдэл** /Frictional unemployment/ Нэг ажлаас нөгөө ажилд шилжих болон анх удаа ажил хайж буй хүмүүс ажиллах хүчинд орж ирэх үед үүсэх ажилгүйдэл. Эдийн засагт үргэлж байх ажилгүйдлийн хэлбэр.

**Шилжилтийн эдийн засаг** /Transition economy/ Эдийн засгийн нэг системээс нөгөө систем рүү шилжиж буй улс орон. Ихэвчлэн төвлөрсөн төлөвлөгөөт системээс зах зээлийн систем рүү шилжиж буй улс орнуудын хувьд хэрэглэгддэг нэр томьёо.

**Шилжүүлгийн төлбөр** /Transfer payments/ Засгийн газар хүн амын нэг бүлгээс цуглуулсан мөнгийг нөгөө хэсэгт шилжүүлж буй явдал. Тухайлбал, нийгмийн хангамжийн тэтгэлэг, ажилгүйдлийн тэтгэмж, хөдөө аж ахуйн салбарт олгож буй татаас гэх мэт.

**Шинэ сонгодог онол** /New classical theory/ Хүмүүсийн хүлээлтэд онцгой ач холбогдол өгдөг эдийн засгийн онол. Хувь хүмүүс болон компаниуд шийдвэр гаргахдаа Засгийн газрын бодлогыг харгалzan үзэх тул Засгийн газраас бизнесийн мөчлөгт нөлөөлж чадахгүй, үндэсний орлогод гарч буй бодит өөрчлөлт нь үнийн түвшний хүлээгдэж байгаагүй хөдөлгөөний үр дүн гэж үздэг.

**Шударга үнэ** /Fair-return price/ Зохицуулалттай монопольд (тухайлбал, цахилгаан үйлдвэрлэгч) хэвийн ашигтай ажиллах боломжийг олгож буй үнэ.

**Шууд бус зардал /Indirect costs/** Тухайн объект (тодорхой төсөл, барилга байгууламж, үйл ажиллагаа, үйлдвэрлэл, бүтээгдэхүүн)-ын өртөгт шууд шингэдэггүй зардал. Шууд бус зардал нь тогтмол, эсхүл хувьсах шинжтэй байж болно. Удирдлага, аюулгүй байдал, дулаан, ус, цахилгаан болон бусад нэмэлт зардлууд шууд бус зардлын жишээ болно.

**Шууд бус хамаарал /Indirect relationship/** Нэг хувьсагчийн утга нэмэгдэхэд нөгөө хувьсагчийн утга буурах хамаарал. Сөрөг хамаарал ч гэх нь бий.

**Шууд хамаарал /Direct relationship/** Нэг хувьсагчийн утга нэмэгдэх тусам нөгөө хувьсагчийн утга нэмэгдэх явдал. Эерэг хамаарал ч гэх нь бий.

## Э

**Эдийн засгийн алдагдал /Economic loss/** Нийт орлогоос нийт зардлыг хасч тооцох ба нийт зардал нь алдагдсан боломжийн бүх өртгийг агуулна.

**Эдийн засгийн ашиг /Economic profit/** Компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг (алдагдсан боломжийн өртөг мөн орно) хасч тооцсон ялгавар.

**Эдийн засгийн аюулгүй байдал /Economic security/** Ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, бизнесийн дампуурал, эсхүл байгалийн гамшиг зэрэг хүмүүсийн хянах боломжгүй эдийн засгийн эрсдэлүүдээс хамгаалах явдал.

**Эдийн засгийн институтууд /Economic institutions/** Байгууллагууд (өрхийн аж ахуйнууд, компаниуд, засгийн газар, банкууд, үйлдвэрчний эвлэлүүд, хоршоод), хууль эрх зүйн систем, ямар нэгэн зүйл хийх тогтсон арга хэлбэр (мөнгө ашиглах, ажил олгогч болон ажилчдын хооронд гэрээ хэлцэл хийх, баяр ёслол тэмдэглэх гэх мэт), үнэт зүйлс, итгэл үнэмшил зэрэг өргөн цар хүрээтэй ойлголт юм.

**Эдийн засгийн нөөц /Productive resources/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд шаардлагатай байгаль, хүн, капитал, удирдлагын нөөц.

**Эдийн засгийн онол /Economics/** Хүмүүс, компаниуд болон нийгмийн зүгээс эдийн засгийн ховор нөөцийг

хэрхэн хуваарилж буйг судалдаг шинжлэх ухаан. Эдийн засгийн нөөцийг ашиглаж болох хувилбаруудаас сонголт хэрхэн хийгдэж буйг судлах салбар.

**Эдийн засгийн орлого /Economic earning/** Хүчин чадал, чадварыг өөрчлөхгүйзэр бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд тогтмол олж болох мөнгөний хэмжээ. Эдийн засгийн орлогыг бизнесийн ирээдүйн ашигт ажиллагаатай холбоотойгоор өнөөгийн нөхцөл байдал хадгалагдана гэж үзэн төсөөлдөг ч уг таамаглал олон хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх болно.

**Эдийн засгийн өсөлт /Economic growth/** Бодит ДНБ, эсхүл нэг хүнд ногдох бодит ДНБ-ээр илэрхийлэгдэх өсөлт.

**Эдийн засгийн рент /Economic rent/** Үйлдвэрлэлийн нөөцөд (хүчин зүйл) төлж буй алдагдсан боломжийн өртгөөс давсан төлбөр (хүний үйл ажиллагаатай холбоотой алдагдсан боломжийн өртөг, үйлдвэрлэгчийн илүүдэл, хэвийн ашигтай эндүүрч болохгүй). Эдийн засгийн рент нь үйлдвэрлэгдээгүй орц, нөөцийн өртөг юм.

**Эдийн засгийн систем /Economic systems/** Юуг үйлдвэрлэх вэ? яаж үйлдвэрлэх вэ? бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрхэн хуваарилах вэ? гэдгийг шийдвэрлэх институциональ тогтолцоо.

**Эдийн засгийн сэтгэлгээ /Economic way of thinking/** Шийдвэр гаргалтын зардал болон үр ашгийг харьцуулан судлах явдал.

**Эдийн засгийн тэгш байдал /Economic equity/** Эдийн засаг дахь "шударга ёс"-ны тухай ойлголт, үзэл баримтлал. Эцсийн дүндээ орлого, баялгийн хуваарилалттай холбоотой.

**Эдийн засгийн уналт /Recession/** Эдийн засгийн идэвхжил сулрах үзэгдэл, бодит ДНБ хоёр улирал (буюу б сарын турш) дараалан буурах үзэгдэл.

**Эдийн засгийн уналтын хэмжээ /Recessionary gap/** Бодит ДНБ нь инфляцийн дарамтгүй, бүрэн ажил эрхлэлттэй боломжит ДНБ-ий түвшинээс хэр дутуу буюу зөрүүтэй байгааг харуулна.

**Эдийн засгийн үр ашиг /Economic efficiency/** Хэн нэгний нөхцөлийг дордуулахгүйгээр нөгөө хүний нөхцөлийг сайжруулах боломжгүй нөхцөл байдал.

**Эдийн засгийн хөгжил /Economic development/** Амьжиргааны түвшинг дээшлүүлэх замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулах үйл явц. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг бодвол илүү өргөн цар хүрээтэй ойлголт. Эдийн засаг, нийгэм, улс төрийн институтуудын хөгжлийн асуудалтай нягт уялдаатай.

**Эдийн засгийн хөтөч үзүүлэлтүүд /Leading economic indicators/** Эдийн засаг (бодит үйлдвэрлэл) бүхэлдээ өөрчлөгдхөөс өмнө урьтаж өөрчлөгддөг эдийн засгийн хувьсагдахуунууд (ажилгүйдлийн тэтгэмж, үйлдвэрлэгчдийн шинэ захиалга, хувьцааны үнэ, шинэ тоног төхөөрөмжийн захиалга гэх мэт). Монгол улсын Сангийн яамнаас сар бүр тооцдог Нэгдсэн Түрүүлэгч Индикатор (НТИ) нь үүний нэг жишээ юм. НТИ нь эдийн засаг ойрын ирээдүйд ерөнхий чиг хандлагатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдхөхийг таамаглах зорилготой үзүүлэлт юм.

**Эдийн засгийн хөшүүрэг /Economic incentives/** Хувь хүн, аж ахуйн нэгжийн (компани, засгийн газрын агентлагууд мөн орно) үйл хөдлөлд нөлөөлж, сэдэл өгч байдаг хүчин зүйлс. Зах зээлийн эдийн засагт үнэ, ашиг, алдагдал нь эдийн засгийн чухал хөшүүрэг болдог.

**Эдийн засгийн хэрэгцээ /Economic wants/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэнээр хангаж болох хүсэл.

**Эдийн засгийн эрх чөлөө /Economic freedom/** Зах зээлийн эрх чөлөө, хэрэглэгчид аль бүтээгдэхүүн, үйлчилгээнд мөнгөө зарцуулах эрх чөлөө, ажилчид ажлаа солих, үйлдвэрчний эвлэлд нэгдэх, эсэргүүцлээ илэрхийлэх (тухайлбал, ажил хаях) эрх чөлөө, хувь хүмүүс бизнес эрхлэх, юу үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн хэв маягаа хэзээ өөрчлөхөө шийдэх эрх чөлөө, мөнгөө хадгалж буй хүмүүс хуримталаа хэзээ, хаана, юунд хөрөнгө оруулах эрх чөлөө.

**Эерэг дам нөлөө /Positive externality, Spillover benefit/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, эсхүл хэрэглээ нь зах зээлийн солилцоонд шууд оролцохгүй байгаа хүмүүсийн аж амьдралд эерэгээр дам нөлөөлөх үзэгдэл.

Энэхүү үр нөлөөг “гуравдагч этгээдийн нөлөө”, эсхүл “эерэг дам нөлөө” ч гэх нь бий. Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээнээс гуравдагч талын төлбөрийг нь төлөлгүйгээр хүртэж буй үр ашиг.

**Эзэмшилийн төлбөр /Carrying charges/** Хөрөнгийг эзэмших үед гарч буй сул байгаа хөрөнгө, эсхүл баригдаж байгаа хөрөнгөд ногдох буй татвар, хүү гэх мэт зардал.

**Экспорт /Exports/** Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бусад улсад зарж борлуулах явдал.

**Эрчимтэй өсөлт /Intensive growth/** Орцын хэмжээг нэмэгдүүлэлгүйгээр гарцыг нэмэгдүүлэх явдал. Тухайн салбар, эсхүл бус нутгийн түргэн, хурдацтай өсөлт.

**Эрэлт /Demand/** Үнийн байж болох түвшин бүрийн хувьд худалдан авагчдын авахад бэлэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээг тодорхой хугацааны (7 хоног бүр, сар бүр, жилд гэх мэт) хувьд харуулна.

**Эрэлтийг тодорхойлогч хүчин зүйлс /Determinants of demand/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийн муруйг шилжүүлэх үнийн бус хүчин зүйлс (хэрэглэгчдийн орлого, too, сонирхол, хамааралтай бүтээгдэхүүний үнэ гэх мэт). Эрэлтийн муруй баруун (зуун) тийш шилжвэл үнийн түвшин бүрийн хувьд хэрэглэгчдийн тодорхой хугацаанд (тухайлбал, 7 хоног бүр) худалдан авах бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ нэмэгдэнэ (буурна).

**Эрэлтийн гаралтай инфляци /Demand-pull inflation/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгдэх, эсхүл “хэт их мөнгө хэт цөөн тооны бүтээгдэхүүний араас ангуучлах” үед үүсэх инфляци.

**Эрэлтийн мэдрэмж /Elasticity of demand/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нэг хувиар өөрчлөгдөхөд эрэлтийн хэмжээ нь хэдэн хувиар өөрчлөгдөхийг харуулна.

**Эрэлтийн орлогоын мэдрэмж /Income elasticity of demand/** Орлого нэг хувиар өөрчлөгдөхөд бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийн хэмжээ хэдэн хувиар өөрчлөгдөж буйг харуулна.

**Эрэлтийн солбисон мэдрэмж /Cross-price elasticity of demand/** Эрэлтэд нөлөөлдөг бусад хүчин зүйлс тогтмол

үед нэг бүтээгдэхүүний үнэ нэг хувиар өөрчлөгдхөд нөгөө бүтээгдэхүүний эрэлтийн хэмжээ хэдэн хувиар өөрчлөгдж буйг харуулах харьцаа (бусад хүчин зүйлс тогтмол үед). Бүтээгдэхүүнүүд хоорондоо хослох, эсхүл орлох шинжтэй байгааг илтгэх хэмжүүр. Солбисон эрэлтийн мэдрэмж эерэг байвал бараанууд орлох шинжтэй, харин сөрөг байвал хослох шинжтэй байна.

**Эрэлтийн үнийн мэдрэмж** /Price elasticity of demand/ Үнийн өөрчлөлтөөс шалтгаалан тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийн хэмжээнд гарч буй өөрчлөлтийн хэмжүүр. Үнэ нь нэг хувиар өөрчлөгдхөд тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийн хэмжээ хэдэн хувиар өөрчлөгдж буйг харуулна.

**Эрэлтийн хууль** /Law of demand/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ нэмэгдвэл (буурвал) худалдан авах тоо хэмжээ нь (тодорхой хугацаанд хамаарах) буурах (өсөх) зүй тогтол.


**Эрэлтийн хэмжээ** /Quantity demanded/ Хүмүүсийн тодорхой хугацаанд тухайн үнээр худалдан авах бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ.

**Эрэлтийн шок** /Demand shock/ Бараа үйлчилгээний эрэлтэд огцом нөлөөлөх үйл явц. Эерэг шок нь эрэлтийг өсгөдөг бол сөрөг шок нь эрэлтийг бууруулдаг. Эдгээрийн аль аль нь бараа үйлчилгээний үнэд нөлөөлдөг.

## Я

**Ядуурал** /Poverty/ Материаллаг баялаг, мөнгөгүй байх нөхцөл байдал. Туйлын ядуурал нь хүний үндсэн хэрэгцээ (хоол хүнс, ус, ариун цэвэр, хувцас хунаар, байр сууц, эрүүл мэнд, боловсрол) хангагдахгүй байхтай холбоотой. Харин харьцангуй ядуурал нь тухайн хүний амьдарч буй нийгэм, эсхүл байршил дахь эдийн засгийн тэгш бус байдалтай холбоотой ойлголт юм.

**Ялгаагүйн муруй** /Indifference curve/ Хэрэглэгч ижил хэмжээний ханамж авах бараануудын боломжит хослолыг харуулсан муруй.



Зураг 1. Ялгаагүйн муруй

**Ялгавартай үнэтэй арилжаа /Multiple-price auction/** Арилжаанд оролцогчийн өрсөлдөөнт бус санал нь тухайн арилжааны амжилттай биелсэн өрсөлдөөнт саналын жигнэсэн дундаж хүүгээр, өрсөлдөөнт санал нь тухайн оролцогчийн ирүүлсэн хүүгийн саналаар биелэх арилжааг хэлнэ.

---

## БАНК, САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

---

### A

Авах-зарах үнийн зөрүү /*Bid-ask spread*/ Гадаад валют, үнэт цаас гэх мэт хөрөнгө оруулалтын активыг худалдан авах болон худалдах үнийн зөрүү. Дилерийн худалдах үнээс худалдан авах үнийг хасч тооцно.

Авлага /*Accounts receivable*/ Төрөл бүрийн ажил, үйлчилгээний үр дүнд бий болсон бусад байгууллага, иргэдээс авах актив буюу хөрөнгө.

Авлага барагдуулагч /*Debt collector*/ Бусдаас авах авлага барагдуулах ажил гүйцэтгэгч хүн.

Авлагын хугацаа хэтрэлт /*Delinquency*/ Өр, авлага хугацаандаа эргэн төлөгдөхгүй байх.

Автоматжуулсан төлбөр /*Automatic bill payment*/ Банк үйлчлүүлэгчийн урьдчилан өгсөн зөвшөөрлийн дагуу түүний данснаас зарим төлбөр тооцоог автоматаар төлөх үйлчилгээ. Тухайлбал, утасны төлбөр, орон сууцны төлбөр гэх мэт.

Агент-ээзэн хоорондын зөрчил /*Agency problem*/ Компани, аж ахуйн нэгжийн өмчлөгч (хувьцаа эзэмшигч), менежер болон зээлдүүлэгч (бонд эзэмшигч) нарын хоорондох сонирхлын зөрчил. Компанийн менежер өмчлөгчдийн эрх ашгийг хамгийн сайнаар хангаж, тэдний төлөө үйлчлэх ёстой байдаг ч энэ нь бодит байдалд хэрэгжихгүй байх тохиолдол байдаг. Тухайлбал, өмчлөгчид ирээдүйд өндөр үр өгөөжтэй төслүүдийг хэрэгжүүлэх сонирхолтой байхад менежерийн хувьд шагнал гэх мэт өөрийн эрх ашигт нийцүүлэн урт хугацаанд үр ашиг муутай ч ойрын ирээдүйд ашиг өгөх төслүүдэд хөрөнгө оруулалт хийхийг илүүд үзэх тохиолдол байдаг. Мөн өмчлөгчид компанийн нөөцийг хамгийн үр ашигтай зарцуулах сонирхолтой байхад менежер нь удирдлага, томилолтын зардлыг нэмэгдүүлэх, оффисоо тохижуулах гэх мэтээр компанийн хязгаарлагдмал нөөцийг үр ашиггүй зарцуулах тохиолдол байдаг.

Ажлын өдөр /Business day/ Олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг ажлын өдөр.

Азийн санхүүгийн хямрал /Asian financial crisis/ Хөрөнгийн үнэ хэт үнэлэгдсэн байж болзошгүй хэмээн болгоомжлон Азийн хэд хэдэн орноос хөрөнгө оруулагчид хөрөнгөө татснаар тус хямрал эхэлжээ. Тайланд, БНСУ, Индонези, Малайз зэрэг улсад дотоодын мөнгөн тэмдэгтийн ханш сулрах, банкнаас хадгаламж зугтах, хувьцааны үнэ унах, компаниуд дампуурах, ажилгүйдэл нэмэгдэх зэрэг сөрөг үр дагавар үүсч байжээ.

Аkkruэл суурьт арга /Accrual basis, system, or method/ Мөнгө хүлээн авсан, эсхүл төлснөөс үл хамааран ажил үйлчилгээний гүйцэтгэлтэй уялдуулан орлогыг олсон, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

Актив /Asset/ Актив гэдэг нь өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болж, байгууллагын мэдэлд орсон бөгөөд ирээдүйд үр өгөөжөө өгөх нөөц, баялаг, хөрөнгө юм.

Актив-пассивын нийцгүй байдал /Asset-liability mismatch/ Банкны ямар нэгэн төрлийн актив тухайн төрлийн пассивтай тэнцэхгүй буюу зөрүүтэй байх тохиолдол. Тухайлбал, банкны хүү олдог актив нь хүү төлдөг пассивтай тэнцэхгүй байх. Мөн богино хугацаат пассиваар урт хугацаат активыг санхүүжүүлэх гэх мэтээр актив-пассивын зөрүүтэй байдал үүснэ.

Актив-Пассивын удирдлага /Asset Liability Management/ Актив пассивын удирдлага гэдэг нь банкны найдвартай, тогтвортой, ашигтай үйл ажиллагааг хангах зорилгод чиглэгдсэн банкны үйл ажиллагааны хамгийн чухал удирдлага юм. Актив, пассивын удирдлага нь банкны хөрвөх чадварыг сайжруулах, хөрөнгөө зохих түвшинд барих асуудлыг шийдвэрлэхэд чиглэгддэг. Энэ нь банкны хөрөнгө оруулалтын багцад багтаж активуудыг хэрхэн сонгох, мөнгөний захаас хэчнээн мөнгө, хэрхэн олох, депозитоо хэрхэн байршуулах, хэзээ, хэдэн төгрөгийн зээл олгох зэрэг асуудлуудыг хамарна.

Актив-Пассивын удирдлагын Хороо /ALCO (Asset Liability Committee)/ Банкны Актив, пассивын удирдлагын хороо гэдэг нь хүүний эрсдэл, хөрвөх чадвар, хөрөнгийн

удирдлагын эрсдэл зэрэг санхүүгийн эрсдэлийг удирдах, банкны хөрөнгийн удирдлага төлөвлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, санхүүгийн төлөвлөгөөт үр дүнд хүрэх стратегийг тодорхойлох, санхүүгийн гүйцэтгэлийг хэлэлцэх үүрэгтэй нэгж юм.

**Активын өгөөж /Return on assets/** Хүүгийн төлбөр болон татварын өмнөх ашгийг нийт хөрөнгөнд харьцуулсан харьцаа бөгөөд тухайн компанийн ашигт ажиллагааг илэрхийлэх үзүүлэлт.

**Активын хуваарилалт /Asset allocation/** Хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлэхдээ хөрөнгийн ерөнхий төрлүүдээс сонголт хийхийг хэлнэ. Тухайлбал, багцын хэдэн хувийг хувьцаанд, хэдэн хувийг бондод, хэдэн хувийг хөрвөх чадвартай хөрөнгөнд байршуулах вэ? гэх мэт.

**Алдагдалтай опцион /Out-of-the money Option/** Зарах опционы хувьд гэрээнд тусгасан активын таслах үнэ (strike price) нь активын зах зээлийн үнээс бага; худалдан авах опционы хувьд таслах үнэ нь зах зээлийн үнээс их бол тухайн опционыг алдагдалтай опцион гэнэ.

**Алдагдлыг хязгаарлах захиалга /Stop-loss order/** Хөрөнгө оруулагчид үүсэх алдагдлыг хязгаарлах зорилгоор үнэт цаасыг тодорхой үнийн түвшинд хүрэх үед зарах тухай хөрөнгө оруулагчаас дилерт өгсөн захиалга.

**АНУ-ын хадгаламжийн бонд /U.S. Savings bonds/** АНУ-ын Сангийн яамнаас иргэдэд зориулан харьцангуй бага нэрлэсэн үнээр гаргаж буй үнэт цаас. Хадгаламжийн бондыг худалдан авч буй хөрөнгө оруулагчид Засгийн газартаа (авсан зээлээ хүүтэй эргүүлэн төлөх амлалтын хариуд) зээл олгож байна гэсэн үг юм. Бондын хүүгийн орлого нь мужийн болон орон нутгийн татвараас чөлөөлөгдсөн байдаг. Хадгаламжийн бондын ард АНУ-ын засгийн газар байдаг тул тус төрлийн бондыг эрсдэлгүй хөрөнгө оруулалт хэмээн үздэг байна.

**Анхдагч зах /Primary market/** Шинэ үнэт цаасыг анх удаа зарж борлуулдаг зах зээл. Хөрөнгө оруулалтын банкууд үнэт цаасыг гаргаж буй компаниудаас нь худалдан авч буссад зардаг.

**Арилжааны банк /Commercial bank/** Арилжааны банкны эрхлэх үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаанаас ялгаатай байдаг. Арилжааны банк нь иргэд, байгууллагаас харилцах, хадгаламж хэлбэрээр эх үүсвэр татах, түүгээр зээл олгох, харилцагчийн төлбөр тооцоог гүйцэтгэх гэх мэт санхүүгийн үйлчилгээ үзүүлж, хүүгийн зөрүүнээс ашиг олдог санхүүгийн зуучлалын байгууллага юм. Манай улсад 2014 оны эхний хагас жилийн байдлаар 13 банк үйл ажиллагаа явуулж байна.

**Арилжааны данс /Trading account/** Данс эзэмшигч нь үнэт цаас худалдан аваад хадгалах зорилгоор бус үнэт цаасны арилжааны зориулалтаар үнэт цаасны дилерт нээсэн банкны уламжлалт харилцах данстай адилаар бэлэн мөнгө, үнэт цаасыг бүртгэдэг данс.

**Арилжааны мэргэжилтэн /Trader/** Зуучлах, ашиг хонжоо хайх, үнийн зөрүүнээс ашиг олох, эрсдэлээс хамгаалах зэрэг зорилгоор хувьцаа, бонд, түүхий эд, дериватив зэрэг санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх хувь хүн, эсхүл хуулийн этгээд.

**Аудит /Audit/** Аливаа аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бичилт болон санхүүгийн тайланг шинжлэн бизнесийн үйл ажиллагаа нь хууль ёсны дагуу явагдаж байгаа эсэх, аж ахуй санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгээ зөв тусгасан эсэхийг шалган дүгнэж, баталгаа гарган сонирхсон хэрэглэгч нарт тайлагнадаг санхүүгийн үйлчилгээ юм.

**Аудитор /Auditor/** Хуульд заасан тодорхой шаардлагыг хангаж, аудитын байгууллагад аудитын үйл ажиллагаа эрхэлж байгаа мэргэшсэн нягтлан бодогчийг хэлнэ.

**Ашгийн өгөөж /Earnings yield/** Энэ нь үнэ, ашгийн (P/E) харьцааны урвуу үзүүлэлт бөгөөд сүүлийн 12 сарын нэгж хувьцаанд ногдох ашгийг нэгж хувьцааны зах зээлийн үнэд харьцуулж тооцно. Хувьцаанд оруулсан нэг төгрөг тутмын хэдэн хувьтай тэнцэх хэмжээний ашгийг тухайн компани олж байгааг харуулна.

**Ашгийн сэдэл /Profit motive/** Мөнгө хуримтлуулах хүсэл эрмэлзэл нь хүмүүсийг бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд хөтлөж буй сэдэл, шалтгаан.

**Ашиг /Profit/** Байгууллагын тодорхой хугацаан дахь үйл ажиллагааны үр дүнгийн мөнгөн илэрхийлэл буюу бизнес эрхэлж, эрсдэл хүлээсний төлөө авч буй үр өгөөж, компанийн нийт орлогоос бүх мөнгөн болон хийсвэр зардлыг хасч тооцно.

**Ашиг хонжоо хайсан арилжаа /Speculation/** Худалдаалагддаг бараа тухайлбал, санхүүгийн хэрэгслийн зах зээлийн үнийн богино, дунд хугацааны хэлбэлзлийн зөрүүнээс ашиг хүртэхийг зорьсон санхүүгийн эрсдэлтэй үйл ажиллагаа. Ихэнх спекуляторууд тухайн үнэт цаасны суурь үнийг бус үнийн хөдөлгөөнийг голлон анхаардаг. Спекуляторууд ихэвчлэн хувьцаа, бонд, түүхий эдийн фьючерс, гадаад валют, уран зураг, цуглувулга, үл хөдлөх хөрөнгө, деривативийн зах зээлд ажилладаг.

**Ашигт үйл ажиллагаанд хүрэх түвшин /Break-even point/** Компанийн зардлаа нөхөн орлогын түвшин. Энэ үед ашиг тэгтэй тэнцүү байна. Зарим тохиолдолд ашигт үйл ажиллагаанд хүрэх түвшин нь компани зардлаа нөхөхийн тулд хэдий хэмжээний бүтээгдэхүүн борлуулах шаардлагатайг илэрхийлнэ.

**Ашигтай опцион /In-the-money Option/** Зарах опционы хувьд гэрээнд тусгасан активын таслах үнэ нь активын зах зээлийн үнээс их, худалдан авах опционы хувьд биелэх үнэ нь зах зээлийн үнээс бага бол тухайн опционыг ашигтай опцион гэнэ.

## Б

**Багц /Portfolio/** Хувь хүн, байгууллагын хадгаламж болон хөрөнгө оруулалтуудын цуглувулга.

**Багцалсан арилжаа /Block sales/** Их хэмжээний хувьцаа болон бондыг багцаар худалдаа арилжаа болон арилжааны захиалга. Тухайлбал, багцалсан арилжаагаар 10 мянган ширхэг хувьцааг нэг багц, эсхүл 200 мянган ам.долларын өртөгтэй бондыг нэг багц болгох зэргээр арилжаалдаг. Хувьцааны ширхэг болон нийт өртөг нь улс бүрийн хувьд өөр байж болно.

Багцын үнэ цэнэ /Portfolio value/ Багцад буй үнэт цаас тус бүрийн одоогийн үнийг тухайн үнэт цаасны тоо хэмжээгээр харгалзан үржүүлж тэдгээрийг хооронд нь нэмснээр гарах үнэ цэнэ.

**Базел 1 /Basel I/** Базел 1-ийн шалгуур үзүүлэлтүүдийг 1988 онд гаргасан бөгөөд энэ нь банкинд учирч болох хүлээгдээгүй алдагдлын үед банкны өөрийн хөрөнгийг хүрэлцээтэй байлгахад чиглэгдсэн. Уг шалгуураар банкны активыг эрсдэлийн 5 бүлэгт (0%, 10%, 20%, 50%, 100%) ангилсан байдаг.

**Базел 2 /Basel II/** 2004 онд Базелийн хорооноос Базел 2 шалгуур үзүүлэлтүүдийг Базел 1-ийг шинэчилсний үндсэн дээр танилцуулсан. Базел 2 нь эрсдэлийг илүү сайн тодорхойлон өөрийн хөрөнгийн шалгуурыг сайжруулах, санхүүгийнхэрэгслийг дэргачуйшинчлэл, өөрчлөлтүүдийг илүү сайн тусгахад чиглэгдсэн. Мөн эрсдэлийг хэмжиж, удирдахад гарч буй ахиц дэвшилийг, идэвхжүүлэх нь шинэ үзүүлэлтүүдийн зорилго юм.

**Базел 3 /Basel III/** Базелийн хорооны Базел 3 шалгуур үзүүлэлтүүдийг 2010-2011 онд хэлэлцэн баталжээ. Тус зөвлөмж нь дэлхийн санхүүгийн хямралтай холбоотойгоор өмнөх санхүүгийн зохицуулалтуудыг өөрчлөн шинэчлэхийн зорьсон бөгөөд өөрийн хөрөнгө, хөрвөх чадварт тавих шаардлагыг чангатгасан байна. Базел 3 шинэ дүрэм журмуудын зорилго нь эрсдэлийн удирдлагыг шат ахиулахад оршино. Базел 3 банкны шинэ стандартыг 2012-2019 оноос эхлэн мөрдөж эхэнэ.

**Базелийн банкны хяналт шалгалтын хороо /Basel Committee/** Базелийн хороо нь 1974 онд гишүүн 10 орны Төв банкны ерөнийлөгч нарын санаачилгаар байгуулагдсан. Уг хорооны зорилго нь тухайн улсын банкны хяналт шалгалтын байгууллагаас том болон жижиг банкуудын аль алинд нь тавих хяналт шалгалтын арга зүйг боловсронгуй болгож хөгжүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд гишүүн болон гишүүн бус улс орнуудад тусламж дэмжлэг үзүүлэх явдал юм.

**Базелийн зөвлөмж /Basel accord/** Банкны зах зээл, үйл ажиллагаа болон өөрийн хөрөнгийн эрсдэлтэй холбоотой “Базелийн банкны хяналт шалгалтын хороо”-ноос санал болгож буй зохистой харьцааны зөвлөмж юм. Энэхүү гэрээ,

зөвлөмж, шалгуур үзүүлэлтүүдийн гол зорилго нь банкинд учирч болох эрсдэлийг давж гарах хэмжээний өөрийн хөрөнгөтэй байлгахад оршино.

**Балансын гадуурхи санхүүжилт /Off balance sheet financing/** Балансын гадуурх санхүүжилт нь компанийн хөшүүргийн харьцааг доогуур түвшинд хадгалах арга юм. Тухайлбал, үндсэн хөрөнгийг үйл ажиллагааны лизингээр ашиглах нь балансын гадуурхи санхүүжилтийн хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд үндсэн хөрөнгийн лизингээр үндсэн хөрөнгө худалдан авах зардал хэмнэгдэж, лизингээр авч буй үндсэн хөрөнгө нь лизинг олгогчийн тэнцэлд бүртгэгддэг. Харин лизинг авагч нь зөвхөн үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой түрээсийн төлбөрийг л компанийн зардалд бүртгэх болно.

**Балансын гадуурхи үйл ажиллагаа /Off balance sheet activities/** Балансын гадуурхи үйл ажиллагаанд тухайн байгууллагын балансад тусгагддаггүй буюу баланс харагддаггүй төрөл бүрийн хэлцэл, үйл ажиллагааг хамруулна. Тухайлбал, банкны хувьд худалдаж авсан болон худалсан санхүүгийн дериватив хэрэгслүүд, зээлийн үнэт цаасжуулалт гэх мэт үйл ажиллагаа нь банкны баланс тусгагдахгүй боловч балансын гадуур бүртгэгдэж, банкны ашигт нөлөөлж байдаг.

**Балансын шилжүүлэг /Balance transfer/** Нэг зээлийн картын үлдэгдэл балансыг өөр зээлийн картанд шилжүүлэх үйлдэл. Банкны үйлчлүүлэгч ихэнхдээ зээлийн хүүг бууруулах зорилгоор үүнийг хийдэг. Өөрөөр хэлбэл, өндөр хүүтэй зээлийн картнаас хямд хүүтэй зээлийн карт руу шилжүүлэг хийнэ.

**Банк хоорондын зах /Inter-bank market/** Банкууд зээлэх, зээлдүүлэх, үнэт цаас авах, зарах гэх мэтээр хоорондоо хэлцэл хийж, богино хугацааны нөөцийн хэрэгцээгээ хангаж буй захыг хэлнэ.

**Банк хоорондын зээл /Inter-bank loan/** Банкууд харилцагчийн гэнэтийн төлбөр тооцоонд зориулж тодорхой хэмжээний бэлэн нөөцийг хадгалж байх шаардлагатай. Хэрэв банкинд харилцагчийн хүлээгдээгүй гүйлгээний шаардлага гарсан бол банк нэмэлт эх үүсвэр олох шаардлагатай болно. Энэ тохиолдолд банкууд богино

хугацаагаар хоорондоо зээл авах, олгох үйчилгээ үзүүлдэг. Банк хоорондын зээлийн хүү нь тухайн үеийн банк хоорондын зах дээрх бэлэн нөөцийн хэмжээ, банкуудын итгэлцлээс хамаарна.

**Банкны ажиллах өдөр /Banking day/** Банкны олон нийтэд үйлчилгээ үзүүлдэг ажлын өдөр.

**Банкны баталгаат өрийн хэрэгсэл /Banker's acceptance/** Харилцагчаас мөнгөний зах дээр гаргасан, банкаар баталгаажуулсан, ирээдүйд тохиролцсон өдөр тодорхой хэмжээний мөнгөн төлбөрийг төлөхөөр амласан богино хугацаат өрийн хэрэгсэл. Банкны баталгаат өрийн хэрэгслийг гадаад худалдаанд ихэвчлэн хэрэглэдэг бөгөөд эзэмшигч нь дуусгавар хугацаа хүртэл эзэмшилгүйгээр хоёрдогч зах дээр нэрлэсэн үнээс хямдруулан зарах боломжтой байдгаараа давуу талтай.

**Банкны данс /Bank account/** Харилцагчийн мөнгийг түүний нэрийн өмнөөс хадгалах банкны арга хэрэгсэл.

**Банкны нөөц /Bank reserves/** Банкуудын Төв банкин дахь харилцах, хадгаламж болон банкуудын касст байгаа нөөцийн нийлбэр (зээл болж гараагүй хэсэг нь).

**Банкны овердрафт /Bank overdraft/** Харилцагчийн банкин дахь дансны үлдэгдэл төлбөр тооцоо хийхэд хүрэлцэхгүй тохиолдолд банк өмнөөс нь төлбөр гүйцэтгэж болдог. Харилцагчийн өмнөөс банкны төлсөн мөнгөн хэмжээ нь "Банкны овердрафт" гэсэн богино хугацаат өр төлбөр болно. Банкны овердрафт нь нэг төрлийн банкны зээлийн үйлчилгээ бөгөөд хүүтэй, эсхүл хүүгүй байж болно.

**Банкны теллер машин /Automated Teller Machine (ATM)/** Хэрэглэгч нууц дугаар бүхий хуванцар картыг ашиглан бэлэн мөнгө авах, мөнгө гүйвуулах зэрэг банкны үйлчилгээг автоматжуулсан хэлбэрээр авч болох төхөөрөмж.

**Банкны үйл ажиллагаа /Banking/** Иргэд аж ахуйн нэгжээс хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлж, иргэд аж ахуйн нэгжүүдэд зээл олгож буй үйл ажиллагаа.

**Банкны үйлчилгээний шимтгэл хураамж /Bank service Charges/** Харилцагч санхүүгийн үйлчилгээ (чекийг мөнгөжүүлэх, овердрафт, ATM, эсхүл банкны зээлийн карт ашигласны төлөө) авсныхаа төлөө банкинд төлбөр.

**Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам /Truth in lending regulation of the Bank of Mongolia/ Тус журмын дагуу банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээний хүү, шимтгэл, хураамжийг нэгдсэн байдлаар, тодорхой стандартын дагуу зээлдэгчид тайлагнахыг шаарддаг. Ингэснээр харилцагч авах гэж буй зээлийн бодит үйлчилж буй хүү, зээлийн бодит өртгийг мэдэх боломжтой болно.**

**Бараа, материал //Inventory/** Хувь хүн, компанийн худалдах зорилгоор олж зээмшсэн бараа, эсхүл борлуулах зориулалт бүхий бүтээгдэхүүн болон түүний үйлдвэрлэлд ашиглах хөрөнгийн зүйлсийг хэлнэ.

**Барилгын зээл /Construction loan/** Бүх төрлийн барилга угсралтын үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа зээл.

**Барьцаа хөрөнгийг борлуулж үүргийн гүйцэтгэл хангуулах шийдвэр /Decree of foreclosure and sale/** Зээлийн өрийн үлдэгдлийг төлүүлэх зорилгоор барьцаанд буй хөрөнгийг зарж борлуулан өр төлбөрийг барагдуулах тухай шүүхийн мэдэгдэл. Жишээ нь, зээлдүүлэгч зээлийн төлбөрийг 6 сар авч чадаагүй тул шүүхэд хандана. Шүүгч нийтэд зарлан мэдэгдсэний дараа барьцаа хөрөнгийг дуудлага худалдаагаар борлуулж зээлийн үндсэн төлбөр, төлөгдөөгүй хүүгийн төлбөр, шүүхийн зардлыг төлөх шийдвэр гаргана.

**Барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах /Foreclosure/** Зээл эргэн төлөгдөх найдваргүй болсон үед барьцаа хөрөнгийг зарж борлуулах замаар зээлийг төлүүлэх хуулийн үйл явцыг хэлнэ.

**Барьцаагүй бонд /Debenture or unsecured bond/** Засгийн газар болон компаниас гаргадаг хамгийн түгээмэл хэлбэрийн бонд юм. Тухайн бондын эргэн төлөлтийг баталгаажуулсан ямар нэгэн барьцаа байдаггүй. Зөвхөн бонд гаргагчийн зээлийн эрсдэл даах чадвар, нэр хүнд зэрэг нь баталгаа болохоос гадна зээлдэгчийн эрсдэл нь бондын хүүгийн хэмжээнд тусгалаа олдог. Эрсдэл өндөртэй зээлдэгчийн гаргасан бонд өндөр хүйтэй байна.

**Барьцаагүй өр /Unsecured debt/** Барьцаагүй өр, тухайлбал, зээлийн карт.

**Барьцаалбар /Pledge certificate/** Хууль ёсны эзэмшигчийн 1) өөр нотолгоо шаардахгүйгээр үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар хангагдсан мөнгөн төлбөрийн үүргийн биелэлтийг хүлээн авах, шаардах эрх, 2) үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийг гэрчилсэн зөвшөөрлийн, биет үнэт цаасыг барьцаалбар гэнэ.

**Барьцааны зүйл /Collateral/** Зээлдэгчийн өр төлбөрийг төлөх, эсхүл амлалтаа биелүүлэх үүрэг хүлээж барьцаа болгосон, өр төлбөрөө төлөөгүй, эсхүл амлалтаа биелүүлж чадаагүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хангах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх.

**Барьцааны нийтлэг эрх /General lien/** Үүрэг гүйцэтгэгчийн тодорхой нэг хөрөнгийн эрх бус түүний өмчилж буй бүх хөрөнгийн эрх. Жишээ нь, Бат З сарын түрээсийн төлбөрөө төлж чадалгүй байрнаасаа гарсан. Дорж түрээслүүлэгч бөгөөд Батын эсрэг шүүхийн шийдвэр гаргуулж, барьцааны нийтлэг эрх олж авна. Хэрэв Бат түрээсийн төлбөрийг төлөхгүй бол Дорж барьцааны тусгай эрхийг авах талаар шүүхэд хандаж, Батын тавилгыг зарж борлуулна.

**Барьцааны эрх /Lien/** Өр төлбөр, шүүхийн шийдвэр, ипотекийн зээл, татварын төлбөрийн барьцаа болох хөрөнгийн эрх бөгөөд шаардах эрхийн нэг төрөл. Барьцааны тусгай эрх нь зөвхөн тодорхой хөрөнгийн эрх бол барьцааны нийтлэг эрх нь үүрэг гүйцэтгэгчийн өмчилж буй бүх хөрөнгийн эрх юм.

**Барьцаатай өр /Secured debt/** Зээлдүүлэгчид хөрөнгө (тухайлбал, орон сууц, машин)-өө барьцаалж авсан зээл.

**Баталгаа /Guarantee/** Зээлдэгч төлбөрийн чадваргүй болох тохиолдолд зээлдэгчийг зээлийн төлөгдөөгүй үндсэн төлбөрөөс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлж, зээлдүүлэгчийн алдагдлыг нөхөх төлбөр.

**Баталгаат чек /Certified check/** Чек бичигчийн гарын үсэг үнэн болох, дансанд нь хангалттай мөнгө байгаа талаар банкнаас баталгаа гаргасан чекийг хэлнэ.

**Батламж /Deed/** Аливаа сонирхол, эрх, эсхүл хөрөнгийн эрхийг баталгаажуулсан, гарын үсэг зурсан, тамга тэмдэг дарсан, бичгээр үйлдсэн хууль эрх зүйн баримт бичиг.

**Батлан даагч /Guarantor/** Зээлдэгч өрөө төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн өмнөөс өрийг төлөхийг зөвшөөрсөн талыг хэлнэ.

**Бета коэффициент /Beta/** Тухайн компанийн, эсхүл хөрөнгө оруулалтын багцын бета коэффициент нь тухайн хувьцаа, эсхүл багцын хэлбэлзэл (эрсдэл) нь зах зээлийн хэлбэлзэл (эрсдэл)-тэй харьцуулахад ямар байгааг харуулна. Хэрэв тухайн хувьцааны бета нэгээс их (бага) бол уг хувьцаа нийт зах зээлээс илүү өндөр (бага) хэлбэлзэлтэй болохыг илэрхийлнэ. Тухайлбал, А компанийн бета 1.1 гэвэл онолын хувьд уг хувьцаа нийт зах зээлээс 10%-иар өндөр хэлбэлзэлтэй гэж ойлгоно.

**Биет бус өртөг /Intangible value/** Компанийн биет бус хөрөнгийн үнэ цэнэ.

**Биет бус хөрөнгийн хорогдуулалт /Amortisation/** Биет бус хөрөнгийг ашиглалтын хугацааны туршид бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаатай нь уялдуулан хорогдуулах.

**Биет бус хөрөнгө /Intangible assets/** Үндсэн хөрөнгөтэй адил биетээр, бодитоор оршдоггүй хэдий ч эзэмшигчидээ давуу тал болон давуу эрхийг олгодог патент, лиценз, зохиогчийн эрх, барааны тэмдэг, нэр төр, гүдвил гэх мэт удаан хугацаанд үнэ цэнэтэй байх актив (хөрөнгө)-ыг хэлнэ.

**Биет бус хөрөнгө /Intangible property/** Компани, хувь хүн өмчлөх эрхийг нь эзэмшдэг, уг өмчлөх эрхийг бусдад шилжүүлж болдог, газар, барилга зэрэг биет хөрөнгөөс ялгаатай биет бус үнэт зүйл. Патент, худалдааны тэмдэг, зохиогчийн эрх, бизнесийн аргачлал зэрэг оюуны өмч, гүдвил, барааны тэмдэг зэрэг нь зах зээлд түгээмэл байдаг биет бус хөрөнгө юм.

**Биет капитал /Physical capital/** Машин, байшин барилга, компьютер зэрэг үйлдвэрлэлд хэрэглэгддэг хөрөнгө.

**Биет хөрөнгө /Tangible property/** Хүрч болохуйц биет хэлбэртэй аливаа үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө. Жишээ нь, орон сууц, ферм, тавилга зэрэг нь биет хөрөнгүүд юм.

**Бином загвар /Binomial model/** Опционы үнэлгээний загвар. Энэ загвараар опционы гэрээнд тусгагдсан

хэрэгслийн үнэ ойрын хугацаанд тодорхой магадлалтайгаар зөвхөн 2 өөр утга руу өөрчлөгдөнө гэж үздэг.

**Биржийн бус зах** /Over-the-counter market/ Зохион байгуулагдсан биржээр арилжаалагддаггүй санхүүгийн хэрэгслүүдийн зах. Энэ зах дээрх арилжаа нь цахим системээр дамжин дилерүүдийн хооронд болон дилер үйлчлүүлэгчийн хооронд хийгдэнэ. Дилерүүд нь авах болон зарах үнийг тогтоо замаар захыг тодорхойлогчийн үүрэг гүйцэтгэнэ. Энэ зах дээр хоёр талын хэлцлийн үнэ, хэмжээг гуравдагч этгээдэд мэдэгдэх албагүй тул харьцангуй ил тод биш гэж үздэг.

**Блак-Шолесын томьёо** /Black-Scholes formula/ Опционы үнэлгээний нэг загвар. Опционы үнийг хувьцааны одоогийн үнэ, таслах үнэ, эрсдэлгүй хүү, гэрээний хугацаа, хувьцааны өгөөжийн хэлбэлзэл (стандарт хазайлт) зэргийг ашиглан тооцно.

**Блю чип хувьцаа** /Blue chip stocks/ Үрт, удаан хугацаанд ашигтай ажиллаж буй, олон нийтэд нэгэнт танигдсан, итгэлийг нь хүлээсэн үндэсний хэмжээний томоохон компаниудын хувьцаа. Блю чип гэдэг нь покер хөзрийн тоглоомын хамгийн үнэтэй хасааны нэр юм.

**Богино позици** /Short position/ Үнэт цаас, түүхий эд, гадаад валют зэрэг хөрөнгийг ирээдүйд тогтоосон хугацаанд шилжүүлэх үүрэг хүлээсэн хөрөнгө оруулагчийн позици.

**Богино позицийг хаах** /Short covering/ Өмнө нь зээлээр авч зарсантай ижил төрлийн үнэт цаас, түүхий эд, гадаад валют зэрэг хөрөнгийг худалдан авч, шилжүүлэн нээлттэй байгаа bogino позицийг хаах. Өмнө нь зээлээр авч зарсан үнээс доогуур үнэрээр bogino позицийг хаах тохиолдолд зээлээр борлуулалт хийх үйл ажиллагаанаас ашиг олно.

**Богино хугацааны зорилт** /Short-term goal/ Хувь хүн, байгууллагын нэг жилийн дотор хүрэхээр төлөвлөсөн зорилт.

**Богино хугацаат хөрөнгийн орлого** /Short-term capital gain/ Ихэвчлэн 12 сараас bogino хугацаагаар эзэмшсэн хөрөнгийг боруулснаас бий болсон орлого. Татвар төлөгчийн bogino хугацаат хөрөнгийн ашиг, алдагдлыг

нэгтгэж, цэвэр дүнг урт хугацаат хөрөнгийн орлогын цэвэр дүнтэй нэгтгэж тооцдог.

**Бодит ашиг /Realized gain/** Ахь худалдаж авсан үнээс өндөр үнээр актив хөрөнгийг борлуулснаас олох ашиг.

**Бодит нийлмэл өгөөж /Realized compound return/** Купоны төлбөр төлөгдөх үед түүнийг тухайн үеийн зах зээлийн хүүгээр бондын хугацаа дуусах хүртэл дахин хөрөнгө оруулалт хийхээр тооцсон өгөөж.

**Бодит өгөөжийн хувь /Real rate of return/** Инфляци болон бусад гадаад хүчин зүйлсийн нөлөөллийн улмаас бий болсон үнийн өөрчлөлтөөр тохируулга хийгдсэн хөрөнгө оруулалтын бодит өгөөжийн хувь. Жишээ нь, хадгаламж дахь мөнгөндөө жилийн 9 хувийн хүүгийн орлого олдог. Энэ үед инфляци 5 хувь байсан бол хадгаламжийн бодит өгөөжийн хувь 4 хувь байна. Өөрөөр хэлбэл, хадгаламж дахь мөнгөний худалдан авах чадвар бодитоор жилд 4 хувиар өссөн гэсэн үг.

**Бодит үйлчилж буй нийт орлого /Effective gross income/** Тухайн хөрөнгийн олох орлого, бусад нэмэлт орлогийн нийлбэрээс ашиглаагүй хоосон байлгасан болон цуглуулах зардлыг хассан орлого. Жишээ нь, орон сууцыг бүрэн түрээсэлбэл 5 сая төгрөгийн орлого олох боломжтой. Уг сууцыг бүрэн түрээсэлж чадахгүй сул байлгах магадлал 20%. Өөрөөр хэлбэл, (5 сая\*20%) 1 сая төгрөгийн орлого алдах магадлалтай. Уг хөрөнгийн бодит үйлчилж буй орлого 4 сая (5 сая-1 сая) төгрөг.

**Бодит үйлчилж буй хүү /Effective interest rate/** Хүү бodoх давтамжийн нөлөөг оруулсны дараах зээлд төлж буй, эсхүл хөрөнгө оруулалтанд авч буй хүү. Бодит үйлчилж буй хүү нь зээлийн нэрлэсэн хүүгээс өндөр байдаг. Нөгөө талаас нийлмэл хүүтэй санхүүгийн бүтээгдэхүүний бодит хүүгийн өгөөжийг харуулсан үзүүлэлт юм. Энэ тохиолдолд бодит үйлчилж буй хүүг  $r = (1 + \frac{i}{n})^n - 1$  томъёогоор тооцно. Үүнд,  $r$  бодит үйлчилж буй хүү,  $i$  зарласан хүү,  $n$  нийлмэл хүү бodoх давтамж. Тухайлбал, хадгаламжийн хувьд нийлмэл хүүгийн аргачлалаар хүүгээ тооцдог бол бодит үйлчилж буй хүү нь хадгаламжийн нэрлэсэн хүүгээс өндөр байдаг. Жишээ нь, хадгаламжийн хүү жилийн 12%, улирал тутам хуримтлуулж тооцно гэвэл бодит үйлчилж буй хүү нь 12.55% болно.

**Бодит үнэлгээ (компанийн) /Intrinsic value (of firm)/** Компанийн бизнестэй холбоотой бүхий л хүчин зүйлсийг харгалзан ирээдүйн мөнгөн хөрөнгийн ургасалын өнөөгийн цэвэр үнэ цэнийг тооцож гаргасан компанийн бодит үнэлгээг хэлнэ. Энэ нь зах зээлийн одоогийн үнээс их, эсхүл бага гарч болно.

**Бодит цагийн горимоор төлбөр тооцоо хийх /Real time gross settlement/** Төв банкин дээр төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхдээ дебит, кредит гүйлгээг цэвэрлэсэн дүнгээр бус нийт дүнгээр төлбөр тооцоог бодит цагийн горимоор гүйцэтгэх. Энэ нь ихэвчлэн их дүнтэй төлбөр тооцооны систем байдаг бөгөөд өдрийн эцэст бус өдрийн турш банк хоорондын төлбөр тооцоог хийснээрээ төлбөр тооцооны эрсдэлийг бууруулдаг.

**Болзошгүй авлага /Contingent claim/** Өнгөрсөн хугацаанд болсон ямар нэгэн үйл явдалтай холбоотойгоор ирээдүйд үүсч болзошгүй авлага. Өөрөөр хэлбэл, авлага үүсгэж болох эрх юм. Болзошгүй авлага нь санхүүгийн тэнцэлд шууд тусгагдахгүй боловч тайлангийн нэмэлт тэмдэглэгээнд тусгагдсан байдаг. Мөн авлагын дүн нь тухайн цагт тодорхой биш бөгөөд холбоотой активын үнэлгээнээс хамааран өөрчлөгдж байдаг.

**Болзошгүй өр төлбөр /Contingent liabilities/** Бизнесийн үйл ажиллагааны явцад урьд өмнөх хийж гүйцэтгэсэн ажил үйлчилгээнээс ирээдүйд гарч магадгүй гарзаас үүсэх өр төлбөрийг урьдчилан тооцож бүртгэлд тусгахыг болзошгүй өр төлбөр гэнэ.

**Боломжит үлдэгдэл /Available balance/** Дансын боломжит үлдэгдэл нь дансан дахь бэлэн мөнгөний үлдэгдлээс дансын доод үлдэгдэл, хараахан төлөгдж дуусаагүй байгаа гүйлгээний дүн зэргийг хассан дүн юм.

**Бонд /Bond/** Бонд нь зээлдэгчийн өртэй болохыг баталсан үнэт цаас юм.

**Бондыг хуваах /Bond stripping/** Бондын купоны (хүүгийн) болон үндсэн төлбөрийг хямдруулан хоёр тусдаа үнэт цаас болгон борлуулахыг хэлнэ.

**Бондын гэрээ /Bond indenture/** Бонд гаргагч (зээлдэгч) болон бонд худалдан авагч (зээлдүүлэгч, хөрөнгө оруулагч)-

ийн хооронд байгуулсан гэрээ. Уг гэрээгээр бондын хугацаа, бондын хүү, хугацаанаас өмнө дуудах эрхтэй эсэх, хүү бodoх аргачлал, купоны төлбөр хийх хугацаа гэх мэт бондтой холбоотой бүхий л зүйлийг тодорхойлдог.

**Бондын зах /Bond markets/** Өрийн бичиг арилжаалагдаж буй санхүүгийн захыг бондын зах гэдэг. Шинээр өрийн бичиг гаргаж байгаа бол анхдагч, өмнө гаргасан өрийн бичгийг өмнөх худалдан авагчаас дараагийн худалдан авагч худалдан авч буй бол бондын хоёрдогч зах гэнэ. Мөн Засгийн газрын болон компанийн бондын зах гэж ангилацаг.

**Бондын урсгал өгөөж /Current yield of bond/** Бондын купоны орлогыг бондын зах зээлийн үнэд харьцуулж тооцно. Энэ нь хөрөнгө оруулагч өнөөдөр бонд худалдан аваад дараагийн бондын төлбөр авах хүртэлх хугацаанд хадгалвал ямар өгөөж олох вэ? гэдгийг харуулна. Гэхдээ хугацааны эцэст бондын үнэ өөрчлөгдөх тул нарийн хэмжүүр болж чаддаггүй. Хэрэв бондын үнэ өсвөл үнийн ашиг хүртэнэ, харин үнэ унавал үнийн алдагдал хүлээнэ.

**Бондын эквивалент өгөөж /Bond equivalent yield/** Бондын жилд шилжүүлсэн өгөөж. Энэ нь богино хугацаат хямдруулсан үнэт цаас болон бондын өгөөжийг бусад урт хугацаат үнэт цаасны өгөөжтэй харьцуулах боломжийг олгоно. Тухайлбал, 8%-ийн өгөөжтэй 2 жилийн хугацаатай купон төлдөг бонд, 3 сарын хугацаатай 100 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 97.5 мянган төгрөгийн хямдруулсан үнэтэй тэг купонтой бондын аль нь илүү өгөөжтэй вэ? гэсэн асуултад хариулахын тулд бондын эквивалент өгөөжийг тооцох хэрэгтэй. Хямдруулсан бондын 3 сарын өгөөж нь  $(100-98)/98=2.04\%$  байна. Харин жилд шилжүүлсэн өгөөж нь  $2.04\%*(365/90)=8.28\%$  болж байна. Иймээс хүү тогтмол гэж үзвэл хямдруулсан үнэт цаас нь илүү өгөөжтэй байна.

**Бондын эргэн төлөгдөх дундаж хугацаа/Duration (Macaulay's)/** Бондын төлбөр бүрийн өнөөгийн үнэ цэнээр бондын төлбөр хийгдэх хугацаа бүрийг жигнэж бондын төлбөрийн дундаж хугацааг тооцно.

$$MD = \frac{\sum_{i=1}^n \frac{t \cdot C}{(1+i)^t} + \frac{n \cdot F}{(1+i)^n}}{P}; \text{ Энд нь эргэн төлөгдөх дундаж хугацаа, } t \text{ нь хугацаа, } i \text{ нь өгөөж, } C \text{ нь купоны төлбөр, } n \text{ төлбөр}$$

хийгдэх тоо,  $F$  нь нэрлэсэн үнэ,  $P$  нь зах зээлийн үнэ. Тэг купон буюу хямдруулсан бондын эргэн төлөгдөх хугацаа нь бондын төлбөрийн дундаж хугацаатай ижил байдаг. Харин бусад купон бондын хувьд эргэн төлөгдөх хугацаа нь төлбөрийн дундаж хугацаанаасаа ямагт урт байна.

**Борлуулалт /Sale/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг мөнгөөр солилцох үйл явц.

**Борлуулалтын орлого /Sales revenue/** Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч буй хэрэглэгчдээс авах мөнгө (ашиг биш).

**Борлуулалтын өгөөж /Return on sales/** Компанийн үйл ажиллагааны үр ашгийг үнэлэх хэмжүүр. Мөн борлуулалтын өгөөжийг үйл ажиллагааны ахиуц ашиг гэж нэрлэдэг бөгөөд дараах томьёогоор тооцдог:

$$X = \frac{x_{yy} \text{ болон татварын өмнөх цэвэр орлого}}{\text{Борлуулалт}},$$

Энэхүү харьцаа нь тухайн компанийн нэгж борлуулалт хэдий хэмжээний ашиг бий болгож байгааг харуулах бөгөөд уг харьцаа өсөх нь компанийн үр ашигтай өсөлтийг харуулж байгаа бол буурах нь компанийн санхүүгийн байдалд хүндрэл учирч болзошгүйг харуулна.

**Борлуулалтын татвар /Sales tax/** Бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулсан үнийн тодорхой хувиар илэрхийлэгдэх татвар буюу бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах үед Засгийн газарт төлөх төлбөр.

**Борлуулсан барааны өртөг /Cost of sales, Cost of goods sold/** Тайлант үед борлуулсан барааны өртгийг хэлнэ. Борлуулсан барааны өртгийг агуулахад байгаа барааны эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдлийг хасч тайлант үед худалдан авсан барааны өртгийг нэмж тооцно.

**Босоо нэгдэлт /Vertical merger/** Тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч компани нь орц, түүхий эд нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэгч, борлуулагч компанийтай нэгдэж нийлэх үйл явц.

**Брокер /Broker/** Хөрөнгө оруулагчийн захиалгаар үнэт цаас, түүхий эд, гадаад валют зэрэг хөрөнгийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа явуулж, зуучилсны хариуд тодорхой хэмжээний шимтгэл авч байдаг хувь хүн, хуулийн этгээд.

**Брокерийн зах /Brokered market/** Дилерийн зах дээр дилер өөрөө санхүүгийн хэрэгслийг худалдан авч, цааш нь дамжуулан зарах үүрэг гүйцэтгэдэг. Харин брокер санхүүгийн хэрэгслийг өөрөө худалдаж авахгүй бөгөөд зөвхөн худалдагч, худалдан авагч хоёрыг олж, зуучлах үүрэг гүйцэтгэнэ.

**Брэнд /Brand/** Тухайн бүтээгдэхүүнийг бусад компанийн ижил төсөөтэй бүтээгдэхүүнээс ялгахын тулд хэрэглэж буй худалдааны нэр.

**Буцаагдсан чек /Bounced check/** Чек бичигчийн дансны үлдэгдэл хүрэлцээгүйн улмаас төлбөр тооцоо нь хийгдэлгүйгээр чек бичигч рүү торгуулийн хамтаар буцаагдсан чекийг хэлнэ.

**Буцаалт /Rebate/** Нэгэнт төлөгдсөн аливаа зүйлийн төлбөрөөс хөнгөлөлт үзүүлж хасах, эсхүл буцаан олгох замаар төлж буй дүн. Энэ нь борлуулалтын урамшууллын нэг төрөл юм.

**Буцаан дуудах өдөр хүртэлх өгөөж /Yield to call/** Худалдан авч, эзэмшиж буй үнэт цаасны дуусах хугацаанаас нь өмнө буцаан дуудах өдөр хүртэлх өгөөж. Энэхүү өгөөжийг купоны хэмжээ, эзэмшсэн хоног, зах зээлийн үнэ зэрэгт үндэслэн тооцно.

**Буцаан худалдан авах гэрээ /Buy-back agreement/** Хөрөнгийг худалдаж буй этгээд тохиролцсон хугацааны эцэст гэрээнд тогтоосон үнээр уг хөрөнгийг худалдан авагчаас буцаан худалдан авахыг зөвшөөрч байгуулсан худалдагч, худалдан авагчийн хоорондын гэрээ. Уг гэрээг репо гэрээтэй харьцуулан доорх хүснэгтэнд харуулав.

Репо гэрээ	Буцаан худалдан авах гэрээ
1 Нэг гүйлгээ	Худалдах, худалдан авах - хоёр гүйлгээ
2 Худалдагч, худалдан авагчийн хооронд ерөнхий гэрээ хийхийг шаарддаг	Хууль зүйн аливаа бичиг баримт шаардахгүй
3 Гэрээний хугацаанд төлөгдөх купоны төлбөрийг худалдагч авна	Гэрээний хугацаанд төлөгдөх купоны төлбөрийг худалдан авагч авна

**Буцаах эрхтэй бонд /Put bond/** Бонд эзэмшигч нь бондын төлөгдөх хугацаанаас өмнө бонд гаргагчид үнэт цаасыг буцаан худалдах эрхтэй бонд. Буцаан худалдан авах үнэ нь үнэт цаасыг гаргах үед тодорхойлогддог бөгөөд ихэвчлэн нэрлэсэн үнэ байдаг.

**Бүртгэлгүй хувьцаа /Unlisted stock/** Хөрөнгийн биржийн бус арилжаагаар арилжигддаг санхүүгийн хэрэгсэл.

**Бүртгэлийн алдагдал /Accounting loss/** Нийт мөнгөн зардал нь нийт мөнгөн орлогоос давах үед үүсэх алдагдал.

**Бүртгэлийн ашиг /Accounting profit/** Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудын дагуу тооцсон компанийн нийт ашиг (бизнес эрхлэхэд гарсан мөнгөн зардлыг оруулж тооцно). Бүртгэлийн ашиг нь эдийн засгийн ашгаас ялгаатай. Тухайлбал, бизнес хийх зорилгоор 100 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 120 сая төгрөгийн орлого олсон гэвэл бүртгэлийн ашиг нь 20 сая төгрөг болно. Харин эдийн засгийн ашгийг тооцно гэвэл хийсвэр зардлыг мөн хамруулах шаардлагатай болно. Жишээ нь, бизнес эрхлэхийн оронд хөлсний ажил хийж олох байсан 50 сая төгрөгийн алдагдсан боломжийн өргтийг хамруулсан тохиолдолд эдийн засгийн алдагдал нь 30 сая төгрөг болохоор байна (120 сая ₮ -100 сая ₮-50 сая ₮).

**Бүртгэлийн болон зах зээлийн үнийн харьцаа /Book-to-market ratio/** Компанийн бүртгэлийн үнийг компанийн зах зээлийн үнэд харьцуулж тооцно. Харьцаа нь тухайн компанийн хувьцаа хэт, эсхүл дутуу үнэлэгдсэн эсэхийг тодорхойлох нэг оролдлого юм. Энгийнээр авч үзвэл, уг харьцаа 1-ээс их (бага) бол дутуу (хэт) үнэлэгдсэн гэж үзэж болно.

**Бүртгэлийн үнэ /Book value/** Нийт активаас нийт пассивыг хасч тооцно. Актив болон пассивын үнэ цэнийг тодорхойлоходоо санхүүгийн тайланд бүртгэгдсэн үнийг ашигладаг тул компанийн зах зээлийн бодит үнэлгээг илэрхийлэхгүй.

**Бүртгэлийн цэвэр үнэ /Net book value/** Компанийн тэнцэл дэх активуудын нийт үнээс нийт элэгдлийг хасч тэнцлийн цэвэр үнийг тооцно.

**Бүртгэлтэй бонд /Registered bond/** Өмчлөгчөөр бүртгүүлсэн бонд. Өмчлөгчийн нэр, хаягийн талаарх мэдээллийг хавтас хэрэгт бичиж, хадгалах бөгөөд ингэснээр бондын купоны төлбөрийг холбогдох өмчлөгчид төлөх боломжтой болно.

**Бүрэн тайлагнал (тодруулга хийх) /Full disclosure/** Бүртгэгдсэн компаниудыг одоогийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой баримт материалаа нийтэд ил тод мэдээлэхийг шаардсан эрх бүхий байгууллагын шаардлага.

**Бүрэн хорогдох зээл /Fully amortized loan/** Зээлийн хугацааны туршид эргэн төлөх хуваарийн дагуу зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хэсэгчлэн төлснөөр хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусах зээл.

**Бэлэн мөнгө /Cash/** Цаасан, эсхүл зоосон хэлбэрээр байгаа мөнгө (чек, зээлээс ялгаатай).

**Бэлэн мөнгө бий болгох дахин санхүүжилт /Cash-out refinance/** Шинээр авах ипотекийн зээлийн хэмжээ одоо байгаа ипотекийн зээлийн үлдэгдэл болон зээл олгохтой холбоотой гарсан зардлын нийлбэрээс илүү байх ипотекийн зээлийн дахин санхүүжилт. Бэлэн мөнгө бий болгох дахин санхүүжилтийн зорилго нь зээлдэгчийн орон сууцнаас мөнгөн хөрөнгө бий болгох бөгөөд энэ нь орон сууцны өөрийн хөрөнгийн зээлийн нэг хувилбар юм.

**Бэлэн мөнгө гаргасны шимтгэл /Cash advance fee/** Харилцагч ATM болон банкны ажилтнаар дамжуулан өөрийн данснаас бэлэн мөнгө гаргаж авсны шимтгэлийг банкинд төлдөг.

**Бэлэн мөнгөөр хаах /Cash settlement/** Зарим фьючерс нь гэрээнд тусгагдсан активыг хүргэх үүргийг хүлээдэггүй бөгөөд хугацааны эцэст ашиг, алдагдлаа тооцон бэлэн мөнгөөр гэрээгээ хаах боломжтой байдаг. Тухайлбал, А компани 3 дугаар сард 1000 ам.доллараар алт зарах фьючерс гэрээ худалдаж авсан гэж үзье. Гэрээний хугацаа 3 дугаар сард дуусахад алтны спот үнэ 1050 ам.доллар болсон бол А компани 50 ам.долларын алдагдлаа гэрээ худалдан авагчид төлнө. Харин алтаа хүргэж өгөх албагүй байж болно.

**Бэлэн мөнгөтэй адилтгах актив /Cash equivalent assets/** Үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөнд шууд хөрвөх нэгээс гурван сарын хугацаатай хөрөнгө оруулалт юм.

**Бэлэн орлого /Disposable income/** Татвар, нийгмийн даатгалын шимтгэл, бусад шимтгэл, хураамжийг төлсний дараа хуриамтлах, эсхүл зарцуулахад бэлэн орлого.

## В

**Валютын ханшийн эрсдэл /Currency risk, Foreign exchange risk/** Валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн өр төлбөрийн хэмжээ өсөх, хөрөнгө оруулалтын өгөөж буурах, алдагдал хүлээх, багцын үнэ цэнэ буурах зэргийг валютын ханшийн эрсдэлд хамааруулж ойлгоно. Тухайлбал, ам.доллараар орон сууцны зээл авсан бол төгрөгийн ханш супарснаар сарын төлбөрийн хэмжээ нэмэгдэнэ. Мөн хөрөнгө оруулагч ам.доллараар хадгаламж байршуулсан үед төгрөгийн ханш чангарвал уг хадгаламжийн төгрөгөөр илэрхийлсэн үнэ цэнэ буурна. Энэ нь хүүгийн орлогоос бий болох ашгийг бууруулна. Жишээ нь, ам.долларын орон сууцны зээл авсан эээлдэгч сард 500 ам.долларын төлбөр төлдөг гэвэл төгрөгийн ханш ам. долларын эсрэг супарч 1500 төгрөгөөр 1600 төгрөг болоход сарын төлбөрийн хэмжээ 750,000 төгрөгөөс 800,000 төгрөг болж, 50,000 төгрөгөөр өснө.

**Вексель /Promissory note/** Төлбөр хариуцагчаас тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг тогтоосон хугацаанд ямар нэгэн нөхцөл болзолгүйгээр вексель эзэмшигчид төлөхийг харилцан тохиролцож баталсан төлбөр тооцооны үнэт цаас.

**Вестерн Юнион /Western union/** Мөнгө гүйвуулах, хүлээх авах мөнгөн гүйвуулгын сүлжээ.

**Гадаад ацаглаа (Оффшоринг, Аутсорсинг) /Offshoring, Outsourcing/** Компани үйлдвэрлэлийн зарим хэсгийг өөр улсад байршуулан, хямд ажиллах хүчин хөлслөх замаар зардлаа хямдруулах явдал.

## Г

**Гадаад валютын зах буюу ФОРЕНКС зах /Foreign exchange market/** Гадаад валют арилжаалагдаж, эрэлт, нийлүүлэлт нь валютын ханшийг тодорхойлж буй санхүүгийн захын нэг төрөл юм.

**Гадаад валютын своп /Foreign exchange swap/** Тодорхой хугацааны дараа буцаан солилцох нөхцөлтэйгээр хоёр талын хооронд хийгдсэн нэг валютыг түүнтэй дүйцэхүйц хэмжээний өөр нэг валютаар солилцох гэрээ.

**Гарын үсгийн баталгааны маягт /Signature card/** Санхүүгийн байгууллагад хадгалагдаж буй хувь хүний гарын үсгийн жишээг агуулсан баримт. Сэжигтэй тохиолдолд гарын үсгийг баталгааны маягтын гарын үсэгтэй тулгаж харьцуулна.

**Геометр дундаж /Geometric average/** Тоон олонлогийн дундаж утгыг хэмжих математикийн арга. Тоон утгуудын үржвэрээс н зэргээр язгуур авч геометр дундажыг олно.

$$\bar{x} = \sqrt[n]{x_1 \cdot x_2 \cdot x_3 \cdot \dots \cdot x_n}$$

**Гүдвил /Goodwill/** Хэрэв худалдан авч буй компанийн төлсөн мөнгө нь худалдагдаж буй компанийн цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнээс их байвал уг зөрүүг гүдвил гэж нэрлэнэ. Эсрэг тохиолдолд буюу цэвэр хөрөнгийн бодит үнэ цэнэ нь худалдан авч буй компанийн төлсөн мөнгөнөөс их байвал уг зөрүүг сөрөг гүдвил гэж нэрлэнэ. Тухайлбал, нэр хүнд, технологи, үйлчүүлэгчдийн хүрээ зэрэг нь гүдвил бөгөөд биет бус активт хамруулж бүртгэдэг.

**Гүдгэр шинж чанар /Convexity/** Бондын багцын зах зээлийн эрсдэлийг хэмжиж, удирдахад ашиглагддаг эрсдэлийн удирдлагын хэрэгсэл. Гүдгэр шинж чанар нь бондын үнэ болон өгөөжийн шугаман бус хамаарлыг харуулсан хэмжүүр.

**Гэрээ зөрчих /Breach of contract/** Хуулийн дагуу хийсэн гэрээний нөхцөлийг зөрчих буюу гэрээний үүргийг биелүүлэхгүй байх. Гэрээний нөхцөлийг зөрчих нь эсрэг талдаа гэрээг цуцлах, хохирлыг барагдуулж, гэрээний гүйцэтгэлийг хангуулах талаар шүүхэд хандах үндэслэл болдог.

## Д

**Даатгагдсан хадгаламж** //*Insured Deposits*/ Хадгаламжийн даатгалын корпорациар даатгагдсан банкин дахь мөнгөн хадгаламжийг хэлнэ.

**Даатгал** //*Insurance*/ Даатгалын компаниас эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд хохирол учирвал нөхөн төлбөр олгох баталгаа. Иргэд зохих хураамж төлснөөр энэхүү баталгааг худалдаж авна. Даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжлэх иргэд харьцангуй цөөн гарах тул даатгуулагчдын эрсдэлийг тархаах боломжтой байдаг.

**Даатгалын гэрээт төлбөр** //*Annuity*/ Даатгуулагч болон даатгалын компанийн хооронд байгуулж буй даатгалын гэрээний дагуу даатгуулагч тодорхой хугацааны турш тогтсон хэмжээний төлбөрийг даатгалын компанид төлнө. Харин даатгалын компани ирээдүйн тодорхой хугацаанаас эхлэн даатгуулагчид хуримтлуулсан дүнгээс хамааруулан эргүүлэн төлбөр төлөх болно. Тухайлбал, тэтгэврийн даатгалын хувьд даатгуулагч тэтгэвэрт гарах хүртлээ даатгалын компанид төлбөр төлж, тэтгэвэрт гарснаас хойш тухайн компаниасаа тэтгэвэр авна.

**Даатгалын хамрах хүрээ** //*Insurance coverage*/ Даатгалын үйлчилгээгээр дамжуулан хувь хүн, эсхүл хуулийн этгээдийн өр төлбөр, эрсдэлийг хааж буй хэмжээ.

**Даатгалын хураамж** //*Premium*/ Эрсдэл учирсан тохиолдолд хохирлоо барагдуулахын тулд төлж буй төлбөр.

**Давагдашгүй хүчин зүйл** //*Force majeure*/ Гэрээний үүргийг цаг хугацаанд нь биелүүлж чадахгүйд хүргэх зайлсхийх боломжгүй шалтгаан. Тухайлбал, газар хөдлөлт, төрийн эргэлт гэх мэт.

**Давтамжит хүү** //*Periodic rate*/ Зээл болон хөрөнгө оруулалтын тодорхой хугацааны үе тутмын хүү юм. Тухайлбал, жилийн хүү, улирлын хүү, сарын хүү гэх мэт. Хүүг жилээс богино хугацаанд хуримтлуулдаг бол жилийн хүүг дамтамжит хүүнд шилжүүлнэ. Тухайлбал, хүүгийн орлогыг улирал тутамд хуримтлуулдаг бол жилийн хүүг улирлын хүүнд шилжүүлсэний дараа хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцно.

**Давуу эрхтэй өр /Senior debt/** Бусад өр төлбөрөөс тэргүүн ээлжинд буцаж төлөгдөх өр. Ихэвчлэн тэргүүн ээлжинд барьцаа хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэх эрхтэй байдаг.

**Давуу эрхтэй хувьцаа /Preferred stock/** Ашиг хуваарилах болон компани татан буугдах үед эзэмшигчдээ давуу эрх олгодог хувьцааг хэлнэ. Давуу эрхтэй хувьцаа нь саналын эрхгүй боловч энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж тогтмол хэмжээний ашиг хүртэх боломжийг олгодог. Мөн давуу эрхтэй хувьцаа эзэмшигч нь компани татан буугдах нөхцөлд энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж өөрт ногдох хөрөнгөө гаргуулж авах эрхтэй байдаг.

**Давхар бичилт /Double-entry accounting/** Аливаа санхүүгийн гүйлгээ нь заавал хоёр дансанд бүртгэгдэх шаардлагатай. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тэнцэтгэл (Хөрөнгө=Өр төлбөр+Эзэмшигчдийн өмч) хангах нөхцөл болно.

**Давхар татвар /Double taxation/** Нэг орлогод хоёр үе шаттай ногдуулах албан татвар. Жишээ нь, А компани 25 сая төгрөгийн цэвэр орлоготой ажилласан бөгөөд 5 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлж, үлдсэн 20 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилсан. Хувьцаа эзэмшигчид нь ногдол ашгийн орлогын албан татварт 8 сая төгрөг төлсөн. Тиймээс А компанийн орлогод давхар татвар оногдуулсан гэсэн үг юм.

**Далан хоёрын дүрэм /Rule of 72/** Хөрөнгө оруулалт нь хоёр дахин нэмэгдэхэд хэдэн жил хэрэгтэйг тодорхойлох математикийн дүрэм. Жилийн тоог олоходоо 72-ыг жилийн өгөөжийн түвшинд харьцуулна. Тухайлбал, 8 хувийн хүйтэй хөрөнгө оруулалтын хэмжээ нь  $72/8$  буюу 9 жилийн дараа хоёр дахин нэмэгдэхээр байна. Нөгөө талаас хөрөнгө оруулагч нь тодорхой хугацаанд өгөөжөө хоёр дахин өсгөхийг сонирхож болох юм. Тэгвэл 72-ыг жилийн тоонд харьцуулах замаар өгөөжөө хоёр дахин өсгөхөд шаардлагатай өгөөжийн түвшинг олж болно.

**Далд зардал /Implicit cost/** Компани өөрийн эзэмшлийн нөөцөө (мөнгөн бус хөрөнгө) ашигласнаас бий болох алдагдсан боломжийн өртөг буюу нөөцийг өөрөө ашиглалгүй харин зах зээлд нийлүүлсэн бол, хамгийн

сайн хувилбараар ашигласан бол (түрээслэх, зarah, эсхүл зээлдүүлэх) олж болох байсан орлого.

**Дамжуулагч банк** /Correspondent bank/ Θөр улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын банкинд банкны үйлчилгээ үзүүлж байгаа гадаадын банкийг дамжуулагч банк гэнэ. Энэ үйлчилгээ нь хоёр банкны хоорондын гэрээ, зөвшилцлийн дагуу зохицуулагддаг. Тухайлбал, БНСУ-д үйл ажиллагаа явуулж буй банк гадаад төлбөр тооцоо гүйцэтгэхийн тулд АНУ-ын аль нэг банкыг өөрийн дамжуулагч банкаар сонгож болно.

**Дампуурал** /Bankruptcy/ Компани, аж ахуйн нэгж болон иргэн санхүүгийн өр төлбөрөө төлж чадахгүй болох төлөв байдлыг дампуурал гэж ойлгоно. Зээлдэгч болон зээлдүүлэгчийн аль нэг нь өрөө төлж чадахгүй, эсхүл төлүүлж чадаагүй тухай хуулийн байгууллагад өргөдөл гаргаснаар дампуурах үйл явц эхэнэ.

**Данс эзэмшигч** /Account holder/ Тухайн дансыг ашиглан гүйлгээ хийх, бизнес эрхлэх эрх бүхий хүн. Тухайн данснаас хийгдэх гүйлгээ нь данс эзэмшигчийн гарын үсгээр баталгаажина.

**Дансны доод үлдэгдэл** /Minimum balance/ Дансыг хаалгахгүйн тулд дансандаа байнга байршуулж байх хамгийн бага мөнгөний үлдэгдлийг хэлнэ.

**Дансны дугаар** /Account number/ Данс бүрийг бусад данснаас ялгах давтагдашгүй кодыг хэлнэ.

**Дансны түүх** /Account history/ Тодорхой хугацааны туршид тухайн дансны бүх гүйлгээнүүдийн мэдээ.

**Дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байх** /Non-sufficient funds (NSF)/ Бичсэн чекүүдийн дүн нь дансан дахь үлдэгдлээс хэтрэх явдал. Ийм тохиолдолд банкнаас харилцагчид торгууль оногдуулдаг.

**Дансны хуулга** /Bank statement/ Банкны харилцах данс, хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн дансны талаархи сар бүрийн мэдээлэл.

**Дархлаажуулалт** //Immunization/ Хөвөгч хүүтэй үед хүүгийн хэлбэлзлээс үүдэлтэй эрсдэл, алдагдлаас сэргийлэх зорилгоор актив болон пассивын үргэлжлэх хугацааг нийцүүлэх стратегийг хэлнэ.

**Дахин балансжуулах /Rebalancing/** Багцад орсон үнэт цааснуудын зах зээлийн үнэ өөрчлөгдхөйн хэрээр тухайн үнэт цааснуудын багцад эзлэх жин байх ёстой жишиг жингээсээ өөрчлөгддөг. Тиймээс хөрөнгө оруулагч байх ёстой жинг дахин тэнцвэржүүлэхийн тулд зарим хувьцааг зарах, заримыг нэмж худалдаж авах шаардлагатай болдог. Энэхүү дахин балансжуулах арилжааг улирал тутам, сар тутам гэх мэт тодорхой давтамжтайгаар хийдэг.

**Дахин санхүүжилт /Refinancing/** Зээлийн хугацааг сунгах, зээлийн хүүг бууруулах, сарын төлбөрийг бууруулах, илүү таатай нөхцөлтэй банк сонгох, тогтмол хүүгээс хувьсах хүүнд шилжих гэх мэт таатай нөхцөлийг бий болгох зорилгоор зээлдэгч хуучин зээлээ шинэ зээлээр солихыг хэлнэ.

**Дахин хөрөнгө оруулалтын хүүгийн эрсдэл /Reinvestment rate risk/** Бондын ирээдүйд төлөгдөх купоны төлбөрийг анх бондыг худалдан авах үеийн зах зээлийн хүүгээр дахин хөрөнгө оруулалт хийхгүй тохиолдолд үүсэх эрсдэл. Хүү буурах үед дахин хөрөнгө оруулалтын хүүгийн эрсдэл их болно.

**Дебит /Debit/** Нягтлан бодох бүртгэлийн Т дансны зүүн тал.

**Дебит карт /Debit card/** Харилцагч картын дансанд мөнгөө урьдчилан байршуулж, байршуулсан мөнгөн дүнгийн хэмжээгээрээ зарцуулалт хийх төлбөрийн карт юм.

**Дилер /Dealer/** Үнэт цаасны зах зээл дээр ямар нэгэн үнэт цаасыг өөрийн дансандаа худалдан авч, дамжуулан зарах үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, эсхүл аж ахуйн нэгжийг хэлнэ. Дилерийн ашиг нь авах, зарах үнийн зөрүүгээр тодорхойлогдоно.

**Дилерийн зах /Dealer market/** Дилер-ийг харах. Дилерээр дамжин арилжаа явагдаж буй захыг хэлнэ.

**Динамик хамгаалалт /Dynamic hedging/** Зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан хамгаалалтын позицио тасралтгүй өөрчлөх эрсдэлийн хамгаалалтын стратегийг динамик хамгаалалт гэдэг.

**Дотоод активыг илүүд үзэх /Home bias/** Гадаад активын хэмжээг нэмэгдүүлэх нь дотоод эдийн засгийн системийн

эрсдэлийг бууруулж, төрөлжүүлэлтийн үр ашгийг бий болгох байсан хэдий ч хөрөнгө оруулагч багцынхаа дийлэнх хэсгийг дотоод эдийн засгийн үнэт цааснаас бүрдүүлэх хандлагатай байдаг. Энэ нь гадаад активт хөрөнгө оруулахтай холбоотой хууль журмын хязгаарлалт, гүйлгээний нэмэлт зардал, мэдээллийн тэгш бус байдал үүсэх зэргээс шалтгаалдаг.

**Дотоод мэдээлэл** */Inside information/* Нийтэд мэдээлэгдээгүй буюу зөвхөн байгууллагын өмчлөгч, удирдлага, менежер болон тусгай эрхээр тухайн мэдээллийг хүртэж буй хүмүүсийн хооронд дамжигдаж байгаа бизнес төлөвлөгөө, санхүүгийн нөхцөл байдлын талаархи нийтэд ил зарлаагүй баримт бичиг, мэдээллийг байгууллагын дотоод мэдээлэл гэдэг. Ямар нэгэн компанийн дотоод мэдээллийг олж авсан хөрөнгө оруулагч тухайн компанийн хувьцааны үнийн талаар давуу талтай болдог.

**Дотоод шинжтэй арилжаа** */Insider trading/* Компанийн хувьцаа эзэмшигчид, захирлууд, менежерүүд гэх мэт дотоод мэдээлэлтэй хөрөнгө оруулагчид мэдээллийн давуу талаа ашиглан ашиг олох зорилгоор тухайн компанийн хувьцааг авах, зarah арилжааг хэлнэ.

**Доу Жонс индекс** */Dow Jones industrial average (DJIA)/* Тус индексийг Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг аж үйлдвэрийн "Блю Чип" 30 хувьцааны дундаж үнээр тооцдог. Энэ индекс нь хөрөнгийн зах зээлийн төлөв байдлыг илэрхийлэхэд маш түгээмэл ашиглагддаг индексүүдийн нэг юм.

**Дунд хугацааны зорилт** */Medium-term goal/* Хувь хүн, аж ахуйн нэгжийн 1-5 жилийн дотор хүрэхээр зорьж буй зорилт.

**Дундаж хугацааны зөрүү** */Duration gap/* Актив болон пассивийн эргэн төлөгдөх хугацааг тэдгээрийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр жигнэж тооцсон дундаж хугацааны зөрүүг хэлнэ.

**Дундын алба** */Middle office/* Байгууллагын эрсдэлийн удирдлага, тодорхой түвшний судалгаа хийх, ашиг алдагдлын тооцоо шинжилгээ хийх зэргийг хариуцсан алба, нэгжийг хэлнэ.

**Дуудах эрхгүй бонд /Non-callable bonds/** Бонд гаргагч нь хугацаанаас нь өмнө дуудаж, эргүүлэн худалдан авах эрхгүй энгийн бонд.

**Дуудах эрхийн хязгаарлалт /Call protection/** Дуудах эрхтэй бондын хувьд бонд гаргаснаас хойш тодорхой хугацааны туршид дуудах эрхийг хязгаарлахыг хэлнэ.

**Дуудах эрхтэй бонд /Callable bond/** Бонд гаргагч эргэн төлөгдөх хугацаанаас нь өмнө төлөх боломжтой бондыг хэлнэ. Хүүгийн түвшин нэлээд хэмжээгээр буурсан тохиолдолд бонд гаргагч өндөр хүүтэй үед гаргасан бондоо хугацаанаас нь өмнө эргүүлэн төлж, хямд хүүгээр шинээр бонд гаргах боломжтой. Гэхдээ эргүүлэн дуудсан тохиолдолд бонд гаргагч нэрлэсэн үнээс илүү үнэ төлөх ёстой.

**Дуудлага худалдаа /Auction/** Аливаа хөрөнгийг худалдан авахаар ирүүлсэн саналыг хүлээн авч, хамгийн өндөр үнэтэй санал ирүүлсэн оролцогчид хөрөнгийг худалдах үйл ажиллагаа.

**Дуусах нөхцөл /Sunset clause/** Тодорхой нэг өдрөөс хойш хууль эрх зүйн баримт бичиг бүхэлдээ, эсхүл тодорхой хэсэг нь автоматаар хүчин төгөлдөр бус болохыг тогтоосон хууль эрх зүйн заалт.

**Дюпон шинжилгээ /DuPont system/** Компанийн ашигт нөлөөлөх хүчин зүйлсээр компанийн ашигт ажиллагааг задлан шинжлэх систем. Тухайлбал, Дюпон системээр өөрийн хөрөнгөд ногдох ашиг буюу ашиг, өөрийн хөрөнгийн харьцааг ROE = Ашигийн норм (Ашиг/Борлуулалт) \* Активын эргэлт (Борлуулалт/Актив) \* Өөрийн хөрөнгийн үржүүлэгч (Актив/Өөрийн хөрөнгө) томьёогоор тооцно.

## E

**Евро банк хоорондын хүү /EURIBOR/** Европын мөнгөний холбоонд багтсан өндөр зэрэглэлтэй банкууд хоорондоо хадгаламж байршуулахаар санал болгож буй жишиг хүү юм.

**Европ загварын опцион /European-style Option/** Европ загварын опцион нь талуудын урьдчилан тохиролцсон хугацааны эцэст л опционыг хэрэгжүүлэх боломжтой гэрээ юм. Харин Америк загварын опцион нь гэрээ дуусах өдрөөс өмнө опцион худалдан авагч тал уг опционыг хэрэгжүүлэх боломжийг олгодог. Тиймээс Америк загварын опцион нь Европ загварын опционтой харьцуулахад худалдан авагч талдаа илүү давуу талыг бий болгодог. Опционыг хэрэгжүүлэх гэдэгт опционы гэрээнд тусгасан активыг худалдаж (зарах опционы хувьд), эсхүл худалдан авч (худалдан авах опционы хувьд) гэрээг дуусгавар болгохыг ойлгоно.

**Ерөнхий дэвтэр /Ledger/** Ерөнхий дэвтэр нь тухайн данстай холбоотой бүх гүйлгээг огноогоор нь дараалуулан бүртгэж, дансны эцсийн үлдэгдлийг тодорхойлсон тухайн дансны дэлгэрэнгүй бүртгэл юм.

## Ж

**Жилд шилжүүлсэн өгөөж /Annualized return/** Жилд шилжүүлсэн өгөөж нь хөрөнгө оруулалтын хугацааны туршид жилд дунджаар ямар хэмжээний өгөөж олж байсныг харуулна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын сан эхний жилд 3%-ийн алдагдалтай ажилласан боловч дараах хоёр жилд 2% ба 10%-ийн өгөөжтэй ажилласан бол жилд шилжүүлсэн өгөөж нь  $(1-3\%)(1+2\%)(1+10\%)^{(1/3)}=2.86\%$  гарч байна. Өөрөөр хэлбэл, жилд шилжүүлсэн өгөөж нь өгөөжийн хэлбэлзлийн талаар ямар нэгэн мэдээлэл өгөхгүй бөгөөд зөвхөн жилд дунджаар хэдэн хувийн өгөөж хүртэж байгааг л харуулна. Үүнийг тооцсоноор бусад хөрөнгө оруулалттай харьцуулах боломжтой болно.

**Жилийн бодит үйлчилж буй өгөөж /Effective annual yield/** Бодит үйлчилж буй өгөөж нь нэрлэсэн өгөөж (купонын хүү)-өөс ялгаатай. Бондын купоны орлогыг хөрөнгө оруулагч дахин хөрөнгө оруулалт хийхэд хүүгээс хүү бодогдох тул бодит үйлчилж буй өгөөж нь нэрлэсэн өгөөжөөс их болно. Тухайлбал, хагас жил тутамд 5%-ийн купон төлдөг бондыг эзэмшиж буй хөрөнгө оруулагч жилд 2 удаа купоны орлого авна. Хөрөнгө оруулагч купоны орлогоороо дахин хөрөнгө оруулалт хийвэл эхний купоны орлого нь дараагийн хөрөнгө оруулалтын суурийг нэмэгдүүлэх тул хүүгээс хүү бодогдох

зарчмаар бодит үйлчилж буй хүү нь нэрлэсэн өгөөж буюу купоны хүүгээс өндөр байна.

**Жилийн өрийн төлбөр /Annual debt service/** Тухайн жилийн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр.

**Жилийн төлбөр /Annual fee/** Зээлийн карт, эсхүл зээлийн данс ашигласны жилийн төлбөр.

**Жилээр тооцсон өгөөжийн хувь /Annual percentage yield/** Тухайн хөрөнгө оруулалтаас жилдээ олсон ашгийг анхны хөрөнгө оруулалтын дунд харьцуулсан харьцаа.

**Жишиг багц /Benchmark portfolio/** Хөрөнгө оруулалтын менежерийн ажлын үр дүнг үнэлэх зорилгоор жишиг болгон сонгон авсан багц. Энэ багцын олж болох байсан өгөөжийг менежерийн бодит өгөөжтэй харьцуулж, ажлын үр дүнг хэмжинэ. Менежер үйлчлүүлэгчээ алдахгүй байх, нэмэлт бонус авах, хөрөнгө оруулагч буюу үйлчлүүлэгч шинээр татахын тулд жишиг багцын өгөөжөөс өндөр өгөөжтэй ажиллах шаардлагатай.

**Жишиг үзүүлэлтээс хазайх хэмжээ /Tracking error/** Хөрөнгө оруулалтын багцын үнэ жишиг үнийн индексээс хазайх зөрүү. Энэ нь хэдж сан, хамтын сан төлөвлөсөн хэмжээндээ хүртэл үр ашигтай ажиллаж чадаж байгаа эсэхийг илэрхийлэх бөгөөд хүлээгдээгүй ашиг, эсхүл алдагдлыг хэмжинэ.

**Журнал бичилт /Journal/** Журнал нь өдөр тутмын бүртгэл гэсэн утгатай латин үг бөгөөд бизнесийн байгууллагын өдөр тутмын ажил гүйлгээг цаг хугацааны дэс дарааллаар бүртгэж харуулдаг.

### 3

**Заавал байлгах барьцаа (өөрийн) хөрөнгө /Maintenance margin/** Арилжаанд оролцогчийн барьцаа болгон дансандаа байршуулсан өөрийн хөрөнгийн хамгийн доод үлдэгдлийн хэмжээг хэлнэ. Хэрэв үнийн хэлбэлзлээс шалтгаалан өөрийн хөрөнгийн хэмжээ уг түвшнээс доош буурахаар бол арилжаанд оролцогч позицоо нээлттэй хэвээр хадгалахын тулд өөрийн (барьцаа) хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай.

**Заавал байлгах нөөцийн шаардлага** /Reserve requirements, Required reserves/ Банк нөөцийнхөө хуулиар тогтоосон хэсгийг өөр дээрээ, эсхүл Төв банкинд хадгалах шаардлага.

**Завсрын бүтээгдэхүүн** //Intermediate good/ Эцсийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ашиглагдаж буй бүтээгдэхүүн (түүхий эд, орц).

**Завсрын зээл** /Bridge loan/ Хувь хүн, эсхүл компанийн байнгын санхүүжилт олж авах хүртлээ, эсхүл одоогийн үүргийн гүйцэтгэлийг хангахад хэрэглэх зорилгоор авч буй богино хугацаат зээл. Энэ төрлийн зээл нь 1 жил хүртэл хугацаатай, харьцангуй өндөр хүүтэй, үл хөдлөх хөрөнгө, бараа материал зэрэг хөрөнгөөр баталгаажсан байдаг.

**Залилан** /Fraud/ Санхүүгийн ашиг олох зорилготой хууль зөрчсөн үйлдэл.

**Залилангийн эрсдэл** /Fraud risk/ Тухайн хөрөнгө оруулалтын талаар худал мэдээлэл өгөх, санаатай төөрөгдүүлэх үед үүсч болзошгүй эрсдэл.

**Зарах-Авах опционы үнийн тэнцвэр** /Put-call parity theorem/ Нэг активт бичигдсэн опционы хувьд авах, зарах опционы үнийн хооронд дараах харьцаа хадгалацдана. Авах (зарах) опционы үнэ мэдэгдэж байвал зарах (авах) опционы тэнцвэрт үнийг олж болно. Энэ харьцаа алдагдсан бол эрсдэлгүй ашгийн боломж үүснэ.  $c+K(1+r_f)T = p+So$ ;  $c$ - авах опционы үнэ,  $p$ - зарах опционы үнэ,  $So$ - хувьцааны үнэ,  $K$ - таслах үнэ,  $r_f$ - эрсдэлгүй активын хүү,  $T$ - опционы хугацаа.

**Зардал** /Costs/ Ямар нэгэн зүйлийг олж авах, худалдан авахад төлж буй дүн. Ямар нэгэн зүйлд хүрэх, эсхүл олж авахын тулд шаардагдах хүчин чармайлт, алдагдал, золиос.

**Зардал ба үр ашгийн шинжилгээ** /Cost/Benefit analysis/ Боломжтой хувилбар тус бүрийн давуу (үр ашиг) болон сул талыг (зардал) шинжилсний үндсэн дээр шийдвэр гаргах үйл явц.

**Зарлагын гүйлгээ** /Withdrawal/ Харилцагч санхүүгийн данснаас мөнгө авах үйлдэл.

**Зарцуулалт (зардал) /Expenses/ Бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр.**

**Зарцуулалтын бүртгэл /Spending diary/ Зарцуулалтын цаг хугацаан дахь бүртгэл.**

**Зарцуулах /Spend/ Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдаж авахын тулд мөнгө ашиглах үйлдэл.**

**Засгийн газрын богино хугацаат үнэт цаас /Treasury bill (T-bill)/** Засгийн газраас гаргасан нэг жил ба түүнээс богино хугацаатай өрийн бичиг. Засгийн газрын богино хугацаат үнэт цаасыг нэрлэсэн үнээр гаргаж, анхдагч зах дээр хямдруулсан үнээр худалдах ба хугацааны эцэст нэрлэсэн үнээр буцаан төлнө.

**Засгийн газрын бонд /Government bonds/** Засгийн газрын бонд гэдэг нь Засгийн газраас тодорхой хугацааны дараа хүүгийн хамт эргэн төлөх нөхцөлтэйгээр гаргаж, хөрөнгө оруулагчдад худалдаалсан өрийн бичиг юм. Өрийн бичиг гаргаснаар Засгийн газар мөнгө зээлж, ирээдүйд эргүүлэн төлөх өр үүсгэж байгаа хэрэг юм. Засгийн газрын бонд нь эргэн төлөгдөх хугацаанаасаа хамааран богино, дунд, урт хугацаат гэж ангилагдана. Ерөнхийдөө Засгийн газраас гаргасан нэг жилээс дээш хугацаатай өрийн бичгийг Засгийн газрын бонд гэдэг.

**Зах зээлийн багц /Market portfolio/** Хөрөнгийн зах дээрх бүх хувьцааг зах зээлийн үнэлгээтэй нь хувь тэнцүүлэн бүрдүүлж байгуулсан багцыг хэлнэ. Зах зээлийн багцын эрсдэл нь бүрэн тархаагдсан гэж үздэг тул түүний эрсдэл зөвхөн зах зээлийн эрсдэл байна.

**Зах зээлийн бус эрсдэл /Nonsystematic risk/** Тархааж болохуйц эрсдэлийг харна уу.

**Зах зээлийн захиалга /Market order/** Хөрөнгийн бирж дээр сонгосон хувьцаагаа тухайн үеийн зах зээлийн үнээр худалдан авах захиалга. Энэ захиалгын үед хувьцааг худалдах, худалдан авах үнэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй учраас брокер хөрөнгө оруулагчийн захиалгыг биелүүлэх боломж маш өндөр юм.

**Зах зээлийн өнөөгийн үнэлгээ /Current market value/** Хөрөнгө оруулагчийн эзэмшиж буй үнэт цаасны үнэлгээг

зах зээлийн тодорхой үеүд дэх үнээр, эсхүл хаалтын үнээр шинэчилж тооцохыг хэлнэ.

**Зах зээлийн тэнцвэргүй төлөв /Non-clearing markets/** Зах дээр тогтох буй үнэ нь бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлж чадахгүй байх явдал. Зах зээлийн тэнцвэргүй байдал нь бүтээгдэхүүний илүүдэл (илүүдэл нийлүүлэлт), эсхүл хомсдлыг (илүүдэл эрэлт) арилгаж чаддаггүй.

**Зах зээлийн үнийн эрсдэл /Market price risk/** Эрэлт, нийлүүлэлтэд өөрчлөлт орсноор хөрөнгө оруулалтын үнэ буурах магадлал.

**Зах зээлийн үнэ /Market price/** Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдах болон худалдан авч болох өнөөгийн үнэ. Эдийн засгийн онолоор зах зээлийн үнэ эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр тогтдог гэж үздэг.

**Зах зээлийн үнэ цэнэ /Market value/** Компанийн зах зээлийн үнэлгээг нийт хувьцааны тоог нэгж хувьцааны зах зээлийн үнээр үржүүлж тооцно.

**Зах зээлийн үнэ, балансын үнийн харьцаа /Market-book-value ratio/** Компанийн бүртгэлийн үнэ болон зах зээлийн үнийг харьцуулах замаар компанийг үнэлэхэд ашиглагддаг харьцаа. Энгийнээр авч үзвэл, уг харьцаа 1-ээс их бол уг компанийн хувьцаа дутуу үнэлэгдсэн, 1-ээс бага бол илүү үнэлэгдсэн гэж дүгнэж болох юм.

**Зах зээлийн үнэлгээ /Market capitalization/** Компанийн зах зээлийн нийт үнэлгээ. Компанийн нэгж хувьцааны үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлж тодорхойлно. Зах зээлийн үнэлгээг хөвөлт буюу гүйлгээнд буй хувьцаатай эндүүрч болохгүй. Компанийн зах зээлийн үнэлгээ нь ялангуяа, анх хувьцаа гаргаж буй тохиолдолд хөвөлтөөс үлэмж их байж болно.

**Зах зээлийн үнэлгээгээр жигнэсэн индекс /Market-value-weighted index/** Бүлэг үнэт цааснуудыг нэгтгэн тэдгээрийн зах зээлийн үнэлгээгээр жигнэж тооцсон индекс.

**Зах зээлийн үнэлгээний хувь /Market capitalization rate/** Хөрөнгө оруулж буй хөрөнгийн бий болгох орлого дээр үндэслэн тооцсон хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь. Уг хөрөнгийн бий болгох жилийн орлогыг хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд харьцуулан тооцдог.

**Зах зээлийн үнээрх дахин үнэлгээ /Marked to market/** Хувьцаа, үнэт цаасны үнэлгээг тодорхой давтамжтайгаар зах зээлийн үнээр шинэчилж, үнэ цэнийг тодорхойлохыг хэнтэй.

**Зах зээлийн хүүгээс доогуур хүү /Below-market interest rate/** Санхүүгийн зах зээлд зонхицж буй хүүгийн түвшнээс бага хүү. Аливаа хөтөлбөр, хөнгөлөлтийн арга хэмжээний хүрээнд олгогдож буй зээлийн хүү нь энэ төрлийн хүүнд хамаарна. Улс орнууд ихэвчлэн бага орлоготой иргэд болон эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор зах зээлийн хүүгээс бага хүүтэй зээл олгодог.

**Зах зээлийн хэсэгчлэл /Market segmentation/** Хэрэглэгч, худалдан авагчдыг ижил төстэй хэрэгцээ, шинж чанараар нь бүлэглэх маркетингийн арга. Жишээ нь, спортын хувцас үйлдвэрлэгч компани худалдан авагчдаа сагсан бөмбөг тоглогч, гүйлтийн спортоор хичээллэгч гэж бүлэглэж болно.

**Зах зээлийн эрсдэл /Market risk, Systematic risk/** Хувьцаа, бонд гэх мэт хөрөнгө оруулалтын үнэт цаасанд нөлөөлөх нийтлэг эрсдэл бөгөөд үүнийг хөрөнгө оруулалтын төрөлжүүлэлтээр тархааж, бууруулах боломжгүй байдаг. Энэхүү эрсдэлийг системийн эрсдэл, нийт макро эдийн засгийн эрсдэл, тархаах боломжгүй эрсдэл гэх мэтээр нэрлэдэг бөгөөд тухайн хувьцааны бета коэффициентээр хэмждэг. Макро эдийн засгийн төлөв байдал доройтож, нийт хөрөнгийн зах зээл муудсанаар тухайн нэг компанийн хувьцаанд ч сөргөөр нөлөөлнө. Зарим тохиолдолд банк болон компаний эзэмшиж буй активын зах зээлийн үнэ өөрчлөгдсөнөөс хүлээж болзошгүй алдагдлыг зах зээлийн эрсдэл гэж нэгж аж ахуйн нэгжийн түвшинд ойлгодог.

**Зөвхөн хүү төлөгдөх зээл /Interest-only loan/** Зээлийн хугацаанд зөвхөн зээлийн хүүг төлөх зээл. Зээлийн үндсэн төлбөр зээлийн хугацаанд өөрчлөгдхгүй.

**Зөрүү /Spread/** Хоёр үнийн хоорондох зөрүү, ялгавар. Жишээ нь, хөрөнгийн захын хувьд зөрүү нь худалдан авах дээд үнэ болон зарах доод үнийн хоорондох ялгавар болно. Тогтмол орлого авчрах үнэт цаас (тухайлбал, бонд)-ны хувьд зөрүү гэдэг нь хөрөнгө оруулалтын ижил зэрэглэлтэй хэрнээ харилцан адилгүй хугацаатай хоёр үнэт цаасны

өгөөжийн зөрүү болно. Тухайлбал, урт хугацаатай засгийн газрын бондын өгөөж нь 6%, харин богино хугацаатай бондын өгөөж нь 4% бол зөрүү нь 2% болно. Түүнчлэн ижил хугацаатай хэрнээ хөрөнгө оруулалтын өөр зэрэглэлтэй 2 үнэт цаасны өгөөжийн зөрүү байж болно. Тухайлбал, 9%-ийн өгөөжтэй бонд болон 6%-ийн өгөөжтэй засгийн газрын бондын төлөгдөх хугацаа нь ижил бол зөрүү нь 3% байна.

**Зуучлал /Intermediation/** Санхүүгийн хөрөнгийн илүүдэлтэй хэсгээс хөрөнгийн дутагдалтай хэсэг рүү шилжүүлэн хуваарилах үйл явц. Тухайлбал, банкууд хадгаламжийг харьцангуй бага хүүгээр татан төвлөрүүлж, улмаар илүү өндөр хувиар зээл олгоно.

**Зээл /Credit/** Дараа эргэн төлөх нөхцөлтэйгээр мөнгө зээлдэх, эсхүл бүтээгдэхүүн, үйлчилгээг авах боломж.

**Зээл олголт /Loan origination/** Зээлдэгч зээлийн өргөдөл гаргах, харин зээлдүүлэгч тэрхүү өргөдлийг шийдвэрлэх үйл явц. Энэхүү үйл явц зээлийн өргөдлийг хүлээн авахаас эхлээд зээлийг олгох (эсхүл татгалзах) хүртэлх бүхий л үе шатыг хамарна.

**Зээл олголтын шимтгэл /Loan origination fee/** Банкуудын зээл олгохтой холбоотойгоор авдаг төлбөр. Тухайлбал, зээл олголтын шимтгэлийг ихэвчлэн баталсан зээлийн дүнгийн 0.5%-1.0%-иар тооцож авдаг.

**Зээл төлөх чадвар /Creditworthiness/** Зээлдэгчийн зээлийн үндсэн дүн, хүүгийн төлбөрийг зээлийн хугацааны эцэст барагдуулах чадвар. Зээлийн түүх, зээлийн оноо зэрэг үзүүлэлтэд тулгуурлан зээл төлөх чадварыг үнэлнэ.

**Зээл, үнэлгээний харьцаа /Loan to value ratio/** Зээл, үнэлгээний харьцаа гэж зээлийн дүн буюу үлдэгдлийг барьцаа хөрөнгийн үнэлгээнд харьцуулсан хувь хэмжээг хэлнэ.

**Зээл, хадгаламжийн харьцаа /Loan-to-deposit ratio/** Банкны активын хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг бөгөөд банкны олгосон нийт зээлийг нийт хадгаламжид харьцуулж тооцно. Уг харьцаа өндөр байх нь тухайн банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар харьцангуй доогуур болохыг харуулдаг бол уг харьцаа бага

байх нь тухайн банкинд илүү ашиг олох боломж байгааг харуулдаг.

**Зээлдүүлэгч /Creditor, Lender/** Мөнгө зээлдүүлж буй хувь хүн, эсхүл байгууллага (банк, санхүүгийн байгууллага).

**Зээлдүүлэх /Lend/** Хэн нэгэнд ямар нэгэн зүйлийг эргүүлж авах нөхцөлөөр (мөнгө бол хүүтэйгээр) ашиглаулах.

**Зээлдэгч /Borrower/** Бусдын эзэмшиж буй зүйлийг буцааж өгөх нөхцөлтэйгээр авч ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж (мөнгө зээлдэх тохиолдолд хүүтэй эргэн төлөх).

**Зээлдэгч /Debtor/** Зээлдэгч гэж өөр хэн нэгэнд өртэй буюу хэн нэгэн этгээдийн өмнө санхүүгийн өглөгийн үүрэг хүлээсэн иргэн, аж ахуйн нэгжийг хэлнэ. Хэрэв үнэт цаас, өрийн бичиг (тухайлбал бонд) гаргах хэлбэрээр өр үүсгэсэн бол түүнийг үнэт цаас гаргагч, бонд гаргагч зэргээр нэрлэнэ.

**Зээлдэгчийн амь насны даатгал /Credit life insurance/** Зээлдэгч зээлээ бүрэн төлж барагдуулахаас өмнө нас барсан тохиолдолд зээлдэгчийн өмнөөс зээлийг төлж барагдуулах даатгалыг хэлнэ.

**Зээлдэгчийн гэнэтийн ослын даатгал /Credit disability insurance/** Зээлдэгч өвчин тусах, осолд орох зэргээс шалтгаалан хөдөлмөрийн чадвараа алдсан үед зээлдэгчийн өмнөөс зээлийн төлбөрийг төлөх даатгалыг хэлнэ.

**Зээлдэгчийн оноо /Credit score/** Харилцагчийн зээлийн оноо нь ирээдүйд тухайн харилцагчийн зээлээ эргүүлэн төлөх чадварыг илтгэдэг. Зээлийн оноог харилцагчийн боловсрол, нас, хүйс, орлого зэрэг хүчин зүйлс дээр үндэслэн тооцдог.

**Зээлдэгчийн эрсдэлийн үнэ /Default premium/** Зээлдэгчийн зээлээ эргүүлэн төлж чадахгүй байх эрсдэлтэй холбоотойгоор төлж буй зээлийн нэмэлт хүү. Нөгөө талаас, хөрөнгө оруулагчдын эрсдэлтэй зээлдэгчдээс зээлийн эрсдэх магадлалыг тооцоолон шаардаж буй хүүгийн нэмэгдэл. Доогуур зэрэглэлтэй компани болон муу зээлийн түүхтэй хувь хүн зээл авахын тулд зэрэглэл өндөртэй болон эрсдэлгүй зээлдэгчийн хүүгээс өндөр хүү төлснөөр л зээл авах буюу бонд гаргах боломжтой.

**Зээлдэх /Borrow/** Бусдын эзэмшиж буй зүйлийг (бараа, мөнгөн хөрөнгө) буцааж өгөх нөхцөлтэйгээр авч ашиглах явдал (мөнгө зээлдэх тохиолдолд хүүтэй эргэн төлөх).

**Зээлжих зэрэглэл /Credit rating/** Тухайн компани, эсхүл засгийн газрын зээлээ эргэн төлөх чадварын үнэлгээ.

**Зээлийг барагдуулж дуусгах /Payoff/** Зээлийн хугацаа дуусахад, эсхүл түүнээс өмнө үндсэн зээлийг хүү, бусад төлбөрийн хамт бүрэн төлж дуусгахыг хэлнэ.

**Зээлийг барагдуулж дууссаны баримт /Payoff statement/** Зээлийн бүрэн төлөлтийг баталгаажуулах албан ёсны баримт.

**Зээлийн анхдагч дүнгээс тооцох хүү /Add-on rate/** Энэ аргыг ашиглах үед хүүг зээлийн анхдагч үндсэн дүнгээс тооцно. Үүний дараа хүүг зээлийн анхдагч үндсэн дүн дээр нэмэх ба нийлбэр дүнг төлбөр хийх давтамжийн тоонд хувааснаар зээлийн нэг удаагийн төлбөрийн хэмжээг тодорхойлно. Нэг жилийн хугацаатай, 2 удаа ижил дүнтэйгээр төлбөр хийх, 5 хувийн анхдагч дүнгээс тооцох хүүтэй 1000 төгрөгийн зээл авсан гэе. Тэгвэл 50 төгрөгийн хүүг (1000 төгрөгийн 5 хувь нь) зээлийн анхдагч үндсэн дүн болох 1000 төгрөг дээр нэмбэл эргэн барагдуулах дүн нь 1050 төгрөг болно; ингэснээр эхний хагас жилийн эцэст 525 төгрөг, хоёрдугаар хагас жилийн эцэст мөн 525 төгрөгийг төлж барагдуулахаар байна. Энэ зээлийн бодит үйлчилж буй хүүг тооцвол жилийн 6.631 хувь болно. Бодит үйлчилж буй хүү нь ийнхүү өндөр байгаа нь зээлдэгч 1000 төгрөгийг зөвхөн эхний хагас жилд, харин хоёрдугаар хагас жилд 500 орчим төгрөгийг ашиглаж байгаатай холбоотой юм. Зээлийн анхдагч үндсэн дүнгээс тооцох хүүнд үндсэн дүн буурах нөлөөг харгалzan үздэггүй нь эндээс харагдаж байна.

**Зээлийн бодит өртөг /Annual Percentage Rate (APR)/** Хүүгээс хүү бодох нөлөө болон шимтгэл, хураамжийн нөлөөг оруулсан жилийн хувиар илэрхийлэгдэх зээлийн бодит өртөг. Зээлийн бодитоогоор ашиглах буй үндсэн дүнгээс (буурах) хүү нь бодогдох тул зээлийн анхдагч үндсэн дүнгээс тооцох хүүгээс ялгаатай.

**Зээлийн гэрээ /Credit agreement, Loancontract/** Зээлийн хүү, хугацаа, эргэн төлөлтийн хуваарь гэх мэт зээлийн бүх

нөхцөлийг тусгасан зээлдэгч болон зээлдүүлэгчийн хооронд байгуулж буй гэрээг хэлнэ.

**Зээлийн карт /Credit card/** Банкнаас гаргасан карт; карт эзэмшигчид бүтээгдэхүүн, үйлчилгээг зээлээр авах эрхийг олгож буй тусгай код бүхий хуванцар карт.

**Зээлийн карт гаргагч /Credit card issuer/** Харилцагчийн хүсэлтийн дагуу төлбөрийн карт гаргагч банкийг хэлнэ.

**Зээлийн картын боломжит зээл /Available credit/** Зээлийн картын батлагдсан зээлийн дээд хязгаар болон одоогийн ашигласан зээлийн хэмжээгээр тодорхойлогоно. Өөрөөр хэлбэл, зээлийн картын ашиглагдаагүй зээлийн үлдэгдлийг хэлнэ.

**Зээлийн картын гэрээ /Credit card account agreement/** Картын дансны нөхцөл, төлбөрийн зориулалт, карт гаргагчийн үүрэг, хариуцлага зэргийг тусгасан бичгээр үйлдсэн гэрээг хэлнэ.

**Зээлийн картын хуулга /Credit-card statement/** Банкнаас сар бүр карт эзэмшигчид хүргүүлдэг хураангуй мэдээлэл (худалдан авалт, төлбөр, шимтгэл хураамж, зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээ гэх мэт).

**Зээлийн луйвар /Loan scam/** Их хэмжээний өртэй иргэдэд хууль бус сурталчилгаа хийн, бүх өр зээлийг нь маш таатай нөхцөлтэй нэг зээл (зээлийн нэгтгэл) болгоно хэмээн амлаж, тус зээлд хамрагдахын тулд хураамж төлөхийг шаарддаг. Хэрэглэгч хураамжаа төлсөн ч зээлээ авч чаддаггүй байна.

**Зээлийн нөхцөл /Loan terms/** Зээлийн гэрээнд тусгагдсан зээлийн нөхцөл. Зээлийн нөхцөл нь зээлдүүлэгч болон зээлдэгчийн харилцан тохиролцсон зээлийн дүн, хугацаа, хүү болон бусад нөхцөлийг тодорхойлно.

**Зээлийн өргөдлийн хураамж /Loan application fee/** Зээлийн өргөдлийг хүлээн авах, үнэлэх, шийдвэр гаргахтай (зээлийн түүхийг шалгах, хөрөнгийн үнэлгээ хийх гэх мэт) холбоотойгоор авдаг хураамж. Зээлийн өргөдлийн хураамжийг зээл хүсэгчид буцаан олгохгүй.

**Зээлийн өргөдөл /Credit application/** Зээл авахыг хүссэн этгээдээс зээл олгогчид (тухайлбал, банк) хандан гаргасан баримт. Зээл олгогч зээлийн өргөдөл суурилан зээл хүссэн

этгээдийн төлбөрийн чадвар (зээлийг эргэн төлөх чадвар)-ыг үнэлж зээл олгох эсэхээ шийдвэрлэнэ.

**Зээлийн түүх /Credit history/** Харилцагчийн өмнө нь авч байсан зээл, эргэн төлөлтийн талаархи бүртгэл, тайлан.

**Зээлийн тэлэлт /Credit enhancement/** Компанийн зээлжих чадвараа нэмэгдүүлэх арга. Зээлдэгч нэмэлт барьцаа хөрөнгө, даатгал, эсхүл гуравдагч талын батлан даалт зэргийг ашиглан зээлийн тэлэлт хийснээр үүргээ бүрэн гүйцэтгэнэ гэсэн баталгаагаар зээлдүүлэгчийг хангадаг. Зээлийн тэлэлт нь зээлдэгчийн зээлийн болон төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулдаг тул зээлийн зэрэглэлийг нэмэгдүүлж, хүүгийн түвшинг бууруулах нөлөөтэй.

**Зээлийн үйлчилгээ /Loan servicing/** Зээлийн үйлчилгээ гэдэг нь банк зээлдэгчээс хүү, үндсэн төлбөр болон эскроу төлбөрийг цуглуулах үйл явцыг хэлнэ.

**Зээлийн үндсэн төлбөр нэмэгдэх /Negative amortization/** Зээлдэгчийн барагдуулж буй төлбөр нь төлөх ёстой хүүгийн төлбөрөөс бага үед зөрүү нь зээлийн өрийн үндсэн дүнг нэмэгдүүлнэ. Тухайлбал, 30 жилийн тогтмол 6%-ийн хүйтэй 100,000 ам.долларын ижил төлбөртэй ипотекийн зээл авсан зээлдэгч сар бүр 600 ам.долларын төлбөр хийх ёстой болно. Эхний сард төлөх хүүгийн төлбөр нь 500 ам.доллар болох ба ингэснээр зээлийн үндсэн дүн 100 ам.доллараар хорогдоно. Ийнхүү нэг сарын дараа зээлийн үндсэн төлбөр 99,900 ам.доллар болохоор байна. Гэтэл ямар нэгэн шалтгааны улмаас эхний сард зөвхөн 400 ам.доллар төлсөн гэвэл хүүгийн төлбөр 100 ам.доллараар дутах ба энэхүү зөрүүг зээлийн үндсэн дүн дээр нэмнэ. Ингэснээр сарын эцэст зээлдэгчийн төлөх зээлийн өрийн үлдэгдэл 100,100 ам.доллар болно. Үндсэндээ зээлдэгч нь өмнөх зээлийн өрийн үлдэгдэл дээр нэмж өр тавьж байна гэсэн уг юм. Төлбөр нь хүүгийн зардлыг нөхөхгүй байгаа тохиолдолд зээлийн үндсэн дүн нэмэгддэг байна.

**Зээлийн хавтаст хэрэг /Loan package/** Тухайн зээлийн өргөдөлтэй холбоотой баримт бичгүүдийн бүрдэл. Тухайлбал, зээлдэгчийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг шалгаж магадласан баримт гэх мэт.

**Зээлийн холбоо /Credit union/** Гишүүдийнх нь эзэмшилд буй ашгийн бус санхүүгийн байгууллага. Данс, зээл зэрэг төрөл бүрийн санхүүгийн үйлчилгээг санал болгодог.

**Зээлийн хүүгийн дээд хязгаар** /Interest rate cap/ Зарим улс оронд банкны зээлийн хамгийн өндөр хүүг хууль, дүрэм журмаар тогтоосон байдаг.

**Зээлийн хязгаар** /Credit limit/ Санхүүгийн байгууллага, эсхүл зээлийн карт гаргагчийн (тухайлбал, банк) зүгээс хувь хүнд олгох мөнгөний дээд хэмжээ.

**Зээлийн шимтгэл** /Origination fee/ Банкууд зээлдэгчид олгосон зээлийн дүнгээс тодорхой хувиар авч буй нэг удаагийн шимтгэл юм.

**Зээлийн шугам** /Line of credit/ Банк болон байгууллагын хооронд урьдчилан байгуулсан зээлийн эрхийн гэрээ юм. Энэхүү гэрээгээр зээлдэгчийн зээлжих чадварт үндэслэн зээлийн дээд хязгаарыг зааж өгөх бөгөөд компани нь зээлийн хязгаараа хэтрүүлээгүй тохиолдолд шаардлага гарсан буюу хүссэн үедээ зээлийн эрхээ ашиглан зээл авах боломжтой.

**Зээлийн эрсдэл** /Credit risk/ Зээлийн эргэн төлөлт тасалдах эрсдэл. Зээлдэгч тогтсон хуваарийн дагуу зээлийн хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөө хийж чадахгүй байх эрсдэл.

**Зээлийн эрсдэлийн своп** /Credit default swap/ Нэг талын зээлийн эрсдэлийг өөр талд шилжүүлэх санхүүгийн своп гэрээ буюу зээлийн эрсдэлийн даатгал юм. Зээлийн эрсдэлийн своп худалдаж буй тал нь тухайн гэрээтэй холбоотой зээл чанарагүй болох буюу эргэн төлөгдөхгүй тохиолдолд своп худалдан авагч талдаа нөхөн төлбөр төлнө. Харин худалдан авагч тал нь даатгагч буюу своп худалдагч талдаа тодорхой хугацааны давтамжтайгаар шимтгэл төлнө.

**Зээлийн эрсдэлийн үнэ** /Credit spread/ Зээлийн эргэн төлөлтийн эрсдэлээрээ ялгаатай зээлдэгчийн төлж буй хүүгийн зөрүүгээр тодорхойлогдоно. Зээлдэгчийн зээлээ эргүүлэн төлөхгүй байх эрсдэл өндөр байх тусам зээлдүүлэгч илүү өндөр хүү шаардана. Тухайлбал, компанийн бонд Засгийн газрын бондоос илүү эрсдэлтэй тул илүү өндөр хүү төлсөн тохиолдолд л хөрөнгө оруулагч уг компанийн бондыг худалдаж авна. Мөн улс орнуудын засгийн газрын бонд зээлийн эрсдэлээс хамааран харилцан адилгүй хүйтэй байна. Монгол улс 2014 байдааар B+ зэрэглэлтэй байгаа

бөгөөд 5 жилийн хугацаатай засгийн газрын бондын зах зээлийн өгөөж 6.6% байгаа нь АНУ-ын засгийн газрын 5 жилийн хугацаатай бондоос 5 нэгж хувиар өндөр байна.

**Зээлийн эх үүсвэрийн зах /Loanable funds market/** Мөнгөний эрэлт, нийлуулэлт нь (банкны хадгаламж болон зээлийн хэлбэрээр) хүүгийн түвшинг тодорхойлох зах зээл.

**Зээлээр борлуулалт хийх /Short sale/** Хөрөнгө оруулагч өөрийн эзэмшилд байхгүй үнэт цаасыг брокероор дамжуулан ирээдүйтгээснэг хугацаанд буцаан шилжүүлэх нөхцөлтэй бусдаас зээлж, худалдах үйл ажиллагаа.

## И

**Идэвхгүй багц /Passive portfolio/** Зах зээлийн индексүүд. Жишээ нь, S&P 500, ТОП-20 гэх мэт.

**Идэвхтэй багц /Active portfolio/** Хөрөнгийн идэвхтэй удирдлага-ыг харах.

**Иж бүрэн багц /Complete portfolio/** Эрсдэлтэй болон эрсдэлгүй активын аль алиныг багтаасан хөрөнгө оруулалтын багцыг хэлнэ.

**Индекс /Index/** Эдийн засаг (эсхүл үнэт цаасны захад)-т гарч буй өөрчлөлтийг индексийн тусlamжтайгаар хэмждэг. Индексийг тодорхой аргачлалын дагуу тооцно. Индексийн өөрчлөлтийг ихэвчлэн суурь үетэй харьцуулж харуулдаг байна.

**Индексжүүлсэн түрээс /Index lease/** Ямар нэгэн индекстэй уялдан түрээсийн төлбөр нь тодорхой давтамжтайгаар өөрчлөгдөх нөхцөлтэй түрээсийн гэрээг хэлдэг.

**Инерцийн нөлөө /Momentum effect/** Хувьцааны үнэ өнгөрсөн хугацаанд өсч байсан бол цаашдаа ч хэсэг хугацаанд өссөөр байх тухай ойлголт. Инерцийн нөлөө нь зөвхөн хувьцааны захад төдийгүй валютын болон түүхийн эдийн захад ч хамаатай.

**Институционал зээлдүүлэгч /Institutional lender/** Хөрөнгөө (өөрийн эсхүл бусдын) компанийн хувьцаа, бонд, засгийн газрын үнэт цаас, орон сууцны ипотек, бизнесийн зориулалттай үл хөдлөх хөрөнгө, ипотекийн

зээлээр баталгаажсан үнэт цаас худалдан авахад зориулж буй санхүүгийн байгууллага (эсхүл институционал хөрөнгө оруулагч). Ийм хөрөнгө оруулагчид ипотекийн зээлийг тэр чигээр нь, эсхүл үнэт цаас болгон багцалсан хэлбэрээр, түүнчлэн хаалттай хөрөнгө оруулалтаар арилжаалж буй шинэ үнэт цаасыг худалдан авах нь нийтлэг байдаг. Ипотекийн хоёрдогч зах дээр хадгаламж зээлийн хоршоод, хадгаламжийн банкууд, амь насны даатгалын компаниуд, банкууд болон тэтгэврийн сангүүд зэрэг институциональ зээлдүүлэгчид үйл ажиллагаа явуулдаг.

**Институционал хөрөнгө оруулагч** /*Institutional investor/* Үйлчлүүлэгчдээ хувьцаа болон бусад хөрөнгө оруулалтыг худалдан авч өгч буй санхүүгийн зуучлагч (тухайлбал, тэтгэврийн сан, хамтын сан).

**Иргэдийн зээл** /*Debt for individual/* Хувь хүний хэн нэгэнд (ихэвчлэн санхүүгийн байгууллага) төлөх өр.

**Ирээдүйн үр дагавар** /*Future consequences/* Тухайн сонголтоос үүдэн ирээдүйд төлөх зардал, эсхүл олох ашиг.

**Итгэмжлэгдэгч** /*Fiduciary/* Итгэмжлэгдэгч гэж итгэмжлэгчээс хүлээн авсан бэлэн мөнгө, зээл, бусад активыг түүнтэй байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах үүрэг хүлээсэн, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдийг хэлнэ.

**Итгэмжлэгч** /*Trustee/* Итгэмжлэгч гэж өөрийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг итгэмжлэгдэгчийн удирдлагад шилжүүлж, түүнээс гарах үр шимийг өөртөө хүртэх, эсхүл хувь хүртэгчид хүртээх зорилго бүхий иргэн, хуулийн этгээдийг хэлнэ.

**Итгэмжлэл** /*Trust/* Хэлцлээр олгогдсон төлөөлөх бүрэн эрхийг ойлгоно.

**Итгэмжлэлийн гэрээ** /*Trust deed/* Итгэмжлэлийн гэрээ гэж итгэмжлэгчийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор итгэмжлэгч, итгэмжлэгдэгчийн хоорондын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ.

**Итгэмжлэлийн данс /Trust account/** Итгэмжлэгдэгч өмчийн татвар, ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалын хураамж зэргийг төлөх үүднээс хөрөнгө байршуулж буй данс. Итгэмжлэлийн дансыг эскроу данс гэж мөн нэрлэдэг.

## К

**Картын гүйлгээ гүйцэтгэгч байгууллага /Acquiring financial institution/** Өдөр тутмын картын гүйлгээг гүйцэтгэгч санхүүгийн байгууллага буюу банк.

**Кастодиан банк /Custodian bank/** Кастодиан банк нь харилцагчийн төрөл бүрийн санхүүгийн актив буюу биет болон биет бус үнэт цаасыг найдвартай хадгалах үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллага юм.

**Компани /Company, Corporation/** Хувьцаа эзэмшигчдийн мэдэлд буй хуулийн этгээд. Компани алдагдал хүлээсэн нөхцөлд хувьцаа эзэмшигчид эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр алдагдлыг хариуцна.

**Компанийн бонд /Corporate bond/** Компанийн зүгээс эх үүсвэр босгох зорилгоор хөрөнгө оруулагчдад худалдаалж буй өрийн бичиг юм. Компанийн энгийн бонд худалдан авагч нь компанийг эзэмшигч биш бөгөөд ашиг хүртэхгүй. Бондын хүү нь компанийн зээлжих зэрэглэлийн үнэлгээнээс хамаардаг.

**Компаний засаглал /Corporate governance/** Компанийн засаглал гэж компаниудыг чиглүүлэх, хянах бүтэц болон үйл явцуудыг хэлнэ. Компанийн засаглалыг хамгийн энгийнээр тодорхойлбол компанийн ирээдүйд хаана байх стратегийг тодорхойлдог эзэн, өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж байгаа гүйцэтгэх удирдлагын харилцаа юм. Азийн хямралын дараа 1999 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХ)-аас компаний засаглалын зарчмуудыг тодорхойлсон байдаг. Ингэснээр компаний засаглалын хууль эрх зүй, институционал, зохицуулалтын орчинг үнэлж цэгнэх боломжтой болов.

**Компанитай холбоотой эрсдэл /Firm specific risk/** Тархааж болохуйц эрсдэлийг харна уу.

**Купон бонд /Coupon bond/** Купон бонд гэдэг нь хугацааны тодорхой үеүдэд купоны төлбөр төлж, хугацааны эцэст нэрлэсэн үнээрээ эргэн төлөгддөг бонд юм.

**Купоноос салгах /Stripped of coupons/** Тухайн бондын хүүгийн төлбөрийг үндсэн төлбөрөөс нь салгах замаар хоёр шинэ бонд бий болгох үйл явц. Купоноос салгаснаар анхдагч бонд нь тэг купонтой бонд болж хувирах бол хүүгийн төлбөрүүд нь мөн ялгаагүй тэг купонтой тусдаа бонд болно. Нэрлэсэн үнээс хямдруулалтын хувийг тооцох замаар хоёр шинэ бондын зарагдах үнийг тооцно. Ингэхдээ хугацаанаас хамаарч хямдруулалтын хувь харилцан адилгүй байх болно.

**Купоны хүү /Coupon rate/** Бондын нэрлэсэн үнээс тооцон тодорхой үеүдэд (тухайлбал, хагас жил тутамд) бонд эзэмшигчид төлөх хүүгийн хувь хэмжээ. Тухайлбал, 1 сая төгрөгийн үнэтэй, хагас жил тутамд купоны төлбөр төлөх бондын купоны хүү нь жилийн 6% гэвэл 6 сар тутамд 30 мянган төгрөгийн купоны төлбөрийг бонд эзэмшигч (хөрөнгө оруулагч)-д төлнө.

**Куртозис /Kurtosis/** Хэдж сангийн хувьд түгээмэл хэрэглэгддэг магадлалын онол, тархалттай холбоотой ойлголт. Куртозис нь тархалтын “өндөр” болон тархалтын “сүүл”-ний зузааныг хэмжинэ. Тархалтын куртозис өндөр байх тусмаа (3-аас их) энгийн тархалтыг бодвол оргил нь өндөр, сүүл нь зузаан байна. Энэ нь өндөр эрсдэл, улмаар алдагдлын илэрхийлэл байдаг тул арилжааны мэргэжилтнүүд хамгийн бага куртозистай активыг сонгохыг илуүд үздэг. Куртозисыг экспесс буюу экспессийн коэффициент гэх нь ч бий.

## Л

**Лиценз /License/** Лиценз олгох гэдэг нь зөвшөөрөх гэсэн утгыг илэрхийлнэ. Лиценз гэдэгт энэхүү зөвшөөрөл, эсхүл зөвшөөрлийг тусгасан баримт бичгийг ойлгоно.

**Ломбард хүү /Lombard rate/** Зарим улсад Төв банкнаас банкуудад олгож буй барьцаат зээлийн хүүг ломбард хүү гэж нэрлэдэг. Энэ нь банк хоорондын захын хүүгээс өндөр хүү байна.

Лондонгийн банк хоорондын захын хүү */LIBOR/* Банкуудын хоорондоо богино хугацаат зээл өгөх жишиг хүү юм. Энэ хүүг Лондонгийн банк хоорондын зах дээр тодорхой банкуудын харилцан бие биедээ богино хугацаат зээл олгож буй хүүгийн дунджаар тооцно. Валютын төрөл болон хугацаагаараа ялгаатай тооцогдох бөгөөд хамгийн түгээмэл ашиглагддаг хүү нь америк долларын зээлийн Зарын хүү юм.

## M

**Мезанин санхүүжилт** */Mezzanine financing/* Өрийн болон хувь эзэмшлийн санхүүжилтийн завсрын хувилбар. Тус төрлийн санхүүжилт нь ихэвчлэн компанийн үйл ажиллагааг тэлэхэд чиглэгддэг. Зээл хугацаандаа, эсхүл бүрэн хэмжээгээр төлөгдөөгүй нөхцөлд мезанин санхүүжилт нь өрийг хувьцаанд хөрвүүлэх боломжийг зээлдүүлэгчид олгоно.

**Мобайл банк** */Mobile banking/* Харилцагч өөрийн гар утсаа ашиглан харилцагч банкин дахь данснаасаа төлбөр төлөх, мөнгө шилжүүлэх, дансны үлдэгдэл шалгах гэх мэт харилцагч банкаас зөвшөөрсөн төрөл бүрийн банкны санхүүгийн үйлчилгээ юм.

**Монголбанк** */Bank of Mongolia/* Монгол Улсын Төв банк. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

**Мөнгө угаах** */Money laundering/* Илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилснийг ойлгоно. Хар тамхины наймаа, хууль зэвсгийн наймаа гэх мэт нь хууль бус үйл ажиллагааны жишээ юм.

**Мөнгөн гүйлгээний тайлан** /Cash flow statement/ Байгууллагын тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг харуулсан тайлан. Мөнгөн гүйлгээний тайлан нь компанийн мөнгөн хөрөнгийн өөрчлөлт, түүний шалтгааныг үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаар ангилан харуулна. Санхүүгийн тайлангийн гадаад мэдээлэл хэрэглэгчид мөнгөн гүйлгээний тайланг ашиглан аж ахуйн нэгжийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө бий болгох чадварыг үнэлдэг бол тухайн аж ахуйн нэгж нь өөрийн мөнгөн хөрөнгийн хэрэгцээг тодорхойлоход ашиглана.

**Мөнгөн суурьт арга** /Cash method/ Бэлнээр мөнгө хүлээж авсан үед нь орлогод, бэлнээр мөнгө төлсөн үед нь зардалд бүртгэх нягтлан бодох бүртгэлийн арга.

**Мөнгөн тэтгэмж** /Allowance/ Хэн нэгэнд ямар нэгэн зорилгоор тодорхой давтамжтайгаар төлөх, хуваарилах мөнгө (тухайлбал, эцэг эхчүүд хүүхэддээ хувийн хэрэглээнд нь зориулан мөнгө өгдөг); заримдаа үзүүлсэн үйлчилгээний төлбөр байдаг.

**Мөнгөн хөрөнгийн удирдлага** /Money management/ Санхүүгийн болон хэрэглэгчийн зорилтуудыг хангах орлого, зарцуулалтын систем.

**Мөнгөн хөрөнгийн урсгал** /Cash flow/ Мөнгөн хөрөнгийн урсгал нь бизнесийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бэлэн мөнгөний хэмжээг тодорхойлно. Энэ нь аж ахуйн нэгжийн тайлант хугацаанд олсон ашгаас өөр үзүүлэлт юм.

**Мөнгөн хөрөнгийн урсгалын нийцтэй байдал** /Cash flow matching/ Хөрөнгө оруулалтын багцаас орж ирэх мөнгөн хөрөнгийн урсгалыг санхүүгийн үүргээр хүлээсэн мөнгөн хөрөнгийн гарах урсгалтай нийцүүлэх стратеги. Тухайлбал, бондын хүүгийн орлогыг ирээдүйд төлөх зээлийн төлбөртэй хугацааны хувьд давхцуулах нь хөрвөх чадварын эрсдэл орохоос хамгаална. Даатгалын сан болон тэтгэврийн сангийн хувьд энэ асуудал маш чухал байдаг.

**Мөнгөн хөрөнгийн урсгалын шинжилгээ** /Cash flow analysis/ Тодорхой хугацааг хамруулан компанийн мөнгөн хөрөнгийн орох, гарах урсгалд хийж буй шинжилгээг хэлнэ. Шинжилгээ нь эхлэлтийн балансаар эхэлж, тухайн хугацааны

туршид компанийн орж, гарсан мөнгөн хөрөнгийг бүртгэсний эцэст эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

**Мөнгөний зах /Money market/** Mash өндөр хөрвөх чадвартай, эрсдэл багатай, 1 жилээс богино хугацаатай санхүүгийн хэрэгслүүд арилжаалагддаг санхүүгийн захыг мөнгөний зах гэнэ.

**Мөнгөний захын данс /Money market account, Money market deposit account/** Хүүгийн орлого авчирдаг данс (чекийн данстай төстэй). Тус дансанд хүссэн үедээ мөнгө нэмж хийх боломжтой. Зарим дансны хувьд мөнгөн зарлага гаргах боломж хязгаарлагдмал байдаг (мөнгө гаргавал торгууль төлнө). Мөнгөний захын хадгаламжийн данс гэх нь ч бий.

**Мөнгөний захын хамтын сан /Money market mutual fund (MMMF)/** Зөвхөн мөнгөний захын богино хугацаатай хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийх сан. Хамтын сан нь өгөөж багатай (эрсдэл багатай) хэрэгслүүдэд хөрөнгө оруулдаг ч хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хадгалж чаддаг байна.

**Мөнгөний захын хөрөнгө оруулалтын сан /Money-market fund/** Хамтын сангийн нэг хэлбэр бөгөөд мөнгөний зах дээр буюу Засгийн газрын богино хугацаат үнэт цаас, хадгаламжийн сертификат гэх мэт богино хугацаат, өндөр чанартай, түргэн борлогдох активуудад хөрөнгө оруулалт хийдэг. Энэ сангийн хөрөнгө оруулалтын эрсдэл нь хамгийн бага байдаг. Харин үүнийг дагаад түүний өгөөж хамгийн бага байдаг.

**Мөнгөний үнэ цэнэ /Value of money/** Мөнгөний бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах чадвар. Хүн төрөлхтний түүхэнд мөнгөний үүргийг гүйцэтгэж байсан олон зүйл байдаг. Мөнгө нь өөрөө үнэ цэнэтэй зүйл байх албагүй юм. Мөнгөний үнэ цэнийг бий болгож буй зүйл нь хүмүүс түүнийг хүлээн зөвшөөрдөгт оршино.

**Муу авлага /Bad debts/** Эргэн төлөгдөх найдвартай болсон авлага.

**Мүүдисийн үнэлгээ /Moody's rating/** Moody's нэртэй олон улсын үнэлгээний байгууллагаас улс орон болон компанийн зээлжих чадвар буюу зээлээ эргүүлэн төлөх найдвартай

байдлыг үнэлж зэрэглэл тогтоосон үнэлгээ. Aaa, Aa1, Aa2 гэх мэтээр тэмдэглэдэг.

**Мэдээллийн харьцаа /Information ratio/** Багцын хүлээгдэж буй, эсхүл жишиг хүүгээс давсан өгөөжийг өгөөжийн стандарт хазайлтад харьцуулсан харьцаа. Энэ харьцаа нь хөрөнгө оруулагч 1 нэгж нэмэлт эрсдэл хүлээнээрээ өгөөжөө хэдээр нэмэгдүүлж чадаж байгааг буюу хөрөнгө оруулагчийн үр ашгийг харуулдаг. Өөрөөр хэлбэл, жишиг багцтай харьцуулахад өндөр эрсдэл хүлээсэн боловч өгөөжөө түүнийг нөхөх хэмжээнд нэмэгдүүлж чадаагүй бол энэ нь үр ашиг муутай хөрөнгө оруулалт юм.

**Мэдээлэх өдөр /Announcement date/** Компанитай холбоотой ямар нэгэн шинэ мэдээлэл олон нийтэд мэдээлэгдэх өдөр. Тухайлбал, компани өөрийн борлуулалт, ашгийн мэдээгээ зарлах, шинэ төсөл хэрэгжүүлэх, удирдлага солигдох, өөр компанийн нэгдэх, шинэ бүтээгдэхүүн гаргах болсон тухай гэх мэт. Эдгээр шинэ мэдээлэл нь хувьцааны үнийг өөрчилж, улмаар компанийн үнэлгээг өөрчилдөг.

## Н

**НАСДАК /NASDAQ/** АНУ-ын хөрөнгийн бирж. Үнэт цаасыг худалдах, худалдан авах дэлхийн цахим зах зээл. Зах зээлийн үнэлгээгээр дэлхийд хоёрт буюу Нью-Йоркийн хөрөнгийн биржийн дараа ордог. Техник, технологийн дэвшлээр дэлхийд тэргүүдэг 3000 компанийн хувьцааг арилжаалдаг (NASDAQ индекс).

**Нийлмэл хүү /Compound interest/** Нийлмэл хүүгийн аргачлал нь тодорхой хугацааны эцэст бодогдсон хүүгийн орлого нь дараагийн хүү тооцох суурийг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл, хүүгээс хүү бодох аргачлал юм. Тухайлбал, 8 хувийн энгийн хүүтэй дансанд 2000 төгрөгийг байршуулбал нэг жилийн дараа 160 төгрөгийн хүүгийн орлого олж дансны үлдэгдэл нь 2160 төгрөг болно. Харин 8 хувийн нийлмэл хүүтэй буюу хагас жил тутамд хүү хуримтлуулах дансанд мөнгөө байршуулбал  $2163.2 = 2000 * (1 + \frac{8\%}{100})^2$  болно. Өөрөөр хэлбэл, нийлмэл хүү нь энгийн хүүгээс 3.2 төгрөгийн илүү өгөөжтэй байна.

**Нийт зээлийн шугам** /Total credit line/ Зээлийн шугам гэдэг нь зээлдүүлэгч зээлийн дээд хэмжээг тогтоож, зээлдэгч түүнээс илүү гаргахгүйгээр зээл авах бөгөөд буцаан төлөх чөлөөт хуваар্তай зээлийн тусгай эрх юм.

**Нийт орлого** /Gross income, Gross pay/ Татвар болон бусад суутгалын өмнөх нийт орлогын (цалин хөлс гэх мэт) дүн.

**Нийт хөрөнгийн эргэлт** /Total asset turnover/ Борлуулалтыг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа. Борлуулалтын орлогыг бий болгоход хөрөнгийг хэр үр ашигтай ашиглаж байгааг илтгэнэ.

**Ногдол ашгийн өгөөж** /Dividend yield/ Нэгж хувьцааны жилийн ашгийн хэмжээг нэгж хувьцааны зах зээлийн үнэд харьцуулж тооцно. Энэ өгөөж нь зах зээлийн үнэлгээний хэдэн хувьтай тэнцэх ашиг олж байгааг харуулах боловч хувьцааны үнийн өсөлтийн өгөөжийг тусгадаггүй. Тиймээс нийт өгөөжийг олохын тулд ашгийн өгөөж дээр үнийн өсөлтийн өгөөжийг нэмнэ.

**Ногдол ашгийн хуваарилалтын харьцаа** /Dividend payout ratio/ Энэ нь компани ашгийнхаа хэдэн хувийг ашиг хэлбэрээр хувьцаа эзэмшигчдэд тарааж буйг харуулна. Нэгж хувьцаанд хуваарилсан ашгийн хэмжээг нэгж хувьцаанд ногдох ашигт харьцуулж тооцно.

**Ногдол ашиг** /Dividend/ Компанийн хувьцаа эзэмшигчдэд цэвэр ашгаас хуваарилж буй хэмжээ.

**Нөөцийн зөрүү** /Liquidity gap/ Компаний нийт хөрвөх актив болон өр төлбөрийн ялгаврыг хэмжих хэмжүүр. Санхүүгийн эрсдлийн хэмжүүрүүдийн нэг. Компаний актив нь өр төлбөрөөсөө давж буй эсэхээс хамаарч энэхүү зөрүү нь эерэг эсвэл сөрөг байж болно. Банкуудын хувьд харилцагчид хадгаламжиндаа мөнгө хийх, эсвэл мөнгөө татахаас хамаарч энэхүү зөрүү нь өдрийн турш өөрчлөгдж байдаг.

**Нууц дугаар** /PIN (Personal Identification Number)/ Хувийн санхүүгийн мэдээлэлд нэвтрэх, эсхүл гүйлгээ хийхэд (тухайлбал, ATM машин) хэрэглэх нууц код.

**Нью-Йоркийн Хөрөнгийн Бирж** /New York Stock Exchange (NYSE)/ 1792 онд үндэслэн байгуулагдсан АНУ-ын хөрөнгийн бирж.

**Нэг үнийн хууль /Law of one price/** Ижил үнэт цаас, эсхүл үнэт цаасны багц нь хаана зарагдаж байгаагаас үл хамааран адил үнээр арилжаалагдах ёстой (гүйлгээ, арилжааны зардлыг үл тооцвол) гэсэн нөхцөлийг нэг үнийн хууль гэдэг. Нэг үнийн хууль зөрчигдөх буюу нэг төрлийн үнэт цаас өөр үнээр зарагдаж байгаа бол эрсдэлгүй ашгийн боломж үүснэ.

**Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа /Tier 1 ratio/** Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа. Монголбанкаас энэ харьцааг 2014 оны 9 дүгээр сарын байдлаар 9 хувь буюу түүнээс дээш байхаар тогтоосон байна.

**Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө /Tier 1 capital/** Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө гэдэгт хувьцаат капитал (ердийн хувьцаа, халаасны хувьцаа), цэвэр ашгаас байгуулсан нөөцийн сан болон хуримтлагдсан ашиг, алдагдал, нэмж төлөгдсөн хувьцаа (ердийн хувьцаа) болон хандивын капитал зэрэг орно.

**Нэгдэлт /Merger/** Хоёр болон түүнээс дээш компаниуд нэгдэн нэг компани болохыг хэлнэ.

**Нэгж хувьцаанд ногдох ашиг /Earnings per share/** Нэгж хувьцаанд ногдох ашиг нь ашигт ажиллагааг илэрхийлэх үзүүлэлт бөгөөдэнгийн хувьцаа эзэмшигчдэх хуваарилагдаж болох ашгийн хувийг харуулна. Үүнийг нийт ашгаас давуу эрхтэй хувьцааны ашгийг хасч, энгийн хувьцааны дундаж тоонд харьцуулж тооцно.

**Нэгж хувьцаанд ногдох бүртгэлийн үнэ /Book value per share/** Нэгж энгийн хувьцаанд ногдох компанийн цэвэр активын бүртгэлийн үнэ цэнийг илэрхийлнэ. Компанийн активын цэвэр үнэ цэнийг нийт активаас биет бус актив, богино болон урт хугацаат пассив, давуу эрхтэй хувьцааг хасч тооцно. Компанийн зах зээлийн үнэтэй харьцуулснаар, нэгж хувьцаанд ногдох бүртгэлийн үнэ нь компанийн хувьцаа хэт, эсхүл дутуу үнэлэгдсэнийг илэрхийлж болох юм. Тухайлбал, хувьцаа нь бирж дээр 500 төгрөгөөр арилжаалагдаж буй компанийн бүртгэлийн үнэ цэнэ нь 200 төгрөг байж болно.

**Нэгж хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийн урсгал / Cash flow per share/** Татвар болон элэгдлийн дараах ашгийн хэмжээг компанийн нийт хувьцааны тоонд харьцуулж тооцно.

**Нэгж хэмжээст санхүүгийн тайлан /Common size financial statement/** Нэгж хэмжээст санхүүгийн тайлан нь санхүүгийн тайлангийн шинжилгээнд түгээмэл ашиглагдах бөгөөд тайлангийн бүх үзүүлэлтийг нэг суурь үзүүлэлтийн хувиар илэрхийлж харуулдаг. Тухайлбал, тэнцлийн үзүүлэлтүүдийг нийт актив буюу хөрөнгийн хувиар харуулдаг бол орлогын тайлангийн үзүүлэлтүүдийг нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар харуулдаг.

**Нэгжийн үнэлгээ /Unit pricing/** Хэрэглэгчийн худалдан авах зүйлийн хэмжих нэгжид ногдох зардал (тухайлбал, 1 литр, 1 кг-ын зардал).

**Нэгтгэх /Commingling/** Бусдын мөнгөн хөрөнгийг брокер өөрийн хувийн дансны хөрөнгөтэй нэгтгэх. Жишээ нь, АНУ-ын ихэнх мужид үнэт цаасны арилжааны дэнчинд тавьсан мөнгөн хөрөнгийг брокерийн өөрийн дансанд нэгтгэхийг хуулиар хориглож, тусад нь данс нээхийг шаарддаг.

**Нэмэгдсэн өртөг /Value added/** Нийт бүтээгдэхүүн болон нийт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашиглагдсан завсрын хэрэглээний (завсрын бүтээгдэхүүн) ялгавраар тодорхойлогдоно.

**Нэрлэсэн өгөөж /Nominal rate of return/** Хөрөнгө оруулалтын инфляциар засварлагдаагүй өгөөжийн түвшин.

**Нэрлэсэн үндсэн төлбөр /Notional principal/** Тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд хүү бодоход ашиглах нэрлэсэн буюу номинал (төсөөлсөн) дүн. Үндсэн төлбөр нь гараас гарг шилжихгүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд (тухайлбал, хүүгийн своп) энэхүү ойлголт хамаарна.

**Нэрлэсэн үнэ /Face value, Par value/** Бондын хөрөнгө оруулалтын хувьд хугацааны эцэст бонд эзэмшигчид төлөгдөх мөнгөн дүн юм. Зах зээлийн хүү болон купоны хувиас хамааран бондын хоёрдогч зах дээр арилжаалагдах үнэ нэрлэсэн үнээс их, эсхүл бага байж болно.

**Нэрлэсэн хүү /Nominal interest rate/** Нэрлэсэн хүү гэдэг нь зээл, хадгаламж гэх мэт санхүүгийн хэрэгсэлд санал болгож буй хүү юм. Инфляци нь мөнгөний худалдан авах чадварыг бууруулж байдаг. Хадгаламжийн нэрлэсэн хүү жилийн 12% гэвэл таны 1 сая төгрөг жилийн дараа 1 сая 120 мянган төгрөг болно. Гэвч энэ хугацаанд барааны үнэ (инфляци) 8% өсвөл таны 1 сая төгрөгийн бодит худалдан авах чадвар ойролцоогоор 4% буюу 40 мянган төгрөгөөр л өсөх юм. Инфляци 8%, нэрлэсэн хүү 12% бол инфляциар тохируулсан бодит хүү нь 4% байна.

**Нэхэмжлэлийн өдөр /Billing date/** Өдөр, сар, жил гэх мэт тодорхой давтамжаар нэхэмжлэл гаргадаг өдөр.

**Нэхэмжлэлийн хугацаа /Billing cycle/** Төлбөрийн нэхэмжлэл хоорондын хугацаа. Таны утасны хэрэглээний төлбөр сар бүрийн 12-ны өдөр тасалбар болдог бол таны утасны төлбөрийн нэхэмжлэлийн хугацаа 30 хоног байна.

**Нээлттэй захын үйл ажиллагаа /Open market operations/** Төв банкны зүгээс банкны нөөц, мөнгөний нийлүүлэлтийг хянахын тулд үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагаа.

**Нээлттэй зээл /Open-end credit/** Зээлийн гэрээгээр зээлийн дээд хязгаарыг тогтоох бөгөөд хугацааны эцэст зөвхөн ашигласан зээлээ, хүүгийн хамт эргүүлэн төлдөг. Зээлийн шугамтай адил юм. Энэ нь зээлийн хэмжээ болон зээл авах өдрийг зээлдэгч өөрөө сонгох боломжийг олгодгоороо зээлдэгчид таатай байдаг.

**Нээлттэй позици /Open position/** Хөрөнгө оруулагч ба арилжаандоролцогч ямар нэгэн хөрөнгө оруулалтын позици нээсэн боловч түүний эсрэг позици нээж эрсдэлээ хаагаагүй тохиолдлыг хэлнэ. Нээлттэй позицийг урт ба богино гэж хоёр ангилна. Ирээдүйд үнэ өснө гэсэн хүлээлтээр ямар нэгэн активыг худалдан авч нээлттэй позици үүсгэхийг урт позици гэнэ. Харин ирээдүйд үнэ унана гэсэн хүлээлтээр зээлсэн ямар нэгэн активыг худалдах, нээлттэй позици үүсгэхийг богино позици гэнэ. Тухайлбал, ам.долларын ханшийн өсөлтөөс ашиг олох зорилгоор өнөөдөр ам.доллар худалдан авсан, эсхүл худалдахаа хойшлуулсан гэж үзье. Хэрэв ирээдүйд ам.доллараа худалдах форвард, своп гэх

мэт ямар нэгэн хамгаалалтын гэрээ байгуулж эсрэг позици нээгээгүй бол ам.долларын нээлттэй урт позици үүснэ. Эсрэгээр ам.доллар зээлж, ам.долларын ханш супарна гэсэн хүлээлтээр өнөөдөр худалдсан бол ам.долларын богино позици үүснэ. Энэ тохиолдолд ам.долларын зээлээ эргүүлэн төлөх үед ам.доллар буцаан худалдан авах тул ам.долларын ханш хүлээсний дагуу супарвал ашиг олох боловч чангартал алдагдал хүлээнэ. Өөрөөр хэлбэл, уг нээлттэй богино позици нь ханшийн эрсдэл үүсгэж байна.

**Няглан бодох бүртгэлийн стандарт /Accounting standards/** Няглан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн, нийтээр дагаж мөрдөх стандарт.

## О

**Овердрафт /Overdraft/** Харилцагч тодорхой хязгаарын хүрээнд дансны үлдэгдлээсээ илүү хэмжээний мөнгө данснаасаа авсан үед бий болох богино хугацаат зээл.

**Олгосон цалин /Net pay, Take-home pay/** Олговол зохих цалингийн дүнгээс татвар болон бусад суутгалыг хассан дүн.

**Олсон орлого /Earned income/** Хийж гүйцэтгэсэн ажлын төлөө авч буй мөнгөн дүн. Тухайлбал, цалин, цайны мөнгө, шимтгэл гэх мэт.

**Он-лайн банк /Online banking/** Интернетийн сүлжээг ашиглан харилцагч банкин дахь дансаа ашиглан төлбөр төлөх, мөнгө шилжүүлэх, дансны үлдэгдэл шалгах гэх мэт банкнаас зөвшөөрөгдсөн санхүүгийн гүйлгээг хийх банкны үйлчилгээ.

**Опцион /Option/** Санхүүгийн үүсмэл хэрэгсэл. Санхүүгийн хэрэгслийг тодорхой хугацааны дараа, урьдчилж тохирсон үнээр арилжаалж болох эрхийг хэлнэ.

**Опцион бичигч /Writer/** Худалдан авагчаас хураамжийн төлбөр авч буй опцион худалдагч. Жишээ нь, опцион бичигч худалдан авах эрхтэй опцион дээр богино позицитой бөгөөд хэрэв худалдан авах эрхтэй опционыг хэрэгжүүлбэл опцион бичигч тухайн үнэт цаасыг тохиролцсон үнээр худалдах ёстой болно. Харин худалдах эрхтэй опцион

бичигчийн хувьд урт позицитой тохиолдолд тухайн үнэт цаасыг тохиролцсон үнээр худалдан авах ёстой болно.

**Опционы барьцаагүй худалдаа /Naked option writing, Uncovered option writing/** Гэрээнд тусгагдсан актив дээр ямар нэгэн позици (Опцион дээр нээгдсэн позицоо хаах) нээлгүйгээр опционы гэрээнд үүрэг хүлээх буюу бичихийг хэлнэ.

**Опционы үнэ /Option premium/** Опцион худалдан авагч талаас опцион бичигч талд опционы гэрээний төлбөр болгон төлж буй үнэ.

**Орлого /Gain/** Мөнгөн орлогын дүн.

**Орлого /Income/** Эдийн засгийн нөөц нийлүүлсний (түрээслэсний) төлөө өрхийн аж ахуйн секторт төлж буй төлбөр (цалин, хүү, ашиг).

**Орлого /Revenue/** Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авагчдад зарж борлуулснаас олох мөнгө (ashiг биш).

**Орлогын бонд /Revenue bond/** Орон нутгийн засаг захиргаанаас усан хангамжийн объект, зам, онгоцын буудал, боомт, цахилгаан станц барих зорилгоор гаргадаг бонд. Тус бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг татварын орлогоор бус харин бондоор санхүүжүүлсэн төслөөс орж ирэх орлогоор барагдуулна.

**Орлогын голч /Median income/** Дундаж орлогыг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг. Хүн амын 50 хувь нь тухайн орлогын түвшнээс доогуур, харин 50 хувь нь дээгүүр байх түвшинг орлогын медиан гэнэ. Орлогын ялгаа ихсэх тусам орлогын үзүүлэлтийг арифметик дунджаар бус харин медианаар төлөөлүүлэх нь тохиромжтой.

**Орлогын дахин хуваарилалт /Redistribution of income/** Засгийн газраастатвар, зарцуулалт болон хүн амын зорилтот бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөрүүдээр дамжуулан орлогыг (мөнгөн, эсхүл биет хэлбэрээр) шилжүүлэх явдал. Ажилчдыг дахин сургалтад хамруулах, хувийн секторын хүний нөөцдөд (тухайлбал, боловсрол) хийх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөрүүд. Орлогын дахин хуваарилалтын зорилго нь мөнгийг өндөр орлоготой бүлгүүдээс бага орлоготой бүлгүүдэд шилжүүлэхэд оршино.

**Орлого олдог актив /Earning assets/** Хүүгийн эсвэл ногдол ашгийн гэх мэт ямар нэгэн орлого олдог активыг хэлнэ. Тухайлбал, үнэт цаас, зээл гэх мэт.

**Орлогын тайлан /Income statement/** Компанийн олсон орлого, гаргасан зардлыг тодорхой хугацаагаар (тухайлбал, сар, улирал, жил) тасалбар болгон харуулсан тайлан.

**Оролцогч тал /Stakeholder/** Байгууллагын хөрөнгө оруулагчид, ажиллагсад, бэлтгэн нийлүүлэгчид гэх мэт тухайн байгууллага, аж ахуйн нэгжтэй ямар нэгэн байдлаар холбоотой талуудыг хэлдэг. Хамгийн түгээмэл ойлголт бол компани, төсөл зэрэг ямар нэгэн зүйлд хөрөнгө оруулсан этгээдийг оролцогч тал гэж ойлгодог.

**Орон нутгийн бонд /Municipal bond/** Орон нутгийн засаг захиргаанаас хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан өрийн бичиг. Ихэнхдээ тухайн орон нутгийн татвараас чөлөөлөгддөг. Бондын адилаар хөрөнгө оруулагчид хүү, хугацаа, эрсдэлийг харгалзан үздэг.

**Оффшор /Offshore, Off-shore/** Татварын болон бусад хөнгөлөлтийг гадаадын компаниудад эдлүүлэх замаар гадаадын хөрөнгийг татаж буй санхүүгийн төв. Оффшорыг ашиглах нь татварын хэмжээг бууруулах хамгийн үр дүнтэй аргуудын нэг юм. 2013 оны байдлаар оффшор бүсэд 18.5 их наяд ам.долларын хөрөнгө эргэлдэж байж болзошгүй гэсэн мэдээ байдаг.

**Оффшор банк /Offshore banking/** Олон улсын санхүүгийн зах дээр үйл ажиллагаа явуулж байгаа банкны салбар нэгжийг хэлдэг.

## Ө

**Өглөгийн данс /Accounts payable/** Байнгын бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай холбоотой зээлийн үйл ажиллагаанаас үссэн өр төлбөрийг хэлнэ.

**Өгөөж /Return/** Хөрөнгө оруулалтаас олох ашиг, ихэвчлэн хувиар илэрхийлэгдэнэ.

**Өгөөж /Yield/** Үнэт цаас (хувьцаа, бонд)-наас олж буй ашиг, хүүгийн орлоготой холбоотой ойлголт. Тухайлбал, хувьцааны үнэ 50 ам.доллар ба нэгж хувьцаанд 50 центийн

ашгийг тухайн улиралд хуваарилсан бол ашгийн өгөөж 4% [(50 цент x 4 улирал) / (\$50)] болно. Ашгийн хэмжээ хэвээрээ, харин хувьцааны үнэ 100 ам.доллар болж өсвөл өгөөж нь 2% болж буурахаар байна.

**Өгөөжийн дундаж хувь /Average rate of return/** Хөрөнгө оруулалтын ашигт ажиллагааг хэмжих нэг үзүүлэлт. Нэг жилд ногдох цэвэр ашгийг хөрөнгө оруулалтын анхны дүнд харьцуулан тооцно. Тухайлбал, Дорж 800 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн гэж саная. Бүх зардлыг хассаны дараа Дорж эхний жилд 65 сая, 2 дахь жилд 71 сая, гурав дахь жилд 69 сая, дөрөв дэх жилд 70 сая төгрөгийн ашиг олсон гэе. Тэгвэл нийт цэвэр ашиг нь 275 сая төгрөг болох ба үүнийг 4 жилд хуваавал жилийн дундаж өгөөж нь 68.75 сая төгрөг болохоор байна. Энэ 68.75 сая төгрөгийг 800 сая төгрөгт харьцуулвал өгөөжийн дундаж хувь буюу 8.59% байхаар байна.

**Өгөөжийн зөрүү /Yield spread/** Өрийн хэрэгслүүдийн өгөөжийн зөрүү. Нэг өрийн хэрэгслийн өгөөжөөс нөгөө хэрэгслийн өгөөжийг хасч тооцно. Зөрүүг харилцан адилгүй хугацаатай, зээлжих зэрэглэлтэй, эрсдэлтэй өрийн хэрэгслүүдийн хувьд тооцож болно. Тухайлбал, Засгийн газрын 5 жилийн хугацаатай бондын өгөөж 5%, харин 30 жилийнх 6% бол өгөөжийн зөрүү нь 1% болно.

**Өгөөжийн муруй /Yield curve/** Адил төстэй бондуудын өгөөжийг хугацаанаас нь (тухайлбал, 2 сар, 2 жил, 20 жил гэх мэт) хамааруулан харуулсан муруй.

**Өгөөжийн муруйн дагуу удирдах /Riding the yield curve/** Өгөөжийн муруй ээрэг үед урт хугацааны бондыг худалдан авч, хугацаа нь дуусахаас өмнө зарах хөрөнгө оруулалтын стратеги. Тухайлбал, 10,000 ам.долларын нэрлэсэн үнэтэй, 26-долоо хоногтой, жилийн 10%-ийн өгөөжтэй Засгийн газрын бонд 9,524 ам.доллараар зарагдана. Харин 10,000 ам.долларын нэрлэсэн үнэтэй, 13-долоо хоногтой, жилийн 9%-ийн өгөөжтэй засгийн газрын бонд 9,780 ам.долларын үнээр зарагдана. 26-долоо хоногтой үнэт цаасыг 13 долоо хоног эзэмшээд 13-долоо хоногтой үнэт цаасны үнээр зарахад 256 ам.долларын ашиг олох ба энэ тохиолдолд жилийн өгөөж нь ( $\$256/\$9,524$ ) \*4 буюу 10.75% болохоор байна.

**Өгөөжийн муруйн эрсдэл /Yield curve risk/** Өгөөжийн муруйн хэлбэр, наалт, шилжилттэй холбоотойгоор тухайн хөрөнгө оруулалтын багцад үүсч буй эрсдэл. Өгөөжийн муруй дээрх бүх хугацаанд харгалзах хүүнүүд ижил хэмжээгээр шилжих тохиолдолд хөрөнгө оруулагчийн багц нь өгөөжийн муруйтай параллель шилжилт хийх хандлагатай байдаг. Гэвч бодит байдал дээр өгөөжийн муруй ингэж хөдөлдөггүй. Муруй илүү босоо болоход богино хугацааны хүүтэй харьцуулахад муруйн төгсгөл дэх (урт хугацааны) өгөөж өснө, муруй хэвтээ болоход төгсгөл дэх (урт хугацааны) өгөөж эхлэл дэх (богино хугацааны) өгөөжээс илүү хурдацтай буурна. Учир нь хүүгийн эрсдэлийн аливаа хэмжүүрт өгөөжийн муруй дээрх шилжилт ижил хэмжээтэй байх бөгөөд хөрөнгө оруулагчийн багц хэрхэн хариу үйлдэл үзүүлж буйн ойролцоо хэмжигдэхүүн байна гэж үздэг. Энэхүү ойролцоо хэмжигдэхүүн нь өгөөжийн муруйн бодит шилжилттэй нийцэхгүй байх цар хүрээгээр эрсдэл тодорхойлогдоно.

**Өгөөжийн хувь /Rate of return/** Хөрөнгө оруулалтаас олох ашиг бөгөөд хөрөнгө оруулсан дүнгийн хувиар жилийн үндсэн дээр тооцно.

**Өгөөжийн хугарлын хувь /Internal rate of return/** Тухайн төсөл, хөрөнгө оруулалтын орох, гарах мэнгэн урсгалын өнөөгийн үнэ цэнэ тэгтэй тэнцэх үеийн хүү. Энэ үзүүлэлтийг тооцох нь хэд хэдэн төсөл, хөрөнгө оруулалтыг харьцуулах боломжийг бурдуулж, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой байдаг. Жишээ нь, А компани 30 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авахаар болжээ. Уг тоног төхөөрөмжийг 3 жил ашиглах бөгөөд жилд 15 сая төгрөгийн ашиг олох бололцоотой гэж үзсэн. Ашиглалтын эцэст 1 сая төгрөгөөр борлуулна гэж тооцсон бол уг төслийн өгөөжийн хугарлын хувийг дараах байдаар тооцно:

$$0 = -30,000,000 + \frac{15,000,000}{1+IRR} + \frac{15,000,000}{(1+IRR)^2} + \frac{15,000,000}{(1+IRR)^3} + \frac{1,000,000}{(1+IRR)^4}$$

IRR=24.31% гарна. Үүнийг бусад хөрөнгө оруулалт, төслийн өгөөжийн хугарлын хувьтай харьцуулж, уг тоног төхөөрөмжийг худалдан авах эсэхээ шийдвэрлэнэ.

**Өгөөж-хэлбэлзлийн коэффициент /Reward-to-volatility ratio/** Хөрөнгө оруулалтын илүүдэл өгөөжийг багцын стандарт хазайлтад харьцуулсан харьцаа. Мөн Шарпе

харьцаа гэж хэлдэг бөгөөд экс-анте Шарпе харьцааг дараах томьёогоор тооцно:  $= \frac{\bar{r}_p - r_f}{\delta_p}$  Энд  $\bar{r}_p$  -багцын хүлээгдэж буй өгөөж,  $r_f$ -эрсдэлгүй өгөөж,  $\delta_p$ -багцын стандарт хазайлт. Экс-пост Шарпе харьцааг дээрхтэй ижил томьёогоор бодох боловч багцын хүлээгдэж буй өгөөжийн оронд багцын бодит өгөөжийг ашиглана.

**Өгөөш хаях үйлдэл /Bait and switch/** Тухайн барааг хямд хэмээн хуурамч сурталчилгаа хийж хэрэглэгчдийг татах, улмаар тус бараа борлогдож дууссан хэмээн тайлбарлаж илүү үнэтэй бараа зарах үйлдэл.

**Өмнөх үеийн үлдэгдэл /Previous balance/** Зээлийн өрийн үлдэгдлийг өмнөх сарын байдлаар харуулна. Энэ сарын гүйлгээнүүд (худалдан авалт, дансанд хийсэн мөнгө гэх мэт) өмнөх сарын үлдэгдэл орохгүй.

**Өндөр эрсдэлтэй бонд /Junk or Speculative-grade bond/** S&P-ийн BBB-гээс, эсхүл Мүүдизийн Baa-ээс доош зэрэглэлтэй бондыг хэлнэ.

**Өнөөгийн үнэ цэнэ /Present value/** Ирээдүйн мөнгөн хөрөнгийн өнөөдрийн үнэ цэнийг тооцох явдал. Тухайлбал, хямдруулалтын хүү 10% гэвэл 1 жилийн дараа олох 1 сая төгрөгийн өнөөдрийн үнэ цэнэ нь  $1,000,000/(1+10\%/100)=909,091$  болно. Энэ нь 1 жилийн дараах 1 сая төгрөг өнөөдрийн 909,091 төгрөгтэй тэнцүү үнэ цэнэтэй болохыг харуулж байна.

**Өрийн хөрөнгийн өгөөж /Return on equity/** Компанийн ашигт ажиллагааны хэмжүүрийн нэг. Тухайн жилийн компанийн ашгийг өөрийн хөрөнгөд нь харьцуулж тооцно. Тус үзүүлэлт нь компанийн нэг төгрөгийн өөрийн хөрөнгө хэдэн төгрөгийн ашгийг бий болгож буйг харуулна.

**Өрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа /Capital adequacy ratio/** Банкны өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлэгчдийн эзэмшлийн хөрөнгийг эрсдэлээр жигнэсэн активт харьцуулж тооцно. Банкны зохицтой харьцааны шалгуураар энэ харьцааны доод хязгаарыг зааж өгдөг. Тиймээс энэ харьцаа өндөр байх нь банкуудын эрсдэл даах чадвар өндөр байна гэсэн үг юм.

**Өр /Debt/** Бусдад төлөх ёстой мөнгө (хувь хүн, компани, эсхүл Засгийн газрын өр байж болно).

**Өр төлбөр /Liability/** Өр төлбөрөө төлөх хуулиар хүлээсэн үүрэг.

**Өр төлбөрийг барагдуулах /Liquidate/** Компанийн үйл ажиллагааг зогсоох явдал; компанийн өр төлбөрийг тогтоож, хөрөнгийг нь борлуулах замаар зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулна.

**Өр, өөрийн хөрөнгийн харьцаа /Debt-to-equity ratio/** Энэ нь компанийн санхүүгийн хөшүүрэг, санхүүгийн эрсдэлийн хэмжүүр юм. Тухайн компанийн нийт өглөг, өр төлбөр хэлбэрээр бий болгосон эх үүсвэрийг өөрийн хөрөнгөд харьцуулж тооцно. Тус харьцаа өсөх нь тухайн компанийн санхүүгийн эрсдэл нэмэгдэж буйг илтгэнэ.

**Өргөдлийн хураамж /Application fee/** Өргөдөл хүлээн авах үед зээл хүсэгчээр төлүүлдэг хураамж. Тус хураамжийн мөнгөөр зээлийн өргөдөл боловсруулах зардлыг санхүүжүүлнэ.

**Өрийн бичиг /Debt security/** Өрийн бичиг нь мөнгө зээлсэн болохыг баталгаажуулж, зээлийн хүү, хугацаа болон бусад нөхцөлийг тусгасан үнэт цаас буюу санхүүгийн хэрэгслийг хэлнэ. Өрийн бичиг нь Засгийн газрын бонд, компанийн бонд, хадгаламжийн сертификат, хөрөнгөөр баталгаажсан төрөл бүрийн үнэт цаас гэх мэт төрлүүдтэй байдаг.

**Өрийн үйлчилгээ /Debt service/** Өрийн үйлчилгээ гэдэг нь 1 жилийн хувьд тооцсон эргүүлэн төлөх зээлийн үндсэн дүн болон хүү юм. Тухайлбал, 100 мяанган төгрөгийг 10 жилийн хугацаатай, 9% хүүтэйгээр зээлдсэн гэвэл эхний жилд төлөх үндсэн болон хүүгийн төлбөр нь 6,333.79 төгрөг болно. Энэ төлбөрийн дүн нь эхний жилийн “өрийн үйлчилгээ” юм.

**Өртөмтгийн байдал /Exposure/** Аливаа хор хөнөөлтэй зүйлийн эсрэг хамгаалалтгүй байх нөхцөл байдал. Тухайлбал, валютын ханшийн хэлбэлзэл нь компанийн мөнгөн гүйлгээ, гадаад хөрөнгө оруулалт болон ашиг орлогод сөргөөр нөлөөлж болох ба үүнийг эдийн засгийн өртөмтгийн байдал гэдэг.

**Өршөөл /Forbearance/** Эргэн төлөгдөхгүй байгаа зээлд эргэн төлөлтийг тодорхой хугацаагаар хойшлуулах боломжийг олгосон зээлдэгч болон банкны хооронд байгуулагдсан гэрээг хэлнэ.

**Өсөлтийн сан /Growth fund/** Активын (тухайлбал, хувьцаа, бонд) үнийн өсөлтийг урт хугацааны зорилтоо болгож буй хамтын сан. Хэдийгээр өсөлтийн сан нь активын үнийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх боломжийг олгох ч нөгөө талдаа хувьцааны үнэ санхүүгийн захын идэвхижлийг даган хэлбэлзэж байдгийг санах хэрэгтэй.

**Өсөлттэй зах зээл /Bull market/** Хөрөнгө оруулагчдын дунд ирээдүйд үнэ өснө гэсэн эерэг итгэл үнэмшил, хүлээлт үүссэн буюу үнэ нь өсч буй зах зээлийг хэлнэ.

**Өсөлттэй хувьцаа /Growth stock/** Зах зээлийн дундаж өсөлтөөс илүү хурдтайгаар өсөн томорч буй компанийн хувьцааг өсөлттэй хувьцаанд багтаана. Өндөр хурдтай өсч, томорч буй компаниуд ашиг тараахаас илүү ашгаараа дахин хөрөнгө оруулалт хийдэг. Ихэнх өсөлттэй компаниуд технологийн салбарын компаниуд, мөн дэвшилтэт технологид суурилан зах зээлд хүчтэй нөлөө үзүүлэх шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниуд байдаг. Өсөлттэй хувьцаанаас үнийн өсөлтийн ашиг олох магадлал өндөр хэдий ч тогтвортой биш байдаг тул үнэ огцом унах эрсдэл мөн өндөр байдаг.

**Өсөн нэмэгдэх татвар /Progressive tax/** Татвар ногдуулах орлого өсөхийн хэрээр татварын хувь хэмжээ буурах үзэгдэл. Жишээ нь, борлуулалтын татвар болон онцгой татвар нь үүний жишээ юм.

**Репо гэрээ /Repurchase agreement/** Худалдагч үнэт цаасыг тохиролцсон хугацааны эцэст гэрээнд тохиролцсон үнээр худалдан авагчаас буцаан худалдан авахаар тохиролцож байгуулсан худалдагч, худалдан авагчийн хоорондын гэрээ. Хөрөнгийг репо гэрээний дагуу хямдруулан худалдан авсан тохиолдолд буцаан худалдан авах үнэ нь анхны худалдсан үнээс их байдаг бөгөөд энэхүү зөрүү нь репо хүү болно.

**Репо хүү /Repo rate/** Ямар нэгэн бонд болон үнэт цаасыг ирээдүйд буцаан худалдан авах нөхцөлтэйгээр зарах замаар богино хугацаат санхүүжилт олж буй санхүүгийн хэлцлийг репо гэрээ гэдэг. Энэхүү репо санхүүжилтээс олж буй өгөөж буюу зээлдэгч талын төлж буй хүүг репо хүү гэдэг.

**Роялти /Royalty/** Патент, зохиогчийн эрх, байгалийн нөөц гэх мэт ямар нэгэн өмчийг ашиглаж, хэрэглэсний төлөө өмчийн эздэд төлж буй төлбөрийг хэлнэ.

## С

**Салбар болон охин компанийн ялгаа /Branch vs Subsidiary/** Салбар нь байгууллагын бизнесийн үйл ажиллагааг хэрэглэгчдэд хүртээмжтэй болгох зорилгоор төв оффисоос салбарлан байгуулагдсан бизнесийн үйл ажиллагааны нэгж юм. Салбар нь хуулийн хувьд бие даасан нэгж биш юм. Харин охин компани нь толгой компанийн харьяанд байх боловч хуулийн хувьд бие даасан этгээд болж үйл ажиллагаа явуулдаг.

**Саналын эрх /Voting right/** Компанийн бодлогыг тодорхойлох, удирдлагыг томилох гэх мэт асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хэлнэ.

**Сангүудын сан /Funds of fund/** Бусад хэдж сангүудад хөрөнгө оруулалт хийсэн хэдж санг хэлнэ.

**Санхүүгийн алдагдлын эрсдэл /Risk of financial loss/** Хөрөнгө оруулалт (үндсэн дүн)-ын дүн буурах магадлал.

**Санхүүгийн жил /Fiscal year/** Аж ахуйн нэгж, компани болон Засгийн газар нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хамарч буй хугацаа буюу санхүүгийн тайланг гаргахад хамруулж буй 1 жилийн хугацааг хэлнэ. Санхүүгийн жил нь хуанлийн жилтэй давхцахгүй байж болно. Тухайлбал, АНУ-ын Холбооны Засгийн газрын санхүүгийн жил нь жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлээд дараа оны 9 дүгээр сарын 30-ны өдөр дуусдаг.

**Санхүүгийн зах /Financial market/** Санхүүгийн зах зээл дээр нэг талаас мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй зээлдүүлэгчид, нөгөө талаас мөнгөн хөрөнгийн хэрэгцээтэй зээлдэгчид уулзан санхүүгийн хэлцэл хийж, зээлэх, зээлдүүлэх

хэрэгцээгээ хангана. Санхүүгийн зах зээл дээр бонд, хувьцаа, гадаад валют, дериватив гэх мэт санхүүгийн хэрэгслүүд арилжаалагдана. Санхүүгийн зах зээлийг арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслээс нь хамааруулан мөнгөний зах, бондын зах, хөрөнгийн зах гэх мэтээр ангила.

**Санхүүгийн зуучлагч** /*Financial intermediary*/ Хөрөнгө оруулалт хийх боломжтой өрх, пүүс (зээлдүүлэгч) болон хөрөнгө оруулалтын эх үүсвэр шаардлагатай өрх, пүүс (зээлдэгч)-ийг холбох, зуучлах үүрэг бүхий санхүүгийн байгууллагуудыг хэлнэ. Банк, хөрөнгө оруулалтын банк, даатгалын компани, хамтын сан гэх мэт санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. Тухайлбал, банкны хувьд авч үзвэл, өрхүүд буюу иргэд банкинд мөнгөө хадгалуулж, банкууд түүнийг хөрөнгийн эх үүсвэр шаардлагатай байгаа пүүс, компаниудад зээлдүүлнэ.

**Санхүүгийн инженерчлэл** /*Financial engineering*/ Харилцагчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үнэт цаас гэх мэт санхүүгийн хэрэгслүүдийг бий болгох, загварчлахыг санхүүгийн инженерчлэл гэдэг.

**Санхүүгийн лизинг** /*Finance lease*/ Санхүүгийн лизинг буюу капиталын лизинг нь урт хугацааны лизинг бөгөөд хөрөнгийг хугацааны эцэст түрээслэгч талд шилжүүлдэг.

**Санхүүгийн тайлан** /*Financial statement*/ Иж бүрэн санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрднэ.

**Санхүүгийн төлөвлөлт** /*Financial planning*/ Богино, дунд, урт хугацааны зорилтыг тодорхойлох явдал. Орлого, зарлагын мэдээллийг цуглуулан судалж, зорилтоо хэрхэн биелүүлэхийг тодорхойлох явдал.

**Санхүүгийн түрээс** /*Leasing*/ Лизинг нь санхүүжилтийн нэг хэлбэр бөгөөд газар, байшин, тоног төхөөрөмж гэх мэт хөрөнгийг тодорхой хугацааны туршид лизинг олгогч талаас лизинг авагч талд түрээсээр ашиглуулах санхүүгийн гэрээ юм. Лизинг авагч нь лизинг олгогчид хөрөнгийг нь ашигласны төлөө тогтсон давтамжийн дагуу лизингийн буюу түрэсийн төлбөр төлнө. Лизингийг тухайн байгууллагын

санхүүгийн тэнцэлд хэрхэн бүртгэх нь лизингийн төрлөөс хамаарна.

**Санхүүгийн үүрэг** /*Financial obligation*/ Санхүүгийн нэр томьёонд санхүүгийн үүрэг гэдгийг өртэй байх, өрийн үлдэгдэлтэй байх гэж ойлгодог. Өөрөөр хэлбэл, хэн нэгэнд тодорхой хэмжээний мөнгийг төлөх үүрэг юм. Хэрэв энэ үүргээ биелүүлж чадахгүй бол төлбөрийн чадварын хүндрэлд орсон гэж үзнэ.

**Санхүүгийн хөрөнгө** /*Financial asset*/ Бонд, хувьцаа, банкны хадгаламж гэх мэт гэрээний дагуу авлага үүсгэж буй хөрөнгийг хэлнэ.


**Санхүүгийн хэрэгсэл** /*Financial instrument*/ Санхүүгийн хэрэгсэл гэдэг нь мөнгөн хөрөнгийн төлбөр төлөх болон хүлээн авах эрх, үүргийг бий болгосон төрөл бурийн худалдаалагдаг активыг хэлнэ. Тухайлбал, засгийн газрын өрийн бичиг гэх мэт.

**Санхүүгийн эрсдэл** /*Financial risk*/ Хөрөнгө оруулалт (хадгаламж, хувьцаа, бонд, хамтын сан гэх мэт)-д хийсэн мөнгөн хөрөнгөө алдах магадлал.

**СВИФТ** /*SWIFT*/ Дэлхий нийтийг хамарсан банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны нийгэмлэг гэсэн үгийн товчлол юм. Дэлхий даяар санхүүгийн байгууллага хооронд төлбөр болон санхүүгийн мэдээ солилцоог гүйцэтгэдэг сүлжээг ажиллуулдаг банкуудын үүсгэн байгуулсан, хамтын хувь зэмшилийн байгууллага юм. СВИФТ төлбөрийн мэдээ нь хөрөнгийн шилжүүлгийн даалгавар болдог бөгөөд хөрөнгө (төлбөр тооцоо)-ийн солилцоо нь төлбөрийн системүүд, эсхүл харилцагч банкны харилцаа холбоогоор дамжуулагдан хийгддэг.

**Своп** /*Swap*/ Хөрөнгө оруулалтын зорилт, эрсдэл, өгөөжийг өөрчлөх, актив, пассивын бүтцээ өөрчлөхийн тулд ямар нэг актив, өр, төлбөр, мөнгөн хөрөнгийн урсгал зэргийг урьдчилж тохиролцсон хүү болон үнээр тодорхой хугацааны эцэст буцаж солигдох нөхцөлтэйгээр өнөөдөр солилцох санхүүгийн хэлцлийг хэлнэ. Свопын хамгийн түгээмэл хэлбэр нь валютын болон хүүгийн своп юм. Жишээ нь, А компани тогтмол хүүтэй зээл авсан боловч хувьсах хүүгээр зээлийн хүүгийн төлбөрийг төлөх сонирхолтой. Харин Б компани хувьсах хүүтэй зээл авсан боловч тогтмол хүүгээр

зээлийн хүүгийн төлбөрөө төлөх сонирхолтой гэе. Доорх хийсвэр жишээнээс харахад хоёр компани хүүгийн своп гэрээ байгуулснаар хоёр талын сонирхол хангагдаж байна. А компани Б-д хувьсах хүү (Лондонгийн банк хоорондын захиын хүү)-гээр төлбөр хийхийг, харин Б компани А-д тогтмол хүү (10%)-гээр төлбөр хийхийг зөвшөөрсөн хүүгийн свопын хэлцэл байгуулна. Ингэснээр А компани банкинд төлөх тогтмол хүүгийн төлбөрөө Б компаниас олох хүүгийн орлогоор бүрдүүлж, харин Б компани Банкинд төлөх хувьсах хүүгийн төлбөрөө А-аас олох хувьсах хүүгийн орлогоор бүрдүүлж байна.



Зураг 2. Хүүний своп

**Системийн эрсдэл /Systemic risk/** Зах зээлийн эрсдэлийг харах.

**Солбисон хэдж /Cross-hedge/** Ямар нэгэн активын эрсдэлийг өөр төрлийн активын фьючерс, форвард гэх мэт үүсмэл хэрэгслээр хамгаалах арга. Энэ нь бүрэн төгс эрсдэлийн хамгаалалт болж чадахгүй ч тодорхой түвшинд эрсдэлийг бууруулна. Тухайлбал, байгалийн хийн фьючерс гэрээ арилжаалагддаггүй тул түүхий нефтийн фьючерс гэрээг ашиглан байгалийн хийн эрсдэлийг бууруулж болно. Уг хоёр бүтээгдэхүүн нь нэг төрлийн биш боловч, тэдний үнийн хөдөлгөөн нь маш ойролцоо байдаг.

**Спекулятив бонд /Junk bond/** Өндөр өгөөжтэй боловч өндөр эрсдэлтэй бонд буюу Стандарт энд Пүүрсийн үнэлгээгээр BB-ээс доош, Мүүдизийн үнэлгээгээр Ba-ээс доош үнэлгээтэй бондыг хэлнэ.

**Спот ханш /Spot rate/** Спот ханш гэж үнэт цаас, валют, эрдэс бүтээгдэхүүн гэх мэт активуудын спот арилжааны зах зээл дээр тогтох байгаа буюу дилерүүдийн санал болгож буй ханш, үнийг хэлнэ.

**Суурь нэгж /Basis point/** Нэг хувийг 100-д хуваасантай тэнцүү. Өөрөөр хэлбэл, 100 суурь нэгж нь 1%-тай тэнцүү юм.

**Суурь таамаглал /Baseline forecast/** Зах зээл тэнцвэртэй үед үнэт цаастай холбоотой бүх мэдээллийг үнэлгээний тооцоонд хамруулан тооцсон үнэт цаасны өгөөжийн таамаглалыг суурь таамаглал гэнэ.

**Суурь хүү /Base rate/** Суурь хүү нь банкны зээлийн бүтээгдэхүүний хүүг тогтоох хамгийн бага хүү юм. Тухайлбал, репо хүү, Төв банкнаас авах богино хугацаат санхүүжилтийн хүү зэрэг хүү нь банкны зээлийн бүтээгдэхүүний суурь хүү болдог.

**Суурь эрсдэл /Basis risk/** Спот болон фьючерс үнийн зөрүүний тодорхой бус байдал. Өөрөөр хэлбэл, спот болон фьючерс захууд дээрх эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулагчдынхүүлээлтээргээсшалтгааланспотболонфьючерс үнүүдийн өөрчлөлт ижил байдаггүй тул эдгээр үнүүдийн зөрүү нь онолын хувьд тооцсон зөрүүнээс өөрчлөгдөх буюу тэлж, агшиж байдаг. Үүнийг таамаглахад төвөгтэй бөгөөд зарим хөрөнгө оруулагчид энэ хэлбэлзлийн зөрүүнээс ашиг олох стратегийг баримтладаг. Гэрээний хугацааны туршид дээрх хоёр үнийн зөрүү ингэж хэлбэлзэхээс гадна хугацааны эцэст ч зөрүүтэй байх тохиолдол байдаг. Энэ нь эрсдэлээс хамгаалах зорилготой хөрөнгө оруулагчийн хувьд том эрсдэл болдог. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт эрсдэлээс бүрэн хамгаалагдаж чадахгүй байдал үүсдэг.

**Суурь эрсдэл /Fundamental risk/** Хөрөнгийн зах дээр хувьцааны үнэ буруу үнэлэгдсэн байсан ч эрсдэлгүй ашгийн боломж үүсэхгүй байх нөхцөл. Эрсдэлгүй ашиг үүсэхгүй байх шалтгаан нь уг хувьцааны буруу үнэлэгдсэн үнэ тэнцвэрт үнэ рүүгээ дөхөхөөсөө өмнө суурь шалтгаанаас болж улам хазайдаг.

**Сүлжээний луйвар /Pyramid scam/** Дэлхийн олон оронд хуулиар хориглогдсон, тогтвортой оршин тогтох чадваргүй сүлжээний бизнесийн загвар. Гол төлөв шинэ гишүүдийг сүлжээнд элсүүлбэл үлэмж ашиг хүртэх боломжтой хэмээн сурталчилгаа явуулдаг.

**Сүүлд авснаа эхэлж зарлагдах арга /LIFO/** Энэ аргын үед бараа материалын өртгийг тооцоходоо хамгийн сүүлийн

худалдан авалтаас эхэлж тооцох бөгөөд үлдэгдэлд эхний үлдэгдэл болон эхний худалдан авалтаас үлдэнэ. Баласанд тусгагдах бараа материал нь эхний худалдан авалт болон үлдэгдлээс бүрдэх учир одоогийн бодит үнээрээ тусгагдах боломжгүй. Харин борлуулсан барааны өртөг нь тухайн үеийн үнэтэйгээр уялдаж өгдөг.

**Сэтгэл зүйд суурилсан санхүүгийн онол /Behavioral finance/** Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтанд хөрөнгө оруулагчийн сэтгэл зүйн байдал (тухайлбал, өөдрөг, гутранги байх, олон нийтийг дагаж хошуурах гэх мэт) чухал нөлөөтэй болохыг судалж буй санхүүгийн онолын харьцангуй залуу салбар юм.

## Т

**Тайлан тэнцэл /Balance sheet/** Компанийн нийт хөрөнгө болон нийт өр төлбөрийг бүлэглэн жагсааж тухайн үеийн санхүүгийн байдал, нийт хөрөнгийн хэмжээг харуулах тайлан.

**Тайлантуу /Accounting period/** Аж ахуйн нэгж, байгууллагын ашиг, алдагдлыг тооцож буй хугацааг хэлнэ. Ерөнхийдөө сар, улирал, жилийг хамруулж авч үзнэ.

**Тархааж болохуйц эрсдэл /Diversifiable risk/** Зах зээлийн, системийн, нийт эдийн засгийн биш эрсдэл буюу зөвхөн тухайн компани, салбартай холбоотой, төрөлжилт сайтай багц бүрдүүлэх замаар бууруулж болох эрсдэлийг хэлдэг. Тухайлбал, дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ унавал зөвхөн нүүрсний компанийн хувьцаагаар багцаа бүрдүүлсэн хөрөнгө оруулагч том хохирол хүлээх магадлалтай. Иймээс хөрөнгө оруулагч нүүрсний салбартай хамаарал багатай бусад салбарын хувьцааг багцдаа оруулснаар нүүрсний салбараас хүлээх алдагдлаа бусад хувьцааны ашгаас нөхөж, улмаар алдагдал хүлээхгүй байх боломжтой.

**Тасалбар цаг /Cut-off time/** Тухайн өдрийн гүйлгээний тасалбар цаг. Уг цагаас хойш хийгдсэн гүйлгээ нь дараагийн ажлын өдөр орсноор тооцогдоно.

**Таслах (Хэрэгжүүлэх) үнэ /Strike price, Exercise price/** Таслах үнэ гэж Европ загварын опционы хувьд гэрээ

байгуулагдахад гэрээнд заасан активыг худалдах, эсхүл худалдан авахаар урьдчилан тохирсон үнийг хэлнэ.

**Татан буулгах өртөг /Liquidation value/** Компанийн активыг борлуулсны дараа зээл хэлбэрээр татсан өрийг төлөөд бодитоор үлдэж буй хөрөнгийн хэмжээг хэлнэ. Компанийн активыг ихээр хямдруулж зарсан тохиолдолд зээл хэлбэрээр татсан өрөө төлөхөд хүрэлцэхгүй байж болно.

**Татвараас чөлөөлөгдөх үнэт цаас /Tax-exempt securities/** Зарим үнэт цааснаас олох орлого, өгөөж нь улсын болон орон нутгийн татвараас чөлөөлөгддөг. Үүний нэг жишээ нь хотын буюу орон нутгийн бондын орлого байдаг.

**Татварын суурь /Tax base/** Татвар ногдуулах орлого, хөрөнгө, хөрөнгө оруулалт зэргийг татварын суурь гэнэ.

**Татварын хорогдуулалт /Tax deduction/** Нийт орлогоос уг орлогыг бий болгохтой холбоотойгоор татвар төлөгчийн гаргасан зардлыг хасах замаар татвар ногдуулах орлогын цэвэр дүнг тодорхойлохыг хэлнэ.

**Татварын хөнгөлөлт /Tax credit/** Татварын хөнгөлөлт нь татварын системээр дамжуулан олгож буй Засгийн газрын татаасын нэг хэлбэр юм. Ямар нэгэн шалтгаанаар иргэн, аж ахуйн нэгжийн төлөх ёстой татварын өрийг бууруулахыг татварын хөнгөлөлт гэдэг.

**Татварын хуваарилалт /Tax incidence/** Тухайн татварын эдийн засгийн баялгийн хуваарилалтад үзүүлж буй нөлөөг судална. Чухам хэн татвар төлж буйн хэмжүүр.

**Татварын хувь хэмжээ /Tax rate/** Татварын хувь гэдэг нь иргэн, аж ахуйн нэгжийн орлогод ногдуулж буй татварын хэмжээг хэлнэ. Зарим улс орны хувьд татварын хувь нь орлогын түвшнээс хамааран өсөн нэмэгдэх тогтолцоотой байхад зарим улсын хувьд орлогын түвшнээс үл хамааран тогтмол нэг хувь хэмжээтэй байдаг. Жишээ нь, Монгол улсын хүн амын орлогын албан татвар нь тогтмол 10% байхад Австрали улсын хувьд \$0-\$18000-ийн жилийн орлогод 0%-ийн татвар, \$18201-\$37000-ийн орлогын хэсэгт 19%-ийн, \$37,001 – \$80,000-д 32.5%-ийн, \$80,001 – \$180,000-д 37%-ийн, \$180,001 болон түүнээс дээшх хэсэгт 45%-ийн татварыг шатласан байдлаар ногдуулдаг байна.

**Татварын цоорхой /Tax loophole/** Татвараас зайлсхийх боломжийг (хууль зэрчихгүйгээр) олгож буй хуулийн цоорхой, тодорхой бус байдал.

**Тобиний Кю харьцаа /Tobin's Q ratio/** Тобиний Кю харьцаа нь компанийн зах зээлийн үнэ цэнэ болон компанийн нийт активын үнэ цэнийн харьцааг харуулна. Харьцаа нэгээс их (бага) бол компанийн зах зээлийн үнэ цэнэ активын үнэлгээнээс их (бага) болохыг илэрхийлнэ. Мөн харьцаа нэгээс бага (их) бол компанийн хувьцаа дутуу (илүү) үнэлгэдсэн байх магадлалтай.

**Товч анкет /Resume/** Ажил олгогч тухайн орон тоог сонирхож буй хүмүүсээс товч анкет шаарддаг. Товч анкет нь ажил хайж буй хүний нэр, утасны дугаар, хаяг, цахим шуудангийн хаяг, боловсрол, ажлын туршлага, ур чадвар, шагнал, өмнө нь хашиж байсан албан тушаал болон сонирхол зэргийг тусгасан байdag.

**Тогтмол зардал /Fixed cost/** Компанийн үйлдвэрлэлийн хэмжээ өөрчлөгдсөн ч тогтмол гарах үйлдвэрлэлийн зардал. Компани үйлдвэрлэл явуулж буй эсэхээс үл хамааран гарах зардал.

**Тогтмол зарлага /Fixed expenses/** Тодорхой хугацааны интервал бүрт тогтмол гарах зардал (тухайлбал, ипотекийн, эсхүл түрээсийн төлбөр гэх мэт).

**Тогтмол орлого /Fixed income/** Тодорхой хугацааны интервал бүрт тогтмол орох орлого (ихэвчлэн тэтгэвэр, бондын орлогын хувьд хэрэглэгддэг).

**Тогтмол орлоготой үнэт цаас /Fixed income security/** Тодорхой хугацааны туршид урьдчилан тогтсон хэмжээний орлого авчрах үнэт цаасыг хэлдэг.

**Тогтмол төлбөрийн даатгал /Fixed annuities/** Тогтмол төлбөрийн даатгалын гэрээ гэдэг нь даатгалын компаниас нэгдүгээрт, тодорхой түвшнээс багагүй хэмжээгээр таны хуриатлуулсан тэтгэврийн дансанд хүү төлөхийг зөвшөөрсөн; хоёрдугаарт, тодорхой хугацааны туршид, эсхүл байнга (та, эсхүл таны эхнэр/нөхөрийг нас барах хүртэл) тогтмол хэмжээний төлбөр (тэтгэврийн дансанд хуриатлагдсан дүнгийн нэг төгрөгт ногдох хэмжээгээр тооцсон)-ийг тодорхой давтамжтайгаар танд төлөхийг

зөвшөөрсөн даатгалын компани болон таны хооронд байгуулсан даатгалын гэрээ юм.

**Тогтмол төлбөртэй зээл** /*Constant payment loan*/ Зээлийг эргүүлэн төлөх бүхий л хугацааны туршид сарын (эсхүл улирлын, жилийн) төлбөр нь тогтмол байх зээлийг хэлнэ. Тогтмол төлбөр нь хүү болон үндсэн төлбөрийг багтаана.

**Тогтмол уясан ханш** /*Pegged exchange rate*/ Үндэсний мөнгөн тэмдэгтийн нэг гадаад валютын эсрэг, эсхүл хэд хэдэн гадаад валютаас бүрдэх сагсны эсрэг ханшийг тогтмол байлгах явдал.

**Тогтмол ханш** /*Fixed exchange rate*/ Дотоодын мөнгөн тэмдэгтийн гадаад валютуудтай харьцах ханшийг нэг түвшинд тогтоох явдал. Иймээс дотоодын мөнгөн тэмдэгтийн эрэлт, нийлүүлэлтэд өөрчлөлт гарсан ч ханшид нөлөөлөхгүй.

**Тогтсон хүүтэй зээл** /*Locked in interest rate*/ Анх зээл авах үед харилцан тогтсон зээлийн хүү зээлийн эргэн төлөгдөх эцсийн хугацаа хүртэл тогтмол байх нөхцөлтэй зээлийг хэлнэ.

**Тогтсон хүү** /*Locked in interest rate*/ Зээлдэгч болон зээлдүүлэгч зээлийн хүүг тодорхой хугацааны туршид тогтмол байхаар харилцан тохирсон зээлийн хүүг хэлнэ.

**Тодорхой хувийг нөөцлөх банкны систем** /*Fractional reserve banking system*/ Банкны хадгаламжийн зөвхөн тодорхой хэсгийг нөөц хэлбэрээр хадгалах систем. Банк бусад хадгаламжийг зээл хэлбэрээр (мөнгө бий болох явц) байршуулна.

**ТОП 20 индекс** /*TOP 20 index*/ Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй зах зээлийн үнэлгээ, арилжааны идэвхээрээ бусдаасаа манлайлдаг шилдэг 20 компанийн хувьцааны үнийн индекс. Топ 20 компанийн үнэт цаасны ханш өсвөл Топ 20 индекс өсөх ба харин ханш нь буурвал тус индекс дагаад буурдаг байна.

**Торгууль** /*Penalty*/ Хууль болон гэрээний зүйл заалтыг зөрчсөний улмаас ногдуулж буй мөнгөн төлбөрийг хэлнэ. Тухайлбал, гэрээнд заасан хугацаанаас зээлийн төлбөрөө хоцроож төлсөн тохиолдолд гэрээнд заасан торгуулийн нэмэлт хүү төлдөг.

**Төв банк** /Central bank/ Төв банк нь Засгийн газар болон банкуудад санхүүгийн үйлчилгээ үзүүлж, төрийн мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлдэг төрийн байгууллага юм. Монгол улсын Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд “Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ.” гэж заасан байдаг.

**Төлбөр хийгдэх огноо** /Payment due date/ Гэрээний дагуу зээлийн төлбөр хийх огноо.

**Төлбөр хоцроосны тorgууль** /Late fee/ Зээлийн хувьд төлбөр хоцроовол ногдуулах тorgууль.

**Төлбөрийн хуваарь** /Amortization schedule/ Зээлийн гэрээнд заасан хүү, хугацаа гэх мэт зээлийн нөхцөлд үндэслэн тодорхой давтамжтайгаар эргүүлэн төлөх төлбөрийн хэмжээг тогтоосон хүснэгтийг хэлнэ.

**Төлбөрийн чадвар** /Solvency/ Компани болон аж ахуйн нэгжийн өглөг, өр төлбөрөө эргүүлэн төлөх чадвар.

**Төлбөрийн чадвар алдагдах** /Default/ Төлбөрийн чадвар алдагдах гэдэг нь компани санхүүгийн үүргээ биелүүлэхгүй буюу зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө хугацаанд нь төлж чадахгүй байх эрсдэл юм. Төлбөрийн чадвар алдагдах эрсдэл гэдэг нь төлбөрөө хугацаанд нь төлж чадахгүй байх эрсдэл юм. Үүнийг зээлийн эрсдэл гэж бас нэрлэдэг.

**Төлбөрийн чадваргүй болох** //Insolvent/ Төлбөрийн чадварын эрсдэлийг харах.

Төлбөрийн чадварын эрсдэл //Insolvency risk/ Өглөг, өр төлбөрийн эргэн төлөлтийн хугацаа болоход тухайн байгууллага гэрээний дагуу төлбөрөө төлж чадахгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэдэг. Тухайн байгууллагын борлуулалтын орлого буурах, хэт өндөр үйл ажиллагааны зардалтай байх зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан хөрвөх чадвар нь муудаж, зээлийн хүү болон үндсэн төлбөрөө төлж чадахгүйд хүрвэл уг байгууллагыг төлбөрийн чадварын хүндрэлд орсон гэж үзнэ.

**Төлбөрөөс чөлөөлөх хугацаа** /Grace period/ Зээлийн гэрээний дагуу төлөх төлбөрийг зээлдэгч гэрээнд заасан

хугацаанаас хойш ямар нэгэн торгууль, шимтгэлгүйгээр эргүүлэн төлж болох хоногийн тоо (тухайлбал 15 хоног). Тус хугацааны дотор төлбөрөө төлсөн тохиолдолд хугацаа хожимдуулсны шимтгэл төлөхгүйн дээр энэ нь зээлийн гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

**Төлөгдөх үнэ буюу дуудагдах үнэ /Redemption price/** Бонд гаргагч бондоо хугацаанаас нь өмнө дуудаж буцаан худалдан авах үнийг хэлдэг. Заримдаа дуудах үнэ гэж бас нэрлэдэг.

**Төлөгдөх хугацаа /Redemption period/** Санхүүгийн зарим хэлцлийн үед зээлдэгч тодорхой хугацааны туршид зээлээ хугацаанаас нь өмнө эргүүлэн төлж болох эрхээр хангагддаг бөгөөд энэхүү эрх хүчинтэй байх хугацааг төлөгдөх хугацаа гэдэг.

**Төлөгдөх хугацаа хүртэлх өгөөж /Yield to maturity/** Хэрэв хөрөнгө оруулагч бондыг хугацаа нь дуустал эзэмших тохиолдолд хүртэж болох хүлээгдэж буй өгөөжийг илэрхийлнэ. Үг өгөөж нь бондын үнийг тодорхойлоход ашиглагдана.

**Төлөгдсөн чек /Canceled check/** Харилцагчийн данснаас төлөгдсөн, банк "төлөгдсөн" гэсэн тэмдэглэгээ хийсэн чекийг хэлнэ. Төлөгдсөн чекийг төлбөр гүйцэтгэгчийн банк төлөх бөгөөд энэ нь төлбөр хүлээн авагч, төлбөр хүлээн авагчийн банк, Төв банкаар зөвшөөрөгдсөн байна. Мөн төлөгдсөн чекийг төлбөр төлсөн баталгаа болгон хэрэглэдэг.

**Төлөх чадварын зарчим /Ability-to-pay principle/** Татварыг хүмүүсийн төлбөрийн чадварыг харгалзан ногдуулах ёстой, орлого өндөртэй хүмүүс илүү татвар төлөх ёстой гэсэн үзэл бодол, зарчим, онол (өсөн нэмэгдэх татвар).

**Төрөлжилт /Specialization/** Хэрэглэж байгаагаасаа цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж буй нөхцөл байдал. Төрөлжилт нь бүтээмжийг нэмэгдүүлнэ. Төрөлжилт бий болох зайлшгүй нөхцөл нь худалдаа юм, төрөлжилт нь харилцан хамаарлыг нэмэгдүүлнэ.

**Төрөлжүүлэлт /Diversification/** Олон төрлийн активыг (тухайлбал, хувьцаа, бонд, мөнгөний захын хэрэгсэл, эрдэс

түүхий эд, хамтын сан) хөрөнгө оруулалтын нэг багцад багтаах замаар хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах, нэг төрлийн активаас үүсч болох эрсдэлийг тархаахыг хэлнэ.

**Төрөлжүүлэх** /Diversify/ Эрсдэлийг тархаахын тулд төрөл бүрийн санхүүгийн хэрэгслүүдэд (хувьцаа, бонд, мөнгөний захын хэрэгслүүд) хөрөнгө оруулах явдал.

**Транч** /Tranche/ Ямар нэгэн санхүүгийн хэлцэл, эсхүл санхүүжилтийн хэрэгслээр авч буй санхүүжилтийн тухайн цаг хугацаанд орж ирж буй хэсгийг хэлнэ.

**Түргэн хөрвөх харьцаа** /Quick ratio/ Компанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг харуулах бөгөөд нийт богино хугацаат эргэлтийн хөрөнгөөс борлогдоогүй бүтээгдэхүүний үлдэгдлийг хасч, богино хугацаат өглөг, өр төлбөрт харьцуулж тооцно.

**Түргэн хөрвөх хөрөнгө оруулалт** /Liquid investments/ Богино хугацаанд бэлэн мөнгө болгож болох хөрөнгө оруулалт, эсхүл хадгаламж (тухайлбал, хугацаатай хадгаламж, мөнгөний захын хамтын сан гэх мэт).

**Түрээс** /Lease/ Лизинг-ийг харах.

**Түүхий эдийн зах** /Commodities market/ Ихэвчлэн хөдөө аж ахуйн, эсхүл ашигт малтмалын бүтээгдэхүүний фьючерс (бүтээгдэхүүнийг ирээдүйн тодорхой цагт худалдах гэрээ)-ийг худалдах, худалдан авах зах зээл.

**Тэг хариуцлага** /Zero liability protection/ АНУ-ын хуулиар зээлийн карт эзэмшигч нь зөвшөөрөлгүй гүйлгээ, запилиангийн эсрэг хамгаалагдсан байдаг. Тухайлбал, карт эзэмшигч картаа гээсэн, эсхүл хулгайд алдсан тохиолдолд аливаа зөвшөөрөлгүй гүйлгээнээс үүдэлтэй хохирлыг банк хариуцаж карт эзэмшигчийг хохиролгүй болгоно.

**Тэнцлээс хасах** /Write-off/ Эргэн төлөгдөх магадлал бага буюу найдваргүй авлагыг байгууллагын бүртгэл, тэнцлээс хасч хорогдуулахыг хэлнэ.

**Тэтгэврийн сан** /Pension fund/ Ажил олгогч болон ажилчдын хувь оролцоогоор бий болсон, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтыг удирдах зорилгоор ажил олгогчийн байгуулсан сан. Тэтгэврийн сан нь урт хугацааны

тогтвортой өсөлтийг бий болгох активуудын багц бөгөөд ажилчдын ажиллах хугацаа дуусч, тэтгэвэрт суух үед тэдний тэтгэврийн эх үүсвэр болдог. Тэтгэврийн сан нь хувьцаа, бонд, хамтын сан болон үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийдэг.

## Ү

**Улсын эрсдэл** /Country risk, Sovereign risk/ Гадаад бонд, хувьцаа зэрэг үнэт цаас, актив эзэмшиж буй үед тухайн хөрөнгө оруулсан улстай холбоотойгоор үүсч буй эрсдэл юм. Бондын зах зээлийн хувьд бонд гаргасан улс бондын хүүгийн болон үндсэн төлбөрөө төлж чадахгүй байх эрсдэлийг хэлнэ.

**Уналттай зах зээл** /Bear market/ Тухайн активын үнэ буурна гэсэн хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд үүсч, үнэ буурч буй зах зээлийн төлөв байдлыг хэлнэ. Хөрөнгө оруулагчдын энэхүү гутранги байдал нь тодорхой хугацааны туршид үнэ үргэлжлэн буурах шалтгаан болдог.

**Универсал банк** /Universal bank/ Универсал банк нь маш өргөн хүрээнд банкны үйл ажиллагаа явуулдаг банкийг хэлнэ. Тухайлбал, арилжааны болон хөрөнгө оруулалтын банкны аль алиных нь үйлчилгээг үзүүлдэг банк.

**Урамшуулалтай бонд** /Premium bond/ Зах зээлийн хүү болон купоны хүүгээс хамааран нэрлэсэн үнээсээ өндөр үнээр хоёрдогч зах дээр арилжаалагдаж буй бондыг хэлнэ.

**Үрвуу хөшүүрэг** /Reverse leverage/ Хөрөнгө оруулалтын мөнгөн хөрөнгийн сөрөг урсгал буюу хөрөнгө оруулалтын хүүгийн өгөөж нь эх үүсвэрийн буюу зээлийн хүүгийн төлбөрөө нөхөж чадахгүй байхыг хэлнэ. Энэ нь санхүүжилтийн өртөг хэт өндөр буюу ашиггүй байгааг харуулна.

**Урсгал өгөөж** /Current yield/ Үнэт цаасны хүүгийн орлого, ногдол ашиг зэрэг жилийн бүх орлогыг тухайн үеийн зах зээлийн үнэд харьцуулж урсгал өгөөжийг тооцно. Хувьцааны хувьд хүүгийн орлого гэж байхгүй бөгөөд жилийн орлого нь зөвхөн ногдол ашгаас бүрдэх тул хувьцааны урсгал өгөөж нь ногдол ашгийн өгөөж юм.

**Үрт позициор хамгаалах /Long position hedge/** Ямар нэгэн активыг ирээдүйд худалдан авахаар төлөвлөж буй хөрөнгө оруулагч форвард, фьючерс зэрэг санхүүгийн хэрэгсэл дээр үрт позици нээх замаар тухайн активын үнэ өсөх эрсдэлээс өөрийгөө хамгаалах стратегийг үрт позициор хамгаалах гэнэ.

**Үрт хөрөнгө оруулалт /Long investments/** Хөрөнгө оруулагч үнэ өсч, үнийн өсөлтөөс ашиг олно гэсэн хүлээлтээр хувьцаа, бонд, гадаад валют гэх мэт актив худалдан авах хөрөнгө оруулалтыг хэлнэ.

**Үрт хугацааны зорилт /Long-term goal/** Хувь хүн, байгууллагын 5-аас дээш жилийн дараа хүрэхээр төлөвлөсөн зорилт.

**Үрт хугацаат өглөг /Long-term debt/** Нэг жилээс дээш хугацаатай бонд, лизинг гэх мэт өр төлбөрийг хэлнэ.

**Үрьдчилан төлөлт /Prepayment/** Зээлийн хүүгийн төлбөр, үндсэн төлбөр зэрэг ямар нэгэн төлөх ёстой өглөг, өр төлбөрийг хуваарыг хугацаанаас нь өмнө төлөхийг хэлнэ.

**Үрьдчилан төлөх нөхцөл /Prepayment clause/** Хэдийгээр зарим зээлийн бүтээгдэхүүний урьдчилан төлөлт нь торгуультай байдаг боловч хугацаанаас нь өмнө эргүүлэн төлөх эрхийг зээлдэгчид олгох явдал.

**Үрьдчилан төлсөн хүү /Prepaid interest/** Эргэн төлөлтийн хуваарыг хугацаанаас өмнө зээлдэгчийн төлсөн хүүгийн төлбөр. Энэ нь татвар ногдох орлогод нөлөөлдөг.

**Үрьдчилж олсон орлого /Deferred income/** Аж ахуйн нэгж байгууллага аливаа үйл ажиллагаа явуулахаасаа өмнө үйлчлүүлэгчээс төлбөрийг урьдчилан хүлээн авахыг хэлэх бөгөөд энэ нь өр хэлбэрээр пассивт бүртгэгдэнэ. Харин ажил, үйлчилгээгээ гүйцэтгэмэгц энэ нь орлого болж бүртгэгдэнэ.

**Үрьдчилж төлсөн зардал /Prepaid expenses, Deferred charges/** Ажил үйлчилгээ авахаас өмнө буюу үр дүн нь гарахаас өмнө төлсөн төлбөр бөгөөд энэ нь хөрөнгө болж бүртгэгдэнэ. Харин ажил үйлчилгээгээ авмагц энэ нь зардал болж бүртгэгдэнэ. Тухайлбал, урьдчилж төлсөн түрээсийн болон даатгалын зардал гэх мэт.

Урьдчилсан иж бүрэн судалгаа, шинжилгээ /*Due diligence*/ Ямар нэгэн хөрөнгө худалдаж авах болон хөрөнгө оруулалт хийхээс өмнө худалдан авагч тал аль болох иж бүрэн нарийн шинжилгээ хийхийг хэлнэ. Худалдагч тал ч бас худалдан авагчийн талаар болон түүний үйл ажиллагаа тогтвортой байж чадах эсэх талаар шинжилгээ хийдэг. Энэхүү шинжилгээний үр дүнгээс худалдаж авах, хамтарч нэгдэх эсэх мэт хөрөнгө оруулалтын шийдвэр хамаарна.

Уссан зардал /*Sunk costs*/ Бизнесийн эхлэлийн үед буцалтгүй гарчихсан бөгөөд өнөөдөр болон ирээдүйд гарах шийдвэртэй холбоогүй зардал. Жишээ нь, компани 1 сая төгрөгийн компьютерийн програм хангамж авч суулгасан бол энэ нь нэг удаагийн зардал бөгөөд буцаах боломжгүй нэгэнт зарцуулагдсан мөнгө юм.

## Y

Үе тутмын төлбөрийн өнөөгийн үнэ цэнэ /*Present value of annuity*/ Тодорхой өгөөжийн хувь, эсхүл хямдруулалтын хувиар тооцсон жил тутмын ирээдүйн мөнгөн урсгалын одоогийн үнэ цэнэ.

Үе тутмын төлбөрийн үржүүлэгч /*Annuity factor*/ Тогтоосон хугацааны туршид хугацааны үе тутамд нэг төгрөгийн орлого бий болгож буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг илэрхийлсэн математикийн тооцоолол. Жишээ нь, Бат газар түрээслүүлсний төлбөрт жил тутам 1 сая төгрөгийг 10 жилийн турш авна. Батын орлогын үнэ цэнийг тооцохын тулд хүүг 10 хувь гэж үзвэл жил тутмын төлбөрийн үржүүлэгч 6.144567 гарах бөгөөд түрээсийн орлогын өнөөгийн үнэ цэнэ 6,144,567 (6.144567\*1,000,000) төгрөг болно.

$$\text{Жил тутмын төлбөрийн үржүүлэгч} = \frac{1 - \frac{1}{(1+i)^n}}{i};$$

Энд:  $i$ -хүүгийн түвшин,  $n$ -орлогын урсгал бий болох хугацааны үе тутмын тоо.

Үйл ажиллагааны ашгийн норм /*Operating margin*/ Үйл ажиллагааны ашгийг цэвэр борлуулалтын хэмжээнд харьцуулсан харьцаа.

**Үйл ажиллагааны ашиг /Operating income/** Нийт орлогоос үйл ажиллагааны зардал болон элэгдлийн зардлыг хасч тооцно. Үйл ажиллагааны эх үүсвэр болох хүүгийн зардал болон ашгийн татвартай холбоотой зардлыг үйл ажиллагааны зардалд хамаарулахгүй. Тиймээс энэхүү ашгийг хүү болон татварын өмнөх ашиг гэж нэрлэдэг.

**Үйл ажиллагааны зардал /Operating costs and expenses/** Бизнесийн өдөр тутмын тасралтгүй үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдон гарч буй зардлыг үйл ажиллагааны зардал гэж тодорхойлдог. Тухайлбал, борлуулсан бүтээгдэхүүний өртөг, хангамжийн зардал, цалин гэх мэт бүх үйл ажиллагааны зардлууд хамарагдана.

**Үйл ажиллагааны зардал /Operating costs/** Бизнес эрхлэхэд гарч буй зардал.

**Үйл ажиллагааны лизинг /Operating lease/** Түрээслүүлэгч буюу өмчийн эзний ямар нэгэн тоног төхөөрөмж, хөрөнгийг түрээслэгч тал түр хугацаагаар хэрэглэж, ашиглахыг зөвшөөрсөн гэрээг хэлнэ. Энэ нь тоног төхөөрөмж, хөрөнгийг худалдаж авах шаардлагагүй болгож байгаа тул санхүүжилтийн нэг хэлбэр гэж үздэг.

**Үйл ажиллагааны мөнгөн урсгал /Cash flow from operations/** Байгууллагын санхүүгийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас бусад буюу тухайн байгууллагын орлого олох үндсэн үйл ажиллагаанаас орж ирэх мөнгөн хөрөнгийг хэлнэ.

**Үйл ажиллагааны эрсдэл /Operational risk/** Үйл ажиллагааны эрсдэлд санхүүгийн болон системийн эрсдлээс бусад төрлийн эрсдлүүдийг хамруулж ойлгох бөгөөд дотоод үйл ажиллагаа, хүний хүчин зүйл, системээс үүдсэн эрсдэл юм.

**Үл хөрвөх байдлын үнэ /Liquidity premium/** Хөрвөх чадварын үнэ-ийг харах.

**Үлдэгдэл авлага /Residual claim/** Түрүүлж төлөгдөх ёстой өглөг, өр төлбөрүүдийг төлсний дараа ашиг, орлого болон өгөөжөөс үлдэж буй хэсгийг хүртэх эрхийг хэлнэ. Тухайлбал, компанийн ашиг, эсхүл нийт хөрөнгөөс бүх өглөг, өр төлбөр төлөгдөөд үлдэж буй хэсэг нь хувьцаа эзэмшигчдэд ногдоно.

Үлдэгдэл зээлийн шугам /*Total available credit*/ Нийт зээлийн шугамаас ашигласан зээлийг хассан дүн.

Үлдэгдэл тэнцэл /*Outstanding balance*/ Цаг хугацааны ямар нэг агшин дахь үлдэгдэл төлбөр, дүнг хэлнэ.

Үндсэн болон хүүгийн төлбөр /*Principal and interest payment*/ Төлгөдөөгүй зээлийн үлдэгдлээс тооцсон хүүгийн төлбөр болон эргэн төлөлтийн хуваарийн дагуу тухайн сард хамаарах үндсэн зээлийн төлбөрийн нийлбэрээр зээлдэгчийн тухайн сард төлөх нийт зээлийн төлбөрийн хэмжээг тодорхойлно.

Үндсэн дүн /*Principal*/ Анх хөрөнгө оруулсан, эсхүл зээлдүүлсэн мөнгөн дүн.

Үндсэн хөрөнгө /*Fixed asset*/ Байшин, барилга, машин, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил гэх мэт худалдан борлуулах зориулалтгүй, үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаанд урт хугацаанд ашиглагдах буюу 1 жилээс бага хугацаанд борлогдож мөнгөн хөрөнгө болохгүй хөрөнгийг хэлнэ.

Үндсэн хүү /*Prime rate*/ Банкуудын эрсдэл багатай зээлдэгчидээ санал болгож буй хамгийн бага зээлийн хүү. Энэ хүү нь автомашин, орон сууц, цалин гэх мэт бусад төрлийн зээлийн хүүгийн суурь хүү болох бөгөөд үүн дээр эрсдэлийн нэмэгдлийг нэмж харгалзах зээлийн хүүг тодорхойлдог.

Үндэстэн дамнасан корпораци /*Multinational corporation*/ Хоёр ба түүнээс дээш улс оронд үйл ажиллагаа явуулж буй компани.

Үнийн өөрчлөлтийн эрсдэл /*Repricing risk*/ Активыг доогуур хүүгээр дахин хөрөнгө оруулах эрсдэл. Энэ нь үлэмж алдагдалд хүргэж болзошгүй юм. Дахин санхүүжилтийн буюу дахин хөрөнгө оруулалтын эрсдэл ч гэдэг.

Үнийн шаталбар бүхий захирамж /*Scale order*/ Хөрөнгийн бирж дээр хувьцаа худалдан авахдаа үнийн өсөлт, эсхүл бууралтын тодорхой интервалаар хэд хэдэн хязгаарлагдмал захиалга өгөхийг хэлнэ. Хязгаарлагдмал захиалга-ыг дэлгэрүүлж харна уу.

Үнэ хямдруулах дуудлага худалдаа /Dutch auction/ Өндөр үнээр эхлүүлж, аажмаар бууруулах дуудлага худалдааны арга хэлбэр.

Үнэ цэнийг бууруулж бүртгэх /Write-down/ Зах зээлийн үнийн бууралтанд тулгуурлан тухайн активын бүртгэлийн үнийг бууруулж бүртгэхийг хэлнэ.

Үнэ-ашгийн харьцаа /Price-earnings (P/E) ratio/ Үнэ, ашгийн харьцааг компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ногдох ашигт хувааж тооцно. Хэдийгээр энэ харьцаа нь компанийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн өсөлтийн талаар бүрэн мэдээлэл өгч чадахгүй хэдий ч өндөр үнэ, ашгийн харьцаатай компани бага үнэ, ашгийн харьцаатай компанийтай харьцуулахад ирээдүйд их ашиг олохыг, илүү өндөр өсөлттэй байхыг хөрөнгө оруулагчид хүлээж байгааг илтгэнэ. Тухайлбал, А компанийн P/E=20 гэж үзвэл хөрөнгө оруулагчид 1 төгрөгийн ашгийн төлөө 20 төгрөг төлөхөд бэлэн байна гэж тайлбарлаж болно.

Үнэлгээ буюу капиталжилт /Capitalization/ Компаниудын бүх хувьцааны зах зээлийн нийт үнэ. Компанийн үлдэгдэл хувьцааг зах зээлийн үнээр үржүүлэх замаар зах зээлийн үнэлгээг тооцно. Хөрөнгө оруулагчид капиталжилтаар нь компанийн хэмжээг тодорхойлдог.

Үнэт цаасжуулалт /Securitization/ Хөрвөх чадвар муутай иргэдийн зээл болон бусад өрийн хэрэгслийг багцлан, түүнийг хөрвөх чадвар сайтай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болгох үйл ажиллагаа хэлнэ. Үнэт цаасжуулах үйл ажиллагаа нь З үе шатыг дамжин хөгжих ирсэн байдаг. 1 дүгээр үе шат: 1970-аад оны үеэс анх АНУ-д үүсч эхэлсэн бөгөөд орон сууцны ипотекийн зээлийг шууд үнэт цаас (pass-through securities)-нд хөрвүүлэх. 2 дугаар үе шат: Активыг мөнгөн урсгал болон зээлийн эрсдэлээр ялгаварлан барьцаат өрийн бичиг (Collateralized Debt Obligations-CDOs)-ээр дамжуулан хөрөнгө оруулагчдад нийцэхүйц ялгавартай транчид хөрвүүлэх. 3 дугаар үе шат: Синтетик үнэт цаасжуулалт (synthetic securitizations) буюу эх үүсвэргүй үнэт цаасжуулалтыг бий болгох.

Үнэт цаасны дахин нээсэн шинэ арилжаа /Seasoned new issue/ Үнэт цаас гаргагч өмнө нь арилжсан үнэт цаасан дээр нэмж үнэт цаас гаргах арилжаа.

Үнэт цаасны тодорхойлогч шугам /Security characteristic line/ Ямар нэгэн хувьцааны өгөөжийг зах зээлийн өгөөжөөс хамааруулан үнэлсэн регрессийн тэгшитгэлээс зурсан шулууныг хэлнэ. Энэхүү шулуун нь тухайн хувьцааны өгөөж болон зах зээлийн өгөөжийн хоорондох шугаман хамаарлыг харуулна.

Үнэт цаасны төлбөр тооцооны төв /Clearinghouse/ Хөрөнгийн бирж дээр харилцагч гүйлгээ хийснээр түүний дансан дахь үнэт цаасны тоо өөрчлөгдөх байдаг. Тухайлбал, А компанийн 1000 ширхэг хувьцааг нэмж худалдан авч, Б компанийн 500 ширхэг хувьцааг худалдсан бол дансан дахь ААА компанийн хувьцаа 1000 ширхэгээр нэмэгдэж, БББ компанийн хувьцаа 500 ширхэгээр хорогдоно. Энэ үнэт цаасны шилжилт хөдөлгөөн, бүртгэлийг хариуцаж, зохион байгуулдаг нэгжийг үнэт цаасны төлбөр, тооцооны төв гэж нэрлэдэг.

Үр ашиг /Benefit/ Тухайн шийдвэр, үйлдлээс үүдэлтэй мөнгөн эсхүл мөнгөн бус хожоо.

Үр ашиг хүртэгч /Beneficiary/ Ямар нэгэн ашиг, мөнгө хүлээн авагч. Тухайлбал, амьдралын даатгалын гэрээнд таныг нас барсны дараа таны хуримтлуулсан үлдэгдэл хөрөнгийг хүлээн авахаар таны зөвшөөрч буй хүн эсхүл хуулийн этгээдийг хэлдэг.

Үр ашигтай захын таамаглал /Efficient market hypothesis/ Зах зээл үр ашигтай бол боломжит бүх мэдээлэл хувьцааны үнэд бүрэн тусгагдсан байх ёстой. Тиймээс хөрөнгө оруулагч үр ашигтай зах дээр хувьцаа худалдаж авч байгаа бол өгөөж нь тэнцвэрт өгөөж байна.

Үүрэг гүйцэтгүүлэгч /Obligee/ Санхүүгийн нэр томьёонд бондхудалдан авагч талбуу санхүүгийн үүрэг гүйцэтгэгчээс төлбөр, үр ашиг хүлээн авч буй талыг хэлнэ.

Үүрэг гүйцэтгэгч /Obligor/ Ямар нэгэн гэрээ, тохиролцоо ёсоор биелүүлэх үүрэг хүлээсэн талыг хэлнэ. Санхүүгийн нэр томьёонд өглөг, өр төлбөр төлөгч талыг хэлнэ. Тухайлбал бонд гаргасан талыг хэлнэ.

## Φ

**Факторинг /Factoring/** Факторинг нь компани хүлээгдэж буй ирээдүйн авлага (орлого)-аа хямдруулсан үнээр гуравдагч талд худалдах санхүүгийн хэлцэл юм.

**Фитчийн үнэлгээ /Fitch rating/** Фитч нэртэй олон улсын үнэлгээний байгууллагаас улс орон болон компанийн зээлжих чадвар буюу зээлээ эргүүлэн төлөх найдвартай байдлыг үнэлж зэрэглэл тогтоосон үнэлгээ. AAA, AA+, AA, AA- гэх мэтээр тэмдэглэдэг.

**Форвард гэрээ /Forward contract/** Гадаад валют, алт, нефть гэх мэт хөрөнгийг тодорхой хугацааны эцэст урьдчилж тогтсон үнээр худалдах, худалдан авах буюу худалдагч тал худалдан авагч талд хүргэх гэрээг хэлнэ. Форвард гэрээ нь гэрээнд оролцогч хоёр талыг ирээдүйн үнийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалах бөгөөд гэрээ байгуулах үед хоёр талын хооронд ямар нэгэн төлбөр шилжихгүй.

**Франчайзинг /Franchising/** Франчайзингийн хамгийн түгээмэл хэлбэр нь зах зээлд байр сууриа олсон компанийн бүтээгдэхүүний брэнд нэрийг ашиглан өөрийн бүтээгдэхүүнээ борлуулах явдал юм.

**Фронт алба /Front office/** Байгууллагын үйлчлүүлэгчидтэй харилцах, бүтээгдэхүүний борлуулалт, зар сурталчилгаа зэргийг хариуцсан алба, газар, нэгжийг хэлнэ.

**Функционал хуваарилалт /Functional distribution/** Өөр өөр бүлгүүдэд хуваарилах явдал.

**Фьючерс /Futures/** Ямар нэгэн активыг тодорхой хугацааны эцэст, урьдчилж тогтсон үнээр худалдах, эсхүл худалдан авахыг тохирсон стандартчилагдсан, бирж дээр арилжаалагдаг хөрөнгө оруулалтын гэрээ юм. Фьючерс нь гэрээнд тусгагдсан активын чанар, тоо хэмжээг стандартчилан нарийн тодорхойлсон байдаг. Фьючерсийн гэрээг хөрөнгө оруулагчид ашиг олох болон эрсдэлээс хамгаалах аль аль зорилгоор хэрэглэдэг.

**Фьючерс гэрээ /Futures contract/** Форвард гэрээг харах. Форвард гэрээнээс ялгарах гол онцлог нь фьючерс гэрээ нь зохион байгуулагдсан зах буюу бирж дээр арилжаалагддаг.

**Фьючерс опцион /Futures option/** Фьючерс үнэ урьдчилан тохирсон түвшинд хүрэхэд фьючерс гэрээ байгуулах опцион гэрээг хэлнэ. Тухайлбал, нефтийн фьючерсийн одоогийн үнэ 100 ам.доллар байгаа боловч хөрөнгө оруулагч уг үнэ 90 ам.долларт хүрэх үед фьючерс гэрээ худалдах нь ашигтай гэж үзсэн тохиолдолд 90 ам.доллараар нефтийн фьючерс зarah опцион гэрээ худалдан авч болно.

**Фьючерс үнэ /Futures price/** Фьючерс үнэ гэдэг нь тухайн гэрээнд тусгагдсан бүтээгдэхүүнийг ирээдүйд худалдах, эсхүл худалдан авахад ашиглагдах урьдчилан тохирсон гэрээний үнэ юм.

## Х

**Хаалттай зээл /Closed-end credit and loan/** Зээлийн хэмжээ нь урьдчилан батлагдсан бөгөөд хугацааны эцэст уг хэмжээгээр, харгалзах хүүгийн төлбөр болон шимтгэлийн хамт бүрэн төлөгдөх зээл.

**Хаалттай сан /Closed-end fund/** Хувьцаа нь хөрөнгийн бирж дээр арилжаалагдаг хөрөнгө оруулалтын компани. Тогтмол тооны хувьцааг анх бирж дээр арилжаалах замаар хөрөнгө босгож, түүгээрээ хөрөнгө оруулалтын багцаа үүсгэдэг. Хөрөнгө оруулагчид тухайн санд хөрөнгө оруулалт хийхийг хүсвэл түүний хувьцааг худалдан авч, сангаас гарахыг хүсвэл хувьцааг нь зарна. Энэ нь зарим хөрөнгө оруулалтын сангүүдтэй харьцуулахад хөрөнгө оруулагчийн хувьд харьцангуй уян хатан нөхцөлийг бүрдүүлдэг. Сангийн хувьцааны үнэ нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлт болон сангийн багцын үнэ цэнээс хамааран өөрчлөгднө.

**Хадгаламж /Deposit/** Санхүүгийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгө.

**Хадгаламж эзэмшигчид /Savers/** Мөнгөн хөрөнгөө хадгалуулсан иргэд, аж ахуйн нэгж.

**Хадгаламжийн баталгаа /Deposit guarantee/** Хадгаламжийн баталгаа гаргасан бол банк дампуурах үед хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг баталгаа гаргагч дампуурсан банкны өмнөөс буцаан олгоно. Ямар хэмжээний, ямар хугацаатай хадгаламжийг хэн батлан даах нь тухайн улсын хуулиар зохицуулагдана.

**Хадгаламжийн бонд /Savings bond/** АНУ-ын Сангийн яамнаас иргэдэд зориулан харьцангуй бага нэрлэсэн үнээр гаргаж буй үнэт цаас (шилжүүлж үл болох). Хадгаламжийн бондыг худалдан авч буй хөрөнгө оруулагчид Засгийн газартаа зээл олгож байна гэсэн үг юм. Бондын хүүийн орлого нь мужийн болон орон нутгийн татвараас чөлөөлөгдсөн байдаг. Хадгаламжийн бондыг АНУ-ын Засгийн газар гаргах тул тус төрлийн бондыг эрсдэлгүй хөрөнгө оруулалт хэмээн үздэг байна.

**Хадгаламжийн даатгалын корпораци /Deposit Insurance Corporation/** Хадгаламжийн даатгалын корпораци (ХДК) нь банкуудын хадгаламжинд баталгаа гаргаж буй байгууллага юм. Монгол Улсын Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн дагуу манай ХДК нь 20 сая хүртэлх төгрөгийн хадгаламжид баталгаа гаргадаг. Хэрэв Төв банкнаас тухайн банкийг татан буулгах шийдвэр гаргавал хадгаламж эзэмшигчдийн хохирлыг ХДК барагдуулна.

**Хадгаламжийн данс /Savings account/** Хүүгийн орлого авчирдаг, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (тухайлбал, хугацаатай хадгаламж).

**Хадгаламжийн дэвтэртэй данс /Passbook savings account/** Хөрвөх чадвар өндөр боловч харьцангуй бага хүүтэй хадгаламжийн данс. Хадгаламжийн үлдэгдэл болон харилцгачийн данснаас татсан хэмжээг хадгаламжийн дэвтэрт бүртгэнэ.

**Хадгаламжийн сертификат /Certificate of deposit (CD)/** Тодорхой хугацаагаар (тухайлбал, 6 сар, 1-2 жил) мөнгөө байршуулж буй хадгаламж эзэмшигчдэд банкны зүгээс олгосон үнэт цаас. Хадгаламжийн сертификатад байршуулсан мөнгөө дуусах хугацаанаас нь өмнө татвал торгууль төлнө.

**Хадгаламжийн хайрцаг /Safe deposit box/** Үнэ бүхий зүйлсийг хадгалах зориулалттай банкны дотор байршуулсан найдвартай хайрцаг. Уг хадгаламжийн хайрцгийг түрээсээр эзэмших ба хамгаалалтыг нэвтрэх эрх бүхий нууц код, эсхүл түлхүүртэй байдаг. Хадгалуулж буй үнэт зүйлс, бичиг баримт гадны ямар нэг нөлөөллөөс бүрэн хамгаалагддаг.

**Хадгаламжийн хэрэгслүүд /Savings instruments/** Хүмүүсийн мөнгөө хадгалах арга хэрэгслүүд (тухайлбал,

хадгаламжийн данс, хадгаламжийн сертификат, мөнгөний захын хадгаламжийн данс гэх мэт).

**Хадгалах /Save/** Ирээдүйд зарцуулах зорилгоор хадгалах. Мөнгийг өнөөдөр зарцуулах бус хадгаламжийн данс, эсхүл хөрөнгө оруулалтын бусад хэлбэрээр байршуулах.

**Хамгаалагдсан худалдан авах опцион /Covered call option/** Худалдан авсан актив дээрээ худалдан авах опцион зарах. Худалдан авах опционыг зарахдаа тухайн гэрээнд заасан активыг худалдан авсан байдаг тул хамгаалагдсан опцион гэж нэрлэдэг.

**Хамгаалалтын харьцаа /Hedge ratio/** Нийт нээлттэй позицийн дүн болон санхүүгийн хэрэгслээр хамгаалагдсан позицийн дүнгийн харьцааг хамгаалалтын харьцаа гэдэг. Тухайлбал, та 10,000 ам.долларын дүнтэй гадаад валютаарх хөрөнгийн зөвхөн 5,000 ам.доллартай тэнцэх хэсгийг форвард гэрээгээр ханшийн эрсдэлээс хамгаалсан гэж үзвэл таны хамгаалалтын харьцаа 0.5 байна.

**Хамгийн бага төлбөрийн шаардлага /Minimum payment/** Зээлийн карт эзэмшигчийн сард төлөх ёстой хамгийн бага дүн. Энэхүү дүнг төлөөгүй тохиолдолд торгууль оногдуулна.

**Хамгийн бага эрсдэлийн хязгаар /Minimum variance frontier/** Багцын хүлээгдэж буй өгөөжийн тухайн түвшинд харгалзах хамгийн бага вариацын график.

**Хамгийн их эрсдэл /Value-at-risk/**

Санхүүгийн бүтээгдхүүний багцаас тодорхой хугацаанд тодорхой магадлалтайгаар хүлээж болзошгүй алдагдлын дээд хэмжээ (VaR гэж тэмдэглэдэг).

**Хамгийн сүүлд гаргасан үнэт цаас /On the run security/**

Хамгийн сүүлд гаргасан үнэт цаас, эсхүл гэрээ. Энэ нь хамгийн хөрвөх чадвар сайтай санхүүгийн хөрөнгө бөгөөд урамшуулалтай борлогддог.

**Хамтын данс /Joint account/** Нэгээс дээш хүн хамтран эзэмшдэг дансыг хэлнэ. Дансыг эзэмшигч бүр дансыг ашиглан гүйлгээ хийх боломжтой.

**Хамтын зээл /Syndicated loans/** Зээл олгох эрх бүхий байгууллагуудын хамтран олгосон зээл. Ингэснээр том

хэмжээтэй зээл олгох боломж бурдэхээс гадна зээлдүүлэгчид зээлийн эрсдлээ хуваалцах боломжтой болдог.

**Хамтын зээлжүүлэлтийн нэгдэл /Syndicate/** Дангаараа гүйцэтгэх боломжгүй том хэмжэний төлбөр тооцоо, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор бий болж буй нэгдлийг хэнлэ. Тухайлбал, хөрөнгө оруулалтын банкууд хувьцааны томоохон анхны нийтийн арилжаа зохион байгуулахын тулд синдикат үүсгэдэг.

**Хамтын сан /Mutual fund/** Төрөл бүрийн хувьцаа, бонд, эсхүл мөнгөний захын хэрэгслүүдийг худалдан авах зориулалттай мөнгөн сан. Хамтын сан нь хөрөнгө оруулагчдад төрөлжилт хийх, хөрөнгийг мэргэжлийн түвшинд удирдах боломжийг олгодог.

**Хамтын хөрөнгө /Venture capital/** Хөрөнгө оруулагчдаас урт хугацаанд өсөх боломжтой, үйл ажиллагаагаа эхлүүлж буй компани, жижиг бизнес эрхлэгчдэд өгч буй санхүүгийн хөрөнгө. Энэ нь хөрөнгийн зах зээлээс эх үүсвэр татах бололцоогүй нөхцөлд эхлэлийн санхүүжилтийн чухал эх үүсвэр болдог.

**Хамтын хөрөнгө оруулалттай үйлдвэр /Joint venture/** Хоёр ба түүнээс дээш талуудын шинэ аж ахуйн нэгж, шинэ хөрөнгө бий болгооор өөрсдийн нөөц хөрөнгийг дайчлан хамтран эрхэлж буй бизнес. Хамтын бизнест оролцогч тус бүр нэгдсэн үйл ажиллагаанаас олох ашгаас хүртэх, эсхүл алдагдлыг үүрнэ. Харин өөрсдийн үндсэн бизнесийн ашиг, алдагдал үүнд хамаарахгүй.

**Харилцагч данс /Counterparty account/** Харилцагч данс нь санхүүгийн гүйлгээг хүлээн авагч дансыг хэлнэ.

**Харилцах данс /Transactional account, Checking account/** Өдөр тутмын төлбөр тооцоог хурдан шуурхай, найдвартай гүйцэтгэх зорилгоор банк эсхүл санхүүгийн байгууллагад нээсэн данс. Харилцах дансыг хүү олох зорилгоор эсхүл мөнгө хадгалах зорилгоор нээдэггүй.

**Харилцах, хадгаламжийн данс /Deposit account/** Банкны байгууллагад хөрөнгөө хадгаламж, харилцах байдлаар байршуулан орлого, зарлага гаргадаг данс. Эдгээр дансыг банкны тайланда пассив талд харилцагчид өгөх өглөг байдлаар бүртгэдэг. Банкууд эдгээр дансны үлдэгдэлд

хүү төлдөг бөгөөд зарим банкууд үйлчилгээний шимтгэл авдаг.

**Хариуцлагын шимтгэл /Commitment fee/** Зээлдүүлэгч зээлдэгчээс түүний ашиглаагүй зээлийн шугам, эсхүл ашиглаагүй зээлийн дүнгээс тооцож авдаг шимтгэл. Өөрөөр хэлбэл, зээлдүүлэгч зээлийн шугамыг нээлттэй хадгалах, эсхүл ирээдүйд тодорхой цаг хугацаанд зээл гаргах амлалт өгч байгаагийн хувьд уг шимтгэл авч, зээлдэгч үүний хариу болгон шимтгэл төлдөг. Ихэвчлэн ашиглаагүй зээлийн үлдэгдэл дүнгээс тогтмол хувиар бодогддог.

**Хийсвэр хүү /Imputed interest/** Зээл болон үнэт цаасны хүү төлөгдсөн эсэхээс үл хамааран татвар ногдуулах зорилгоор тооцоолсон хүүгийн орлого болон төлбөрийг хэлнэ.

**Хоёр долоо хоног тутам төлөгдөх зээл /Biweekly loan/** Хоёр долоо хоног тутам зээлийн үндсэн төлбөр, хүүг төлдөг зээл. Зээлийн төлбөрийг ийнхүү хоёр долоо хоногоор төлөх нь сар бүр төлөхөөс илүү хэмнэлттэй байдаг. Жишээ нь, 6.5 хувийн хүүтэй 200 сая төгрөгийн 30 жилийн хугацаатай ипотекийн зээлийг сар бүр төлөхөөр авбал сар бүр 1,264.14 мянган төгрөг төлөх хуваарытай байна. Харин төлбөрийг хоёр долоо хоног тутам төлөхөд 632.07 мянган төгрөгийг нэг удаадаа төлөх бөгөөд зээлийн төлөгдөх хугацаа 6 жилээр богиносч, сард 1 удаа төлөх зээлээс 58.4 сая төгрөгийн хэмнэлт гарна.

**Хоёр талт гэрээ /Bilateral contract/** Хоёр талт гэрээ гэдэг нь хоёр этгээд тодорхой асуудлаар бие биедээ ямар нэгэн эдлэх эрх, үүрэг хүлээх талаар тохиролцож, хуулийн хүрээнд үйлдсэн бичиг баримтыг хэлнэ. Жишээ нь, худалдан авагч үнийнтодорхой хэсгийг төлсний дараа орон сууцыг худалдаж байгаа иргэн орон сууцны өмчлөх эрхийг шилжүүлнэ гэсэн байдлаар хоёр талт гэрээг байгуулж болно.

**Хоёрдогч зах зээл /Secondary market/** Хөрөнгө оруулагчид үнэт цаасыг гаргагч компаниудаас бус бусад хөрөнгө оруулагчдаас худалдан авах зах (тухайлбал, Нью-Йоркийн хөрөнгийн бирж, NASDAQ).

**Хоёрдогч нөлөө /Secondary effects/** Үйл явдлын өрнөлтэй шууд холбоогүй, ирээдүйд үүсэх үр дагаврын нөлөө.

**Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө /Tier 2 capital/** Банкны өөрийн хөрөнгийн нэг хэсэг. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө нь дахин үнэлгээний сан, хоёрдогч өглөг, бусад сан зэргээс бүрддэг.

**Хойшлогдсон төлбөр /Deferred payment/** Ирээдүйн тодорхой хугацаа хүртэл хойшлогдсон төлбөрийн гүйлгээ.

**Холимог хүү /Blended rate/** 1. Дахин санхүүжүүлж байгаа зээлийн хувьд хэрэглэгддэг, өмнөх зээлийн хүүгээс өндөр, шинээр олгож буй зээлийн хүүгээс бага хүү. Ерөнхийдөө зээлдүүлэгч орон сууц худалдан авч буй зээлдэгчид одоогийн байгаа бага хүйтэй зээлийг дахин санхүүжүүлэхийг санал болгодог. Жишээ нь, Дорж Батад орон сууцaa худалдахыг хүссэн. Үг орон сууцны одоогийн байгаа зээлийн үлдэгдэл 60 сая төгрөг, хүү нь 8 хувь. Доржийн харилцагч банк одоогийн зээлийг 10 хувийн холимог хүүгээр, 120 сая төгрөгийн зээлээр дахин санхүүжүүлэхийг санал болгоно. Хэрэв Бат банкнаас шинээр зээл авбал 12 хувийн хүүгээр авна. 2. Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор өөр өөр хүйтэй хэд хэдэн зээлийн хувьд өр төлбөрийн хэмжээг тодорхойлох, эсхүл хөрөнгө оруулалтын орлогыг тооцох зэрэгт ашигладаг хүү. Жишээ нь, компани 5 хувийн хүйтэй 1 сая, 6 хувийн хүйтэй 3 сая төгрөгийн хоёр зээлтэй байв. Эхний зээлийн хувьд сар бүр 50 мянган төгрөгийг зээлийн хүүд төлдөг. Хоёр дахь зээлийг уг зээлээс жилийн дараа авсан бөгөөд сар бүр 180 мянган төгрөгийг зээлийн хүүд төлдөг. Эдгээр зээлийн холимог хүү 5.75 хувь ((50,000 +180,000)/4,000,000) болж байна.

**Хорогдол /Depletion/** Уул уурхай, мод бэлтгэл, газрын тос, эсхүл бусад ижил төстэй салбарт хамгийн их хэрэглэгддэг нягтлан бодох бүртгэлийн аккруэль суурьт арга. Татварын хөнгөлөлт, нягтлан бодох бүртгэлийн зорилгоор хорогдлыг тооцдог. Нөөцийн бууралт буюу хорогдоор байгалийн нөөцийг бууруулж бүртгэнэ.

**Хорогдох зээл /Amortized loan/** Үндсэн болон хүүгийн төлбөрийн аль алиныг бүрэн төлж дуусгах хуваарь бүхий зээл.

**Хөвөгч хүү /Floating rate/** Зарим зээл болон хадгаламжийн бүтээгдэхүүний хүү эргэн төлөгдөх хүртэл тогтмол байдаг. Тухайлбал, бондын купон, хадгаламжийн тогтмол хүү, орон

сууцны зээлийн тогтмол хүү гэх мэт. Түүнчлэн хүү нь эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдалтай уялдан тодорхой үеүдэд өөрчлөгддөг санхүүгийн хэлцлүүд (зээл, хадгаламж гэх мэт) байдаг. Ийм хэлцлийн хүүг хөвөгч хүү гэж нэрлэдэг.

**Хөвөгч хүүтэй бонд /Floating rate bond/** Хүү буюу купоны хүү нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдан тодорхой давтамжтайгаар (хагас жил, улирал тутам гэх мэтээр) өөрчлөгддөг бондыг хэлнэ.

**Хөндлөнгийн аудит /External audit/** Хөндлөнгийн аудит гэдэг нь компани гадны бие даасан, хараат бус, мэргэжлийн аудитын байгууллагаар өөрийн санхүүгийн үйл ажиллагаандaa шалгалт хийлгэх үйл ажиллагааг хэлнэ. Хэдийгээр байгууллага дотоод аудиттай байх боловч сонирхлын зөрчилтэй холбоотойгоор хөндлөнгийн аудит нь чухал юм.

**Хөрвөх бонд /Convertible bond/** Үрьдчилан тохирсон үнээр тодорхой тооны хувьцаанд хөрвүүлэх боломжтой бондыг хэлнэ. Хөрвөх бонд эзэмшигч нь тогтмол купоны орлого олохоос гадна тухайн бондыг гаргасан компанийн хувьцааны үнийн өсөлтөөс үр ашиг хүртэх боломжтой. Гэхдээ купоны хүү нь энгийн бондын хүүгээс бага байдаг.

**Хөрвөх чадвар /Liquidity/** Хадгаламж, эсхүл хөрөнгө оруулалтын богино хугацаанд бэлэн мөнгө болох чадвар.

**Хөрвөх чадварын үнэ /Liquidity premium/** Ямар нэгэн үнэт цаасны хөрвөх чадвар буюу түргэн борлогдох чадвар муу үед уг цаасыг худалдахын тулд хямдруулахаас аргагүй болдог. Иймээс хөрөнгө оруулагч хөрвөх чадвар муутай үнэт цаас худалдан авахдаа илүү хямд үнэ буюу өндөр өгөөж шаарддаг. Тухайлбал, 2 бондын купон болон хугацаа нь ижил боловч нэг нь хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг харин нөгөө нь үгүй гэвэл хөрөнгийн бирж дээр арилжаалагдаггүй бонд нь хөрвөх чадвар муутай тул хөрөнгө оруулагч маш хямдаар буюу маш өндөр нэмэгдэл өгөөжтэйгээр л худалдан авч болох юм.

**Хөрвөх чадварын харьцаа /Statutory liquidity ratio/** Kacc, үнэт металл, бусад богино хугацаатай үнэт цаас зэрэг хөрвөх чадвартай активыг харилцах, хадгаламжид харьцуулсан харьцаа. Зээлийн хэт өсөлтийг хязгаарлах зорилгоор зарим улсад хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтийг ашигладаг.

**Хөрвөх чадварын эрсдэл /Liquidity risk/** Хөрөнгө оруулалтыг богино хугацаанд бэлэн мөнгө болгож чадахгүй байх магадлал. Мөн банк болон компанийй өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдаагүй боловч харилцагчийн өмнөхүлээсэн санхүүгийн үүргээ цагхугацаанд нь биелүүлэх чадваргүй болох, эсхүл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гаргах нөхцөл байдал үүсэхийг хөрвөх чадварын эрсдэл гэж ойлгодог.

**Хөрөнгийн алдагдал /Capital loss/** Хөрөнгө оруулалтын актив болон үнэт цаасны зах зээлийн үнэ буурах үед уг активыг худалдан авснаасаа хямд үнээр зарахад үүсч буй алдагдлыг хэлнэ.

**Хөрөнгийн ашиг /Capital gain/** Хөрөнгө, хувьцаа, эсхүл бусад хөрөнгө оруулалтыг борлуулснаас олох ашиг.

**Хөрөнгийн бирж /Stock market/** Олон нийт хувьцааг арилжаалах зах буюу хувьцааг худалдах, худалдан авах үйл явц хэрэгжжих буй газар.

**Хөрөнгийн зардал /Capital expenditure (CAPEX)/** Үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж гэх мэт үндсэн хөрөнгө худалдан авах буюу шинэчлэн засварлах зэрэгт зарцуулж буй зардал. Уг зардал нь ирээдүйн ашиг орлогыг бий болгодог. Нягтлан бодох бүртгэлийн хувьд үндсэн хөрөнгө худалдан авах, эсхүл одоо байгаа үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгаж буй зардлыг үүнд оруулж тооцно.

**Хөрөнгийн зах /Capital market/** Мөнгөний зах дээр 1 хүртэл жилийн хугацаатай санхүүгийн хэрэгслүүд арилжаалагдаг бол хөрөнгийн зах дээр хувьцаа, бонд гэх мэт дунд болон урт хугацаат хэрэгслүүд арилжаалагдана. Хөрөнгийн зах дээр хувь хүн болон байгууллагын хөрөнгө оруулагчид (хамтын сан, банк, тэтгэврийн сан, баялгийн сан гэх мэт) арилжаанд оролцно. Эх үүсвэр нийлүүлэгчид хамгийн бага эрсдэлээр хамгийн өндөр өгөөж олохыг эрмэлзэдэг бол эх үүсвэр хайгчид хамгийн бага зардлаар эх үүсвэр босгохыг зорино.

**Хөрөнгийн идэвхтэй удирдлага /Active management/** Нийт зах зээлийн хандлагыг таамаглан түүндээ суурilan хөрөнгө оруулалтын багцаа бүрдүүлэх, эсхүл буруу үнэлэгдсэн зах зээл болон үнэт цаасыг олж илрүүлэн түүнээс

эрсдэлгүй ашиг олох хөрөнгө оруулалтын стратегийг хөрөнгийн идэвхтэй удирдлага гэдэг. Өөрөөр хэлбэл, хэн нэгний бүрдүүлсэн багц, индекс зэргийг дагалгүйгээр хөрөнгө оруулагч өөрөө хаана, хэзээ, юунд хөрөнгө оруулалт хийх вэ? гэдгээ таамаглал, судалгаанд суурilan шийдвэрлэдэг. Хамгийн гол техник нь ирээдүйн талаар зөв таамаглал дэвшүүлэх, хэт болон дутуу үнэлэгдсэн зах зээл, үнэт цаасыг олж илрүүлэх явдал юм.

**Хөрөнгийн орлогын татвар /Capital gains tax/** Бараа материалын бус хөрөнгийг худалдан авсан үнээс өндөр үнээр борлуулахад олсон ашгаас авах татвар. Хувьцаа, бонд, үнэт металл, эд хөрөнгө зэргийг борлуулан ашиг олох байдал түгээмэл байдаг. Зарим улсад уг татварыг авдаггүй бөгөөд авдаг улсуудын дийлэнх нь энэ төрлийн татварын хувийг иргэд, байгууллагын хувьд ялгаатай тогтоосон байдаг.

**Хөрөнгө байршуулах шийдвэр /Capital allocation decision/** Хөрөнгийг тодорхой харьцаагаар эрсдэлгүй актив болон эрсдэлтэй багцад байршуулах тухай хөрөнгө оруулагчийн шийдвэр. Эрсдэлтэй багц нь хувьцаа, бонд, эрдэс бүтээгдэхүүн, дэд бүтцийн төсөл гэх мэт активаас бүрдэнэ. Эрсдэлгүй актив нь засгийн газрын бонд, засгийн газрын богино хугацаат үнэт цаас зэргээс бүрдэнэ.

**Хөрөнгө оруулалтын багц //Investment portfolio/** Хөрөнгө оруулагчийн сонгосон үнэт цаас болон бусад активуудын бүрдлийг хэлнэ.

**Хөрөнгө оруулалтын банк //Investment bank/** Шинээр хувьцаа, бонд гаргагч болон худалдан авагчийн хооронд зуучилж, эх үүсвэр дутагдалтай байгаа талд хувьцаа, эсхүл бондыг хөрөнгө оруулагчдад худалдаж, хөрөнгө босгоход нь тусалдаг. Ерөнхий зарчим нь нэг болон хэд хэдэн хөрөнгө оруулалтын банк нийлж шинээр гаргаж буй үнэт цаасыг худалдан авч, цааш нь хөрөнгө оруулагчдад зарах бөгөөд тэд үйл ажиллагааны шимтгэл болон үнийн зөрүүнээс ашиг олно. Гаргагч талд төлж буй үнээсээ бага үнээр хөрөнгө оруулагчдад зарсан тохиолдолд хөрөнгө оруулалтын банк алдагдал хүлээх эрсдэлтэй.

**Хөрөнгө оруулалтын зөвлөгч //Investment adviser/** Хөрөнгө оруулалтын багцыг тодорхой шимтгэлтэйгээр удирддаг, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгдөг, шинжилгээ


хийдэг мэргэжилтэнг хэлнэ. Жишээ нь, хамтын сангүүд хөрөнгө оруулалтын зөвлөгчид мөн бол хувьцааны брокерууд биш юм.

**Хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй бонд** *//Investment-grade bond// BBB, Baa ба түүнээс дээш зэрэглэлтэй бондыг хэлнэ.*

**Хөрөнгө оруулалтын идэвхгүй стратеги** *//Passive investment strategy//* Хөрөнгө оруулалтын идэвхтэй стратегийн эсрэг стратеги. Энэ стратегийг баримтлагч нь зах зээл үр ашигтай гэсэн таамаглалд итгэх тул буруу үнэлэгдсэн үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслүүдийг олж, эрсдэлгүй ашиг олохыг эрмэлзэггүй. Тиймээс идэвхгүй стратеги баримталж буй хөрөнгө оруулагчид индекс сангүүдад хөрөнгө оруулалт хийдэг.

**Хөрөнгө оруулалтын компани** *//Investment company//* Хөрөнгө оруулалтын компани гэдэг нь хувьцаа гарган хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэж, бонд, хувьцаа гэх мэт төрөл бүрийн үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийдэг компани юм. Хөрөнгө оруулалтын компанийн хувьцааг эзэмшигч буюу хөрөнгө оруулагч нь оруулсан хөрөнгийн хувираа ашиг болон алдагдлыг хуваалцана.

**Хөрөнгө оруулалтын мөчлөг** *//Investment life cycle//* Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалт хийхээс эхлээд орлого, ашгийн менежмент, үр өгөөж буурах, түүнийг борлуулах хүртэлх бүх үе шатууд. Үе шат бүрт хөрөнгө оруулалтын анхны өртөг, менежментийн зардал, мөнгөний урсгал, ханшийн чангарталт, суралт, борлуулах зардлыг хамруулан бодит өгөөжийг тодорхойлдог.



*Зураг 3. Хөрөнгө оруулалтын мөчлөг*

**Хөрөнгө оруулалтын өгөөж /Return on investment (ROI), Investment return/** Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг үнэлэх, эсхүл хэд хэдэн өөр хөрөнгө оруулалтын үр өгөөжийг харьцуулах гүйцэтгэлийн хэмжүүр. Хөрөнгө оруулалтаас олох өгөөжийг зардалд харьцуулсан харьцаагаар илэрхийлэгддэг:

$$ROI = \frac{ХО-аас олох орлого-ХО-ын зардал}{ХО-ын зардал}.$$

Энд; ХО нь хөрөнгө оруулалтын товчлол.

**Хөрөнгө оруулалтын өртөг //Investment value/** Тодорхой нэг хөрөнгө оруулагчийн хөрөнгийн өртөг. Хөрөнгөө бүрэн ашиглах бололцоотой АНУ, Их Британи зэрэг орнуудад хөрөнгө оруулалтын өртөг нь түүний зах зээлийн үнэтэй тэнцүү байдаг. Бусад хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгөө хамгийн их үр ашигтайгаар байршуулах боломж хязгаарлагдмал байдаг тул хөрөнгө оруулалтын өртөг нь зах зээлийн үнээсээ бага байдаг.

**Хөрөнгө оруулалтын хугацаа //Investment horizon/** Ямар нэгэн хувьцаа, үнэт цаас, эсхүл багцыг хөрөнгө оруулалтын зорилгоор хадгалах хугацаа. Хөрөнгө оруулагчийн тухайн хөрөнгө оруулалтын хугацаа нь түүний амьдралын мөчлөг, эрсдэлд хандах хандлага, орлого, зарлага зэргээс хамаарна. Тухайлбал, залуу хөрөнгө оруулагч харьцангуй урт хугацаатай хөрөнгө оруулалт хийх боломжтой бол тэтгэврийн насанд ойртсон хөрөнгө оруулагчийн хувьд урт хугацаат хөрөнгө оруулалт хийх боломж хязгаарлагдмал юм. Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөрөнгө оруулалтын активын сонголтонд нөлөөлдөг.

**Хөрөнгө оруулалтын хугацааны өгөөж /Holding period return/yield/** Хөрөнгө оруулалтын хугацааны өгөөж нь хөрөнгө оруулалтын үр дунгийн энгийн хэмжүүр бөгөөд үүнийг хөрөнгө оруулалтын актив, үнэт цаас, эсхүл тухайн багцыг хадгалах хугацааны туршид түүнээс олсон орлого болон үнийн өсөлтийн өгөөжийг хөрөнгө оруулалтын нийт зардалд харьцуулж тооцдог.

**Хөрөнгө оруулах //Investing/** Санхүүгийн ашиг олох зорилгоор мөнгөө тодорхой хэрэгсэлд (хувьцаа, бонд, хамтын сан, үл хөдлөх хөрөнгө гэх мэт) байршуулах явдал.

**Хөрөнгөөр бүртгэх/Capitalize/** Аж ахуйн нэгжийн гаргасан зардлыг хөрөнгө болгож балансад бүртгэхийг хэлнэ. Тухайлбал, судалгаа шинжилгээний зардал нь урт хугацааны туршид үр өгөөжөө өгөх тул энэхүү зардлын тухайн тайлант үеийн орлогыг бий болгоогүй хэсгийг хөрөнгө хэлбэрээр балансад бүртгэнэ.

**Хөшүүргийн харьцаа /Leverage ratio/** Хоёр төрлийн хөшүүргийн харьцаа тооцдог. Нэгдүгээрт, санхүүгийн хөшүүргийн харьцаа нь компанийн санхүүгийн үүргээ биелүүлэх чадварыг харуулах бөгөөд хамгийн түгээмэл хэмжүүр нь нийт пассивыг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа юм. Мөн хүүг нөхөх харьцаа нь компанийн хөшүүргийн харьцааг илэрхийлнэ. Хоёрдугаарт, үйл ажиллагааны хөшүүргийн харьцааг хэмжих хэд хэдэн арга байдаг. Тухайлбал, тогтмол зардлыг нийт зардалд харьцуулж, үйл ажиллагааны ашгийн өөрчлөлтийн хувийг борлуулалтын өөрчлөлтийн хувьд харьцуулах, цэвэр ашгийг тогтмол зардалд харьцуулах байдлаар тооцно.

**Хөшүүрэг /Leverage/** Хөшүүрэг нь эх үүсвэрийн бүтцийг харуулах бөгөөд өглөг, өр төлбөр хэлбэрээр татсан эх үүсвэрийг нийт өөрийн хөрөнгөд харьцуулж тооцно. Өөрөөр хэлбэл, 1 төгрөгийн өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэдэн төгрөгийн өглөг татсаныг харуулна.

**Хуваарилаагүй ашгийн коэффициент /Retention ratio/** Ногдол ашиг төлөхгүйгээр хуримтлагдсан ашиг болгож байгаа ашгийн хувь. Ногдол ашиг хуваарилахаас илүүтэй бизнесийг өргөжүүлэхэд ашиглах ба хувьцаа эзэмшигчдэд төлдөг ногдол ашгийн хувийг тооцоолох ашгийн харьцааны эсрэг коэффициент юм. Жишээ нь, компанийн нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг 100 төгрөг, нэгж хувьцааны ногдол ашиг 40 төгрөг байсан бол хувьцааны ногдол ашиг хуваарилах харьцаа 40 хувь, харин хуваарилагдаагүй ашгийн коэффициент 60 хувь байна.

**Хуваарилалт /Distribution/** Нийгмийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг хуваарилах (хуваах) үйл явц.

**Хуваарилалтын үр ашиг /Allocative efficiency/** Хэн нэгний нөхцөл байдлыг дордуулахгүйгээр нөгөө этгээдийн нөхцөл байдлыг сайжруулах бүхий л боломжийг ашиглах явдал.

**Хувиараа эрхлэх аж ахуй /Sole proprietorship/** Нэг хүний эзэмшлийн бизнес бөгөөд хувиараа эрхлэх аж ахуйн эзэн нь бүх ашгаа авахын сацуу бүх өр төлбөрийг хариуцана.

**Хувийн банк /Private bank/** Өндөр орлоготой, чинээлэг иргэн болон гэр булийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тусгайлан банкны үйлчилгээ үзүүлэхийг хэлдэг.

**Хувийн компани /Private corporation/** Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хувьцаагаа арилжаалаагүй компани. Хувийн компани нь нийтийн өмчийн компани биш учраас өөрийн санхүүгийн нөхцөл байдлаа олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэггүй.

**Хувиргасан эргэн төлөгдөх дундаж хугацаа /Modified duration/** Бондын хувиргасан эргэн төлөгдөх дундаж хугацааг тооцоходоо бондын энгийн эргэн төлөгдөх хугацааг  $(1+\theta\text{г}\theta\text{ж})^{-1}$ -д хувааж тооцно. Хувиргасан эргэн төлөгдөх хугацаа нь бондын үнийн хүүгийн мэдрэмжийг хэмжинэ. Өөрөөр хэлбэл, өгөөж нэг нэгжээр өөрчлөгдөхөд бондын үнэ хэдэн хувиар өөрчлөгдхийг харуулна.

**Хувь тэнцүүлэх /Pro rata/** Өөрийн эзлэх хувийн дагуу ногдох хэсгийн хэмжээг тодорхойлох хуваарилалт хийхэд ашигладаг арга бөгөөд хувь гэсэн утгатай латин үг. Жишээ нь, хувь тэнцүүлсэн ногдол ашиг гэдэг нь хувьцаа эзэмшигч бүр нэгж хувьцаанд тэнцүү хэмжээний ногдол ашиг хүртэнэ гэсэн үг.

**Хувь хүний мэдээллийг хулгайлах /Identity theft/** Зээл авах, эсхүл бусад үр ашиг хүртэх зорилгоор бусдын хувийн мэдээллийг (тухайлбал, нууц дугаар) зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар ашиглах явдал.

**Хувьсах хүү /Variable interest rate/** Зах зээлийн жишиг хүү, хувьсан өөрчлөгддөг индексийг даган өөрчлөгддөг хүү. Хувьсах хүүгийн гол давуу тал нь жишиг хүү, эсхүл индекс буурсан үед зээлдэгчийн хүүгийн төлбөр даган буурдаг. Эсрэгээрээ жишиг индекс өсөхөд хүүгийн төлбөр нэмэгддэг. Лондонгийн банк хоорондын захын хүү (LIBOR), АНУ-ын Засгийн газрын 5, 10, 30 жилийн хугацаатай хүүг жишиг хүү болгон хэрэглэх нь түгээмэл байдаг. Жишээ нь, зээлдэгч 25 сая төгрөгийн зээлийг 6 сарын хугацаатай LIBOR хүүн дээр нэмэх нь 3.5 хувийн хүүтэйгээр авсан гэе. Зээл авах үед LIBOR хүү 2.5 хувь байв. Эхний 6 сард зээлдэгчийн хүү

(2.5+3.5) 6 хувь байх бөгөөд 1.5 сая төгрөг төлнө. Харин дараагийн 6 сард LIBOR хүү 4 хувь болж өссөн бол зээлдэгч (4+3.5) 7.5 хувийн хүүгийн төлбөрт 1,875 мянган төгрөгийг төлнө.

**Хувьцаа /Equity, Stock/** Компанид хувь эзэмшиж буйг гэрчилсэн үнэт цаас. Энгийн болон давуу эрхтэй хувьцааны төрөл байдаг.

**Хувьцаа буцаан худалдан авах /Share buyback/** Зах зээл дээрх хувьцааныхаа тоог багасгах үүднээс компани өөрийн хувьцааг буцаан худалдан авч буй явдал. Компани одоо байгаа хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд, эсхүл хувьцааны хяналтыг гартаа авахыг хүсч буй хувьцаа эзэмшигчид хувьцааг худалдан авдаг.

**Хувьцаа хуримтлуулан хадгалах /Warehousing/** Ирээдүйд компанийг худалдан авах зорилгоор номиналь эзэмшигчийн нэр дээр тухайн компанийн хувьцааг аажмаар худалдан авч хуримтлуулах үйл ажиллагаа.

**Хувьцаа эзэмшигч /Shareholder/** Компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувь хүн, хуулийн этгээд. Тэдгээр нь компанийн эзэмшигчид юм.

**Хувьцааг хуваах /Stock split/** Компанийн хувьцааны тоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа. Хувьцаа хуваахаас өмнөх үеийн үнийг тохируулан үнийг тогтоо ба өмнөх үе ба дараах үеийн компанийн зах зээлийн үнэлгээ хэвээр хадгалагддаг. Жишээ нь, компани нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 2000 хувьцаатай. Зах зээлийн үнэлгээ нь 2000x100 буюу 200,000 төгрөг. Компани нэгж хувьцааг 2 хувьцаа болгон хуваасан гэвэл 4000 хувьцаатай болж хувьцаа эзэмшигч бүрийн эзэмших хувьцаа хоёр дахин нэмэгдэх болно. Харин нэгж хувьцааны үнийг 50 төгрөг болгон өөрчилнө. Ийнхүү зах зээлийн үнэлгээ хувьцаа хуваахаас өмнөх үеес өөрчлөгдөөгүй буюу 4000x50 буюу 200,000 төгрөг байна.

**Хувьцааны зах зээл /Share (stock) market/** Компаниудын хувьцаа гаргаж, арилжаалах зах зээл. Энэ нь хөрөнгө оруулагчдад компанийн хувьцаа эзэмшигч болоход, компаниудад хөрөнгө босгоход тусалдаг эдийн засгийн чухал үүрэг бүхий зах зээл юм. Хувьцааны зах зээл нь анхдагч болон хоёрдогч гэж хуваагддаг. Анхдагч зах зээлд анх удаа олон нийтэд борлуулж буй хувьцааны арилжаа хамрагддаг бол бусад арилжаа хоёрдогч зах зээлд хамрагддаг.

**Хувьцааны индексийн фьючерс** гэрээ */Stock index futures/* Тодорхой хөрөнгийн захын хувьцааны индексийн үнээр тодорхойлогдох фьючерс гэрээ. Стандарт энд Пүүрс-500 хувьцааны индексийн фьючерс гэрээ хамгийн түгээмэл хэрэглэгддэг.

**Хувьцааны ногдол ашиг** */Stock dividend/* Ногдол ашгийг бэлэн мөнгөөр бус хувьцаа нэмж гарган хувьцаагаар хувьцаа эзэмшигчдэд тараасан ногдол ашиг.

**Хувьцааны өгөөжийн хувь** */Equity yield rate/* Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын өгөөжийн хэмжүүр. Хувьцааны өгөөжийн хувийг хөрөнгө оруулалт хийсэн хувьцаанаас олох өгөөжийг хувьцааны дунд харьцуулж тооцно.

**Хувьцааны хамтын сан** */Stock mutual fund/* Хөрөнгө оруулагчдын ашиг олох зорилгоор хувьцаа худалдан авч буй хамтын сан.

**Хувьцаат капитал** */Share capital/* Хувьцаа гаргах замаар бий болгосон хөрөнгө. Хувьцаат капитал нь энгийн болон давуу эрхтэй хувьцааны аль алинаас бүрддэг.

**Хугацаа** */Term/* Хөрөнгө оруулалтын үргэлжлэх хугацаа. Өрийн хувьд зээлдэгч бүх төлбөрөө зээлдүүлэгчид буцаан төлөх хугацаа. Хувь эзэмшилийн хөрөнгө оруулалтын хувьд хувийг худалдан авч, борлуулах хоорондын хугацаа.

**Хугацаа нь дууссан карт** */Expired card/* Карт нь хүчинтэй хугацаатай бөгөөд уг хугацаа карт дээр хэвлэгдсэн байна. Уг хугацаа дуусч, төлбөр тооцоонд шууд ашиглагдах боломжгүй болсон картыг хэлнэ.

**Хугацаа хэтрэлтийн хувь** */Delinquency rate/* Зээлийн багц дахь хугацаа хэтэрсэн төлбөртэй зээлийн эзлэх хувь. Хугацаа хэтэрсэн төлбөртэй зээлийн тоог нийт зээлийн тоонд хувааж гаргадаг. Жишээ нь, банк нийт 20,000 ширхэг зээлээс бүрдсэн зээлийн багцтай бөгөөд үнээс 2,000 ширхэг зээл нь 90 хоног хүртэл төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд хугацаа хэтрэлтийн хувь 10 хувь (2000/20000) байна. Ихэвчлэн зээлийн хугацааг 3 сараас дээш хугацаагаар хэтрүүлсэн зээлийн тоогоор тооцдог.

**Хугацаа хэтэрсэн өр** */Arrears/* Хуваарыт төлбөр төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөр, үүргийн гүйцэтгэл.

**Хугацаа хэтэрсэн төлбөр /Amount past due/** Зээлийн хувьд хугацаандаа эргэн төлөгдөгүй мөнгөн дүн.

**Хугацаагүй бонд /Consol bond/** Эргэн төлөгдөх хугацаагүй боловч тодорхой давтамжтайгаар купоны төлбөр төлдөг бондыг хэлдэг.

**Хугацаагүй мөнгөн урсгал /Perpetuity/** Төгсгөлгүй мөнгөн урсгалын цуваа. Уг цувааны өнөөгийн үнэ цэнэ (PV)-ийг дараах томъёогоор тодорхойлно:

$$PV = \frac{C}{(1+r)^1} + \frac{C}{(1+r)^2} + \frac{C}{(1+r)^3} \dots = \frac{C}{r}.$$

Английн Засгийн газраас XVIII зууны үеэс гаргах болсон (consols) бонд энэ төрлийн хэрэгслийн сонгодог жишээ юм. Энэ нь үндсэн төлбөр хэзээ ч төлөгдөхгүй, зөвхөн хүүгийн төлбөр төгсгөлгүй төлөгддөг хугацаагүй бонд юм.

**Хугацааны эцэст бөөн дүнгээр төлөгдөх зээл /Bullet loan/** Зээлийн үндсэн төлбөрийг бүхэллээр нь хугацааны эцэст төлдөг зээл. Зарим тохиолдолд үндсэн төлбөрөөс гадна хүүг хугацааны эцэст төлдөг. Бонд, үнэт цаас, ипотекийн зээл, бусад зээлийн үндсэн төлбөр хугацааны эцэст төлөгдөх бол ийм төрлийн зээлд хамруулна.

**Хугацаатай зээл /Term loan/** Эргэн төлөлтийн хуваарь бүхий хугацаатай зээл. Ихэвчлэн 1-30 жилийн хугацаатай зээл байдаг бөгөөд ихэнхдээ хувьсах хүйтэй байдаг.

**Хугацаатай хадгаламж /Time deposit/** Тодорхой хугацаа зааж мөнгөн хөрөнгөө хадгалуулж, хүүгийн орлого олох боломжтой хадгаламж. Заасан хугацааны туршид зарлагын гүйлгээ хийхгүй байх гэрээ байгуулдаг бөгөөд хугацаатай хадгаламж нь хамгийн өндөр хүүгээр мөнгөө өсгөх боломжийг олгоно.

**Худалдан авалт /Purchases/** Компани ямар нэгэн зорилгыг биелүүлэхийн тулд бүтээгдэхүүн, үйлчилгээг олж авах үйл ажиллагаа.

**Худалдан авах /Acquisition/** Нэг компани өөр компанийн хяналтыг авах үйл явц. Худалдан авагч нь тухайн компанийн хяналтын багцыг эзэмшихийн тулд хуучин хувьцаа эзэмшигчдэд зах зээлийн үнээс илүү үнэ төлөх шаардлага үүсэх хандлага байдаг.

**Худалдан авах опцион /Call option/** Худалдан авах опцион нь опцион худалдан авагч талдаа гэрээнд тусгасан активыг урьдчилж тогтсон үнээр ирээдүйд худалдан авч болох эрхийг олгох боловч худалдан авах үүргийг хүлээлгэдэггүй санхүүгийн үүсмэл хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, опцион худалдан авагч гэрээнд тусгасан активыг тохирсон үнээр ирээдүйд худалдан авч ч болно, авахгүй ч байж болох юм. Харин опцион зарсан буюу бичсэн тал нь опцион худалдан авагчийн хүсэлтийг биелүүлэх үүрэг хүлээнэ.

**Худалдан авах үнэ /Bid price/** Цаг хугацааны тухайн агшинд худалдаалагдаж буй зүйлийг (тухайлбал, хувьцаа, гадаад валют гэх мэт) худалдаж авах зах зээлийн хамгийн өндөр үнэ.

**Худалдан авах эрх /Warrants/** Үнэт цаас гаргагчаас тодорхой үнээр тогтоосон хугацаанд үнэт цаас (ихэвчлэн хувьцаа)-ыг худалдан авах эрх буюу үүсмэл үнэт цаас. Худалдан авах эрх нь опционтой адил эзэмшиж буй этгээддээ үнэт цаас худалдан авах тусгай эрх олгодог ч үнэт цаас гаргагчид доогуур хүү, ногдол ашиг төлөх боломж олгож ихэвчлэн бонд, давуу эрхтэй хувьцаанд дагалдаж гардгаараа ялгаатай юм.

**Худалдан авч хадгалах стратеги /Buy-and-hold strategy/** Хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын хэрэгсэл, үнэт цаасыг худалдан авч, урт хугацааны өгөөжид итгэн богино хугацааны хэлбэлзлийг үл хайхран удаан хугацааны турш хадгалах стратегийг хэлнэ. Энэ стратеги нь хөрөнгө оруулалтыг авч, зарах идэвхтэй стратегийн эсрэг стратеги юм.

**Худалдах опцион /Put option/** Зарах опцион нь опцион худалдан авагч талдаа гэрээнд тусгасан активыг урьдчилж тогтсон үнээр ирээдүйд худалдаж болох эрхийг олгох боловч худалдах үүргийг хүлээлгэдэггүй санхүүгийн үүсмэл хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, опцион худалдан авагч гэрээнд тусгасан активыг тохирсон үнээр ирээдүйд худалдаж ч болно, худалдахгүй ч байж болох юм. Харин опцион зарсан буюу бичсэн тал нь опцион худалдан авагчийн хүсэлтийг биелүүлэх үүрэг хүлээнэ.

**Худалдах үнэ /Ask price/** Цаг хугацааны тухайн агшинд худалдаалгаж буй зүйлийг (тухайлбал, хувьцаа, гадаад валют гэх мэт) худалдах зах зээлийн хамгийн доод үнэ.

**Худалдах-худалдан авах гэрээ /Buy-sell agreement/** Бизнесийн хамтран эзэмшигч нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах, эсхүл ямар нэг шалтгаанаар бизнесээ орхих зэрэг тохиолдолд бизнесийн өмчлөлийг зохицуулахаар хамтран эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ.

**Хуйвалдаан /Collusion/** Компаниудын үнэ тогтоох нууц тохиролцоо, гэрээ бөгөөд энэ нь өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэгдсэн хууль бус үйл ажиллагаа юм.

**Хурдавчилсан элэгдлийн арга /Accelerated depreciation/** Шулуун шугаман элэгдлийн аргатай харьцуулахад хөрөнгийг эхний жилүүдэд илүү өндөр хувиар элэгдүүлэх аргыг хэлнэ.

**Хуримтлагдсан ашиг /Retained earnings/** Хувьцаа эзэмшигчдэд ашиг хүртээсний дараа үлдсэн цэвэр ашгийн хэмжээг хэлнэ. Өөрөөр хэлбэл, нийт цэвэр ашгаас ашгийг хасч тооцно.

**Хуримтлагдсан зардал /Accrued expense/** Төлөгдөөгүй боловч тухайн цаг үед тооцогдох зардлыг хуримтлуулан тооцсон зардал. Ийм зардлыг тайлант үед хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгах шаардлагатай байдаг. Жишээ нь, банкны зээлийн хуримтлуулж тооцсон хүүгийн зардал юм.

**Хуримтлагдсан өгөөж /Cumulative return/** Хөрөнгө оруулалтын тодорхой хугацааны туршид багцын үнэ цэнэ хэдэн хувиар өөрчлөгдсөн болохыг хэмжинэ. Хуримтлагдсан өгөөжийг тооцоходо тухайн хугацаанд ашиг, хүү зэрэг орлого олсон эсэх, хэрэв олсон бол тэдгээрийн дахин хөрөнгө оруулалтын өгөөж нь ямар байсан эсэхийг давхар шалгаж, тооцоонд хамруулах шаардлагатай.

**Хуримтлагдсан хүү /Accrued interest/** Өглөг, авлагын аль алинд ашиглаж болох ба өглөг төлөгдөөгүй, авлагыг хүлээн аваагүй байхад нягтлан бodoх бүртгэлийн хуримтлуулж тооцох аргыг ашиглахад хэрэглэгдэг нэр томьёо. Жишээ нь, зээл болон бонд гаргаснаас хойш төлөгдөх өдөр хүртэлх хүүгийн төлбөр болон авлагыг хуримтлуулан хуримтлагдсан хүүг тооцно.

**Хуримтлагдсан элэгдэл** /Accumulated depreciation/ Хөрөнгийн анхны өртийг ашиглагдах хугацааны туршид системтэйгээр хуваарилан зардалд шингээхийн тулд элэгдэл тооцдог. Эдгээр элэгдлийн нийлбэр нь хуримтлагдсан элэгдэл болно. Тайлан тэнцэлд тухайн хөрөнгийн дансны үнэ нь анхны өртөг, хуримтлагдсан элэгдлийн зөрүүгээр тодорхойлогдоно.

**Хуримтлуулах** /Accrue/ Цаг хугацааны туршид хүү, орлого, зардлыг хуримтлуулах чадвар. Жишээ нь, хадгаламжийн дансанд хүүгийн орлого хуримтлагдаж цаг хугацааны туршид хадгаламжийн дүн нэмэгддэг.

**Хүлээгдэж буй өгөөж** /Expected return/ Ирээдүйн боломжит өгөөжүүдийг боломжит магадлалаар жигнэж тооцсон дундаж өгөөжийг хэлнэ.

**Хүлээгдээгүй өгөөж** /Abnormal return/ Хүлээгдээгүй өгөөж нь үнэт цаас болон багцын хүлээгдэж буй өгөөж болон бодит өгөөжийн зөрүүгээр тодорхойлогдоно. Хүлээгдэж буй өгөөж нь багцын болон үнэт цаасны үнэлгээний загвараар тооцоологддог. Тухайн загварт тусгагдаагүй төрөл бүрийн үйл явдал нь бодит өгөөж хүлээгдэж буй өгөөжөөс зөрүүтэй гарах шалтгаан болно.

**Хүү төлдөг пассив** /Interest paying liabilities/ Хүүгийн төлбөр төлдөг пассив. Тухайлбал, бусдаас авсан зээл, бонд гэх мэт.

**Хүүг нөхөх харьцаа** /Interest coverage ratio/ Энэ нь хөшүүргийг хэмжих нэг үзүүлэлт бөгөөд компанийн хүү болон татвар төлөхийн өмнөх ашгийг хүүгийн зардалд харьцуулж тооцно.

**Хүүгийн мэдрэмжийн зөрүү** /Interest sensitivity GAP/ Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий актив болон пассивын зөрүүг хэлнэ. Хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий активт зээл, үнэт цаас зэрэг активууд орох бол хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий пассивт хүү хуримтлуулан тооцдог харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат, банкнаас гаргасан өрийн бичиг, бусад банкнаас авсан зээл зэрэг пассивууд орно.

**Хүүгийн своп** /Interest rate swap/ Үнэт цаасыг бодитоор солилцолгүйгээр зөвхөн үнэт цаасны орлого, эсхүл төлбөр солилцох замаар ирээдүйн хүүгийн эрсдэлээ удирдах

санхүүгийн хэлцэл юм. Тухайлбал, А хөрөнгө оруулагч тогтмол хүүтэй бонд эзэмшдэг боловч ирээдүйд хөвөгч хүүгээр төлбөр төлөх үүрэгтэй, харин Б нь хөвөгч хүүтэй бондоо зарж, тогтмол хүүтэй бонд авах шаардлагатай гэе. Гэвч А ба Б тал эзэмшиж буй бондоо заралгүйгээр зөвхөн хүүгийн орлогоо солилцоо буюу хоорондоо хүүгийн своп хэлцэл хийснээр А нь хөвөгч хүүгийн орлоготой, Б нь тогтмол хүүгийн орлоготой болно. Өөрөөр хэлбэл, хүүгийн своп хэлцэл хийснээр хоёр хөрөнгө оруулагч өөр өөрсдийн анх эзэмшиж буй бондуудыг эзэмшсэн хэвээр боловч А өөрийн тогтмол хүүтэй бондоос олох тогтмол хүүгийн орлогоо Б руу, харин Б өөрийн хөвөгч хүүтэй бондоос олох хөвөгч хүүгийн орлогоо А руу шилжүүлэх юм. Свопыг харна уу.

**Хүүгийн хугацааны бүтэц /Term structure of interest rates/** Хүү болон хугацааны харилцан хамаарал. Үүнийг өөрөөр өгөөжийн муруй ч гэж нэрлэдэг. Энэ нь зах зээлд оролцогчдын ирээдүйн хүүгийн өөрчлөлтийн талаарх хүлээлтийг харуулдагаараа эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг.

**Хүүгийн эрсдэл //Interest rate risk/** Эх үүсвэрийг хугацаатай хадгаламж (тухайлбал, хадгаламжийн сертификат), эсхүл бондод байршуулах үед хүүгийн түвшин нэмэгдэх эрсдэл.

**Хүүд мэдрэмжтэй актив /Rate sensitive assets/** Хүүний өөрчлөлтөөс шалтгаалан зах зээлийн үнэ нь хэлбэлзэдэг актив. Хүүд илүү мэдрэмжтэй үнэт цаасны үнэ мэдрэмж багатай үнэт цаасыг бодвол илүү хэлбэлзэнэ. Хөрөнгө оруулагч бонд аль эсвэл бусад тогтмол орлого авчирдаг хэрэгслийг хоёрдогч зах дээр зарах үед энэ мэдрэмжийг харгалзан үзэх шаардлагатай байдаг.

**Хүүд мэдрэмжтэй пассив /Rate sensitive liabilities/** Хүүний өөрчлөлтөөс шалтгаалан зах зээлийн үнэ нь хэлбэлзэдэг актив. Хувьсах хүүтэй, богино хугацаатай бүх төрлийн хадгаламжууд багтана. Эдгээр пассивт мөнгөний захын сертификатууд, хадгаламжийн дансууд орно.

**Хүүхдийн данс /Custodial account/** 1. Насанд хүрээгүй хүүхдийн өмнөөс дансыг удирдах, хамгаалах үүднээс банк, брокерийн компани, хамтын санд нээсэн, насанд хүрэгчийн хамтран эзэмших данс. 2. Ажилтны кастодианаар удирдуулах тэтгэврийн данс.

Хүчин зүйлийн загвар */Factor model/* Хувьцааны өгөөжид нөлөөлөх хүчин зүйлсийг нийтлэг, эсхүл тухайн пүүстэй холбоотой байдлаар нь задалж, хувьцааны өгөөжийг загварчлах арга.

Хэвийн ашиг */Normal rate of profit/* Нийт орлогоос нийт зардлыг (мөнгөн болон хийсвэр) хассан ялгавар буюу эдийн засгийн ашиг тэтгэй тэнцэх нөхцөл байдал. Хэвийн ашиг нь бүртгэлийн ашгаас ялгаатай (алдагдсан боломжийн өргөөс хамааран). Компани нь тухайн захад үйл ажиллагаа явуулж байхын тулд ядаж хэвийн ашигтай ажиллаж байх ёстой.

Хэвийн бус өгөөж */Anomalies/* Хүлээгдэж буй болон бодит өгөөжийн зөрүү. Өөрөөр хэлбэл, зах зээл үр ашигтай буюу олон нийтэд байгаа мэдээлэл нь хувьцааны үнэд бүрэн туссан л бол хөрөнгө оруулагчдын таамаглаж буй өгөөж гажих ёсгүй юм. Тиймээс нийтэд байгаа бүх мэдээлэлд сууринж тооцоолсон өгөөж нь хөрөнгө оруулалтын эцэст бодит өгөөжөөс зөрүүтэй буюу гажсан бол зах зээл үр ашиггүй байна гэж дүгнэх үндэслэл болдог.

Хэвийн зээл */Performing loan/* Үндсэн болон хүүгийн төлбөр хуваарын хугацаандaa төлөгдж буй зээл.

Хэвтээ нэгдэлт */Horizontal merger/* Ижил бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэж буй хоёр компанийн нэгдэлт.

Хэдж сан */Hedge fund/* Хэдж сан гэдэг нь зөвхөн байгууллага болон томоохон хувь хөрөнгө оруулагчдад нээлттэй хөрөнгө оруулалтын хамтын сан юм. Хэдж сан нь энгийн хамтын сангудтай харьцуулахад харьцангуй эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтын стратеги хэрэглэдэг.

Хэлцэл хийх хугацааг сонгох */Market timing/* Зах зээлийн ирээдүйн төлөв байдлыг зөв таамаглах замаар хөрөнгө оруулалтын активыг худалдах, худалдан авах стратеги буюу тухайн зах зээлээс гарах, дахин нэвтрэч орох оновчтой цаг хугацааг тодорхойлох хөрөнгө оруулалтын идэвхтэй стратеги юм.

Хэсэгчлэн хорогдох зээл */Partially amortized loan/* Зээлийн хугацааны туршид зээлийн үндсэн дүнг хэсэгчлэн төлж, хугацааны эцэст үндсэн төлбөрийн үлдэгдэлтэй байдаг зээл. Зээлийн эхний үеүдэд зээлийн төлбөр бага байдгаараа давуу талтай. Жишээ нь, 200 сая төгрөгийн 6.5 хувийн хүүтэй зээлийг 5 жилийн хугацаатай хэсэгчлэн хорогдох нөхцөлтэй

авсан гэвэл сарын төлбөр 1,264.14 мянган төгрөгийг сар бүр төлөх ба 5 жилийн дараа зээлийн үлдэгдэл болох 187,222 мянган төгрөгийг төлөх, эсхүл дахин санхүүжүүлэх байдлаар зохицуулж болно.

**Хязгаарлагдмал хариуцлага /Limited liability/** Дампуурлын үед хувьцаа эзэмшигчид буюу өмчлөгчид зөвхөн оруулсан хөрөнгөөрөө л зээлдүүлэгчийн өмнө хариуцлага хүлээнэ. Дампуурсан компанийн өөрийн хөрөнгө нь зээлдүүлэгчийн мөнгийг эргүүлэн төлөхөд хүрэлцэхгүй бол хувь нийлүүлэгчид нь зээлдүүлэгчийн мөнгийг эргүүлэн төлөхийн тулд нэмж хөрөнгө оруулалт хийхгүй.

**Хязгаарлалттай захиалга /Limit order/** Хөрөнгийн бирж дээр ямар нэгэн хувьцааны зах зээлийн үнэ тодорхой түвшинд хүрэхэд уг хувьцааг худалдан авах, эсхүл зарах хэлцэл хийгдэх захиалгыг хэлнэ. Энэ захиалгын үед урьдчилан тохирсон үнэд зах зээлийн үнэ хүрэхгүй бол брокер хөрөнгө оруулагчийн захиалгыг биелүүлэхгүй.

**Хязгаарлах захиалга /Stop-limit order/** Арилжааны алдагдлыг хязгаарлах зорилготой тодорхой үнийн түвшин хүрэх үед биелэх худалдах, эсхүл худалдан авах захиалга.

**Хямдруулалт /Discount/** Ирээдүйд хүлээн авах мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох арга. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг авч үзвэл өнөөдрийн нэг төгрөг маргаашийн нэг төгрөгөөс илүү үнэ цэнэтэй байдаг. Учир нь хүүгийн орлого авчрах боломжтой.

**Хямдруулалтай бонд /Discount bond/** Анхдагч зах дээр нэрлэсэн үнээсээ доогуур үнээр арилжаалагдах, хугацааны эцэст нэрлэсэн үнээрээ төлөгдөх, эргэн төлөгддөх хугацаа хүртэл ямар нэгэн хүү (купон)-гийн төлбөр төлөгдхөхгүй бонд (тэг купонтой бонд)-ыг, эсхүл одоогийн байдлаар хоёрдогч зах дээр нэрлэсэн үнээсээ доогуур үнээр арилжаалагдаж буй бондыг хэлнэ.

**Хямдруулалтын хувь /Discount rate/** 1. Мөнгөн урсгалын шинжилгээнд ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэрэглэгддэг хүүгийн хувь хэмжээ. 2. Нэг жилээс богино хугацаатай үнэт цаасны нэрлэсэн үнээс хямдруулан тооцож буй хүүгийн хувь хэмжээ. 3. Тэтгэврийн сан, даатгалын компаниудын өр, төлбөрөө хямдруулан тооцоход хэрэглэгддэг хүүгийн хувь хэмжээ.

**Хямдруулсан зээл** /Discounted loan/ Зээл олгох үед хүү болон зээл олгосны шимтгэлийг зээлийн үндсэн дүнгээс хасч олгох зээл. Өөрөөр хэлбэл, зээлийн үндсэн дүнгээс бага хэмжээтэй зээл олгоно гэсэн үг.

**Хямдруулсан мөнгөн хөрөнгийн урсгал** /Discounted cash flow/ Хөрөнгө оруулалтаас ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгийн урсгалыг тодорхой хүүгээр хямдруулан тооцсон өнөөгийн үнэ цэнийг хэлнэ.

**Хямдруулсан өнөөгийн үнэ цэнэ** /Discounted present value/ Ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ. Өөрөөр хэлбэл, тодорхой хугацааны дараах мөнгөний өнөөдрийн үнэ цэнэ. Жишээ нь, хүү 10 хувь байхад 5 жилийн дараа орж ирэх 1000 төгрөгийн өнөөгийн үнэ цэнэ 620.92 төгрөг байна.

$$PV = \frac{1000}{(1 + 0.10)^5} = 620.92 \text{ төгрөг}$$

## Ц

**Царцаасан данс** /Frozen account/ Маргаан шийдвэрлэгдэх хүртэл мөнгө гаргах эрхийг хаасан дансыг хэлнэ.

**Цахим арилжааны санал** /Online bidding/ Хөрөнгө оруулагч нь санаалаа брокеруудын он-лайн сүлжээгээр дамжуулан хүргүүлж болно. Тодорхой шаардлагыг хангаж буй компани нь хөрөнгийн биржийн он-лайн системийг ашиглан нийтэд үнэт цаас арилжаалж болно.

**Цахим банк** /Electronic banking/ Интернет банкыг харах.

**Цэвэр ашгийн норм** /Net profit margin/ Энэ нь компанийн үр ашиг, ашигт ажиллагааны хэмжүүр бөгөөд цэвэр ашгийг борлуулалтын орлогод харьцуулж тооцно.

**Цэвэр ашиг** /Net income/ Компанийн орлогоос бүх төрлийн зардал болон татварыг хасаад үлдэж буй ашгийн хэмжээ.

**Цэвэр өгөөжийн муруй** /Pure yield curve/ Тэг купонтой засгийн газрын үнэт цааснуудын хувьд байгуулсан өгөөжийн муруй.

Цэвэр өнөөгийн үнэ цэнэ /Net present value/ Мөнгөний орох, гарах урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүү. Цэвэр өнөөгийн үнэ цэнийг тооцох нь төсөл, хөрөнгө оруулалтыг үнэлэхэд чухал ач холбогдолтой байдаг. Цэвэр өнөөгийн үнэ цэнэ хэдий хэр өндөр байна уг төслийг төдий чинээ ашигтай байна гэж үздэг. Хөрөнгө оруулалтын төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнийг дараах байдаар тодорхойлно.

$$NPV = \sum_{t=1}^n \frac{ct}{(1+r)^t} - Co Ct - t \text{ жилд орох мөнгөн урсгал,}$$

*Co*-хөрөнгө оруулалтаар гарах мөнгөн урсгал, *r*-хямдруулалтын хүү, *n*-төслийн хугацаа.

Цэвэр хүүгийн орлогын норм /Net interest margin/

Банк санхүүгийн байгууллагын хүүгийн орлого болон хүүгийн зардлын зөрүүг хүү олдог активын дундаж үлдэгдэлд харьцуулж тооцно.

## Ч

**Чанаргүй зээл /Non-performing loans/** Зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт 90 ба түүнээс дээш хоногоор тасалдсан зээлийг чанаргүй зээлд ангилна.

**Чангарталт /Appreciation/** Хувьцаа, бонд, валют, үл хөдлөх хөрөнгө зэрэг хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэхэд хэрэглэдэг нэр томъёо. Өөрөөр хэлбэл, цаг хугацааны туршид хөрөнгийн үнэ цэнэ нэмэгдэхийг хэлнэ. Эрэлт өсөх, нийлүүлэлт буурах, инфляци, хүүгийн өөрчлөлт зэрэг олон шалтгаанаар үнэ цэнэ өсч болно.

**Чек /Check/** Харилцагчийн данснаас заасан хэмжээний мөнгө төлөхийг банкинд үүрэг болгож бичгээр гаргасан даалгаврыг чек гэнэ.

**Чекийн бүртгэл /Check register/** Чекийн дансны харилцагчийн гүйлгээний бүртгэлээ хөтлөх маягт (ихэвчлэн чекийн дэвтррийн ар талд байдаг). Чекийн бүртгэлийг хөтөлснөөр харилцагч дансны үлдэгдлээ хянах боломжтой.

## Ш

**Шалгах (дэлгэрэнгүй) баланс /Trial balance/** Ерөнхий дэвтрний бүх дансны үлдэгдлийг данс хөтлөлтийн хуудсын дебит болон кредит талд нэгтгэж гаргасныг урьдчилсан тайлан тэнцэл гэдэг.

**Шелф бүртгэл /Shelf registration/** АНУ-ын Үнэт цаас, хөрөнгийн биржийн хорооны тус дүрэм нь компанийд үнэт цаасаа цувуулан, эсхүл тодорхой хугацааны дараа гаргах боломжийг олгоно. Компаний зүгээс шелф танилцуулгыг гаргаснаар хувьцааг дараагийн хоёр жилийн аль ч үед гаргах боломжтой болно. Тус дүрэм нь компанийд үнэт цаасаа ирээдүйд буюу таатай үеийг сонгон зарах боломжийг олгодог байна.

**Шийдвэр /Decree/** Эрх бүхий байгууллагын удирдлагаас гаргасан тушаал. Жишээ нь, Дорж гэрээний үүргээ биелүүлээгүй учир 10 сая төгрөгийг Батад төлөх тухай шүүхийн шийдвэр.

**Шимтгэл /Commission/** Үл хөдлөх хөрөнгийн арилжааны хувьд худалдагч талаас худалдсан үнийн дүнгийн тодорхой хувиар төлсөн шимтгэл юм. Хөрөнгийн бирж дээрх үнэт цаасны арилжааны хувьд захиалагчаас захиалгын тоо хэмжээ болон үнийн дүнгээс хамааран брокерт төлж буй шимтгэл юм.

**Шууд дебитлэх /Direct debit/** Банк үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу тухайн үйлчлүүлэгчийн зарим төлбөрийг (тухайлбал, сар бурийн орон сууцны зээлийн төлбөр, утасны төлбөр, байрны түрээс, цахилгааны төлбөр, орон сууцны төлбөр гэх мэт) данснаас шууд сутгаж, төлбөр хүлээн авагчийн дансанд шилжүүлэхийг хэлнэ.

## Э

**Эзэмшигчдийн өмч /Equity, Net worth/** Эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн хэмжээ буюу эзэмшигчдэд ногдох хөрөнгийн хэмжээг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, нийт активаар нийт пассивыг төлөөд үлдэх хэсэг нь эзэмшигчдэд ногдоно гэж үздэг. Иймээс өөрийн хөрөнгийг нийт активаас нийт пассивыг хасч тооцно.

**Элэгдлийн арга /Depreciation methods/** Хөрөнгийн анхны өртгийг ашиглагдах хугацааны туршид системтэйгээр хуваарилан зардалд шингээх үйл ажиллагааг хэлнэ. Элэгдэл тооцох хэд хэдэн арга байдаг. Шулуун шугамын аргын үед үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид тайлант хугацаабүртэнцүү дүнгээрэлэгдэл тооцно. Үйлажиллагааны арга буюу бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргын хувьд тухайн хөрөнгийн гүйцэтгэх ажлын нормыг харгалzan элэгдэл тооцно. Элэгдэл тооцох хурдавчилсан аргын үед элэгдлийг илүү хурдан тооцож дуусгадаг бөгөөд үүнд жилүүдийн нийлбэрийн арга, үлдэгдлийг бууруулах арга хамаарна. Жилүүдийн нийлбэрийн аргын үед хөрөнгийн ашиглагдах жилийн нийлбэрийг харгалzan элэгдэл тооцдог бол үлдэгдлийг бууруулах аргын үед хөрөнгийн ашиглах жилээр шулуун шугамын аргаар тооцсон элэгдлийн хувийг ашиглаж элэгдэл тооцдог.

**Элэгдэл /Depreciation/** Ашиглалтаас үүдэн үндсэн хөрөнгийн үнэ цаг хугацаа өнгөрөхийн хэрээр буурах үзэгдэл.

**Энгийн бонд /Straight bond/** Нэг төрлийн өрийн хэрэгсэл. Тогтмол хүйтэй, төлөгдөх хугацаатай, хувьцаанд хөрвөх зэрэг онцлог шинж чанаргүй энгийн бонд.

**Энгийн үе тутмын төлбөр /Ordinary annuity/** Тогтоосон хугацааны туршид хугацааны үе тутмын эцэст хийгддэг тэнцүү төлбөрийн цуваа.

**Энгийн хувьцаа /Common stock, Common shares/** Хувьцаат компанийн эзэмшил. Компаниуд ихэнхдээ энгийн хувьцаа гаргах бөгөөд энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, санал өгөх эрхээр хангагдаж, ногдол ашиг хүртэх боломжтой.

**Энгийн хүү /Simple interest/** Зөвхөн анхдагч хөрөнгө оруулалтад (үндсэн дүн) төлөх хүү. Хөрөнгө оруулалтын үндсэн дүн, жилийн өгөөжийн хүү, жилийн тоо гурвын үржвэрээр тооцно.

**Эргэлтийн бус хөрөнгө /Noncurrent asset/** Үндсэн хөрөнгийг харах.

**Эргэлтийн хөрөнгө /Current assets, Working capital/** Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ашиглагдах нэг жил буюу түүнээс бага хугацаанд бэлэн мөнгө болж хувирах активыг хэлнэ. Үүнд бэлэн мөнгө, түргэн борлогдох үнэт цаас, бэлэн бус авлага, борлогдоогүй бараа, материалын үлдэгдэл зэрэг багтана.

**Эргэн төлөгдөх өдөр /Maturity date/** Зээл болон үнэт цаасны нэрлэсэн үнэ хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчид эргэн төлөгдөх огноо.

**Эргэн төлөгдөх хугацаа /Maturity/** Бонд зэрэг тогтмол орлого өгдөг хөрөнгө оруулалтын хувьд эргэн төлөгдөх хугацаа гэж уг бондын хугацаа дуусч зээлдэгч буюу бонд гаргагчаас зээлдүүлэгч (бонд эзэмшигч)-д зээлийн үндсэн төлбөр (бондын нэрлэсэн үнэ)-ийг хүүгийн хамт эргүүлэн төлөх хугацааг хэлдэг.

**Эрсдэл /Risk/** Мөнгөө алдах, алдагдал хүлээх магадлал, мөн тодорхой бус байдлыг хэлнэ.

**Эрсдэл /Өгөөжийн харьцаа /Risk/Reward ratio/** Хөрөнгө оруулалтаас хүлээгдэж буй ашгийг эрсдэлтэй нь харьцуулах явдал. Үнэ хүлээгдээгүй чиглэлд хөдөлсөөс (эрсдэл) үүсэх алдагдлыг позици хаагдах үед хүлээгдэх ашигт (урамшуулал) харьцуулах замаар тус харьцааг олно.

**Эрсдэл хуваалцах /Risk sharing/** Эрсдэлтэй үйл ажиллагааг бусадтай хамтран хариуцах эрсдэлийн удирдлагын нэг арга. Өөрөөр хэлбэл, эрсдэлээс үүдэн гарах алдагдлыг бусадтай хуваалцана. Жишээ нь, хамтын зээлжүүлэлт.

**Эрсдэлгүй актив /Risk free asset/** Ирээдүйн өгөөж нь тодорхой байдаг хөрөнгө. АНУ-ын Засгийн газрын үнэт цаасыг эрсдэлгүй активын тоонд оруулдаг. Учир нь уг үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг АНУ-ын Засгийн газар эргүүлэн төлөх нь баталгаатай гэж үздэг.

**Эрсдэлгүй ашиг /Arbitrage/** Нэмэлт хөрөнгө гаргахгүйгээр эрсдэлгүй олсон ашиг. Тухайлбал, хоёр өөр зах зээл дээр нэг төрлийн бүтээгдэхүүн өөр үнэтэй буюу нэг зах дээрх авах үнэ нь нөгөө зах дээрх зарах үнэ болон эх үүсвэрийн зардаас өндөр үед эрсдэлгүй ашиг олж болно. Мөн нэг захаас хямдаар эх үүсвэр зээлээд, нөгөө зах дээр өндөр хүйтэй эрсдэлгүй активт байршуулах боломжтой бол эрсдэлгүй ашиг үүснэ.

**Эрсдэлгүй хүү /Risk free rate/** Онолын хувьд (тэг эрсдэлтэй) эрсдэлгүй хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь. Тодорхой заасан хугацаанд хөрөнгө оруулалтын хүү огт эрсдэлгүй гэж хөрөнгө оруулагчийн үзэж буй хүү. Амьдралд огт эрсдэлгүй хүү гэж байдаггүй бөгөөд хамгийн найдвартай хөрөнгө оруулалт ч бага боловч эрсдэлтэй байдаг. АНУ-ын Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасны хүүг ерөнхийдөө эрсдэлгүй хүү гэж үздэг.

**Эрсдэлд дурлагч /Risk lover/** Илүү их эрсдэлтэйгээр илүү ашиг, орлого хүртэх сонирхолтой этгээд. Хувь хүмүүсийн ашиг олохоор гаргаж буй шийдвэр нь өөр өөр байдаг. Зарим нь илүү эрсдэлтэй алхам хийдэг бол зарим нь аль болох эрсдэлээс зайлсхийдэг. Мөн эдгээрийн дундуур байх хэсэг ч бий. Ерөнхийдөө, илүү их эрсдэлтэй алхам нь илүү өгөөж авчрах магадлалтай байдаг бол эрсдэл багатай алхам нь өгөөж багатай байдаг. Жишээ нь, эрсдэлээс зайлсхийгч тогтмол хүйтэй хадгаламж, бондод хөрөнгө оруулалт хийж байхад эрсдэлд дурлагч этгээд нь илүү өгөөж бүхий хөрөнгийн захад хөрөнгө оруулалт хийдэг байна.

**Эрсдэлд мэдрэмжгүй хөрөнгө оруулагч /Risk-neutral/** Эрсдэлээс зайлсхийгч ч биш, эрсдэлд дурлагч ч биш. Үүнийг эрсдэлд ач холбогдол өгөхгүй хандах гэж тайлбарлаж болох юм. Эрсдэлд мэдрэмжгүй хөрөнгө оруулагч нь эрсдэлээс зайлсхийгч болон эрсдэлд дурлагч настай харьцуулахад тэдний дундуур нь шийдвэр гаргагчид юм. Жишээ нь, 100/0 төгрөг, эсхүл ямар ч тохиолдолд 50 төгрөг олох боломж бүхий сонголт байхад эрсдэлээс зайлсхийгч хоёр дахь сонголт буюу ямар ч тохиолдолд 50 төгрөг олох боломжийг сонгох бол эрсдэлд дурлагч этгээд эхний сонголтыг хийнэ.

Эрсдэлийг багцлан тархаах */Risk pooling/* Байгалийн гамшиг болон бусад том хэмжээний даатгалын нөхөн төлбөртэй холбоотой эрсдэлийг удирдах даатгалын компаниудын нэг арга. Тодруулбал, далайн шуурга, хар салхи, үер, газар хөдлөлт зэрэг гэнэтийн их хэмжээний хохирол учирахад даатгуулагчийн их хэмжээний нөхөн төлбөрийг уг даатгалыг хамтарч хийсэн гишүүн даатгалын компаниудад тархаана. Ингэснээр даатгалын компани дангаар их хэмжээний нөхөн төлбөрөөс үүдсэн дампуурлаас сэргийлдэг.

Эрсдэлийн нэмэгдэл */Risk premium/* Хөрөнгө оруулагч илүү эрсдэлтэй хөрөнгө оруулалтандaa хүлээж буй эрсдэлийн нөхөн төлбөр. Жишээ нь, өндөр ашиг орлого бүхий найдвартай компанийн гаргаж буй бондын хүү нь ашиг орлого нь тодорхойгүй, олонд танигаагүй компанийн гаргаж буй бондын хүүгээс бага өгөөжтэй байдаг. Энэ тохиолдолд хоёр дахь компанийн бондын хүүгийн эрсдэлийн нэмэгдэл илүү байна.

Эрсдэлийн хамгаалалт */Hedging/* Хөрөнгө оруулалтын эрсдэлийг бууруулах зорилготой хөрөнгө оруулалтын стратеги. Хөрөнгө оруулагч өөрийн багцад байгаа активуудын зах зээлийн үнийн тодорхой бус байдал ихтэй үед энэ стратегийг хэрэглэж, өнөөдрийн ашгаа баталгаажуулж болно. Хамгаалалтын стратегийг хэрэгжүүлэхдээ хөрөнгө оруулагч одоогийн позицоосоо эсрэг позици нээх замаар өөрт нь сэргээр нөлөөлэх үнийн хөдөлгөөнөөс хамгаалдаг. Тухайлбал, алт гэсэн хөрөнгө оруулалтын актив дээр урт позицитой бол алтны фьючерс дээр богино позици нээх замаар алт зарах үнээ өнөөдөр түгжсэнээр алтны үнэ буурах эрсдэлээс хамгаална. Хамгаалалт нь эрсдэлийг бууруулж байгаа хэдий ч зардалтай учраас өгөөжийг бууруулдаг.

Эрсдэлийн хүчин зүйлс */Risk factors/* Компанийн удирдлага гадаад, дотоод эрсдэлүүдийн талаар байр сууриа илэрхийлэх явдал. Энэ мэдээллийг холбогдох баримт бичгүүдэд (тухайлбал, хураангуй үнэт цаасны танилцуулгад) тусгана.


Эрсдэл-өгөөжийн харьцаа */Risk-return trade-off/* Эрсдэл бага байх буюу тодорхойгүй байдал бага байх нь боломжит өгөөжийг бага байлгахад хүргэдэг бол эрсдэл их байх буюу

тодорхойгүй байдал их байх нь боломжит өгөөжийг өндөр байлгадаг. Тиймээс хөрөнгө оруулагч эрсдэлээ нэг нэгжээр нэмэхэд боломжит өгөөж ямар хэмжээгээр нэмэгдэж байгааг сонирхдог.

**Эрсдэлтэй актив /Risky asset/** Тодорхой хэмжээний эрсдэл дагуулж байдаг хөрөнгө. Эрсдэлтэй активт хувьцаа, түүхий эд, өндөр өгөөж бүхий бонд, үл хөдлөх хөрөнгө, гадаад валют зэрэг үнийн хэлбэлзэл ихтэй хөрөнгүүд ордог. Ялангуяа, банкны хувьд хүүгийн түвшин, зээлийн чанар, урьдчилан төлөх эрсдэл зэргээс хамааран үнэ нь өөрчлөгджөх байдаг хөрөнгүүд эрсдэлтэй активт багтдаг.

Эрсдэлтэй активуудын оновчтой багц */Optimal risky portfolio/* Тухайн хөрөнгө оруулагчийн эрсдэлтэй активуудаар бүрдүүлсэн хамгийн сайн багц. Энэхүү эрсдэлтэй активуудын хамгийн сайн багц дээр эрсдэлгүй активыг нэмэх замаар иж бүрэн багцыг бурдуулнэ.

Эрсдэлтэй активуудын үр ашигт хязгаар /Efficient frontier of risky assets/ Хамгийн бага эрсдэлийн хязгаарыг харна уу. Глобал хамгийн бага вариацтай багцаас дээш орших хамгийн бага эрсдэлийн хязгаарын хэсэг



Зураг 4. Эрсдэлтэй яктигуудын үр яшигт хязгаар

Эрсдэлээр жигнэсэн актив /Risk weighted assets/ Банкны активууд эрсдэлтэй байдлаараа харилцан адилгүй байдаг. Тухайлбал, касст байгаа бэлэн мөнгө, Засгийн газрын богино хугацаат үнэт цаас зэрэг активууд хамгийн бага эрсдэлтэй байхад зээл, батлан даалт, санхүүгийн үсмэл хэрэгслүүдийн нээлттэй позици зэргийн эрсдэл өндөр байдаг. Хоёр банкны активын хэмжээ адил боловч эрсдэл багатай болон эрсдэл өндөртэй активын агууламж нь өөр бол тухайн хоёр банкны активын эрсдэл, улмаар эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ өөр өөр байна. Тиймээс банкны эрсдэлээр жигнэсэн активыг тооцох шаардлагатай. Жишээлбэл, А банк 100 тэрбум төгрөгийн бэлэн мөнгө, 200 тэрбум төгрөгийн зээл олгосон, харин Б банк 300 тэрбум төгрөгийн зээл олгосон гэж үзье. Хоёр банкны нийт активын хэмжээ тэнцүү 300 тэрбум төгрөг боловч бэлэн мөнгөний эрсдэлийн жин 0%, зээлийн эрсдэлийн жин 100% гэж үзвэл А банкны эрсдэлээр жигнэсэн актив 200 тэрбум төгрөг ( $0\% * 100 + 100\% * 200 = 200$ ), харин Б банкны эрсдэлээр жигнэсэн актив 300 тэрбум төгрөг ( $100\% * 300 = 300$ ) байна.

Эрсдэлээс зайлсхийх /Risk aversion/ Эрсдэл багатайг сонгох хөрөнгө оруулагчийн хандлага. Эрсдэлээс зайлсхийгч нь эрсдэлд дургүй ба аль болох тодорхойгүй өндөр эрсдэлээс зайлсхийж, өгөөж бага байсан ч эрсдэл багатай сонголтуудыг хийдэг.

Эскроу /Escrow/ Эскроу агент, худалдагч болон худалдан авагчийг хамруулсан З талт хэлцэл. Тус хэлцлийн дагуу худалдагч тал нь худалдан авагч тал үүргээ биелүүлж дуустал өмч хөрөнгө (мөнгө, баримт бичиг, бусад үнэт зүйлс)-өө эскроу агентад шилжүүлнэ. Мөнгөн хөрөнгө болон үнэт цаасыг шилжүүлэх явцад тусгайлсан эскроу дансыг ашигладаг. Эскроу дансыг эскроу агент эсвэл эскроу үүргийг гүйцэтгэж буй банк нээнэ. Гэрээний бүх заалт биелэгдсэн нөхцөлд агент нь хөрөнгө, мөнгө эсвэл үнэт цаасыг үүргээ биелүүлсэн талд шилжүүлнэ. Эс бөгөөс өмчлөгчид эргүүлж өгнө. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хэлцлүүд эскроу дансаар дамждаг байна. Үл хөдлөх хөрөнгө худалдагч болон худалдан авагч хоёр тал ямар нөхцөлд эскроу агент мөнгийг худалдагч талд шилжүүлэхийг гэрээгээр тохирно. Тодорхой хугацаанд

(хэдэн цаг, эсвэл хэдэн сар) худалдан авагчийн мөнгө энэхүү дансанд орно. Үл хөдлөх хөрөнгийн баримт бичгүүд худалдан авагч талд шилжих үед эскроу агент мөнгийг худалдагч талд шилжүүлнэ.

**Эскроу данс** /Escrow account/ Гэрээний үүрэг гүйцэтгэгч болон гүйцэтгүүлэгч нар харилцан тохиролцож, гэрээний нөхцөл биелэх хүртэлх хугацааны туршид мөнгөн хөрөнгийг банкинд байршуулан банктай гурвалсан гэрээ байгуулж нээсэн данс.

**Эх үүсвэрийн бүтэц** /Capital structure/ Банк болон компанийн бизнесийн үйл ажиллагаа болон өсөлтийг ямар эх үүсвэрээр санхүүжүүлж байгааг харуулна. Эх үүсвэр нь богино болон урт хугацаат өглөг болон өөрийн хөрөнгийн нийлбэрээр тодорхойллогдоно.

**Эх үүсвэрийн өртөг** /Cost of capital/ Эх үүсвэрийн өртөг нь боломжит хувилбараас буюу өөр бусад хөрөнгө оруулалтаас олох боломжтой өгөөжийг харуулдаг. Тиймээс энэ нь тухайн хөрөнгө оруулалтын хамгийн багадаа олж болох өгөөжийг харуулдаг. Нөгөө талаас, хөрөнгө оруулалт болон төсөлд шаардагдах эх үүсвэрийг ямар зардалтайгаар босгосныг илтгэнэ.

**Эхэлж авснаа эхэлж зарлагдах арга** /FIFO/ Энэ аргын үед зарцуулсан бараа материалын өртгийг тооцоходоо хамгийн сүүлийн худалдан авалтаас эхэлж тооцох бөгөөд үлдэгдэлд эхний үлдэгдэл болон эхний худалдан авалтаас үлдэнэ. Балансад тусгагдах бараа материал нь эхний худалдан авалт болон үлдэгдлээс бүрдэх учир одоогийн бодит үнээрээ тусгагдах боломжгүй. Харин борлуулсан барааны өртөг нь тухайн үеийн үнэтэйгээ уялдаж өгдөг.



---

## АНХНЫ НИЙТИЙН АРИЛЖАА

---

### A

**АНА-НЫ ОРЛОГО /Proceeds/** Компаниудын хувьцаагаа нийтэд арилжаалж бий болгосон мөнгөн орлого. Үнэт цаасны танилцуулгад орлогыг юунд зарцуулахыг тайлбарласан байна. Хөрөнгө оруулагчид энэхүү хэсгийг уншин тус компани хөрөнгө босгох болсон учрыг магадладаг.

**Андеррайтер /Underwriter/** Андеррайтер гэдэг нь хувьцаа болон бондын захаас компанийд шаардлагатай хөрөнгийг босгож буй брокерийн компани юм. Андерайтер нь үнэт цаас гаргагчаас хувьцаа, эсхүл бондыг нь худалдан авч, улмаар олон нийтэд арилжаалж буй санхүүгийн зуучлагч байгууллага юм.

**Андеррайтерийн үйл ажиллагаа /Underwriting/** Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны анхдагч зах зээлд борлогдоогүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр худалдаж авах үйл ажиллагаа.

**Анхны нийтийн арилжаа (АНА) /Initial Public Offering (IPO)/** Компанийн хувьцааг анх удаа олон нийтэд зарах явдал. Компани “нийтийн өмчийн” болоходо хувьцаагаа АНА-гаар мэргэшсэн хөрөнгө оруулалтын компанийд, компани нь олон нийтэд дахин зарна.

**Анхны өдрийн хаалтын үнэ /First day close/** Арилжааны анхны өдрийн хаалтын үнэ нь андеррайтер хэлцлийг хэр зөв үнэлсний тусгал болох төдийгүй ойрын хугацаанд арилжаа ямар байж болохыг харуулна. Тухайлбал, арилжааны анхны өдөр 100%, эсхүл 200%-иар өссөн хувьцааны үнэ дараа дараагийн өдөр ашиг олох эрмэлзлээс шалтгаалан эргээд унах магадлал өндөр юм. Эсрэгээрээ санал болгосон үнэ тэр даруй буурсан бол хөрөнгө оруулагчид ийм хувьцааг зарахыг илүүд үзэх ба үнэ цаашид улам унаж болзошгүй юм.

АНА-ны үнэ шууд унах нь андеррайтерийн зүгээс хэлцэл, болон түүний үнийг төдийлөн оновчтой тодорхойлж чадаагүйн илэрхийлэл юм.

Анхны үнэ */Issue price/* Хувьцаа гаргагч компани нь андеррайтертай зөвлөлдөн үнээ тогтооно. Хувьцааг гаргах 2 хэлбэр байх ба эхний тохиолдолд компани болон андеррайтер нь тодорхой үнийг (тогтмол үнэ) тогтоодог бол хоёр дахь тохиолдолд доод үнэ, эсхүл үнийн мужийг тодорхойлж, улмаар эцсийн үнийг зах зээл (үнийг тодорхойлох явц) тодорхойлдог байна.

Арилжаалагдаж буй хувьцаа */Listed stock/* Хөрөнгийн бирж дээр арилжаалагддаг компанийн хувьцаа.

Арилжаанд оролцогч банкууд */Bankers to the issue/* Тус банкууд хөрөнгийг цуглуулж эскроу дансанд шилжүүлэх бүхий л үйл ажиллагааг хариуцана. Андеррайтер нь хөрөнгө төвлөрүүлэх төвүүдэд арилжаанд оролцогч банкуудыг томилсон байна. Түүнчлэн андеррайтер нь оролцогч банкуутдай хамтран төвлөрүүлсэн хөрөнгийн урьдчилсан дүнг гарган, хувьцаа гаргагчид арилжааны хаалтын талаархи үнэн зөв мэдээллийг өгнө.

**Аюулгүйн хамгаалалт** */Safety net/* Үнэт цаасыг нийтэд санал болгохтой холбоотой аливаа эрсдэлээс сэргийлэх аюулгүйн хамгаалалт буюу хувьцаа гаргагч компани нь буцаан-худалдан авах зохицуулалтыг үндсэн андеррайтер банктай урьдчилан тохиролцож, энэ тухай үнэт цаасны танилцуулгад мэдээлнэ.

## Б

**Бүртгэгч** */Registrar/* Бүртгэгч нь хөрөнгө оруулагчдын жагсаалтыг эцэслэх, хөрөнгө оруулагчдын хувьцааны дансанд кредит бичилт хийх, холбогдох этгээдүүдэд хөрөнгийг нь буцаан олгох зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ. Үндсэн андеррайтер болон Бүртгэгч нь банкны салбаруудаас ирэх өргөдлүүдийг боловсруулах ажлыг зохион байгуулж хувьцааны хуваарилалтыг эцэслэх, үнэт цаасны сертификатуудыг хүргүүлэх, хөрөнгийг буцаан олгох, үнэт цаасыг бүртгүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэж дуусгана.

**Бүх хувьцааг худалдаж авах хэлцэл /Bought out deal/**  
 Андеррайтер нь компанийн бүх хувьцааг нь худалдан авах амлалт авч, улмаар борлуулах санхүүгийн үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнийг хатуу хуваарилалт гэж нэрлэх нь бий.

## Д

**Дагалдах нийтийн арилжаа /Follow on public offering (FPO)/** Хөрөнгийн биржид нэгэнт бүртгэлтэй, хувьцаа нь арилжаалагддаг нийтийн компани эх үүсвэр босгох зорилгоор дахин хувьцаа гаргах явдал. АНА-наас ялгаатай. АНА нь хувьцааг олон нийтэд анх санал болгож буй арилжаа бол дагалдах нийтийн арилжаа нь хөрөнгийн бирж дээр нэгэнт бүртгэлтэй болсон компани нэмж хувьцаа гаргаж буй явдал юм.

**Дэмжлэг үзүүлэгч /Promoter/** Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаар компанийн мөнгөн хөрөнгийг өсгөхөд дэмжлэг үзүүлж, тодорхой хэмжээний төлбөр авч буй хувь хүн, эсхүл хуулийн этгээд. Дэмжлэг үзүүлэгч нь ихэвчлэн уламжлалт бонд, хувьцаа зэргийг хэрэглэхээс илүүтэйгээр хөрөнгө оруулалтын хэрэгслийг ашиглан мөнгөн хөрөнгийг өсгөдөг. Ихэнх тохиолдолд эдгээр дэмжлэг үзүүлэгчид нь бусдаас мөнгөн хөрөнгө татсан ажлынхаа төлбөрт компанийн хувьцааг авах, эсхүл хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох эрх олж авдаг.

## 3

**Захиалга /Order book/** Хөрөнгө оруулагчдын хувьцаа худалдан авах захиалгын тоо. Захиалгын тоо нь нийлүүлэлтээс хэд дахин хэтэрч болно. Үүнд андеррайтер, хөрөнгө оруулагчдын аль аль нь дуртай байдаг, учир нь хувьцааны үнэ анхны арилжаагаар болон хоёрдогч арилжаагаар өндрөөр тогтох боломжтой.

**Захиалга хэтрэх /Oversubscribed/** Анхны нийтийн арилжааны худалдан авахаар ирүүлсэн саналын тоо нь санал болгосон хувьцааны тооноос хэтрэхийг хэлнэ.

**Зөөлөн андеррайтинг /Soft underwriting/** Андеррайтер нь хувьцааг үнэ тогтох үйл явц дууссаны дараа сүүлчийн шатан дээр худалдаж авахыг зөвшөөрөх явдал юм. Андеррайтер нь ингэж авсан хувьцааг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад шууд арилжаална.

## M

**Мэргэшсэн худалдан авагч /Qualified Institutional Buyer (QIBs)/** Хөрөнгийн захад үнэлгээ, хөрөнгө оруулалт хийх мэдлэг туршлагатай, санхүүгийн чадвартай мэргэжлийн хөрөнгө оруулагчид юм.

## H

**Нийтийн компани /Public corporation, Public company/** Өөрийн хувьцаагаа хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд арилжаалсан компанийг нийтийн өмчлөлийн буюу нийтийн компани гэж нэрлэдэг. Олон нийтээс хөрөнгө татах, нийтийн өмчлөлд шилжсэн тул хуулийн дагуу өөрийн үйл ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдлын талаар хувьцаа эзэмшигчид болон боломжит хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх үүрэг хүлээдэг.

**Нийтэд санал болгох /Public offering/** Бизнесийн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд нэмэлт эх үүсвэр татах зорилгоор компанийн үнэт цаасыг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд зарах явдал. Тухайлбал, компанийн хувьцааг олон нийтэд анх удаа санал болгох үйл ажиллагааг анхны нийтийн арилжаа буюу АНА гэнэ.

**Нийтэд шууд санал болгох арилжаа /Direct public offer/** Компани нь андеррайтерийн тусlamжгүйгээр хувьцаагаа нийтэд шууд арилжаалах хэлбэр. Ийм арилжаагаар босгох хөрөнгийн хэмжээ маш хязгаарлагдмал байдаг.

**“Ногоон гутал” сонголт /Green-shoe option/** 30 хоногоос хэтрэхгүй хугацаанд төлөвлөснөөс илүү олон тооны хувьцааг нийтэд хуваарилах, хувьцааны үнийг тогтворжуулах явдал. Компани нь АНА-ны дунгийн 15%-иас ихгүй хэмжээний хувьцааг нэмж хуваарилна. Хөрөнгө оруулагчийн өнцгөөс

энэхүү сонголт нь хувьцааг авах магадлалыг нэмэгдүүлэх төдийгүй хувьцааны үнэ цаашид харьцангуй тогтвортой байна гэсэн дохио болно.

**Нүүр хуудас** /Cover page/ Санал болгох баримт бичгийн хавтастхувьцааг гаргагч компани, үндсэн андеррайтер болон бүртгэгчдийн бүрэн хаяг, санал болгож буй санхүүгийн хэрэгслүүдийн мөн чанар, тоо, үнэ, хэмжээ, арилжааны дүн, үнэт цаасны бүртгэлтэй холбоотой онцлогийг тусгана. Шаардлагатай тохиолдолд зээлжих зэрэглэл, анхдагч арилжаатай холбоотой эрсдэл зэргийг мөн тусгана.

**Нэмж хуваарилах** /Over allotment/ Андеррайтерууд АНА-ны дараа нэг сарын дотор АНА-ны 15%-тэй тэнцэх хэмжээний нэмэлт хувьцааг арилжаалах эрхтэй байдаг. Үүнийг ногоон гутлын гэрээ ч гэдэг.

## С

**Санал болгох баримт бичиг** /Offer document/ Санал болгох баримт бичиг гэдэг нь хувьцаа гаргах, эсхүл худалдах санал тавьж буй тохиолдолд үнэт цаасны танилцуулгыг, харин эрхийн асуудал хөндөгдөх үед санал болгох захиаг ойлгоно. Санал болгох баримт бичгүүд нь хөрөнгө оруулагчдад шаардлагатай бүхий л мэдээллийг агуулна.

**Санал болгох огноо** /Offer date/ Санал болгох огноо гэдэг нь нийтэд арилжаалах эхний өдөр юм.

**Санал болгох үнэ** /Offering price/ АНА-г нийтэд арилжаалсан анхны үнэ. Тус үнийг үндсэн андеррайтер нь хувьцааны захын үйл ажиллагаа дуусгавар болсны дараа, хувьцааг АНА-ны худалдан авагчдад хуваарилахын өмнөх шөнө тогтоодог байна. Зарим улс оронд АНА-ны хувьд үнэ тогтоох явц бямба, ням гаригт болдог байна.

**Синдикатын гишүүн** /Syndicate member/ Үндсэн андеррайтер нь андеррайтерын үйлчилгээг эрхлэх зөвшөөрөлтэй зуучлагчдыг синдикатын гишүүдээр томилж болно. Синдикатын гишүүд нь саналын хуудсыг цуглуулах ажлыг (хувьцааны үнийг тодорхойлох) гүйцэтгэнэ.

## Т

**Тасалбар үнэ /Cut off price/** Хувьцаа гаргагч компани нь хувьцааны үнийн мужийг, эсхүл доод үнийг “Улаан май загас” танилцуулгад тодорхойлсон байх шаардлагатай. Харин бодит үнэ нь эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогддог байна. Хувьцааг гаргах үнэ нь үнийн муж дотор, эсхүл доод үнээс дээгүүр тогтох боломжтой. Хувьцаа гаргагчийн зүгээс эцэслэн шийдвэрлэсэн үнийг “тасалбар үнэ” гэнэ.

**Туслах андеррайтер /Co-Manager/** Ихэнхи АНА болон хоёрдогч арилжаанд нэгээс илүү тооны андеррайтер оролцдог. Арилжааг хянаж буй андеррайтерийг үндсэн андеррайтер гэнэ. Бусад нь туслах андеррайтерууд юм. Андеррайтеруудын нэрс нь үнэт цаасны танилцуулагын эхний хуудсын доод хэсэг байрших ба ингэхдээ үндсэн андеррайтерийн нэр зүүн талд, харин бусад андеррайтерын нэрс ач холбогдлын эрэмбээр зүүнээс баруун тийш байршина.

**Тогтмол үнийн санал /Fixed price offers/** Хувьцаа гаргагч компани арилжааны үнээ тогтоож, тогтмол үнэ санал болгож болно. Санал болгох баримт бичигт компани нь тухайн үнийг санал болгож байгаа үндэслэлээ тусгана.

**Төлөөлөн удирдах зөвлөл /Board of Directors/** ТҮЗ нь орон тооны болон хараат бус захирлуудаас бүрдэнэ. Хараат бус захирлууд нь компанийтай сонирхлын зөрчлийг үүсгэхүйц санхүүгийн болон хувь хүний холбоогүй байх ба Зөвлөлд мэдлэг чадвар, туршлага, бизнесийн нэр хүндээр орж ирсэн байдаг. Компанийн хараат бус захирлууд нь тухайн компанийн хувьцааг эзэмших эрхтэй ч том хувьцаа эзэмшигчид биш байна. Хөрөнгө оруулагчдын зүгээс хамгийн багадаа хоёр хараат бус захирал байгаа эсэхийг магадладаг. Ихэвчлэн, гадны захирлуудыг АНА-тай зэрэг буюу АНА-г дуусмагц томилдог байна.

**Түгжих /Lock-up/** Гэрээгээр заасан хугацаа (ихэвчлэн АНА-ны дараах 90-180 хоног)-нд хувьцаагаа зарж борлуулахыг компанийн дотоод мэдээлэлтэй этгээдүүд (инсайдер) болон томоохон хувьцаа эзэмшигчдэд хориглосон байдаг. Харин хугацаа дууссаны дараа тус хязгаарлалт хүчингүй болдог.

Тэнцвэрт үнэ /*Clearing price*/ Голланд дуудлага худалдаагаар АНА-ны бүх хувьцааг хөрөнгө оруулагчдад зарж болох үнэ. Зах зээлийн тэнцвэрт үнэ гэх нь ч бий.

Ү

**“Улаан май загас” танилцуулга /*Red herring prospectus*/** АНА хийхээр зэхж буй компаниас хөрөнгө оруулагчдад хандан гаргадаг анхны буюу урьдчилсан танилцуулга. Санал болгох хувьцааны тоо, үнэ, дүн зэргийг агуулахгүй.

Ү

Үндсэн андеррайтер /*Book running lead manager (BRLM)*/ АНА-нд хяналт тавьж эцсийн хариуцлагыг хүлээж буй үндсэн андеррайтер. Хувьцааг нийтэд санал болгохоос өмнө үндсэн андеррайтер нь компанийн үйл ажиллагаа, удирдлага, бизнес төлөвлөгөө, эрх зүйн нарийвчилсан шинжилгээг гүйцэтгэнэ.

**Үнийг тодорхойлох үйл явц /*Price discovery*/** Хувьцааны санал болгох үнийг компани болон зуучлагчдын зүгээс тодорхойлох явдал.

**Үнийн муж /*Price Band*/** Үнэт цаасны үнийн дээд, доод хязгаарыг тодорхойлох арга. Улаан май загас танилцуулгад нэг бол үнэт цаасны доод үнийг, аль эсвэл үнийн мужийг тусгана.

**Үнэлгээний үржүүлэгч /*Valuation multiple*/** Компанийг үнэлэх арга бөгөөд тус компанийн хувьцааны үнийг үйл ажиллагааны орлого, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ, эсхүл нэгж хувьцаанд ногдох ашигтай харьцуулж үзнэ. Үнэлгээний үржүүлэгч өндөр байх тусам компанийн үнэлгээ өндөр байна. Андеррайтерууд ижил төстэй АНА-ны үнэлгээ үржүүлэгчийг ашиглан тухайн АНА-ны тохиромжтой үнийг тодорхойлдог байна.

**Үнэт цаасны танилцуулга /*Prospectus*/** Боломжит хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж, тэдгээрийг мэдээллээр хангах зорилгоор худалдаалагдаж буй үнэт цаас, бизнес, хөрөнгө оруулалтыг тодорхойлсон танилцуулга буюу мэдэгдлийг хэлнэ.

**Үнээр ялгаварлах** /*Differential pricing*/ Нэг бүлэгт санал болгож буй үнэт цаасны үнийг нөгөө бүлгээс ялгавартайгаар тогтоох үйл явц.

X

**Хаалттай хөрөнгө оруулалт** /*Private placement*/ Хувьцааг цөөн тооны хөрөнгө оруулагчдад (томуохон банкууд, хамтын сангүүд, даатгалын байгууллагууд болон тэтгэврийн сангүүд) зарах явдал.

**Хатуу андеррайтинг** /*Hard underwriting*/ Гаргаж буй үнэт цаасны тодорхой хэсэгт андеррайтераас гаргасан баталгаа. Ингэснээр захиалга ирээгүй хувьцааг андеррайтар нь худалдан авах үүрэг хүлээнэ. Зөвлөн андеррайтингтэй харьцуулахад хавьгүй өндөр эрсдэлтэй үйл ажиллагаа юм.

**Хоёрдогч арилжааны гүйцэтгэл** /*Aftermarket performance*/ Хувьцааны үнийг анхны нийтийн арилжааны санал болгосон үнэтэй харьцуулахыг хэлнэ. Зарим хөрөнгө оруулагч эхний өдрийн хаалтын үнийг илүү сайн жишиг гэж үзэн түүнтэй харьцуулах нь бий.

**Хоёрдогч зах зээл** /*Aftermarket*/ Хувьцааны анхны нийтийн арилжааны дараах арилжааг хоёрдогч зах зээл гэнэ. Хоёрдогч арилжааны хэмжээ эхний өдөр их, харин дараа дараагийн өдөр буурдаг байна.

**Хөвөлт** /*Float*/ Хувьцаа гаргаж буй компанийн хувьд нийт арилжаалсан хувьцаа болон гүйлгээнд байгаа хувьцаа (хөвөлт) хэмээн ялгах нь бий. Хөвөлт гэдэг нь олон нийтийн эзэмшиж буй хувьцааг хэлнэ. Тухайлбал, компани нь нийт арилжаалсан 20 сая ширхэг хувьцаатай, харин АНА-гаар 2 сая ширхэг хувьцааг нийтэд санал болгож байгаа бол компанийн хөвөлт нь 2 сая ширхэг хувьцаа болно.

**Хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргах** /*Going public*/ “Нийтэд арилжаалах”-ыг харах.

**Хуанли** /*Calendar*/ Хуанли нь хүлээгдэж буй АНА болон хоёрдогч арилжаанд хамаарна.

**Хуваарилалтыг баталгаажуулах баримт** /*Confirmatory allotment note (CAN)*/ Хувьцааны үнэ тодорхойлогдсноос хойш 15 хоногийн дотор Үндсэн андеррайтераас хувьцаа

хуваарилагдсан хөрөнгө оруулагчдад хүргүүлж буй баримт.

**Хувьцааг дамлах /Flipping/** Хөрөнгө оруулагч нь Анхны нийтийн арилжааны хувьцааг санал болгосон үнээр худалдан аваад удалгүй ашиг олох зорилгоор дахин зarah явдал. Үүнээс зайлсхийхийн тулд андеррайтер нь анхнаасаа (хоёрдогч зах дээр захиалга их байж болзошгүй тохиолдолд) хувьцааг урт хугацаат хөрөнгө оруулагчдад зarahыг хичээнэ.

**Хувьцааг санал болгох үнэ /Offering price/** Андеррайтераас олон нийтэд санал болгож буй хувьцааны үнэ.

**Хувьцааг хуваарилах зарчим /Basis of allocation, Basis of allotment/** АНА-гаар арилжаалсан хувьцааг хатуу хуваарилалт, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон байгууллагын бус худалдан авагчид, жижиглэн худалдан авагч зэрэг бүлгүүдэд хуваарилах зарчим.

**Хувьцааны үнийг нээлттэй тодорхойлох /Open book/** Хувьцааны үнийг зах зээл тодорхойлох нөхцөлд хувьцааны эрэлт болон арилжааны саналыг цахим хэлбэрээр харуулахыг (арилжааны үеэр) гаргагч компани болон андеррайтераас шаарддаг. Энэ нь хувьцааны үнийг тодорхойлох нээлттэй явц юм.

**Хувьцааны үнийг тодорхойлох явц /Book building/** АНА-ны санал болгох үнийг (мэргэжлийн хөрөнгө оруулагчдын эрэлтэд суурilan) андеррайтерын зүгээс тодорхойлох үйл явц.

**Хувьцааны үнэ далд байх /Closed book/** Хувьцааны үнийг нийтэд зарлахгүй ба тухайн хөрөнгө оруулагч нь бусад хөрөнгө оруулагчдын саналын талаар ямар нэгэн мэдээлэлгүйгээр өөрийн үнийн саналаа утсаар баталгаажуулна.

**Хувьцааны хуваарилалт /Allocation/** Хувьцааны үнийг арилжаагаар тодорхойлох тохиолдолд хувьцааны хуваарилалтыг андеррайтер нь арилжаадуусгавар болсноос хойш 2 долоо хоногийн дотор эцэслэн шийдвэрлэнэ.

**Хураангуй танилцуулга /Abridged prospectus/**  
Үнэт цаасны танилцуулгын хураангуй хэлбэр. Үндсэн танилцуулгын бүхий л чухал онцлогийг агуулна.

**Хүлээгдэж буй огноо /Expected date/** Арилжаа болох огноо. Огноог андеррайтер компани тодорхойлно.

## Ц

**Цахим ана /E-IPO/** Тодорхой шаардлагыг хангаж буй компани нь хөрөнгийн биржийн цахим системийг ашиглан нийтэд үнэт цаас арилжаалж болно. Энэ тохиолдолд хувьцаа гаргагчийн томилж буй зуучлагчид нь цахим арилжаа явуулах тоног төхөөрөмжтэй байхыг шаарддаг.


---

## ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ, ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

---

### A

Ад-валорем татвар /*Ad valorem tax*/ Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээнд үндэслэн тооцсон татвар. Ад-валорем гэдэг хэллэг нь “Үнэ цэнэд үндэслэн” гэсэн латин үг юм. Ад-валорем татварыг өмчилж буй хөрөнгөд ногдуулдаг бол борлуулалтын татварыг гүйлгээ гарах үед ногдуулдаг.



*Зураг 5. Амины тусдаа орон сууц*

**Амины тусдаа орон сууц /*Detached house*/** Орон сууцны бүх хэсэг нь тусдаа ханаар хүрээлэгдсэн, ихэвчлэн тусдаа газарт баригдсан орон сууцны зориулалттай байр.

**Анхны ипотекийн зээл /*First mortgage*/** Бусад бүх төрлийн ипотекийн зээлээс тэргүүн ээлжинд барьцаа хөрөнгийн эрхийг шилжүүлж авах ипотекийн зээл. Барьцаа хөрөнгөөр үргийн гүйцэтгэл хангуулах тохиолдолд анхны ипотекийн зээлийн төлбөрийг тэргүүн ээлжинд төлүүлнэ. Жишээ нь, 100 сая төгрөгийн үнэтэй орон сууцыг 75 сая төгрөгийн анхны ипотекийн зээл, 15 сая төгрөгийн хоёр дахь ипотекийн зээл, 10 сая төгрөгийн бэлэн мөнгөөр худалдаж авсан. Хэрэв зээлдэгч төлбөрийн чадваргүй болж, барьцаа хөрөнгийг 80 сая төгрөгөөр борлуулж үргийн гүйцэтгэл хангуулах тохиолдолд анхны ипотекийн зээлийн үндсэн төлбөр болон шүүхийн зардлыг тэргүүн ээлжинд

бүрэн төлгүүлж, үлдсэн хэсгээр хоёр дахь ипотекийн зээлийг төлгүүлнэ.

## Б


**Баллун ипотекийн зээл** /Balloon mortgage/ Зээлдэгч тодорхой интервалд тогтмол төлбөр хийж, үлдсэн төлбөрийг харьцангуй богино хугацаанд төлж дуусгадаг богино хугацаатай ипотекийн зээлийн нэг төрөл. Баллун ипотекийн зээл нь зөвхөн хүү төлөх ипотекийн зээл, эсхүл хэсэгчлэн хорогдох ипотекийн зээлийн хэлбэртэй байж болно.

**Баллун төлбөр** /Balloon payment/ Ипотекийн, арилжааны болон бусад зээлийн хугацааны эцэст төлөгдөх томоохон төлбөрийн дүн. Учир нь зээлийн хугацааны явцад зээлийн төлбөр нь бүрэн хорогдоогүй байдаг.

**Барилгын капиталжих хувь** /Building capitalization rate/ Тухайн барилгын бий болгож буй үйл ажиллагааны цэвэр орлогыг хөрөнгийн (барилга) зардалд харьцуулсан харьцаа. Жишээ нь, тухайн барилгыг 100 сая төгрөгөөр худалдан авч түүнээс жилд 10 сая төгрөгийн үйл ажиллагааны цэвэр орлого (нийт түрээсийн орлогоос тогтмол болон хувьсах зардлыг хассан) бий болгодог гэвэл:  $10 \text{ сая} / 100 \text{ сая} = 0.10 = 10\%$ . Барилгын капиталжих хувь 10% буюу барилгын зардлын аравны нэг нь жилийн үйл ажиллагааны цэвэр орлогоороо нөхөгддөг гэсэн үг юм.

**Барилгын стандарт** /Building codes/ Засгийн газраас баталсан барилга байгууламжид зайлшгүй мөрдөх стандартуудыг тодорхойлсон дүрэм. Барилгын стандарт тогтоох гол зорилго нь тухайн барилгатай холбоотой иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн сайн сайхан байдлыг хамгаалах явдал юм.

**Барилгын шугам** /Building line/ Тухайн барилгын урд тал болон хажуу талаас тодорхой хэмжээний зай авч татсан шугам. Уг шугамаас цааш барилгын ажлыг төлөвлөхгүй.



Зураг 6. Барилгын шугам

**Барьцаат хадгаламж** /Security deposit/ Үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч талаас түрээслүүлэгч талд хадгалуулж буй мөнгөн хөрөнгө буюу барьцаа. Үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч тал хөрөнгийг эвдэж гэмтээсэн тохиолдолд энэхүү барьцаагаар хохирлыг барагдуулна.

**Бизнесийн ипотекийн зээл** /Commercial mortgage loan/ Бизнесийн болон түрээсийн орлого бий болгодог үл хөдлөх хөрөнгө барьцаалсан ипотекийн зээл. Жишээ нь, томоохон банкууд худалдааны төв эзэмшигч этгээдэд бизнесийн ипотекийн зээл олгох нь нийтлэг байдаг.

**Бизнесийн үл хөдлөх хөрөнгө** /Commercial property/ Бөөний болон жижиглэн худалдаа, албан тасалгаа, зочид буудал, үйлчилгээ эрхлэгчдийн хэрэгцээнд зориулж бий болгосон эд хөрөнгө. Жишээ нь, хөрөнгө оруулалтын зорилгоор бизнесийн үл хөдлөх хөрөнгө худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагчдад брокер нь худалдааны төв, албан тасалгааны байр, зочид буудал, дэн буудал, амралтын газар, зоогийн газар зэрэг эд хөрөнгийг санал болгож болно.

**Богино борлуулалт** /Short sale/ Санхүүгийн хүндрэл бэрхшээлд орсон зээлдэгч нь орон сууцаа ипотекийн зээлийн өрийн үлдэгдлийн дүнгээс бага үнээр зарж, олсон орлогыг зээлдүүлэгчид төлөх явдал. Зээлдүүлэгч нь анх олгосон зээлээс дутуу мөнгөн дүн хүлээж авахыг

зөвшөөрснөөр зээлдэгч ипотекийн зээлийн үүрэг хариуцлагаас чөлөөлөгднө. Зээлдэгчийн орон сууц эзэмших эрхийг түдгэлзүүлэх үйл явц нь нэмэлт зардал гарахад хүргэж болзошгүй тул зээлдүүлэгч алдагдлаа өсгөхгүйн тулд бодино борлуулалтыг хүлээн зөвшөөрдөг байна. Бодино борлуулалт нь зээлдэгчийн зээлийн түүхэнд сөргөөр нөлөөлнө.

**Босго зээл /Floor loan/** Зээлдүүлэгчийн зүгээс барилгын ажлын явц, орон сууцны захиалгатай нь уялдуулан олгож буй барилгын ипотекийн зээлийн анхдагч хэмжээ. Тухайлбал, зээлдүүлэгч нь эхлээд тухайн барилгын төслийн 80 хувийг санхүүжүүлж болно. Харин үлдсэн 20 хувийг барилга ашиглалтад орох үед, эсхүл орон сууцны дийлэнх нь ипотекийн зээлд хамрагдах үед олгоно.

## Г

**Газрын түрээс /Land lease/** Газар өмчлөгчид нь тодорхой төлбөртэйгээр газрыг урт хугацааны түрээсийн гэрээгээр ашиглуулах. Жишээ нь, Бат Доржоос 50 жилийн хугацаатай, жилийн 5 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлөхөөр газар түрээслэсэн. Бат уг газар дээр худалдааны төв барьсан бөгөөд 50 жилийн дараа хөрөнгө бүхэлдээ Доржид буцаж шилжинэ.

## Д

**Давхар барьцаатай ипотекийн зээл /Blanket mortgage/** Хэд хэдэн үл хөдлөх хөрөнгө барьцаалсан ипотекийн зээл.

**Доогуур эрэмбэтэй ипотекийн зээл /Subordinate mortgage/** Барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулах тохиолдолд тэргүүн эрэмбэтэй ипотекийн зээлийн үүргийг бүрэн хангасны дараа барьцаа хөрөнгөөр үүрэг гүйцэтгэх нөхцөл бүрдэх ипотекийн зээл.

## И

**Ижил төлбөртэй орон сууцны ипотекийн зээл /Level-payment mortgage/** Сар бүр ижил дүнтэй төлбөр хийх ипотекийн зээл. Хэдийгээр сар бүр төлөх төлбөрийн дүн ижил байх боловч үндсэн болон хүүгийн төлбөрийн хувь хэмжээ харилцан адилгүй байдаг байна. Эхний жилүүдэд төлбөрийн дийлэнх хэсэг нь (90% хүртэл) хүүг төлөхөд зарцуулагддаг байна. Харин хүүгийн төлбөрийн дийлэнх хэсэг нь төлөгдж дуусах сүүлийн жилүүдэд зээлийн үндсэн дүн хурдацтай буурч эхэлдэг байна.

**Индексжүүлсэн зээл /Indexed loan/** Төлбөрийн хэмжээ нь ямар нэгэн индекс (тухайлбал, хэрэглээний үнийн индекс)-тэй уялдаж өөрчлөгдхө зээл. Индексжүүлсэн зээл нь ихэвчлэн урт хугацааг хамарна. Зээлийг индексжүүлэхэд хүргэдэг хүчин зүйлсийн нэг нь инфляци юм. Үнийн өсөлт нь зээлийн үндсэн дүнгийн үнэ цэнийг бууруулах ба ингэснээр зээлдэгч хожиж, харин зээлдүүлэгч хохироход хүрдэг. Иймээс зээлийн хүү, үндсэн дүнг индексжүүлэх замаар зээлдүүлэгчид эрсдэлээ бууруулдаг байна.

**Ипотек /Mortgage/** Тухайн зээл, өр төлбөрийн барьцаа болж буй орон сууц, эсхүл бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийг бий болгож буй бичгээр үйлдсэн хэрэгсэл.

**Ипотекийн анхдагч зах /Primary mortgage market/** Үл хөдлөх хөрөнгө тухайлбал, орон сууц барьцаалсан зээлийг шинээр олгож буй зах зээл. Тус зээлийг банкууд, ипотекийн зээлийн брокерууд, хадгаламж, зээлийн хоршоод болон бусад санхүүгийн байгууллагууд олгодог. Зээлдэгчид олгосон орон сууцны зээлийг ипотекийн хоёрдогч зах дээр арилжаалах нь нийтлэг байдаг.

**Ипотекийн барьцааны эрх /Mortgage lien/** Зээлдүүлэгчийн барьцаа хөрөнгийн хувьд хэрэгжүүлж буй эрх. Барьцаа хөрөнгийн эрхийг зээлдүүлэгч эдлэх эрхтэй тул зээлдэгч нь төлбөрөө төлөхгүй тохиолдолд орон сууцаа алдахад хүрнэ. Харин зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дуусгаснаар зээлдүүлэгчийн ипотекийн барьцааны эрх үгүй болж орон сууц зээлдэгчийн мэдэлд бүрэн шилжинэ.

**Ипотекийн бонд /Mortgage bonds/** Үл хөдлөх хөрөнгө буюу орон сууцны зээлээр баталгаажсан бонд. Уг бондын хүү сар, улирал, эсхүл хагас жил тутам төлөгдж болно. Зээл чанаргүй болсон тохиолдолд үл хөдлөх хөрөнгө нь ипотекийн бонд эзэмшигчид шилжинэ.

**Ипотекийн зээл /Mortgage loan/** Бүрэн баригдаж дууссан, улсын комисс хүлээн авч дүгнэлт гаргасан, улсын бүртгэлд бүртгэгдэж үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээгээр баталгаажсан үл хөдлөх хөрөнгийг барьцаалж олгосон зээл.

**Ипотекийн зээлийн багц /Mortgage pool/** Хоёрдогч зах дээр хөрөнгө оруулагчдад арилжаалах үүднээс ангилаал, хүү, хугацааны хувьд адил төстэй ипотекийн зээлүүдээс бүрдүүлсэн багц. Уг зээлийн багцаар баталгаажсан үнэт цаас гарган хөрөнгө оруулагчдад санал болгодог.

**Ипотекийн зээлийн банк /Mortgage bank/** Ипотекийн зээлийг олгох, зарах, түүний үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй банк, санхүүгийн багууллага. Зээлийт банк өөрийн, эсхүл бусдаас татсан хөрөнгөөр санхүүжүүлнэ. Банк нь олгосон ипотекийн зээлээ өөрөө эзэмших, эсхүл хөрөнгө оруулагчдад арилжаалж болно. Мөн зээлийн үйлчилгээг банк өөрөө үзүүлэхээс гадна өөр санхүүгийн байгууллагаар хийлгэж болно.

**Ипотекийн зээлийн даатгал /Mortgage insurance/** Зээлдэгч төлбөрийн чадваргүй болж зээлийн төлбөрийг гүйцэтгэж чадахгүй болох эрсдэлээс зээлдүүлэгчийг хамгаалж буй даатгалын төрөл. Мөн ипотекийн зээлийн даатгал нь зээлдэгч нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд ипотекийн зээлийн төлбөрийг төлөх баталгаа болдог.

**Ипотекийн зээлийн жилийн тогтмол итгэлцүүр /Annual mortgage constant/** Жилийн өрийн төлбөрийг зээлийн үндсэн төлбөрт харьцуулсан харьцаа. Энэхүү итгэлцүүрийг дараах томьёогоор олно:

$$\frac{\text{Ипотекийн зээлийн жилийн тогтмол итгэлцүүр}}{\text{Жилийн өрийн төлбөр}} = \frac{\text{Жилийн өрийн төлбөр}}{\text{Зээлийн үндсэн төлбөр}}$$

**Ипотекийн зээлийн үйлчилгээ /Mortgage servicing/** Ипотекийн зээлийн үйлчилгээ үзүүлэгч этгээд ипотекийн зээлийн төлбөрийг хүлээн авч бүртгэх, хөвөгч хүүтэй ипотекийн зээлийн хүүг тооцох, зээлдэгчийн эскроу данснаас татвар болон даатгалын төлбөрийг төлөх, зээл чанаргүй болсон тохиолдолд холбогдох хэлэлцээрийг эхлүүлэх, хохирлыг шүүхээр барагдуулах зэрэг үйл ажиллагааг хариуцдаг байна. Ипотекийн зээлийн үйлчилгээг зээл олгосон байгууллага, эсхүл зээлийн үйлчилгээг худалдан авсан байгууллага гүйцэтгэдэг.

**Ипотекийн зээлээр баталгаажсан өрийн хэрэгсэл /Collateralized mortgage obligation/** Ипотекийн зээлийн багцаар баталгаажсан үнэт цаас. Уг үнэт цаас нь төрөл бүрийн хугацаатай, төрөл бүрийн ангилал (tranche)-д хуваагдаж болох бөгөөд ипотекийн зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг транчиудад хуваарилдаг. Хөрөнгө оруулагчдын хэрэгцээ шаардлагыг илүү уян хатан байдлаар хангах үүднээс ипотекийн зээлийн багцыг хугацаагаар нь дахин бүлэглэн багцалж үнэт цаас болгон арилжаалдаг.

**Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас /Mortgage backed security/** Ипотекийн зээлийн багцаар баталгаажсан бонд, эсхүл санхүүгийн бусад өрийн хэрэгсэл. Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг тусгай зориулалтын компани гаргана. Манай улсад тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулж болно.

**Ипотекийн том зээл /Jumbo mortgage/** Тухайн улсын хувьд тодорхой хэмжээний дүнгээс давсан хэмжээтэй ипотекийн зээл. Тухайлбал, АНУ-д Фанни Мэй, Фредди Мак гэсэн Засгийн газрын байгууллагууд зээлдүүлэгчдээс орон сууцны зээлийг худалдан авдаг. Эдгээр хоёр байгууллагаас тогтоосон хэмжээ буюу 417 мянган ам.доллараас (өртөг өндөртэй бус нутагт 625 мянган ам.доллар) давж буй ипотекийн зээлийг том зээл гэдэг. Манай улсад ипотекийн том зээлийг ийнхүү тодорхойлсон хэмжээ байдаггүй.

**Ипотекийн хамтран зээлдэгч /Co-mortgagor/** Үндсэн зээлдэгчийн хамтаар зээлийн гэрээний дагуу үүрэг хүлээсэн этгээд.

**Ипотекийн хоёрдогч зах /Secondary mortgage market/**

Ипотекийн зээлийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа хэрэгжиж буй зах зээл. Тухайлбал, АНУ-д Фанни Мэй, Фредди Мак зэрэг байгууллагууд хамгийн өндөр бодит үйлчилж буй хүйтэй ипотекийн зээлийг худалдан авах зарчмаар долоо хоног бүр арилжаа зарлаж явуулдаг. Ипотекийн хоёрдогч захын хувьд арилжаа хийгдэх тусгайлсан газар гэж байдаггүй.

**К**

**Кадастрын зураглал /Cadastral map/** Геодезийн хэмжилт, тодруулалт, боловсруулалтын үр дүнгээр бүх төрлийн кадастрын зураг үйлдэх үйл ажиллагаа. Кадастрын зураглалыг үл хөдлөх эд хөрөнгийн төрлөөс нь хамааруулан газар, хот байгуулалт, инженерийн шугаман байгууламж, геологи, уул уурхайн, бусад гэж ангилна. Газрын кадастрын зураглалыг газрын үндсэн зориулалт, хэрэгцээг харгалзан газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллаар ялгаж газар, хөрс, ус, ургамлын байр зүйн агуулгатайгаар үйлдэнэ.

**Капиталжих хувь /Capitalization rate/** Үл хөдлөх хөрөнгөөс хүлээгдэж буй өгөөжийн түвшин. Үл хөдлөх хөрөнгөөс хүлээгдэж буй орлогыг (тогтмол болон хувьсах зардлыг хассаны дараах) хөрөнгийн нийт үнэд харьцуулж олно. Капиталжих хувийн тусламжтайгаар хөрөнгө оруулалтаас хүлээгдэж буй өгөөжийг үнэлнэ.

**Н**

**Нийлмэл амины орон сууц /Attached house/** Хаяагаараа нийлсэн, 2 талаараа дундын ханатай орон сууц.

**Нийтийн зориулалттай орон сууц /Apartment/** Бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэг нь дөрөв ба түүнээс дээш сууцны зориулалттай барилга.

**Нягтрал /Density/** Газрын нэгж талбайд ногдох орон сууц, оршин суугчид, эсхүл гэр бүлийн зөвшөөрөгдсөн тоо.



*Zurag 7. Амины нийлмэл орон сууц*

**Нягтралын бүсчлэл /Density zoning/** Тухайн бүс нутгийн нэг га газарт барьж болох орон сууцны тоог хязгаарласан зохицуулалт.

## О

**Орлого авчрах хөрөнгө //Income property/** Түрээслүүлэх, эсхүл үнэ өссөний дараа борлуулан ашиг олох зорилгоор худалдан авсан үл хөдлөх хөрөнгө. Орлого авчрах үл хөдлөх хөрөнгөд орон сууц, худалдааны төв, албан тасалгааны зориулалттай байшин, үйлдвэр, агуулахын байр, рашаан сувилал, амралтын газрын байр, зочин буудал, дэн буудал, зоогийн газар ордог бол хувийн орон сууц, боловсруулаагүй газар, сургууль, сүм, цэцэрлэгт хүрээлэн орохгүй.

**Орлогын аргачлал //Income approach/** Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний арга. Тус арга нь бий болгосон орлогод үндэслэн хөрөнгийн үнийг тооцох боломжийг хөрөнгө оруулагчдад олгодог. Захын үнэлгээг олоходоо үйл ажиллагааны цэвэр орлогыг капиталжих хувьд харьцуулна. Орлогын капиталжих арга гэх нь ч бий.

**Орон байр /Dwelling/** Байшин, амины орон сууц, нийтийн орон сууц, гэр, бусад сууц.

**Орон сууц өмчлөлийн хувь /Homeownership rate/** Оршин суугчдын өмчлөлд буй орон сууцны хувь хэмжээ. Иргэдийн өмчлөлд буй орон сууцны тоог нийт хүн амын оршин сууж буй орон сууцны тоонд харьцуулж олно.

**Орон сууц сайжруулах зээл** /Home improvement loan/ Орон сууцандаа өөрчлөлт хийх, орон сууцны зарим зүйлийг солих, шинэчлэх, орон сууцны засвар хийх зорилгоор авч буй богино хугацаатай зээл.

**Орон сууцны зах зээлийн шингээх хурд** /Absorption rate/ Тухайн хугацаанд, тухайн бүс нутаг дахь орон сууцны борлуулалтын хурд. Тухайн сард зарагдсан орон сууцны тоог зарагдахад бэлэн байгаа нийт орон сууцны тоонд харьцуулж олно.

**Орон сууцны хөрөнгийн зээл** /Home equity loan/ Зээлдэгч нь орон сууцаа барьцаалан зээл авах явдал. Ийм зээлийг орон сууцандаа засвар хийх, эрүүл мэнд, боловсролын зардлыг санхүүжүүлэхэд зориулан авах нь нийтлэг байдаг. Тус төрлийн зээл нь өрөө төлж дуусах хүртэл хөрөнгийг барьцаалах эрхийг үүсгэх ба орон сууцны өөрийн өмчлөх хэсгийг бууруулна.

**Орон сууцны стандарт** /Housing code/ Орон сууцны хүн амьдрах наад захын шаардлагыг хангаж байх зохицуулалт. Тус стандартын зорилго нь оршин суугчдын эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангахад оршино.

**Орон сууцны тоо хэмжээ** /Housing stock/ Тухайн бүс нутгийн хүн амьдарч болох орон сууцны тоо.

**Орон сууцны хүртээмж** /Affordable housing/ Дундаж орлоготой өрх орон сууцны зээлд хамрагдаж чадаж буй эсэхийг харуулах үзүүлэлт. Тус үзүүлэлтийг орон сууцны хүртээмжийн индексээр хэмжинэ.

**Орон сууцны хүртээмжийн индекс** /Housing affordability index/ Орон сууцны хүртээмжийг харуулж буй индекс. Тус индекс 100 гэсэн утгатай байвал дундаж (медиан) орлоготой өрх дундаж үнэтэй орон сууцны зээлд хамрагдаж чадаж буйг харуулна.

## Ө

**Өмчийн татвар** /Property tax/ Газар болон түүн дээр баригдсан байшин барилгад ногдуулах татвар.

**Өмчийн эрх /Property rights/** Өмч эзэмших, өмчлөх хүрээг хууль тогтоомжоор хамгаалах явдал. Хувь хүн, хамт олон, Засгийн газрын өмч эзэмших эрх нь эдийн засгийн тогтолцооноос хамаарна.

**Өсөн нэмэгдэх төлбөртэй ипотекийн зээл /Graduated-payment mortgage/** Орон сууцны зээлийн сарын төлбөр нь бага дүнгээс эхлэн тодорхой хугацааны туршид аажмаар өсөн нэмэгдэж, зохих түвшиндээ хүрэх нөхцөлтэй орон сууцны зээл. Энэ нь орлого багатай боловч ирээдүйд орлого нь нэмэгдэх шинэ гэр бүлүүдийг зээлд хамруулах давуу талтай.

## С

**Солих нөхцөл /Recourse/** Зээлдэгч зээлээ эргүүлэн төлж чадахгүй тохиолдолд зээлийг барьцаа хөрөнгөөр төлүүлэх бөгөөд барьцааг борлуулсны орлого зээлийн өрийг бүрэн барагдуулж чадахгүй тохиолдолд зээлдэгчийн бусад хөрөнгө, орлогоор үлдэгдэл өрийг төлүүлэх эрхийг зээлдүүлэгч (банк)-д олгосон нөхцөлтэй зээл.

**Солих нөхцөлгүй /Nonrecourse, Without recourse/** Зээлдэгч зээлээ эргүүлэн төлж чадахгүй тохиолдолд зээлдэгч зөвхөн барьцаа хөрөнгөөр л зээлийг төлүүлэх нөхцөлтэй зээл. Барьцаа хөрөнгийн борлуулалтын орлого нь зээлийн өрийг бүрэн барагдуулж чадахгүй байсан ч зээлдэгчийн бусад хөрөнгөөр төлүүлэх боломжгүй байдаг.

**Сууц өмчлөл /Homeownership/** Амьдарч буй орон сууцаа өмчилж буй байдал.

## Т

**Татвараас чөлөөлөгдөх хөрөнгө /Tax-exempt property/** Үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөгддөг зарим үл хөдлөх хөрөнгө. Тухайлбал, төрийн байгууллагын газар, байшин барилга, сүм дугана гэх мэт.

**Тогтмол төлбөртэй ипотекийн зээл /Fixed payment mortgage/** Хүү болон үндсэн төлбөрийн нийлбэрээс бүрдэх сарын төлбөр нь тогтмол байх ипотекийн зээлийг хэлнэ.

**Тогтмол хүүтэй ипотекийн зээл /Fixed rate mortgage/** Зээлийн хүүг зээл олгох үед тогтоох бөгөөд зээл эргэн төлөгдж дуусах хүртэл тогтмол байх ипотекийн зээлийг хэлнэ.

**Түргэсгэсэн төлөлт /Accelerated amortization/** Ипотекийн зээлийн гэрээний дагуу төлөх хуваарыт (тухайлбал сарын төлбөр) төлбөрөөс илүү хэмжээгээр төлсөн төлбөр. Ингэснээр зээлийн хугацаа богиносно.

**Түрээс /Rent, tenancy/** Газар, байр орон сууц гэх мэт үл хөдлөх хөрөнгийг гэрээний дагуу түр хугацаагаар эзэмшиж, ашигласны төлөө төлж буй төлбөр.

**Түрээсийн эрх шилжүүлэх /Assignment of lease, Assignment of rents/** Түрээслэгчийн зүгээс өмч ашиглах эрхээ өөр этгээдэд шилжүүлэх үйл явц. Хэдийгээр анхдагч түрээслэгч эрхээ шилжүүлэх боловч анх байгуулсан гэрээний үүргээ хүлээсэн хэвээр байх болно. Жишээ нь, Болд 10 жилийн хугацаатай агуулах түрээслэсэн боловч 5 жилийн дараа уг агуулах хэрэггүй болсон тул Батад дамжуулан түрээслүүлсэн байна. Гэхдээ Болдын агуулахын эзний өмнө хүлээсэн хариуцлага хэвээр байх болно.

**Түрээслүүлэгч /Landlord/** Хөрөнгийн өмчлөгч бөгөөд бусдад түрээслүүлж буй хувь хүн, байгууллага.

**Түрээслүүлэгч /Lessor/** Лизингээр ашиглуулж буй хөрөнгийн эзэн буюу өмчлөгч.

**Түрээслэгч /Lessee/** Түрээслэгч буюу хөрөнгийг лизингээр ашиглаж буй тал.

## Ү

